

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ISSN: 2313-6170

Түлхүүр үг: Орчуулга зүй

# ОРЧУУЛГА ЗҮЙ

## ХІІІ

(Орчуулга заах аргазүй)

Эрхлэн хэвлүүлсэн: Г.Элдэв-Очир

Улаанбаатар

2026

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

**ОРЧУУЛГА ЗҮЙ**

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦУВРАЛ

№13 (640)

**Эрхлэгч:**

**Нарийн бичгийн дарга:**

**Гишүүд:**

**Ариутган хянах зөвлөл**

Ш.Эгшиг (доктор, дэд профессор)

Г.Элдэв-Очир (доктор, дэд профессор)

Э.Равдан (ШУ-ны доктор, профессор)

С.Эрдэнэмаам (доктор, профессор)

Л.Чулуунбаатар (доктор, профессор)

Г.Буяннэмэх (доктор, профессор)

О.Чинбаяр (МОЭ-ийн ерөнхийлөгч)

М.Чимэдцэеэ (доктор, дэд профессор)

К.Окада (Токиогийн ГСИС, доктор, профессор)

Б.Баярмэнд (ӨМИС-ийн МСС, доктор, профессор)

В.В.Мароши (Новосибирскийн УБИС, доктор, профессор)

Мари Доминик Эвен (ФҮШУСТөв, доктор, профессор)

Хоу Ваньжуан (Бээжингийн их сургуулийн Монгол судлалын төвийн зөвлөх, профессор)

Санаачлагч:

Хянан засварласан:

Хуудасны хэмжээ:

Хэвлэлийн хуудас:

Хэвлэсэн тоо:

Хэвлэлийн газар:

МУИС, ШУС, ХУС, Орчуулга зүйн профессорын хамтлаг

Ш.Эгшиг, Г.Элдэв-Очир

А4

19.5 хх

50 ш

“Удам соёл” хэвлэлийн газар

**NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA**

ISSN: 2313-6170

Key title: Орчуулгазүй

# **TRANSLATION STUDIES**

## **XIII**

Compiled by: G.Eldev-Ochir

Ulaanbaatar  
2026

NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

**TRANSLATION STUDIES**

RESEARCH SERIES №13 (640)

<b>Editor:</b>	Egshig.Sh (National University of Mongolia, Mongolia)
<b>Secretary:</b>	Eldev-Ochir.G (National University of Mongolia, Mongolia)
<b>Editorial Boards:</b>	
Ravdan.E (National University of Mongolia, Mongolia)	
Erdenemaam.S (Mongolian State University of Education, Mongolia)	
Chuluunbaatar.L (National University of Mongolia, Mongolia)	
Buyannemekh.G (National University of Mongolia, Mongolia)	
Chinbayar.O (President of the Mongolian Translators Union, Mongolia)	
Chimedtseye.M (National University of Mongolia, Mongolia)	
Okada.K (Tokyo University of Foreign Studies, Japan)	
Bayarmend.B (Inner Mongolia University, P.R.China)	
Maroshi.V.V (Novosibirsk State Pedagogical University, Russia)	
Marie-Dominique Even (French National Center for Scientific Research, France)	
Hou Wanzhuang (Center of Mongolian studies of Peking University, P.R.China)	
<b>Founder:</b>	Professors Team for Translation Studies, Division of Humanities, School of Arts and Science, National University of Mongolia
<b>Edited by:</b>	Egshig.Sh, Eldev-Ochir.G
<b>Paper size:</b>	A4
<b>Number of pages:</b>	156
<b>Number of prints:</b>	50
<b>Press:</b>	“Udam soyol” LLC

**ГАРЧИГ**

Өмнөтгөл үг		7
<b>ОРЧУУЛГА ЗҮЙ</b>		
Э.Мөнх-Учрал	Орчуулагч, хэлмэрчийн эх хэлний сургалтын хөтөлбөр	
Ш.Эгшиг,	боловсруулах асуудалд	9
Ц.Онон	Японы уран зохиолын орчуулгын уламжлалыг түүхэн үүднээс шинжлэх нь	19
Ц.Магсар	Шүлэг гоо зүйн тогтолцоогоо хадгалан орчуулагдах боломжийн тухайд	25
Б.Даваасүрэн	Орчуулгын шинэ чиг хандлага	30
Б.Төмөрхуяг	Анагаахын нэр томъёоны орчуулгын асуудалд	35
Д.Долгорсүрэн	Дипломат орчуулгын хичээлийг заах аргазүй, шинэ боломжууд	40
М.Амартайван	Орчуулгын сургалтад хиймэл оюуныг зохистой хэрэглэх нь	47
Ц.Ичинхорлоо	Монгол хэлний хэлцийг хятад хэлнээ орчуулахад түгээмэл хэрэглэгдэх аргууд	55
Т.Мягмарсүрэн	Сошиал медиа орчинд хэрэглэгдэж буй англи хэлний ярианы үгсийн бүтэц ба орчуулгын дүйцэл	60
Х. Цацрал	Нэр томъёоны орчуулгын асуудалд	69
Г. Мөнхтөгс	Уран зохиолын орчуулгыг ондоошуулах ба идээшүүлэх аргын үүднээс судлах нь	77
Б.Удвал,	Уран зохиолын орчуулга дахь өгүүлбэрийн мэдээллийн бүтэц,	
Д.Алтанхуяг	түүнийг векторын чанарын аналог загвараар шинжлэх нь	82
Э.Жаргалмаа	Амарбаясгалант хийдийн гэрэлт хөшөөний манж-монгол бичээсний орчуулгын үгийн сангийн онцлог	92

**ОРЧУУЛГЫН ШҮҮМЖ СУДЛАЛ**

С.Эрдэнэмаам	Д.Нацагдоржийн “Хуучин хүү” өгүүллэгийн орос орчуулгуудыг өнгөц шинжихүй дор	104
П.Уянга, Б.Хавар	“А Кюгийн үнэн түүх” зохиолын монгол орчуулгын онцлог	113
Б.Дулмаа	Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийн солонгос орчуулгуудын утга, дүрслэл, хэмнэлийн харьцуулсан судалгаа	121
М.Отгонбаяр,	Философийн эх зохиол орчуулах тухайд: логик-философийн	
С.Бүжинлхам	трактат зохиолын жишээн дээр	129
Б.Нэргүйжаргал,	“Гурван улсын үлгэр” сонгодог зохиолын шүлгийн орчуулгыг	
Б.Сүмбэр	тольдохуй	136
Э.Тогтуун,	Япон дэлгэцийн бүтээлийн хадмал орчуулгад хийсэн шинжилгээ	141
Л.Соёл		

**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОРЧУУЛГА**

Рассадин В.И.	Холбоо хамаарлын үүрэг түрэг-монгол хэлний нийтлэг хэв шинж үүсэхэд нөлөөлсөн нь	150
---------------	--	-----

**CONTENTS**

Preface		7
<b>TRANSLATION STUDIES</b>		
E.Munkh-Uchral Sh.Egshig, Ts.Onon	Developing a native language (L1) training curriculum for translators and interpreters Analyzing the tradition of literary translation in Japan from a historical perspective	9 19
Ts.Magsar	The feasibility of retaining aesthetic structures in poetic translation	25
B.Davaasuren	New trends in translation studies	30
B.Tumurkhuyag	Medical terminology translation issues	35
D.Dolgorsuren	Bringing New Opportunities to the Classroom of Diplomatic Translation and Interpreting	40
M.Amartaivan	Appropriate Use of Artificial Intelligence in Translation Education	47
Ts.Ichinkhorloo	Commonly used methods for translating Mongolian idioms into Chinese	55
T.Myagmarsuren	The word formation of English colloquial words used in social media and their translation equivalence	60
Kh.Tsatsral	Issues in translating Railway terminology	69
G.Munkhtugs	A Study of Literary Translation from the Perspectives of Foreignization and Domestication	77
B.Udval, D.Altankhuyag	An analysis of sentence information structure in literary translation using a vector based analog model	82
E.Jargalmaa	Lexical translation features of the Manchu-Mongolian Inscription on the Stele of Amarbayasgalant Monastery	92
<b>TRANSLATION CRITICISM</b>		
S.Erdenemaam	A comparative Analysis of Early and Late Russian Translations of D.Natsagdorj's Short Story "Khuuchin khuu" (The Old Son)	104
P.Uyanga, B.Khavar	Mongolian translation features of the novel "The true story of Ah Q"	113
B.Dulmaa	A comparative analysis of meaning, imagery, and rhythm in korean translations of "Homeland" by Dashdorjiin Natsagdorj	121
M.Otgonbayar, S.Bujinlkham	On the translation of philosophy: using the tractatus logico-philosophicus as an example	129
B.Nerguijargal, B.Sumber	A Study of the poetic translations in "Romance of the Three Kingdoms"	136
E.Togtuun, L.Soyol	Analysis of Subtitle Translation in Japanese Screen Works	141
<b>ACADEMIC TRANSLATION</b>		
V.I.Rassadin	Language affinity role in a formation of common topology of the Turkic-Mongolian languages	150

## ӨМНӨТГӨЛ ҮГ

Монголчуудын орчуулгын үйл хэрэг олон зуун жилийн түүхтэй бөгөөд энэ нь монголчууд эртнээс нааш өөр хэл соёлт олон үндэстэн угсаатантай байнгын харилцаатай байсан хийгээд монголчуудын дэлхий ертөнцийн элдэв сонин сайхныг мэдэх гэсэн тэмүүлэл, бусад улс үндэстэнтэй өргөн харилцаатай байсныг гэрчлэх онцлог тал нь яахын аргагүй мөн билээ. Үүний дотор монголчуудын өвөг дээдс хүннү нар хэлмэрч хийж байсан тухай мэдээ занги манай орчуулгын түүхийг хэдэн зуунаар урагшлуулсан билээ.

“Орчуулгагүйгээр бид өөр өөрийн нутагтаа хил, хязгаараа ч давж төвдөхгүй нам гүмхэн аж төрөн суух байлаа.” гэж Жорж Штейнер (George Steiner), “Орчуулагч бол хоёр газар нэгэн зэрэг оршдог амрахыг мэддэггүй нэгэн.” гэж Рейнер Шүлте (Rainer Schulte) нар нэгэнтээ тус тус хэлцгээсэн байдаг. Энэ мэргэн үгс орчуулгын талаар ихийг бодогдуулах нь дамжиггүй. Орчин үеийн орчуулгазүйн судалгаанд орчуулагч, хэлмэрчийн ажлаа гүйцэтгэдэг цаг хугацааны асуудлаас болж, хоёр тусад нь авч үзэн судалдаг. Эрдэмтэн Мона Бейкер (Mona Baker) Рейнер Шүлтегийн нэгэн адил хэлмэрч бол нэг дор хоёр газар оршин байхаас өөр аргагүй ажил мэргэжил болох тухай мөн өгүүлсэн байдаг. Өнөөгийн орчуулгын зах зээлийн байдлаас хүмүүсийн анхааралд хэлмэрчилгээний салбар орж ирж байгаа нь ажиглагдаж байна.

“Орчуулгазүй” сэтгүүл 2026 онд арван гурав дах дугаараа ийнхүү толилуулж байна. Сэтгүүлийн бодлого бол дэлхийн орчуулгазүйн чиг хандлагыг даган, орчуулгын судлал ба хэлмэрчлэхүйн түвшинд судалгаа хийхийг дэмжих, олон улсын өндөр түвшний эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэн нийтэлдэг сэтгүүлийг хөгжүүлэх явдал юм.

Бид 2013 оноос орчуулгын судалгааг онолын түвшинд хүргэх, туршилт судалгааг эрчимжүүлэх чиглэлд ажиллаж байна. МУИС-ийн тухайн үеийн Гадаад хэл, соёлын сургуульд 2013 оноос Орчуулгазүйн Профессорын баг бүрдэж, гадаад хэлний салбар дундын эрдэм шинжилгээний ажлыг орчуулгазүйн чиглэлээр гүнзгийрүүлэн хийж эхэлснээс гадна, “Гадаад хэлний орчуулга” бакалавр, магистрын хөтөлбөрийг боловсруулан сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн юм. Мөн тус хөтөлбөрийн докторын хөтөлбөрийг боловсруулах шатандаа явж байгаа билээ. Тус сургуульд “Орчуулгазүй”-н эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж эхэлсэн бөгөөд эдүгээ 14 дэх удаагийн бага хурлаа хийгээд байна. Бид Орчуулгазүйн эрдэм шинжилгээний 14-р бага хурлыг “Орчуулга заах арга зүй: Уламжлал, шинэчлэл” сэдвийн дор амжилттай зохион байгуулж, олон эрдэмтэн судлаачдын илтгэлийг хэлэлцсэн билээ. Энэ хурлаар орчуулга ба хэлмэрчилгээ гэх орчуулгазүйн судалгааны хоёр чиглэлийн нэг болох “хэлмэрчилгээ” гэх шинэ үгийг монгол хэлний нэр үг үүсгэх дотоод зүй тогтлын дагуу бүтээж, эрдэмтдийн санал нэгтгэйгээр салбарын нэр томъёог нэгээр нэмлээ.

Орчуулгын сургалт, эрдэм шинжилгээний ажлын зэрэгцээ орчуулгын тухай хэлэлцүүлэг, орчуулгын дугуйлан тогтмолжиж, нийгмийн хүрээний орчуулгын бүхий л салбарын тулгамдаж буй асуудалд ч багш эрдэмтдийн зүгээс анхаарал хандуулж, төр хувийн хэвшлийн орчуулгын үйлчилгээний чанар, орчуулагч, хэлмэрчдийн ур чадварт задлан шинжилгээ, зах зээлийн судалгаа хийж, орчуулгын салбарын удирдлага чиглэл тодорхойгүй, үйл ажиллагааны уялдаа холбоогүй байдал оршиж байгааг тодорхойлж, үүнийг цэгцлэн сайжруулах хамгийн зөв гаргалгаа бол орчуулгын чанар стандартыг төгөлдөржүүлэх, мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэх, салбарын асуудлыг нийтээр хэлэлцэж, орчуулгын салбар бүрийн чиглэл, зорилгыг зөв оновчтой тогтоох асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй гэж үзсээр ирсэн билээ.

Бид 2024 оны 5-р сараас эхлэн Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн ивээл дор “Монголын Орчуулагчдын анхдугаар чуулган”-ыг зохион байгуулах бэлтгэл ажлыг гардан гүйцэтгэж, 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын

газар, Үндэсний мэдээллийн МонЦаМэ агентлагтай хамтран тус чуулганыг Төрийн ордонд амжилттай зохион байгууллаа. Чуулганд нийт 500 орчим орчуулагч, хэлмэрч болон орчуулгын салбарын мэргэжилтэн чуулж, тус салбарын өнөө цагт тулгамдаж буй асуудлаар санал, шүүмж өрнүүлсэн билээ.

Монголын Орчуулагчдын Анхдугаар Чуулганы урьдчилсан хэлэлцүүлгийн хүрээнд танхим болон цахимаар нийт 668 санал дэвшүүлснийг нэгтгэн, чуулганд танилцуулж, төр засгийн байгууллага, мэргэжлийн холбоо, орчуулгын үйл ажиллагаанд оролцогчдод хандсан зөвлөмж гаргасан бөгөөд энэ зөвлөмжийн мөрөөр тус сургуулийн зүгээс мэргэжилтний ур чадварын шалгалт, мэргэшүүлэх сургалтын тогтолцооны суурийг тавьлаа.

2025-2026 онд хийсэн ололттой ажил бол МУИС-ийн Орчуулагч хэлмэрчийн мэргэшлийн үнэлгээний төвөөс Орчуулагч, хэлмэрчийн мэргэшлийн зэрэг тогтоох (МАЕТИ) “Орчуулагчийн анхан шатны бичгийн орчуулгын цогц чадварын туршилт шалгалт”-ыг орчуулгын ба хэлмэрчилгээний шалгалтыг тус бүр гурван удаа зохион байгуулаад байна. Шалгалтанд одоогийн байдлаар 30 гаруй орчуулагч, хэлмэрч мэргэжилтэн анхан шатны буюу гуравдугаар зэргийн болзлыг хангаж гэрчилгээ гарджээ. Мөн 2025 оны намар Орчуулагч, хэлмэрчийн мэргэшүүлэх сургалтыг туршилтаар хийж, 2026 оноос уг сургалтыг орчуулагч, хэлмэрчийн сургалтаын хөтөлбөртэй зохион байгуулж эхэллээ.

“Орчуулгазүй” сэтгүүлийн арван гурав дах дугаар ийнхүү нийтлэгдэж байна. Бид сэтгүүлийг анх үүсгэн хэвлүүлж эхэлснээс хойш тасралтгүй гаргасаар ирлээ. Энэ дугаар “Орчуулгазүй”, “Орчуулгын шүүмж судлал” булантай гарч байна. Манай сэтгүүлийн зорилго бол Монгол дахь орчуулгазүйн чиг хандлагыг тодорхойлж, тулгамдаж буй асуудлыг шийдэх эрдмийн индэр болох явдал билээ.

Эрдэмтэн судлаач, номын садан, уншигч та бүхнээс сэтгүүлийн талаархи санал, шүүмж, зөвлөгөө хийгээд бүтээл туурвилаа байнга ирүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Орчуулга бол дэлхийн олон соёлын уулзвар, үндэстэн хооронд бие биеэ танин мэдэх гүүр нь юм. Сэтгүүлд өгүүллээ нийтлүүлэгч, уншигч, дэмжигчдийн эрдэм оюуны гэгээн мэлмий тунгалаг байж, бүтээл туурвилын уран найралт цагаан мөр ямагт дурайж байх болтугай.

МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбар  
Гадаад хэлний орчуулга хөтөлбөр

Таргуд Шагдарсүрэнгийн Эгшиг (Ph.D)



## ОРЧУУЛАГЧ, ХЭЛМЭРЧИЙН ЭХ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ АСУУДАЛД

Э. Мөнх-Учрал<sup>1</sup>, Ш.Эгшиг<sup>2</sup>

**Abstract:** Organizing a training of translators and interpreters, we had to consider the equal inclusion of native language and foreign language courses in the curriculum. Based on the content of the native language courses taught in the pilot training, we present five modules and 16 teaching methods of the native language training curriculum that were agreed upon through our academic discussions. The article provides a review of the previous research on the training modules and training methods, theoretical basis, and comparison with native language training methods that are not intended for specific specialists.

**Түлхүүр үг:** орчуулга, хэлмэрчилгээ, орчуулгын чадамж, эх хэл, эх хэлний сургалт, сургалтын хөтөлбөр, сургалтын бүрэлдэхүүн (модуль)

### УДИРТГАЛ

Алив хүний төрөлх хэлний мэдлэг боловсрол орчуулгын чанарт нөлөөлдөг нь судалгаагаар тогтоогдсон ч, орчуулагч, хэлмэрч мэргэжилтэнд зориулсан эх хэлний хөтөлбөрийг бид өмнө боловсруулж байгаагүй нь шинэ сорилт болсон билээ.

Сүүлийн үеийн нийгэм, шинжлэх ухаан, хиймэл оюун, техникийн хөгжил, эрэлт хэрэгцээний улмаас *орчуулга (translation)*, *хэлмэрчилгээ (interpretation)*-ний салбарт шинэ сорилт бий болж буйг дагалдан орчуулагч, хэлмэрчийн чадамжийг дээшлүүлэхэд чиглэсэн судалгаа олон улсад эрчимжиж байна (Bell 1991, Ozorco 2000, Leal 2003, Alves and Gorcalves 2007, Cano 2014, Quinci 2014, Robert, Ramael et al. 2016, Ollala-Soler 2017).

Монгол Улсын тухайд, МУИС-ийн “Орчуулагч, хэлмэрчийн мэргэшлийн үнэлгээний төв” (ОХМУТ) 2021 оноос “Монгол Улсын орчуулагч, хэлмэрчийн чадамжийн судалгаа” төслийг санаачлан хэрэгжүүлж, энэ хүрээнд орчуулгын чадамжийн гол загваруудад (РАСТЕ 2003, Klimczak-Pawlak 2018) тулгуурлан, *хос хэлний (bilingual)*, *хэл шинжлэлийн бус (extra-linguistic)*, *орчуулгын мэдлэгийн (knowledge of translation)*, *эх сурвалж ашиглах (instrumental)*, *стратегийн (strategic)*, *сэтгэхүй-сэтгэл зүйн (psycho-psychological)*, *соёл хоорондын (intercultural)* гэсэн долоон дэд чадамж (*sub-competence*)-ийг судалж, англи, хятад, орос, солонгос, япон, турк, итали, испани зэрэг олон хэлний орчуулагч, хэлмэрчийн ур чадварыг судалсны (Egshig нар 2024) үр дүнд мэргэшлийн үнэлгээний арга зүйгээ боловсруулсан болно.

Тус судалгаа болон 2024.09.30-нд МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор амжилттай зохион байгуулсан “Монголын орчуулагчдын анхдугаар чуулган” (МОАЧ)-аас гарсан зөвлөмжид суурилан гадаад хэл, монгол хэлний мэдлэг чадварыг үнэлэх “Орчуулагч, хэлмэрчийн мэргэшлийн шалгалт” (ОХМШ буюу англи хэлээр МАЕТИ - Mongolia Accreditation Exam for Translators and Interpreters)-ыг 2025 оны 9 сараас зохион байгуулж, 3-р түвшний гэрчилгээ олгож эхэллээ.

<sup>1</sup> доктор (Ph.D), МУИС, ШУС, ХУС, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим, 0000-0002-7917-1253.

<sup>2</sup> доктор (Ph.D), дэд профессор, МУИС, ШУС, ХУС, Ази судлалын тэнхим, 0000-0002-5904-9867.

Улмаар, ОХМУТ-ийн төлөвлөгөө, МОАЧ-аас гаргасан зөвлөмж, шалгалтад оролцогчдын зүгээс тавьсан хүсэлтийн дагуу орчуулагч, хэлмэрчид зориулсан сургалтыг 2025 оны 11 сараас зохион байгуулж, одоо хоёр дахь сургалтаа хийж байна.

Дээр дурдсан ОХМУТ-ийн судалгаа, МОАЧ-ы зөвлөмж, шалгалт, сургалтад оролцсон орчуулагч, хэлмэрчдийн зүгээс нэн тэргүүнд сайжруулахыг хүсэж буй зүйл нь монгол хэлний мэдлэг, монгол хэлээр орчуулга, хэлмэрчилгээ хийх чадвар байна.

Энэ нь зөвхөн монголын хамаатай онцгой тохиолдол бус аж. Тухайлбал, орчуулагчийн чадамж нь зөвхөн гадаад хэлний мэдлэгээр тодорхойлогдохгүй, харин тухайн салбарын талаарх мэдлэг, туршлага, эх хэлний нарийн мэдлэг, хэл сэтгэлгээний шүтэн барилдлага, эх хэлээрээ найруулан бичих хийгээд зөв хэлж ярих ур чадвар, дискурсийн бүтэц, хэлний хэрэглээ зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Тийм учраас орчуулгын чадамжийн судалгаанд *эх хэлний мэдлэг* нь *хоёр хэлний* болон *стратегийн* дэд чадамжийн суурь бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг (РАСТЕ 2003; Albir 2015).

Иймээс, энэхүү өгүүлэлд гадаад хэл сайтай боловч орчуулагч, хэлмэрчийн мэргэжлийн түвшинд эх хэлээ сайжруулах шаардлагатай бодит байдлаас урган гарсан уг эрэлт хэрэгцээг хангахуйцаар орчуулагч, хэлмэрчид зориулсан эх хэлний сургалтын үр өгөөжийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор судалгаа хийж, монгол хэлний сургалтад хэрэглэж болох таван модуль, арван сургалтын арга зүйг дэвшүүлэх болно.

## СУДЛАГДСАН БАЙДАЛ

Өнөөгийн байдлаар монгол хэл, бичгийн судалгаанд орчуулгын хэлний нөлөө, орчуулгаас үүдсэн алдаа мэдгийг илрүүлэх, түгээмэл тохиолддог алдааны учир шалтгааныг тайлбарлах, засах арга замыг өгүүлэх байдлаар багагүй анхааран дурдаж ирсэн юм (Ринчен 1991, 2008: 104-149, Шагдарсүрэн 2007, 2010, 2012, 2023, Чоймаа 2009: 125-135, Дулам 2012: 8-12, Өнөрбаян 2012: 38-39, Аким 2013: 13-15, Өвгөнхүү 2013: 21-23, Отгонсүрэн 2012: 35-37, Пүрэв-Очир нар 2013: 49-54, Шархүү 2014: 66-69, Балдан 2014: 23-26, Бадраа 2014: 54-56, Мөнхцэцэг 2014: 70-72, Нэргүй 2014: 73-76, Баттогтох 2015: 83-85, Erdenebat 2020 г.м.). Ялангуяа Ц. Шагдарсүрэнгийн “Эх хэлээ эвдэхгүй юм сан” (2007, 2012, 2022) бүтээлд эх хэлний онцлог, орчуулгаас үүдсэн алдаа мадаг, тэдгээрийг илрүүлэх, алдаа гарах учир шалтгаан, засах арга замыг өгүүлсэн байдгаараа чухал ач холбогдолтой.

Хэдий тийм боловч, орчуулагч, хэлмэрчийн эх хэлний мэдлэг, чадварыг сайжруулахад тухайлан зориулсан судалгаа хомс, сургалтын загвар, хөтөлбөр хараахан гараагүй байна.

Түүнчлэн, орчуулагч, хэлмэрчийн мэргэшлийн шалгалт (ОХМШ)-ыг анхан шат буюу 3-р зэргийн түвшинд авч байна. Шалгалтыг орчуулагч, хэлмэрч тус бүрээр 4 ур чадварыг шалган авч байгаагийн эхний хоёр хэсэг нь гадаад хэлний ерөнхий мэдлэг болон монгол хэлний шалгалт, орчуулагчийн хувьд гурав, дөрөвдүгээр шалгалт нь монгол хэлнээс гадаад хэлээр, гадаад хэлнээс монгол хэлээр орчуулах бол хэлмэрчийн хувьд хоёр тийш хэлмэрчлэх шалгалт байдаг. Үүнээс монгол хэлний ерөнхий мэдлэг, чадвар, хандлагыг

- *цэг цэглэл, тэмдэглэгээ,*
- *зөв бичих дүрэм,*
- *бүтээврийн найруулга,*
- *үгийн сангийн найруулга,*
- *өгүүлбэрийн найруулга,*
- *монгол сэтгэлгээний онцлог* гэсэн дэд хэсгээр үнэлж байна.

ОХМШ-ын бүтэцтэй холбоотойгоор, дээр өгүүлсэнчлэн орчуулагч, хэлмэрчийн чадварыг дээшлүүлэхэд зориулсан тусгай сургалтыг 2025 оны 11 сараас 3 сарын хугацаанд зохион

байгуулсны үндсэн дээр багш нар болон суралцагчдын зүгээс сургалтын чанарыг сайжруулах тодорхой санал гарсныг танилцуулбал:

- Хичээл хоорондын уялдаа холбоог сайжруулах
- Сургалтын тусгай хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах
- Хөтөлбөр нь шалгалттайгаа уялдсан байх
- Орчуулга, хэлмэрчилгээний бодит жишээг түлхүү ашиглах зэрэг болно.

## ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Эдгээр бодит шаардлагын үндсэн дээр орчуулагч, хэлмэрчийн эх хэлний мэдлэг чадвартай холбогдох судалгааны бүтээлүүдийг авч үзье.

Дэвиес, Бентахила нар хэл эзэмшихүй (language possession) нэг хэлийг эх хэл, өөрийн хэл хэмээн авч үздэгт шүүмжлэлтэй хандаж, хэл бол тогтвортой зүйл бус, харин нийгмийн хэрэглээ, харилцааны орчин, соёлын оролцоо, хувь хүний туршлагаас шалтгаалан өөрчлөгдөж, олон түвшинд эзэмшиж болдог динамик үзэгдэл учраас олон хэлтэй (biligual/multilingual) хүмүүсийн бодит байдлыг хэл эзэмших гэдэг ойлголтоор бүрэн илэрхийлж чадахгүй гэж үзсэн байдаг (Davies and Bentahila 1989). Энэ нь олон соёлт, олон үндэстнээс бүрэлдсэн орчны хувьд оновчтой байж болох боловч манайх шиг нэг соёлт, нэгдмэл цул үндэстнээс бүтэж бүрэлдсэн улсын хувьд шууд дагахуйц баримтлал болж чадахгүй нь тодорхой юм. Тэгвэл, Покорн “зөвхөн эх хэл рүүгээ орчуулах” дискурсийг задлан шинжилж, орчуулгын чанар нь аль хэлнээс аль хэл рүү орчуулж байгаа гэдэг чиглэлээс илүүгээр, тухайн орчуулагчийн чадвар, туршлага, мэргэжлийн нөхцөлөөс хамаарна, олон хэлний орчинд орчуулагчид гадаад хэл рүү сайн орчуулга хийдэг байдал олон улсын байгууллага, цөөн хүн ам хэлэлцдэг хэлтэн, мэргэжлийн орчуулгын зах зээлд түгээмэл гэжээ (Pokorn 200). Мэдээжээр, эх хэл рүү орчуулах нь сайн, эсвэл гадаад хэл рүү орчуулах нь сайн гэж үзэх нь хэт явцуу бөгөөд орчуулагч аль хэлнээс аль хэл рүү орчуулах нь тухайн орчуулагчийн чадвараас л шалтгаална. Тэгэхлээр, бид эх хэл юм уу гадаад хэл гэдгийн эргэн тойронд бус, орчуулагчийн чадвар, орчуулгын чанарыг онцлох хэрэгтэй болов уу.

Тэгвэл, Соан орчуулагчийн эх хэл орчуулагчийн сургалтад ямар чухал үүрэгтэй болохыг онцолж, эх хэлний сайн мэдлэг, чадваргүйгээр орчуулга хийх боломж хязгаарлагдахад хүрнэ гэдгийг нотлоход хувь нэмрээ оруулжээ (Soang 2016). Тэр бээр орчуулга нь зөвхөн гадаад хэлний мэдлэг бус, харин эх хэлээрээ илэрхийлэх, найруулах, задлан тайлбарлах чадвар бөгөөд эх хэлийг утгыг задлах (comprehension), дахин илэрхийлэх (re-expression), соёлын үүднээс тайлбарлах (cultural interpretation) бүх шатанд их ашигладаг хэмээн үзэж эх хэлний үгийн баялаг муу, найруулгын мэдлэг сул, өгүүлбэрийн бүтэц, логик зохион байгуулалт хангалтгүй бол гадаад хэл хэдий сайн байвч орчуулга чанаргүй болно гэж үздэг.

Орdoneз-Лопез судлаачид эх хэлийг зөвхөн хэрэгсэл бус, орчуулагчийн мэргэжлийн чадамжийн үндэс гэж үздэг бол олон оюутан эх хэлээ бус, гадаад хэл илүү чухал гэж үзэх хандлагатай, тэрхүү хандлагын улмаас эх хэлээ сайн сурахыг чухалчилдаггүй байдлыг судалсны үндсэн дээр оюутнуудын эх хэлээ хэрхэн үнэлж, эх хэлэндээ хэрхэн хандаж байгаа байдал нь тэдний орчуулгын чадварт шууд нөлөөлж, хэрэв дутуу үнэлж байвал орчуулгын чанарт сөргөөр нөлөөлж байна хэмээн үзжээ (Ordoñez-López (2025).

Орчуулгын чадвар олон зүйлээс бүрдэх бөгөөд орчуулах явцад тэд бүгд нэгдмэл байдлаар оролцдог (Albir 2015). Өөрөөр хэлбэл, Мона Бэйкерийн дурдсанчлан, юуг хэрхэн орчуулах вэ гэдэг шийдвэр зөвхөн үгийг зөв оноох төдийгөөр бус, илүү өргөн хүрээнд харилцааны болон соёлын хүчин зүйлсээр тодорхойлогдоно (Baker 2018). Мөн Кирали орчуулагчийн чадамжийг урьдчилан тогтоосон “ур чадварын жагсаалт” хэлбэрээр бус, харин бодит орчуулгын орчин нөхцөл, хамтын ажиллагаа, туршлагаас аажимдаа бий болж хөгждөг, хөдлөнгө шинжтэй үйл явц (emergent phenomenon) хэмээн үзэх хандлагыг дэвшүүлсэн буй (Kiraly 2013).

Ийм учраас, сүүлийн үед *хамаарлын онол* (relevance theory) чухал үүрэг гүйцэтгэж байна гэж хэлж болох юм. Тус онолын дагуу, орчуулгыг зөвхөн нэг хэлийг нөгөөд буулгаж байгаа явдал бус, харин танин мэдэхүйн (cognitive) болон шийдвэр гаргах (decision making) үйл явц гэж үзсэний үндсэн дээр, орчуулагчийн чадамжийг мэдээллийн хамаарал (relevance) болон мэргэшсэн байдлын (expertise) уялдаанд тайлбарладаг. Тухайлбал, орчуулга бол бичвэрийн утгыг ойлгоходоо хам сэдэв, зорилтот уншигч, соёлын мэдээлэл, харилцааны зорилго зэргийг ашиглан тасралтгүй таамаглал дэвшүүлж баталгаажуулдаг танин мэдэхүй үйл явц бөгөөд орчуулагч шийдвэрийг *автомат* (automatic) болон *ухамсарт* (controlled) хоёр түвшинд гаргадаг. Орчуулагчийн чадвар нь хэлний мэдлэг, стратегийн асуудал шийдвэрлэх чадвар, мэргэжлийн туршлага зэрэг олон хүчин зүйлээс бүрддэг тул тогтвортой (static) ур чадвар биш, харин тухайн нөхцөлөөс шалтгаалдаг хөдлөнгө (dynamic) танин мэдэхүйн тогтолцоо гэж үзэх шаардлагатай гэсэн санааг дэвшүүлжээ (Alves & Gonçalves 2003, 2007).

Келли орчуулгын сургалтын арга зүйг *эргэцүүлэн суралцахуй* (reflective practice)-д тулгуурлахыг санал болгосон буй (Kelly 2005). Уг бүтээлийн гол санаа нь орчуулагч бэлтгэх сургалтаар зөвхөн хэлний мэдлэгийг дамжуулах бус, харин суралцагчдыг өөрийнхөө орчуулгын үйл явцыг шинжлэх, үнэлэх, сайжруулах чадвартай болгох ёстой гэдэгт оршино.

Дээр дурдсаныг нэгтгэн авч үзвэл, орчуулагчийн ур чадварыг сайжруулахын тулд

- нэгд, хэрэглэгдэхүүний талаас тухайн тохиолдлын бодит жишээ, олон хэв маяг бүхий баялаг эх сонгох;
- хоёрт, орчуулагч, хэлмэрчийн зүгээс өөрийнхөө орчуулсан хэлмэрчилсэн байдлыг шүүн тунгаах, хянах, сайжруулах мэдлэг, чадвар эзэмшихийг зорих;
- гуравд, багш, чиглүүлэгчийн хувьд орчуулах, хэлмэрчлэх хэрэглэгдэхүүнийг ойлгож байгаа суурь мэдлэг, задлан тайлбарлаж байгаа үйл явцыг онолын үндэслэл, зөв болон буруу хэрэглэж байгаа учир шалтгааныг хэл, сэтгэхүй, соёл, хам сэдвийн онцлогтой уялдуулан чиглүүлж өгөхийг сургалтын гол онолын үндэслэл болгох нь зүйтэй байна.

## СУРГАЛТЫН АРГУУД

Орчуулагч, хэлмэрчийн ур чадварыг сайжруулахад зориулсан сургалтын аргыг судлан танилцуулбал:

- *Олон нийтийн орчин дахь бичвэр* (Linguistic Landscape): Алгряни олон нийтийн орчинд буй тэмдэг, хаяг, зар сурталчилгаа зэрэг бодит бичвэрийг орчуулгын сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглаж, орчуулгын алдааг илрүүлэх, утга, хэв маяг, соёлын ялгааг задлан шинжлэх, дахин орчуулах, шүүн тунгааж үнэлэх зэрэг даалгавар өгч судлахад оюутнуудын эх хэл болон гадаад хэлний мэдлэг сайжирч, соёлын болон хам сэдвийн талаарх ойлголт дээшилж, стратегийн шийдвэр гаргах олон талт чадвар (linguistics, cultural, strategic competence) илүү хөгжжээ (Algryani 2022).
- Алвес, Магалхаес нар орчуулагчдын хийсэн олон хувилбар орчуулга, орчуулгын завсар, даалгаврын явцын мэдээлэл зэргийг бичил хөмрөг болгон цуглуулж ашигласан бөгөөд ний үр дүнд орчуулга хийх үйл явц (process) болон орчуулгын эцсийн эх (product) хооронд уялдаа холбоо байх ба тэрхүү уялдааг хөмрөгийн аргаар илрүүлэн зурагласны (mapping) үр дүнд орчуулагчийн шийдвэр гаргах, стратеги, алдааны шалтгааныг бодитоор тайлбарлах боломжтой гэж үзжээ (Alves & Magalhães (2004).
- Ж. Эрдэнэбат орчуулгын сургалтын *үгийн сан* (vocabulary)-ийн хэсгийг онцолж, үгийн утгыг зөв сонгох, олон утгатай үгийг тухайн хам сэдэвт нийцүүлэн орчуулах, нэр томьёо ба тогтсон хэллэгийг зөв хэрэглэх явдал хамгийн бэрхшээлтэй байгааг өгүүлж, арга зүйн үүднээс, шууд орчуулга хийх, хам сэдвээ хангалттай судлахгүй байх, суралцагчийн үгийн

сан баялаг бус байгаа нь энэ чиглэлд холбогдох алдааны шалтгаан болдог хэмээн үзжээ (Erdenebat 2020).

- Келли эргэцүүлэн суралцахуйгаар орчуулагчийн чадварыг *даалгавар, өөрийгөө эргэцүүлэх, багшийн чиглүүлэг, хамтын үнэлгээ, ахин дахин засах* гэсэн эргэх холбоонд суурилан хөгжүүлэх боломжийг бүтээлдээ өгүүлсэн бөгөөд түүний санал болгосон аргууд нь:
  1. Эргэцүүлэх туршлагатай болох (reflective practice). Орчуулгын шийдвэр, алдаа, стратеги, сонголтоо ухамсартайгаар задлан шинжилж, “Би яагаад ийм орчуулга хийв?” гэдгээ эргэцүүлэн тайлбарлаж сурах
  2. Үйл явцад суурилсан сургалт (process-oriented learning). Зөвхөн эцсийн бүтээгдэхүүн болсон хувилбараар бус, үйл явцаар үнэлэх. Үүний тулд ноороглох, эх нооргийг хянах, эцсийн эх гаргах, хөндлөнгөөс хянах, багшийн санал зэрэг эргэх холбоот аргуудыг ашиглана.
  3. Тухайлсан зорилгод нийцүүлэн орчуулах (task-based translation training): Олон хувилбартай орчуулга хийх, тодорхой цагт багтаан орчуулах, зорилтот уншигч болон эхийн хэв маягийг өөрчилсөн даалгавар өгөх.
  4. Алдаанд суурилсан шинжилгээ (Error-based analysis): Орчуулагчийн нийтлэг алдааг ангилах, тайлбарлах, засварлах, дахин орчуулах.
  5. Чадамжид суурилах (Competence-based approach): Орчуулагчийн хэлний чадвар, бичвэр боловсруулах чадвар, судалгааны чадвар, технологийн хэрэглээ, мэргэжлийн ёс зүй зэрэг чадамжийг хэсэгчлэн хөгжүүлэх.
  6. Өөрийн санд суурилсан сургалт (Portfolio-based learning): Өөрийнхөө орчуулгын санг бүрдүүлж, алдаа оноо, ахиц дэвшил, өөрчлөлтөө баримтжуулах зэрэг юм (Kelly 2005).
- Кирали бодит орчуулгын нөхцөлд ойр даалгавар ашиглах, суралцагч өөрийн орчуулах үйл явцыг эргэцүүлэх, багаар хэлэлцэх, дүрэмд бус туршлагад суурилсан сургалтын аргуудыг дэмжсэн байдаг (Kiraly 2013).
- Климцак-Павлак соёл хоорондын чадамжийн үүргийг чухалчилж, орчуулга бол нэг хэлийг нөгөөгөөр солих төдий бус, соёлын утга, нийгмийн норм, харилцааны хэв маяг, далд утгыг зөв тайлбарлах шаардлагатай учир соёлын ялгааг таних, соёлын утгыг тайлбарлах, зорилтот соёлд тохируулан дахин найруулах, соёлын эвгүй байдлаас зайлсхийх чадварыг хөгжүүлэх нь зүйтэй болохыг өгүүлжээ. Эдгээр чадварыг хөгжүүлэхэд соёлын зөрчилтэй жишээг задлан шинжлэх (case study), бодит бичвэр ашиглах (authentic text), соёлыг харьцуулах (comparative cultures), эргэцүүлэн хэлэлцэх (reflective discussion) арга санал болгосон буй (Klimczak-Pawlak (2018)
- Соан орчуулгын сургалтад эх хэлээр найруулан бичих, эхийг хувиргах, дахин найруулах, эх хэлээрх алдааг засах аргуудыг хэрэглэх хэрэгтэй гэж үздэг (Soan 2016).
- Янь, Пань, Ван нар орчуулагч, хэлмэрч бэлтгэх сургалтыг тоон шинжилгээ болон суралцаг төвтэй өгөгдлийн судалгаанд тулгуурлан системтэйгээр судалж, орчуулагчийн сургалтыг баримт нотолгоонд суурилсан судалгааны талбар болох талаас нь судалсан байдаг (Yan, PA, Wang 2018). Тэд судалгаандаа орчуулах даалгавар өгөх, хугацаа, нөхцөлийг өөрчлөх, гүйцэтгэлийг харьцуулах, орчуулах явцдаа юу бодож байгаагаа тайлбарлах, орчуулгын хөмрөг бүрдүүлэх зэрэг аргыг хэрэглэжээ.

### **Дэвшүүлж буй эх хэлний сургалтын хөтөлбөр**

Дээрх онолын үндэслэл, сургалтын аргад суурилан орчуулагч, хэлмэрчийн эх хэлний мэдлэг, эх хэлээр мэргэжлийн түвшинд сэтгэх, задлан шинжлэх, найруулах, тухайн тохиолдолд

тохируулан эх хэлээр илэрхийлэх чадварыг дээшлүүлэхийн тулд дараах таван модуль, арван зургаан сургалтын арга зүйг санал болгож байна.

### **Сургалтын бүрэлдэхүүн 1.**

#### **Эх хэлний суурь мэдлэг ба орчуулгын үндэс**

Монгол хэлээр үг үсгийн алдаагүй бичих чадвараас гадна тухайн салбарын мэргэжлийн нэр томьёо, эх хэлний хэлц хэллэгийг ойлгох, тайлбарлах, хийсвэрлэн сэтгэж, тухайн нөхцөлд бага цагт үр бүтээлтэй бичих буюу ярих чадвар дадалтай болоход чиглэнэ.

#### *Эзэмших мэдлэг, чадвар*

- Орчин цагийн монгол хэлний эсвэл орчуулж буй эх зохиогдох үеийн монгол хэлний онцлогийг зохих хэмжээнд эзэмшсэн байх
- Ярианы хэлний үгийг ялгаж ойлгодог, хэрэглэдэг байх
- Шог хошин сэдвийг ойлгодог байх
- Үндэстний онцлогтой үг, соёл, зан заншлын холбогдолтой үг хэллэг, хэлцийг ойлгодог, тайлбарладаг байх
- Монгол хэлний хэмнэх, хийсвэрлэх, товчлох аргыг мэддэг байх
- Хийсвэр, хүнд ойлгомжгүй мэт хэлц, өвөрмөц хэллэгийг эх хэлээрээ энгийн, ойлгомжтой тайлбарлаж, хүнд ойлгогдохоор бичиж эсвэл ярьж чаддаг байх.

Эдгээр чадварыг сайжруулахын тулд дараах аргуудыг хэрэглэж болно.

#### *Сургалтын арга:*

1. Эх хэлээр ажиллах: Эх хэлний бүтэц, зүй тогтол, дүрмийг онолын мэдлэг, хэрэглээтэй хослуулан тайлбарлах, бичвэрийн утга, бичлэг, найруулгыг задлан шинжилж, шүүн тунгаах, хянах засах
2. Олон нийтийн орчин дахь бичвэр, хаяг, зар сурталчилгаа зэрэг бодит бичвэрийг ашиглах
3. Алдаатай орчуулгыг засварлах

### **Сургалтын бүрэлдэхүүн 2.**

#### **Эхийн олон хэв маяг**

Нэг эхийн юм уу нэг илэрхийлэмж утгыг албан хэргийн, эрдэм шинжилгээний, нийтлэлийн, уран зохиолын, бодлогын, харилцан ярианы гэх мэт найруулгын олон янзын түвшинд хувиргаж, янз бүрийн хэв маягаар илэрхийлж сурах чадварыг чухалчилна. Үүнд, бичиж найруулахаас гадна биеийн хэлэмж, дохио зангааг ч багтааж үзнэ. Жишээлбэл, нэг өгүүлбэрийг хуульч, сэтгүүлч, дипломат, судлаач, оюутан сурагч, хүүхэд зэрэг янз бүрийн ажил мэргэжил, хүмүүсийн байр сууринаас эхийг дахин найруулж бичих, ярьж илэрхийлэх зэргийг сургалтын агуулгад багтааж болно.

#### *Эзэмших мэдлэг, чадвар*

- Эхийг найруулгын олон түвшин хувирган бичих
- Эхийн найруулгыг өөрчилж бичих
- Үг хэл, биеийн хэлэмж, дохио зангаагаар тодорхой утга санааг илэрхийлэх

#### *Сургалтын арга:*

1. Эхийн хувиргал (Paraphrasing drills)
2. Найруулгын төрлийг өөрчлөх (Register-switch)
3. Дүрд хувирах (Role play simulation)

### **Сургалтын бүрэлдэхүүн 3.**

#### **Дискурс ба логик бүтэц**

Эхийг учир шалтгааны дараалал, дискурсийн уялдаа холбоонд тулгуурлан засаж найруулах, хянан магадлах чадвартай болоход чиглэсэн модуль.

*Эзэмших мэдлэг, чадвар*

- Шалтгаан, үр дагаврыг ялган тайлах
- Сэдэв ба хам орчны хамаарал, уялдааг тодорхойлох
- Эсрэгцүүлэх, харьцуулах талбараа олж чаддаг байх
- Мэдээллийг зөв дараалалд оруулж чаддаг байх
- Монгол хэлээр учир шалтгааны холбоо харилцаанд сэтгэж найруулах бичих, эсвэл зохион ярих

#### **Сургалтад хэрэглэх аргууд:**

1. Өгүүлбэрийг зөв дараалалд оруулах
2. Бичвэрийг зөв дараалалд оруулан эвлүүлэх
3. Эхийг зорилгодоо нийцүүлэн зохиомжлох

### **Сургалтын бүрэлдэхүүн 4.**

#### **Орчуулгын хэл**

Эх хэлээрээ орчуулах, хэлмэрчлэхдээ түүнийг гадаад хэлний талаас харвал, бас нэг гадаад хэл юм гэж үзэж, задлан шинжлэх чадварт суралцах буюу орчуулгаас үүдсэн алдааг олж харах, түүнийг эх хэлний зүй тогтолд нийцүүлэн засах чадвар эзэмшихэд чиглэсэн модуль болно.

*Эзэмших мэдлэг, чадвар, хандлага*

- Нэр томъёо эх хэлэндээ хэр оновчтой, нийцтэй байгааг нягтлах, өөрийн хувилбарыг дэвшүүлэх
- Үг хэллэг нь эх хэлээр байгаа боловч гадаад хэлний дүрэм, бүтэц загварт автсан байдлыг буюу “орчуулгын хэл”-ийг олж илрүүлэх
- “Орчуулгын хэлээрх” өгүүлбэрийг эх хэлний зүй тогтолд нийцүүлэн “монголчлох”
- Эх хэлнийхээ үнэ цэн, онцлогийг танин мэдэж, эрхэмлэн чухалчлах

#### **Сургалтад хэрэглэх арга:**

1. Алдаан суурилсан сургалт (Error-based learning): Орчуулга, хэлмэрчилгээний түгээмэл алдааны сан бүрдүүлж ашиглах, өөрийн гэсэн “алдааны сан” бий болгох
2. Буцааж орчуулах (Back translation): Эх хэлнээс гадаад хэл рүү орчуулсан эхийг эргүүлээд уг эхийг нь үзэлгүйгээр эх хэл рүүгээ орчуулах
3. Эх бичвэр болон орчуулгыг харгуулан тулгах (Parallel text analysis)
4. Орчуулгыг харьцуулан шинжлэх (Comparative translation analysis): Орчуулгын олон хувилбарыг харьцуулж задлан шинжлэх

### **Сургалтын бүрэлдэхүүн 5.**

#### **Мэргэжлийн болон тухайлсан салбарын найруулга**

Олон салбарын үг хэллэг, найруулгын дотоод учир шалтгааныг олж тогтоож сурах, найруулгын онцлогт нь суралцах, уг хэлбэрийг нь дагах, хадгалах аргуудыг зэрэг ч багтана.

Салбарын жишээ:

- Хууль, бодлого
- Олон улсын харилцаа
- Эдийн засаг
- Судалгааны өгүүлэл
- Хэвлэл мэдээллийн бичвэрүүд
- Уран зохиол, яруу найраг

**Сургалтад хэрэглэх арга:**

1. Найруулгын төрөл, хэлбэрийг задлах шинжлэх (Genre analysis): Эх бичвэрийн холбогдох салбар, найруулгыг тодорхойлох, шинжлэх
2. Дуурайн бичих (Style imitation): Жишиг эх бичвэр уншаад дуурайж бичих
3. Орчуулгын шүүн тунгаах шинжилгээ (Critical Discourse Analysis): буюу анализ хийх

**ДҮГНЭЛТ**

Энэхүү өгүүллээр дэвшүүлсэн орчуулагч, хэлмэрчид зориулсан эх хэлний сургалтын бүрэлдэхүүн хэсэг, сургалтын аргыг хэрэглэснээр, зөвхөн онолын мэдлэг, дүрэмд суурилсан байдлаар бус, эх хэлээрээ сэтгэж, эх хэлнийхээ зүй тогтолд нийцүүлэн орчуулах, хэлмэрчлэх хэрэглээг чухалчилж, тухайн сэдэв агуулгын хүрээнд орчуулж, хэлмэрчилж буй үйл явцыг эргэцүүлэн тунгаах, алдаа мэдгээ илрүүлэх, алдсан учир шалтгаанаа задлан шинжлэх, засаж сайжруулах, хянан магадлах үйл явцад суурилсан сургалт зохион байгуулах боломжтой.

Сургалтад гадаад хэл ба монгол хэлний ялгаа, хэлний сэтгэлгээний онцлогийг харьцуулах, жинхэнэ монгол эх бичвэр, түүний сайн орчуулга, монголын шилдэг нийтлэл, бодлогын баримт бүхий орчуулгуудыг ашиглах, орчуулагчдын алдааны сан бүрдүүлж, ашиглах, өөрийнхөө “алдааны хавтас” бий болгох, эх хэлний бүтэц, зүй тогтол, дүрмийг онолын мэдлэгийг хэрэглээтэй хослуулан тайлбарлах, бичвэрийн утга, бичлэг, найруулгыг задлан шинжилж, шүүн тунгаах, хянах засах зэрэг аргыг ашигласнаар, дараах үр дүнд хүрнэ хэмээн үзэж байна. Үүнд:

- Суралцагч эх хэлээрх бичвэрүүд дундаас орчуулгын эхийг ялган таньдаг болсон байна.
- Нэг өгүүлбэр, нэг эхийг олон янзаар найруулж чаддаг болсон байна.
- Орчуулгад гардаг түгээмэл алдааны талаарх ойлголттой болж, түүнийг засаж залруулах чадвартай болсон байна.
- Эх хэлээрээ зорилгодоо нийцүүлэн бичдэг болсон байна.
- Орчуулах ур чадвар сайжирч, орчуулах хэлмэрчлэх чанар тодорхой хэмжээгээр дээшилсэн байна.
- Монгол сэтгэлгээ болон эх хэлний зүй тогтлын уялдаа холбоог танин мэдэж, эрхэмлэн чухалчлах хандлага төлөвшсөн байна.

ОХМҮТ-ийн зүгээс орчуулагч, хэлмэрчийн дараа дараагийн сургалтын хөтөлбөрийг тус судалгааны үр дүнд тулгуурлан боловсруулж, хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулж эхэлсэн бөгөөд сургалтын үр дүнгийн харьцуулсан шинжилгээ хийж ажиллахаар төлөвлөж байна.

**Товчилсон үг**

МОАЧ - Монголын орчуулагчдын анхдугаар чуулган

ОХМҮТ - Орчуулагч, хэлмэрчийн мэргэшлийн үнэлгээний төв

ОХМШ - Орчуулагч, хэлмэрчийн мэргэшлийн шалгалт (MAETI - Mongolia Accreditation Exam for Translators and Interpreters)

**НОМ ЗҮЙ**

**Монгол хэлээр:**

Аким, Г. 2012. “Махчилсан орчуулгаас монгол хэл минь ...”. *Эх хэл бичиг*. No. 3.

Бадраа, Ж. “Орчуулж болох бүхнийг орчуулах зарчимтай”. *Эх хэл бичиг*. No. 6. 54-56.

Балдан, Л. 2014. “Харь үг нутагшуулж, идээшүүлэхийг хичээх хэрэг юун”. *Эх хэл бичиг*. No.6. 23-26.

Баттогтох, Д. 2015. “Үгийн гарлын тайлбар үнэхээр элэг хөшөөх нь ээ”. *Эх хэл бичиг*. No. 12. 83-85.

Дулам, С. 2012. “Монгол хэл соёлыг минь мөхөөх гээд байна уу даа.” *Эх хэл бичиг*. No. 1. 8-12.

- Мөнхцэцэг, Н. 2014. “Харь хэлний гаж нөлөөг хязгаарлая”. *Эх хэл бичиг*. No. 7. 70-72.
- Нэргүй, Ж. “Гадаадаар нэрлээд сурчихсан 875 ухагдахууныг удахгүй бид монголоороо нэрлэнэ”.  
*Эх хэл бичиг*. No. 7. 73-76.
- Отгонсүрэн, Д. 2012. “зөв сайхан найруулахын учир”. *Эх хэл бичиг*. No. 1.
- Өвгөнхүү, Б. 2013. “Гд-ийн гай”. *Эх хэл бичиг*. No. 3.
- Өнөрбаян, Ц., Л. Цэрэнчимэд. 2012. “Монгол хэлний үйлдэгдэх дагаврыг найруулгад зөв хэрэглэх асуудалд”. *Эх хэл бичиг*. No. 1. 49-54.
- Пүрэв-Очир, Б., Л. Цэрэнчимэд. 2013. “Монгол хэлний үйл үг бүтээх -д дагаврын эргэн тойронд”.  
*Эх хэл бичиг*. No. 3.
- Ринчен, Б. (1991). *Марк Твенний минь махы нь идэж дээ*. Улаанбаатар.
- Ринчен, Б. (2008). “Орчуулгын чанарыг дээшлүүлэх тухай”. *Монгол хэл бичгийг сайжруулах бодлогын өгүүлэл*. 3-р дэвтэр. 104-149.
- Чоймаа, Ш. 2009. “Хэлний экологи”. *Монгол судлал*, XXX (318), 125-135.
- Шагдарсүрэн, Ц. (2007, 2010, 2012, 2022). *Эх хэлээ эвдэхгүй юм сан*. Улаанбаатар. Битпресс.
- Шархүү, А. 2014. “Мохоо орчуулгаар монгол хэлээ буртагласаар”. *Эх хэл бичиг*. No. 5. 66-69.

#### Гадаад хэлээр:

- Albir, A. H. (2015). The Acquisition of Translation Competence. Competences, Tasks, and Assessment in Translator Training. *Meta. Journal des traducteurs Translators' Journal*. Volume 60, Number 2, August 2015, p. 256–280.
- Algyani, A. (2022). The use of linguistic landscape as a training resource for developing students' translation competence. *World Journal of English Language*, 12(6), 274.  
[dx.doi.org/10.5430/wjel.v12n6p274](https://doi.org/10.5430/wjel.v12n6p274)
- Alves, F., & Gonçalves J. L. (2003). A relevance theory approach to the investigation of inferential processes in translation. In Alves, Fabio (Ed.), *Triangulating translation: Perspectives in process-oriented research* (pp.11-34). Amsterdam: John Benjamins.
- Alves, F., & Magalhães, C. (2004). Using small corpora to tap and map the process-product interface in translation. *TradTerm*, 10, 179-211. doi.org/10.11606/issn.2317-9511.tradterm.2004.47162
- Alves, F. (2005). Bridging the gap between declarative and procedural knowledge in the training of translators: Meta-reflection under scrutiny. *Meta*, 50(4), 1-25. doi.org/10.7202/019861ar
- Alves, F., & Gonçalves J. L. (2007). Modelling translator's competence: Relevance and expertise under scrutiny. In Yves Gambier, Miriam Shlesinger & Radegundis Stolze (Eds.), *Translation studies: Doubts and directions. Selected papers from the IV Congress of the European Society for Translation Studies* (pp.41-55). Amsterdam: John Benjamins.
- Baker, M. (2018). *In Other Words: A Coursebook on Translation*.
- Davies, E & Bentahila, A 1989, 'On mother and other tongues: the notion of possession of a language,' *Lingua*, vol. 78, pp. 267-293.
- Egshig, Sh., Gundsambuu, S., Bat-Uchral, G., Davaasuren, B., Demberelmaa, B., Erdenenaran, G., Munkh-Uchral, E., Nerguijargal, B., Purevsuren, B., Selengemurun, Ch. & Soyol, L. (2024). “Exploring translation competence: An experimental study with translators and foreign language teachers in Mongolia.” *Current Trends in Translation Teaching and Learning E,11*. WoS indexed. <https://doi.org/10.51287/cttl202445>
- Erdenebat J. (2020). Vocabulary Translation teaching practices and Challenges, *Translation Studies*, Research series No. 08(529) pp.216-220. Ulaanbaatar: Udam Soyol LLC
- Kelly, D. (2005). *A handbook for translator trainers: A guide to reflective practice*. Manchester: St. Jerome Publishing.
- Kiraly, D. (2013). Towards a view of translator competence as an emergent phenomenon: Thinking outside the box(es) in translator education. In D. Kiraly, S. Hansen-Schirra & K. Maksymski

- (Eds.), *New prospects and perspectives for educating language mediators* (pp.197-224). Narr Verlag.
- Klimczak-Pawlak, A. (2018). Intercultural competence in translator training. *Translatorica & Translata, 1*, 103-114. doi.org/10.18778/2544-9796.01.10
- Munday, Jeremy. (2016). *Introducing Translation Studies*.
- PACTE Group (2003). *Building a Translation Competence Model*.
- Pilar Ordóñez-López, (2025) Translation Students' Attitudes towards Their Native Language (L1): An Understudied Area, *Interpreter and Translator Trainer*, v19 n1 p46-69 2025
- Pokorn, NK 2000, 'Translation into a non-mother tongue in translation theory: deconstruction of the traditional,' in A Chesterman, N Gallardo San Salvador & Y Gambier (eds), *Translation in context: Selected contributions from the EST Congress, Granada, 1998*, John Benjamins, Amsterdam, pp. 61-72.
- Pokorn, NK 2005, 'Challenging the traditional axioms: translation into a non-mother tongue,' John Benjamins, Amsterdam.
- Shreve, G. (1997). Cognition and the evolution of translation competence. In J. H. Danks., G. M. Shreve., S. B. Fountain & M. K. McBeath (Eds.), *Cognitive processes in translation and interpreting* (pp.120-136). Thousand Oaks: Sage.
- Soang, Lih-Lirng (2016). Translation Teaching: The Importance of the Translator's Native Language *Open Journal of Modern Linguistics*, 2016, 6, 247-254 Published Online August 2016 in SciRes. <http://www.scirp.org/journal/ojml> <http://dx.doi.org/10.4236/ojml.2016.64027> Tamkang University, Taiwan Received 14 June 2016; accepted 16 July 2016; published 19 July 2016.
- Stansfield, C.W., Scott, M.L., & Kenyon, D.M. (1992). The measurement of translation ability. *The Modern Language Journal*, 76/(4), 455-467. <https://doi.org/10.2307/330046>
- Yan, J., Pan, J., & Wang, H. (2018). *Research on translator and interpreter training: A collective volume of bibliometric reviews and empirical studies on learners*. Singapore: Springer Nature.



## ШҮЛЭГ ГОО ЗҮЙН ТОГТОЛЦООГОО ХАДГАЛАН ОРЧУУЛАГДАХ БОЛОМЖИЙН ТУХАЙД<sup>3</sup>

Ц.Магсар<sup>4</sup>

*Аннотация:* Переводчики поэтического текста постоянно сталкиваются с проблемами, связанными с переводимостью того или иного стихотворного произведения. По поводу данной темы выделяются две характерные тенденции в современном переводоведении. Для того, чтобы обосновать собственный подход по этой теме, в данном тексте для доклада мы затрагиваем некоторые нюансы относительно специфических моментов в переводе произведений А. С. Пушкина на монгольский язык, ставя во главу угла эстетический параметр стихотворного произведения, так как именно он будет служить главным стержнем в переводе поэзии как искусства слова. В таком случае, наиважнейшей задачей переводчика станет вопрос о том, как решить самую уязвимую на наш взгляд проблему – проблему о сохранении полноценности эстетической системы переводимого произведения.

*Түлхүүр үг:* яруу найраг, дүйцэл ба нийцэл, үндэсний онцлог

Орчин үеийн судлаачид онцлон тэмдэглэдэг яруу найргийн эхийн харьцангуй тогтвортой шинж нь орчуулагчдыг тухайн шүлэглэсэн зохиол орчуулагдах боломжтой эсэх тухай асуудал руу чиглүүлдэг нэг зангилаа сэдэв юм. Энэ сэдвээр яригддаг үй олон үзэл бодлоос нийтлэг хоёр хандлага илэрхий ажиглагддагийн нэг дэхийг яруу найраг орчуулах далай их үйлс бүтээгч мөртлөө шүлгийн орчуулагдах боломжийг туйлын хязгаарлагдмал гэж үзсэн Самуил Маршакийн санаа бодлоор жишээлэн хэлж болно. Тэр бээр “Шүлэг орчуулна гэдэг эрхэм чухал бөгөөд бэрх урлаг. Хэлэхэд хачирхалтай мэт боловч хэрэг дээрээ үнэнийг илтгэсэн хоёр гаргалгааг энд би хэлнэ. Эхнийх нь – шүлгийг орчуулах боломжгүй. Удаах нь – орчуулга бүр онцгой тохиолдол” [Маршак, 1971] гэжээ. Нөгөө хандлагын жишээнд оросын орчуулгын онолчид, тухайлбал А.В.Федоров, И.С.Алексеева, В.В.Сдобников нарын үзэл баримтлалыг дурдаж болно: “...Яруу найргийн эхийн орчуулга харьцангуй чөлөөт шинжтэй тул хамгийн хэцүү орчуулгын төрөл юм. Өөрөөр хэлбэл, энэ төрөлд төгс хувилбар байх боломжгүй, учир нь яруу найргийн дүр дүрслэлийг орчуулагч бүр өөрийнхөөрөө ойлгож, эх хэлэндээ өөр өөрөөр орчуулдаг” [Борисенко, Глухова, 2016]. Яруу найргийн эх орчуулагдах нөхцөл боломжийн талаарх нийтлэг үзэл төсөөлөл ерөнхийдөө ийм бөлгөө.

Эл өгүүлэлд оросын яруу найргаас монгол хэлэнд орчуулах практик ажил үйлийг (тухайн тохиолдолд миний өөрийн) эш болгосон тул яруу найргийн орчуулгын чиглэлээр оросын орчуулга судлалд дэлгэрсэн үзэл онолыг баримтлан А.С.Пушкиний ганц нэг шүлгийг хэрхэн орчуулснаа тухайлан шинжихүл болохгүй зүйлгүй мэт санагдав. Дашрамд тэмдэглэхэд яруу найргийн эхийн тогтолцоот чанарыг гоо зүй, ёс зүй, яруусал, үүрэгт шинж гэх мэт үзүүлэлтээр гүнзгий бөгөөд ул суурьтай тайлбарласан хангалттай эх үүсвэрүүдийг тэндээс олж үзэж болно. Тэгээд ч эдгээр онцлог шинж орчуулагчийн анхаарлын гадна байх боломжгүй. Гагцхүү яруу

<sup>3</sup> «Аксиологические проблемы современных филологических исследований» сэдэвт олон улсын XI эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл (илтгэсэн нэр нь: “К проблеме переводимости поэтического текста как эстетической системы”). Екатеринбург. 2025.04.17.

<sup>4</sup> Доктор, профессор, МУБИС

найргийг үгийн урлаг талаас нь хандаж орчуулах ахул эдгээрээс гоо зүйн үзүүлэлт амин сүнс нь байх болно. Оросын судлаачдын, тухайлбал Ю.Казарины тэмдэглэснээр орон зайн үүднээс авч үзвэл гоо зүйн үзүүлэлт яруу найргийн эхийн гурван гол макро- бүрдлийн нэг ажээ: “Яруу найргийн эх нь хэл ба соёлын тогтолцооны ихээхэн нарийн ээдрээтэй, цогц тэмдэгтүүд, бас өөрөө ч мөн тогтолцоо, буюу хэлний (эхийн) тэмдэгтүүдийн нэгдмэл шинжийг бүрдүүлдгээрээ харилцан адилгүй бөгөөд наад зах нь бүтцийн гурван макро- бүрдэл буюу гурван орон зайг агуулдаг нь соёл, хэл, гоо зүйн орон зай юм” [Казарин, 1999].

Асуудалд энэ үзлээр хандах аваас орчуулагчийн хувьд нэн чухал нь шүлэг хөрвүүлэхэд хамгийн ээдрээтэй зүйл буюу зохиолын гоо зүйн тогтолцоог хэрхэн яаж хэр чинээнд нь хадгалах тухайтад байх болно. Орчуулагч хүн ямагт эргэлзэж эхэлдэг: «орчуулга нь уншигчдад эх зохиолыг хэлээр нь уншиж байгаа янз байдлаараа хүрч чадах уу гэж; яагаад гэвэл “илүү онцлог талд” нь шимтсэн сонголт хийхдээ тэр бээр өөрийн “би”-г тэндээс зайлшгүй олж хардаг» [Позднякова, Бабанина, 2012]. Хэргийн учиг юунд гэвэл орчуулагч гэмээ нь өөрийн гэсэн ертөнцийг үзэх үзэлтэй, гоо зүйн таашаалтай уран бүтээлч бие хүнийхээ хувьд орчуулгын эхийн бүтэц байгууламжийг сонголтоороо шийддэг бөгөөд тэнд нь түүний хувь хүний болон бусад шинж чанараас хамааралтай, субъектив шинжтэй эд эсүүд хүссэн хүсээгүй байх л болно. Тийнхүү би ч мөн адил туршлагаасаа үүдсэн сэдэв рүү орж, тэрхүү өчүүхэн туршлагаа ямар нэг хэмжээгээр дөвийлгөсөн буруутайн мэдрэмжээ илтгэх ялдамд яруу найргийн орчуулгын бүтээлд ямагт цухалздаг өвөрмөц онцлогийг түшиглэн үзэл бодлоо цухас дурдахыг зорив. Ингэхдээ тухайн онцлог шинжүүд нь урьдчилан хэлэх аргагүй, “онцгой тохиолдол” гэдэг утгаараа хэл хэлэнд өөр, орчуулагч бүрд янз янзаар илрэх нигууртайг тэмдэглэх нь зүй. Яруу найргийн эхийн орчуулга “харьцангуй чөлөөт шинжтэй...” талаарх бидний авсан эш чухамхүү энэ онцлогийг тусгах бөгөөд уг чанартаа хувилбар ч мөн олон янз байж болох тухай санааг агуулж буй билээ.

Орчуулга судлалд “дүйцэл”, “нийцэл” гэсэн ойлголтууд байдгийг энэ салбарынхан мэднэ. Аль аль нь орчуулгын эхийн чанарын тухайд шалгуур ойлголт юм. Нийцлийг тодорхойлж, тухайлбал Я.И.Рецкер бичихдээ: “Нийцлийн шалгуур нь уугал эхэд өгөгдсөн бодит байдлын зөвхөн тодорхой нэг хэсэгт таарах тухай асуудал тул сонгон авсан хэрэглэгдэхүүний ижил тэнцүү чанар нь давхацсан байдлаар биш юм гэхэд орчуулгын үр дүн нь уугал эхийн үйлчлэлд туйлын ойр очсон хэмжээсээр тодорхойлогдоно. Хэлний хэрэглэгдэхүүний ижил тэнцүү чанарыг тогтоох үндэс нь хэлбэрийн бус, зөвхөн үүргийн үзүүлэлт гэдгийг ур чадварын өндөр түвшинд гүйцэтгэсэн ямар ч орчуулгын дүн шинжилгээ харуулж байна” [Рецкер, 2007] гэжээ. Харин дүйцүүлэх орчуулгын тухайд гэвэл энэ нь “орчуулж буй хэлний хэм хэмжээг баримтлах үед агуулгын тогтвортой талыг дамжуулах үүднээс зайлшгүй бөгөөд хангалттай түвшинд гүйцэтгэж буй орчуулга” [Бархударов, 2008] билээ. Уран сайхны төгс төгөлдөр орчуулгын шалгуур болгож эдгээр ойлголтын алийг ч хэрэглэх боломжтой ч яруу найргийн орчуулгын тухайд гэвэл нийцлээс илүүтэй дүйцлийн түвшний үзүүлэлтийг онцлон үзүүштэй, учир нь цаад эхийнхээ үг утгас болоод бусад ямарваа нэгэн эд эсээс орхиж гээлгүй орчуулсан гайхамшигтай шүлэг бараг боломжгүй юм. Яруу найргийн орчуулга нь зүгээр нэг хэл хоорондын хувиргал биш нь тодорхой. Орчуулгын энэ төрөл нэн тэргүүнд эхийн гоо зүйн чиг зүгийг гаргадаг уран сайхны ертөнцийн зураглал, соёлын орон зай, үндэсний оюун санааны ертөнц, сэтгэлгээний болон хүртэхүйн дүр дүрслэл гэх мэт хэд хэдэн хүчин зүйлийг өөртөө агуулдаг байна.

Уран сайхны хэлбэр, эхийн гоо зүйн төгс шинжийг хадгалахыг эрмэлзэхдээ орчуулагч хүн энэхүү нийцэл ба дүйцлийн алийг зайлшгүй байдлаар илүүтэй баримтлах төлөвтэйг харуулах зорилгоор Пушкиний хоёр шүлэг, тэдгээрийг орчуулсан хувилбаруудаа авч үзье. Онцлууштай нь эхэд нэг цул болж сүлэлдсэн бүтэц-байгууламжийн, утга-дуурслын нэгдэл болон шүлгийн бусад эд эс орчуулгадаа бүх талаар бүрэн нийцсэн хувиргал гарах нь нэн эргэлзээтэй билээ. Ер нь ч тэгээд яруу найргийн ч бай, гоо зүйн ч бай харь үгийн урлагийн тогтолцоог өөр хэлээр дуурайлган бүтээнэ гэдэг харьцангуй ойлголт юм. Тухайн тохиолдол бүрийг “алтан дунджийг”

хэрхэн олох тухай орчуулагчийн “зовлон” гэж хэлж болно. Эхний хувилбарын жишээ болгож бид энд, тухайлбал Пушкиний “Сэргэлт” шүлгийг орчуулснаа авав:

Художник-варвар кистью сонной  
Картину гения чернит.  
И свой рисунок беззаконный  
Над ней бессмысленно чертит.

Урагшгүй зураач суутны зургийг  
Унтаа бийрээрээ сэглэжээ.  
Ур муутай өөрийн зургийг  
Утгагүй дээрээс нь эрээчжээ.

Но краски чуждые, с летами,  
Спадают ветхой чешуей;  
Созданье гения пред нами  
Выходит с прежней красотой.

Гэвч цагийн уртад ондоо будаг  
Үжирч гандаад хуурав;  
Гоо үзэмжит суутны бүтээл  
Урьдын дүрээрээ тодров.

Так исчезают заблужденья  
С измученной души моей,  
И возникают в ней виденья  
Первоначальных, чистых дней.

Яг л ингэж миний төөрөгдөл  
Энэлсэн сэтгэлээс арилдаг юм,  
Яалт ч үгүй нүцгэрсэн үзлийн  
Эхэн үе эргэж амилдаг юм.

Утга, бүтцийн тал дээр энэхүү орчуулга бараг алдагдалгүй буув. Юуны үр нөлөөгөөр ийнхүү нийцлийн түвшинд хүрсний учир холбогдол нь уугал эх болон орчуулгын эхийн утга, бүтцийн бүрдэл хэсгүүд, тэр дундаа үг илэрхийлэл, өгүүлбэрийн байгууламж, зохиомж, найруулгын хийгээд бусад онцлог шинжүүд тухайн тохиолдолд хоорондоо бүрэн нийцжээ. Нийцлийн ийм жишээ яруу найргийн орчуулгын практикт олноор тааралдах нь лавтай. Харин энэ төрлийн орчуулгад хамгийн ээдрээтэй хоёр дахь хувилбарын жишээнд утга, бүтцийн тал дээр өмнөх эхээс онцын ялгаагүй гэмээр “Хайрлаж дурладаг хавар цаг...” шүлгийн орчуулгыг авч үзье:

Весна, весна, пора любви,  
Как тяжко мне твоё явление,  
Какое томное волнение  
В моей душе, в моей крови...  
Как чуждо сердцу наслаждение...  
Все, что ликует и блестит,  
Наводит скуку и томление.  
Отдайте мне метель и вьюгу  
И зимний долгий мрак ночей.

Хайрлаж дурладаг хавар цаг ирлээ ч  
Харагдах тоолонд чинь би л зовном,  
Буцлах цус, булгилах зүрх минь  
Байж ядан шаналахыг даанч яанам...  
Баяр баясал зүрхэнд багтах газар алга...  
Урамтай хөл хөөрцөг, гял цал бүхэн  
Уйтгар гуныхрал хургаах төдий...  
Яршиг зүгээр, шуурга шамаргатай  
Янгинасан өвөл рүүгээ буцах минь

Монгол хэлэнд буулгасан энэ шүлгийн орчуулга нийцлийн түвшинд бидний хувьд хараахан болсонгүй. Учир нь уугал эхэд орчуулгын хэлний зүй тогтлоор зохиомжлох зайлшгүй шаардлагатай яруу өгүүлэмжийн эрэмбэ, хэлэхүйн онцлог, тухайлбал гаргалга, илэрхийллийн хэрэгслүүд, ярууслын хэлбэртээ үл авцалдах үгсийн сан, өгүүлбэр зүйн зөрөө, үндэсний онцлог, тэр дундаа орос, монгол хүний дүрслэн сэтгэхүйн ялгаа, сэтгэлийн шинж маяг зэрэг үзүүлэлт тусгалаа олсон нь чамгүй аж. Эдгээр тус бүрийг тухайлан авч үзье.

Жишээ нь, *яруу өгүүлэмжийн эрэмбийн тухайд*. Яруу найргийн эхийн орчуулга уугал эхийн гоо зүйн тогтолцоог ямар нэгэн хэмжээгээр “эвдэж”, түүнийгээ орчуулж буй соёлын гоо зүйн тогтолцоотой уялдуулан шинээр бүтээдэг бөгөөд үүний тулд эрхбиш орчуулагч нь өөрөө яруу найргийн дөртэй байх ёстой. Тухайн эхэд кодлогдсон соёлын суурийн зөрөөнөөс үүдэлтэй бэрхшээл үүсэж болох буюу түүнийг зөвхөн яруу өгүүлэмжийн үүргээр дүйцүүлэх түвшинд, чөлөөт хэлбэрээр хувиргал хийх замаар шийдвэрлэх боломжтой. Бидний энд авсан хувилбар ч тийм билээ. Энэхүү эхийн орчуулгад тусгалаа олсон гоо зүйн тогтолцоо, тухайлбал ур хийцийн хэлбэр, шүлгийн байгууламж, сэтгэл хөдлөлийн үр нөлөө гэх мэт зүйлс бүхэлдээ монгол уншигчид чиглэсэн тул орчуулгын эхийн хувьд яалт ч үгүй соёлын хамааралтай үр дүн гарна.

*Хэлэхүйн онцлогийн тухайд*. Яруу найргийн орчуулга үгчилсэн орчуулга биш учраас орчуулагч бээр зохиолоос юуг нь авч үлдээд, юуг нь “золигт гаргах” тал дээр шийдвэр гаргах байнгын асуудалтай тулгардаг ба энэ нь гол төлөв зохиолчийн гоо зүйн үзэл баримтлал хийгээд түүнд нь орчуулагч аль хэр шимтсэн байдлаас ихээхэн шалтгаална. Тухайн эх яруу дүрслэлийн хэрэглүүрээр баялаг тохиолдолд асуудал бүр ч лавшрах талтай. Иймд хэл, хэлэхүйн онцлогтой холбоотой бэрхшээл үүссэн тохиолдолд орчуулагч гол төлөв орчуулгын хэлнийхээ дүйцлийн хэлбэрүүдээс сонгох нь илүүтэй билээ. Дээрх орчуулгад бидний хувьд тухайлбал, “*Весна, весна, пора любви*” хэмээх нэрлэсэн өгүүлбэрээр илэрхийлсэн мөрийг “*Хайр дурлалын цаг хавар ирлээ*” хэмээн энгийн хүүрнэл өгүүлбэрээр, “*Какое томное волнение В моей душе, в моей крови...*” хэмээх хос мөрийг “*Буцлах цус, булгилах зүрх минь Байж ядан шаналахыг даанч яанам...*” хэмээн илүү нарийвчилсан тодотголоор дүйцүүлэн орчуулав. Тухайн тохиолдолд ийнхүү хувиргал хийх шаардлага орос, монгол хэлний үгийн хэрэглээний онцлогтой холбоотой бөгөөд тухайлбал, орос хэлэнд нэрийн хэлбэрээр илрэх боломжтой газар монгол хэлэнд үйл үгийн идэвхтэй хэрэглээний онцлогоо даган үйлших байдлаар илрэх онцлогийн нэг жишээ юм. Мөн “*Как чуждо сердцу наслаждение...*” гэсэн мөрийг үгчлэн орчуулбаас зохимжтой хэлбэрээ олохгүй; иймд “*Баяр баясал зүрхэнд багтах газар алга...*” гэж харьцангуй чөлөөт хэлбэрийг сонгох хэрэгтэй болов. Дашрамд тэмдэглэхэд, чухамхүү яруу найргийн эхийн орчуулгад иймэрхүү ялгаа, зөрөө илүү тод ажиглагддагаас гадна төрөл биш хэлнүүдийн хооронд энэ нь бүр ч их байх магадлалтай.

*Үндэсний онцлогийн тухайд*. Жишээ нь, шүлгийн төгсгөлд хайр сэтгэлдээ шаналсан орос хүний төрх байдлыг тоглоом шоглоомоор, нэг ёсондоо даажигнасан өнгө аясаар илэрхийлсэн нь уншигчийн сэтгэлд санаанд оромгүй, гэнэтийн баясал төрүүлэх ёстой. Хэл хэлэнд өөр өөрөөр илрэх магадлалтай тайллын энэхүү хоёр мөрийг монгол хэлнээ тэр чигт нь буулгах аваас “*Шуурга, шамарга, өвлийн баргар урт шөнүүдийг өгч аль*” гэсэн болхидуу бөгөөд нуршуу орчуулга болох тул монгол хүний сэтгэлгээний онцлог, тухайлбал дүрслэн илэрхийлэх хэрэглүүрийн сонголтыг товч дөт байдлаар хийдэг ёсыг харгалзан хөгжүүн өнгийг бага зэрэг тодотгож, уншигчийн сэтгэлд оч үсэргэх янз маягаар орчуулахаар шийдэв.

Тийнхүү тухайн тохиолдлыг харвал агуулгын талыг мадаггүй илэрхийлэхийн тулд орчуулагч бээр орчуулгын хэлнийхээ хэм хэмжээг баримтлан эхийг зайлшгүй дүйцлийн түвшинд бүтээх хэрэгтэй болж байна.

Үүнээс гадна ямарваа шүлэг орчуулах үед хэлний яруу хувиргалд тэр бүр автдаггүй, бүтэц-байгууламжийн, хийсвэр логикийн болон уугал эхийн бусад онцлогтой холбоотой асуудал чамгүй тааралдах ажээ. Тухайлбал, Пушкиний “*Я вас любил...*” шүлгийг монгол хэлэнд цаад эхтэй нь их бага ямар нэг хэмжээгээр ойртуулж орчуулсан таван ч хувилбар бий. Тухайн шүлгийн зохиомжид “*Как дай вам бог любимой быть другим*” гэсэн төгсгөлийн найм дахь мөр онцгой ач холбогдолтой бөгөөд өвөрмөц тайллын үүрэг гүйцэтгэдэг. Нэгд гэвэл, энэхүү найм дахь мөрөөр уянгын хүүрнэл буюу эхний долоон мөр, уянгын ерөөл буюу төгсгөлийн найм дахь мөр болж эх хоёр хуваагддаг. Хоёрт, уг төгсгөл нь шүлгийн зохиомжийг цоожлон, яруу найрагчийн хүсэл зориг хүрэх ёстой газраа хүрч, агуулгыг цагариган хэлбэрт оруулдаг. Эцэст нь, энэхүү найм дахь

мөр шүлэгт гунигийн аяс оруулж гойд драмлаг шинжтэй болгодог бөгөөд чухамхүү үүгээр яруу найрагчийн сэтгэл нэгмөсөн хоногших ёстой ажээ.

Мөн эхийг шүлэг орчуулагдах боломжийн үүднээс тайлбарлахад утга зохиол судлалын хүчин зүйлс чухал үүрэгтэй бөгөөд жишээ нь, шүлгийн хэмжээ, хэмнэлийг орчуулгад нь хэрхэн тусгах асуудал байнга яригддаг сэдвийн нэг. Энэ шүлгийн хувьд аядуу тайван таван өлмийт ямб, энгийн хэлээр нягт нямбай хайрцагласан хэмнэл нь түүний гуниг харууслын өнгийг дуурьсалтай, эмзэг сэтгэлд хөг нийцтэй болгожээ. Тийнхүү аядуу налархай хөг аясыг орчуулгад ч мөн боломжоор нь тусгах ёстой гэсэн үг. Бидний олж үзсэн таван хувилбараас төгсгөлийн найм дахь мөрийг монгол орчуулгад нь баримталсан тохиолдол анхны орчуулгад буюу Ч.Чимидийнхэд байгаа боловч мөн л төгс хэлбэрээ олсон гэхэд хэцүү [Магсар, 2009]. Учир нь монгол хэлний өгүүлбэр зүйн бүтцийн онцлог уугал эхийн логикийг урвуу дараалалд оруулж орчуулахыг шаардах болно. Ч.Чимид орчуулгаа дараах байдлаар төгсгөжээ:

Я вас любил так искренно, так нежно,	Яг над шиг ийм үнэнч эелдэг хайраар
Как дай вам бог любимой быть другим.	Яамай даа, бусад нь таныг хайрлах болтугай.

Ч.Чимидийнхэд нэлээн ойртсон бас нэг хувилбар бол Чой.Лхагвынх юм:

Өөгүй чин үнэнч энхрийлэн дурласан над шиг  
Өөр тийм эрийг бурхан танд соёрхог.

Гэхдээ Пушкиний шүлэгт найм дахь мөрийг тодотгосон онцолбор нь эзэн бие биш, хайрын хүч (“так искренно, так нежно”) байгаа нь Чой.Лхагвынхад бус (“энхрийлэн дурласан над шиг”), Ч.Чимидийн тодотголд (“над шиг үнэнч эелдэг хайраар”) оновчтой туссан. Үлдсэн гурван хувилбарын хоёрыг мөн дор сийрүүлбэ:

Хайрт та өөр хүнд заяаг гэж би залбирнам  
Хайр минь тийм цогтой, тийм эелдэг байсан юм.  
(С.Дондог).

Дэргэдэх хархүү чинь ингэж л хайрлаг гэмээр  
Дэндүү голоосоо энхрийлэн дурлаж явлаа чамдаа.  
(Ц.Магсар).

Ийнхүү гоо зүйн тогтолцоот чанараараа яруу найргийн эх олон талт шинжийг агуулдаг ба орчуулагдах нөхцөл боломж нь хоорондоо харьцаж буй тухайн хэлтнүүдийн хэл, сэтгэхүйн онцлог төдийгүй үндэсний соёл, урлаг-гоо зүйн болон бусад онцлог ялгаанаас хамаарах хүчин зүйлстэй холбоотой билээ. Бидний энд авсан жишээ орчуулгын ажил үйлд тохиолддог хувь шинжтэй баримт хэдий ч яруу найраг орчуулагчийн ажлын онцлогийг ямар нэг хэмжээгээр харуулахад судалгааны ач холбогдолтойг энд онцлов.

#### АШИГЛАСАН ЭХ ҮҮСВЭРҮҮД

*Бархударов Л. С.* Язык и перевод: Вопросы общей и частной теории перевода. М., 2008, С. 186.

*Борисенко Ю. А., Глухова А. С.* К вопросу о переводе поэзии. // Многоязычие в образовательном пространстве. – Вестник Удмуртского университета. 2016. – Вып. 8. – С. 88-92. – Проблемы перевода в межкультурной коммуникации [Цахим ресурс]. URL: <https://cyberleninka.ru/article/n/k-voprosu-o-perevode-poezii/viewer>

*Казарин Ю. В.* Поэтический текст как система. Издательство Уральского университета. Екатеринбург, 1999. С. 43.

*Магсар Ц.* К проблеме трансформации некоторых моментов в стихотворении “Я вас любил ...”. “История, язык, культура” (Сборник материалов международной научно-практической конференции). УБ., 2009. С. 52-56.

*Маршак С. Я.* Собрание сочинений в 8 тт. Т. 6., М.: Художественная литература, 1971. С. 371-375.

*Позднякова К. Б., Бабанина Т. М.* Проблемы перевода поэзии [Цахим ресурс]. URL: [https://elar.urfu.ru/bitstream/10995/87106/1/978-5-321-02223-8\\_2012\\_027.pdf](https://elar.urfu.ru/bitstream/10995/87106/1/978-5-321-02223-8_2012_027.pdf).

*Рецкер Я. И.* Теория перевода и переводческая практика. М., 200



## ЯПОНЫ УРАН ЗОХИОЛЫН ОРЧУУЛГЫН УЛАМЖЛАЛЫГ ТҮҮХЭН ҮҮДНЭЭС ШИНЖЛЭХ НЬ

Ц.Онон<sup>5</sup>

**Abstract:** *This study aims to examine the tradition of literary translation in Japan from a historical perspective, analyzing changes in translation purpose and strategies within the framework of Skopos Theory, and to elucidate translation methods as well as the role and influence of the translator.*

*In the history of Japanese literature, translation has not merely served as a means of introducing foreign works into another language; rather, it has functioned as a complex and continuous process that has shaped stylistic expression, genre conventions, readers' habits, publishing structures, and ultimately the formation of a distinct national cultural identity. Following the Meiji Restoration, a wave of translations that brought Western literature, theories, and ideas into the Japanese language played a crucial role in standardizing modern written Japanese and in consolidating new literary genres such as the novel and play.*

**Түлхүүр үг:** *Skopos theory, орчуулгын стратеги, орчуулагчийн нөлөө*

### УДИРТГАЛ

Японы уран зохиолын түүхэнд орчуулга нь гадаадын бүтээлийг өөр хэлээр танилцуулах төдий бус, хэл найруулга, төрөл жанрын ойлголт, уншигчийн дадал, хэвлэлийн газрын бүтэц, улмаар үндэсний соёлын өөрийн дүр төрхийг бүтээхэд тасралтгүй оролцсон цогц үйл байсаар иржээ (Keene:1984, Bassnett: 2014). Мэйжийн шинэчлэлийн дараа барууны уран зохиол, онол, үзэл санааг япон хэлэнд авчирсан орчуулгын давалгаа нь орчин цагийн япон бичгийн хэлийг хэвшүүлэн төлөвшүүлэх, роман, жүжиг зэрэг шинэ төрөл жанрын тогтолцоог бэхжүүлэхэд онцгой нөлөө үзүүлсэн (Sato-Rossberg & Wakabayashi: 2012, Keene: 1999, p. 412) байна. Нөгөө талаас ХХ зуунаас хойш япон зохиолууд гадаад хэл рүү орчуулагдан түгэхдээ орчуулагч, хэвлэлийн газар, их сургууль, шагнал, соёлын байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурлан гадаадад “япон уран зохиол” гэх өвөрмөц дүр төрхийг тогтоож иржээ (Venuti, 1995).

### СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АРГА

Бид энэхүү өгүүлэлдээ Японы уран зохиолын орчуулгын уламжлалыг түүхэн үүднээс нь авч үзэн, орчуулгын зорилго, стратегийн өөрчлөлтийг Зорилтот орчуулгын онол (Skopos theory)-ын хүрээнд шинжлэн, орчуулгын арга барил, орчуулагчийн нөлөөг тодруулахыг зорив.

Судалгааны хүрээнд өмнөх судлаачдын бүтээл, зохиолч Мори Оогайн<sup>6</sup> орчуулгын бүтээл, Кавабата Ясүнаригийн<sup>7</sup> зохиолын гадаад хэлээрх орчуулгыг хэрэглэгдэхүүн болгон авлаа.

<sup>5</sup> Доктор, профессор, МУИС, ШУС, ХУС, Ази судлалын тэнхим, ORCID: 0000-0003-3889-505X

<sup>6</sup> Мори Оогай (1862-1922). Мэйжи болон Тайшогийн үеийн зохиолч, шүүмжлэгч, орчуулагч, соён гэгээрүүлэгч, цэргийн эмч. Олон арван өгүүллэг, тууж, орчуулгын бүтээл туурвиснаас монгол хэлээр 5 зохиол нь орчуулагджээ.

<sup>7</sup> Кавабата Ясүнари (1899-1972). Нобелийн шагналт зохиолч. Дэлхийн олон хэлнээ зохиол бүтээл нь танигдсан бөгөөд монгол хэлээр “Изүгээр яваа бүжигч бүсгүй” тэргүүт 10 орчим өгүүлэл, тууж нь орчуулагджээ.

### Гадаадын зохиолыг япон хэлнээ орчуулж ирсэн уламжлал

Японд бичгийн соёл төлөвших эхэн үед нангиад хэлээрх түүх, сургаалын зохиол, яруу найраг, буддын шашны судар гэх мэт сонгодог бичвэрүүд боловсрол, төрийн үйл хэрэг, соёлын гол эх сурвалж байжээ (Keene, 1984). Судлаачид тухайн үеийн орчуулга нь нэг хэлнээс нөгөө хэл рүү шууд хөрвүүлэхээс илүү уншин тайлбарлах, япон хэлний бүтцэд нийцүүлэн галиглах, утгачлан буулгах хэлбэртэй байсан гэж үздэг (Sato-Rossberg & Wakabayashi, 2012) бөгөөд ийн тайлбарлан буулгах уламжлал нь хожмын орчуулгын соёлд хоёр чухал суурь болж өгчээ. Нэгд, гадаад эхийг шууд буулгаж, уншигчдад ойлгомжтой болгохын тулд тайлбар, зүүлт хийн дасан зохицох дадал бий болгох (Sato-Ross & Wakabayashi, 2012), хоёрт, эхийн хэлбэрийг яг таг үгчлэн буулгалгүй, зорилтот хэлний уншигчийн боловсрол, хүлээлттэй нийцүүлэх нь чухал гэсэн ойлголтыг төлөвшүүлэх (Venuti, 1995). Энэ үеийн гол аргачлал болох тайлбарлах арга нь Зорилтот орчуулгын онолын “сургах, дамжуулах” зорилготой нийцэж байна.

Эдогийн үе (XVII–XIX зуун)-д Японы гадаад харилцаа хэдий хязгаарлагдмал байсан ч Голландын сувгаар дамжин өрнийн мэдлэг нэвтэрч, үүнээс улбаалан “Рангакү” буюу Голланд судлал хэмээх шинэ салбар хөгжсөн байна (Keene, 1984). Рангакү нь гол төлөв шинжлэх ухааны буюу анагаах ухаан, газар зүйтэй холбоотой асуудлыг судалж байсан боловч орчуулгын хувьд нэр томъёо бүтээх, шинэ ойлголтыг япон хэлэнд буулгах, эхийн логик бүтцийг тодруулах зэрэг аргуудыг боловсруулжээ (Sato-Rossberg & Wakabayashi, 2012). Өөрөөр хэлбэл, уран зохиолын орчуулгын хэрэгцээ огцом өсөхөөс өмнө ухагдахууны орчуулга, хэл зүйн тохиргоо, үг хэллэгийг жигдлэх ажил ийн боловсронгуй хуримтлагдсан нь дараах үеийн уран зохиолын орчуулгын хөгжилд чухал суурь болжээ.

Мэйжийн шинэчлэл (1868–1912) нь уран зохиолын орчуулгыг боловсрол, хэвлэл, гадаад хэлний сургалттай нэгэн зэрэг өргөжүүлэн хөгжүүлсэн бодлого, тогтолцоотой өөрчлөлт байсан (Keene, 1984) бөгөөд энэ үед өрнийн уран зохиол япон хэлнээ олноор орчуулагдсан нь роман, орчин үеийн жүжиг, реалист өгүүлэмж, сэтгэлзүйн дүрслэл зэрэг шинэ төрөл жанр, аргууд японы уран зохиолд нутагших гол суваг болжээ (Sato-Rossberg & Wakabayashi, 2012). Орчуулга нь уншигчдад шинэ түүхүүдтэй танилцахыг санал болгохын зэрэгцээ япон бичгийн хэлийг шинэчлэх, бичгийн болон ярианы хэлний зөрүүг багасгах бодлого (genbun itchi)-той олон талаараа нийцэж байв (Keene, 1984).

Мэйжийн эхэн үед орчуулга ихэвчлэн чөлөөт хөрвүүлэг хэлбэртэй байсныг тухайн үеийн хэлний стандарт тогтоогүй байдал, уншигчдын соёлын кодын ялгаагаар тайлбарладаг (Sato-Rossberg & Wakabayashi, 2012) ч цаг хугацааны явцад орчуулгын хандлага “эхийг тоймлон өгүүлэх”-ээс “зохиогчийн хэл найруулга, дуу хоолойг хадгалах” руу чиглэж, орчуулга нь найруулгын нарийн ур чадвар шаардсан, бие даасан бүтээлч хөдөлмөр гэж үнэлэгдэх болсон (Venuti, 1995) байна. Тухайлбал, зохиолч шүүмжлэгч Цүбоүчи Шооё<sup>8</sup> У.Шекспирийн зохиолуудыг япон хэлнээ орчуулснаар тайзны хэл, дүрийн ярианы өнгө аясыг япон хэлнээ шинээр бий болгосон бол, зохиолч Мори Оогай Германы уран зохиолыг орчуулж, өөрийн зохиолдоо шинэ хэл найруулгын хэв маягийг нутагшуулсан нь орчуулга дотоодын уран зохиолын хөгжилтэй хэрхэн уяллдагийг харуулж байна.

Энэ үеийн гол төлөөлөгч болох Мори Оогай герман хэлнээс И.В.Гёте зэрэг хэд хэдэн зохиолчийн бүтээлийг танилцуулсан бөгөөд түүний орчуулга эх зохиолын хэв маяг, уран сайхны онцлогийг хадгалахыг зорьсон, онолын үүднээс харвал соёлын ялгааг нь таниулахад анхаарчээ.

---

<sup>8</sup> Цүбоүчи Шооё (1859-1935). Зохиолч, шүүмжлэгч, орчуулагч. "Романы мөн чанар", "Орчин үеийн оюутны дүр" зэрэг шүүмжийн бүтээл, У.Шекспирийн бүрэн түүврийн орчуулга нь орчин үеийн Японы уран зохиолын хөгжил, театрын шинэчлэлийн хөдөлгөөнд чухал нөлөө үзүүлжээ.

Харин өөр нэгэн төлөөлөгч болох Нацүмэ Соосэкигийн<sup>9</sup> хувьд өрнийн уран зохиолын сэтгэлзүйн арга барилыг нутагшуулах буюу уншигчдад шинэ сэтгэлгээ хүргэх зорилготойгоор зохиолоо бичсэн байна. Японы орчуулгын уламжлалд дээрх хоёр стратеги ямагт зэрэгцэн оршиж ирсэн бөгөөд Мори Оогай эхийн онцлогийг хадгалахыг зорьж, Нацүмэ Соосэки уншигчид ойлгомжтой байхыг илүүд үзсэн нь зорилго (skopos) өөр өөр байгааг харуулж байна.

XX зууны эхний хагаст Японд сэтгүүл, хэвлэлийн зах зээл өргөжиж, орчуулга тогтмол нийтлэгддэг болсон нь гадаад уран зохиолын нөлөөг эрчимжүүлж (Keene, 1984), Европын модернизм, символизм, шинэ хүүрнэх арга, яруу найргийн шинэ хэлбэрүүд орчуулгаар дамжин нэвтэрч, дотоодын зохиолчдын хэл найруулга, бүтэц, сэдвийн хүрээг тэлжээ (Sato-Rossberg & Wakabayashi, 2012). Гэхдээ 1930-1945 онд улс төр, нийгмийн нөхцөл байдал хурцдаж, хэвлэлийн хяналт нэмэгдэхэд орчуулгын зохиолын сонголт, хэвлэлтэд бодит хязгаарлалт үүссэн нь орчуулга дан ганц уран сайхны асуудал биш, институцийн болон эрх мэдлийн орчинд захирагддаг үйлдвэрлэл гэдгийн нотолгоо болжээ.

1945 оноос хойш Японд хэвлэлийн салбар эрчимтэй сэргэж, уншигчдын давхарга өргөжиж, орчуулгын уламжлал “хувь хүний ажил”-аас гадна томоохон хэвлэлийн газрын цуврал төслүүд, редакцын бодлогоор улам баталгаажсан (Sato-Rossberg & Wakabayashi, 2012) байна. Олон боть “дэлхийн уран зохиол” цувралууд нь ямар зохиолчийн, ямар бүтээлийг оруулахыг тогтоож, орчуулгыг боловсролын хэрэглээнд нийцүүлэн тайлбар-зүүлттэй, стандарт хэл найруулгатай болгох чиглэл давамгайлжээ (Keene, 1984).

Бидний хэрэглэгдэхүүн болгон барьсан түүврээс үзвэл, энэ үед орчуулгын стратегийн гол зөрчил буюу эхийн соёлын ялгааг “мэдрүүлэх” үү, эсвэл япон уншигчдад саадгүй уншигдахаар “нутагшуулах” уу гэдэг асуудал дахин тодорч ирсэн бололтой, дайны дараах орчуулгад ихэвчлэн “уншигдахуйц байдал”-ыг өндөр үнэлэх редакцын уламжлал хүчтэй байгаа ч сонгодог болон академик хэвлэлүүдэд эхийн онцлог, нэр томьёо, соёлын ойлголтыг зүүлт, тайлбараар хадгалах арга давхар хөгжсөн байна.

### **Японы уран зохиолыг гадаад хэлээр орчуулж ирсэн уламжлал**

Япон зохиолуудыг гадаад хэл рүү орчуулах ажил XIX зууны сүүл, XX зууны эхэн үеэс эрчимжсэн бөгөөд энэ нь Япон улс нээлттэй бодлого явуулж эхэлсэнтэй холбоотой. Барууны орнуудад Японы соёлыг сонирхох хандлага нэмэгдсэн нь орчуулгын хөгжилд түлхэц болсон агаад анхны орчуулгууд нь ихэвчлэн англи хэлээр гарч байжээ.

Японы уран зохиол нь англи, франц, герман хэлээрх орчуулгаар дамжин дэлхий дахинд түгэхийн сацуу XX зууны сүүл хагаст Японы зохиолчдын бүтээлүүд Нобелийн шагнал хүртсэн нь орчуулгын ач холбогдлыг улам бүр нэмэгдүүлсэн байна. Уран зохиолыг гадаад хэл рүү орчуулж түгээхэд орчуулагчийн ур чадвараас гадна хэвлэлийн газар, их сургууль, шагналын систем, соёлын байгууллагын дэмжлэг зэрэг олон хүчин зүйл нөлөөлж иржээ (Venuti, 1995). Англи хэлт орчинд “Гэнжийн туульс” гэх мэт сонгодог бүтээлийн томоохон төслүүд нь Японы сонгодог зохиолыг “дэлхийн утга зохиолын сод бүтээл” гэж хүлээн зөвшөөрөхөд нөлөөлсөн (Waley, 1925–1933) бол дайны дараах үед өрнийн судлаач, орчуулагчид японы уран зохиолын түүхэн тайлбар, өмнөтгөл, шүүмжлэлийг бичиж, орчуулгын урсгалыг тогтвортой болгожээ (Keene, 1984).

Японы сонгодог уран зохиолыг англи хэлээр орчуулан таниулахад А.Волэ, Д.Кийн, Э.Сайдэнстикэр нарын орчуулагч голлох үүрэг гүйцэтгэжээ. Тухайлбал, А.Волэ “Гэнжийн туульс” тэргүүтэй дундад эртний сонгодог зохиолуудыг уран зохиолын англи хэлэнд тохирох чөлөөт хэв

<sup>9</sup> Нацүмэ Соосэки (1867-1916). Японы орчин үеийн уран зохиолыг үндэслэгч, Английн уран зохиол судлаач. Монголчууд 1961 оноос түүний зохиолтой танилцаж эхэлсэн бөгөөд 3 роман, 5 тууж орчуулагдсанаас алдарт “Сэтгэл” роман, “Жаалхүү” тууж нь орчуулгын хоёр хувилбартай байна.

маягаар орчуулан барууны уншигчдад хүргэсэн бол Д.Кийн судлаач-орчуулагчийн өнцгөөс япон уран зохиолыг англи хэлт орчинд тогтолцоотой тайлбарлан хүргэжээ. Харин Э.Сайдэнстикэрийг орчин үеийн зохиолын жишиг орчуулгын нэг шугам тогтоосон гэж хэлж болох бөгөөд тэрээр англи хэлт орчинд эхэндээ ихэвчлэн “чанартай уран зохиол” уншдаг давхарга болон их сургуулийн хүрээнд танигдсан зохиолч Кавабата Ясүнаригийн бүтээлийг нутагшуулан орчуулсан орчуулагч. Зохиолчийн бүтээлүүдийн минималист өгүүлэмж, санааг дутуу үлдээх бичлэгийн арга, улирал болон эд зүйлсийн бэлгэдэл зэрэг нь орчуулгын хувьд өндөр сорилт болж байсан ч орчуулагч хэт нуршилгүй, хэмнэлттэй өгүүлбэрээр, эхийн чимээгүй завсар, үл хэлэгдсэн утгыг илүүдэл тайлбаргүйгээр дамжуулахыг зорьж, үр дүнд нь англи уншигчдын төсөөлөлд зохиолч Я.Кавабатагийн өнгө аяс Э.Сайдэнстикэрийн хэлээр тогтож, жишиг хэмжүүр болсон байна (Venuti, 1995). Зохиолч 1968 онд Нобелийн шагнал хүртсэн нь орчуулгыг зөвхөн уран зохиолын үнэлэмж төдийгүй хэвлэлийн үйлдвэрлэлийн түвшинд (дахин хэвлэх, шинэ гэрээ байгуулах, борлуулах гэх мэт) өсгөж, зохиолчийн “Цасны орон”, “Мянган тогоруу”, “Уулын гаслан” зэрэг гол бүтээлүүд англи хэлт зах зээлд өнөө хэр сонгодог байр сууринд хэвээр байна.

Орос хэлт орчинд ХХ зуунд улсын хэвлэлийн бодлого, академик байгууллага нь япон уран зохиолын орчуулгад зонхилох үүрэгтэй оролцож, уламжлалт шүлгүүд, тус зууны эхэнд бичигдсэн үргэлжилсэн үгийн зохиолуудыг түлхүү орчуулж байсан бол улс төр, гадаад харилцааны өөрчлөлтөөс хамааран хэвлэх тоо, сонголт нь хэлбэлзэх хандлага ажиглагдаж байна (Sato-Rossberg & Wakabayashi, 2012).

Азийн орнууд, тэр дундаа Солонгос, Хятад, Монголд японы уран зохиолын орчуулга харьцангуй хожуу хэдий ч эрчимтэй хөгжиж ирсэн нь тус улсын соёлын нөлөө, хэвлэлийн газрын бодлоготой холбоотой.

Монгол Япон хоёр орны утга зохиолын салбарын харилцаа 1950-аад оноос эхтэй (Долгор нар, 2016) бөгөөд энэ хугацаанд 170 гаруй зохиогчийн 1000 гаруй бүтээл (шүлэг, яруу найраг, үргэлжилсэн үгийн зохиол гэх мэт уран зохиолын бүхий л төрлөөр) монгол хэлээр буужээ. Монгол хэлээрх орчуулгууд эхэн үедээ голдуу орос хэлээр дамжиж байсан бол сүүлийн жилүүдэд эх хэлнээс нь роман голдуу орчуулах хандлага нэмэгдэж байна. 2000 оноос өмнөх буюу шүлэг яруу найраг, өгүүллэг туужийн орчуулгад чөлөөт хэлбэр давамгайлж байгаа бол түүнээс хойших орчуулга үгчлэх, тайлбарлах аргыг голлон барьжээ. Энэ нь өмнөх үеийн орчуулгын бүтээлийг зохиолчид ихэнхдээ дам орчуулж ирсэн, сүүлийн 30 гаруй жилийн бүтээлийн хувьд судлаач, орчуулагчид голлон оролцож ирсэнтэй холбоотой болов уу.

Солонгос болон хятад хэлт орчинд 1980-аад оноос хойш зах зээл тэлж, зохиогчийн эрх, платформ зохицуулах зэрэг орчин үеийн хүчин зүйл орчуулгын урсгалд хүчтэй нөлөөлөх болсон (Sato-Rossberg & Wakabayashi, 2012) бөгөөд япон зохиол гадаадад түгэх, бусад хэлнээ орчуулагдах нь эх зохиолын чанараас гадна тухайн хэлний хэвлэлийн дэд бүтэц, бодлогын орчин, уншигчдын хүлээлтээр тодорхойлогдох болжээ (Venuti, 1995).

Мөн Япон сан зэрэг байгууллагын орчуулга, хэвлэлийн дэмжлэгийн хөтөлбөрүүд нь гадаад хэл рүү буух бүтээлийн тоо, чанар, хэвлэгдэх боломжид бодит нөлөө үзүүлэх бас нэгэн хүчин зүйл болж байна.

## ДҮГНЭЛТ

Японы уран зохиолын орчуулгын уламжлал нь эртний нангиад бичвэрийг тайлбарлан буулгахаас эхэлж, Эдогийн үед нэр томьёо жигдлэх, Мэйжийн үед өрнийн шинэ төрөл жанрыг нутагшуулах, дайны дараах “дэлхийн уран зохиол” цуврал төслүүд, улмаар япон зохиолыг гадаад хэлээр далайцтай орчуулах хүртэл үе үеийн олон сорилт, өөрчлөлттэй уялдан хөгжсөн цогц тогтолцоо бөгөөд орчуулгын стратегийн хувьд уншигдахуйц байх, соёлын ялгааг хадгалах гэсэн зөрчилт аргачлал давтагдсаар ирсэн байна. Үүнийг зорилтот уншигч, хэвлэлийн бодлого,

боловсролын хэрэглээний өөр өөр шаардлагаас үүдэх асуудал гэж үзэж болох бөгөөд Японы орчуулгын уламжлалыг судлах нь нэг улсын уран зохиолын түүх төдийгүй дэлхийн уран зохиолын эргэлтэд “Ямар бүтээл хэрхэн сонгогдож, яаж ойлгогддог вэ?” гэсэн өргөн хүрээний асуудлыг ойлгоход ач холбогдолтой юм.

Түүнчлэн, орчуулагч нь идэвхгүй дамжуулагч биш, харин шинэ соёл түгээгч, шинэ хэлбэрийг бүтээгч байж уран зохиолын хөгжлийг чиглүүлж чаддагийг Мори Оогай, Э.Сайдэнстикэр нарын жишээ харуулж байна.

### НОМ ЗҮЙ

- Bassnett, S. (2014). *Translation Studies*. Routledge.
- Kawabata, Yasunari. *Snow Country* (1956). New York: Alfred A. Knopf.
- Kawabata, Yasunari. *Thousand Cranes* (1958). New York: Alfred A. Knopf.
- Keene, D. (1984). *Dawn to the West: Japanese literature of the modern era* (Vol. 1). Columbia University Press.
- Keene, D. (1999). *Seeds in the Heart: Japanese Literature from Earliest Times to the Late Sixteenth Century*. New York: Columbia University Press.
- Nida, E. (1964). *Toward a Science of Translating*. Leiden: Brill.
- Sato-Rossberg, N., & Wakabayashi, J. (Eds.). (2012). *Translation in Japan*. Routledge.
- Translation and publishing support programs*. Japan Foundation <https://www.jpff.go.jp/e/>
- Venuti, L. (1995). *The translator's invisibility: A history of translation*. Routledge.
- Vermeer, H. J. (1989). *Skopos and Commission in Translational Action*.
- Waley, A. (Trans.). (1925–1933). *The tale of Genji* (Vols. 1–6). George Allen & Unwin.
- Долгор, С., нар (2016) “Японы уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан тойм /2007-2016/”, Орчуулга зүй, Vol. 5 No. 5, 143-153
- 夏目漱石全集 (1988) 筑摩書房.
- 森鷗外全集 (2015) Kindle Edition.



## ОРЧУУЛГЫН ШИНЭ ЧИГ ХАНДЛАГА

Б.Даваасүрэн<sup>10</sup>

**Аннотация:** В данной статье рассматриваются актуальные проблемы в области теории и практики перевода, с которыми сталкиваются в современном мире, а также способы и пути возможного разрешения в связи с практикой перевода в прошлом.

**Ключевые слова:** орчуулгазүй, уламжлалт орчуулга, соёл судлал, орчуулгын түүх, хөгжил шинэчлэл

Техник технологи хөгжихийн хэрээр шинжлэх ухааны олон салбар ухаан сүүлийн арваад жилийн дотор мэдэгдэм үсрэнгүй хөгжиж байгааг бид харж байна. Орчин цагийн техник технологийн хөгжил дэвшил, өөрчлөлт шинэчлэл орчуулга зүйг мөн тойрсонгүй. Өнөөдөр цахим орчинд *Deep L* (33 хэл, дуу хоолой, зураг, цахим хуудас орчуулдаг, төлбөртэй ба төлбөргүй гэсэн 2 хувилбартай), *Microsoft* компанийн *Bing Translator* (ярианы хэл орчуулдаг), *Reverso* (ямар ч текст орчуулдаг. Орчуулсан зүйлээ *Word, PDF, PowerPoint, Excel*-ээр хадгалж болдог), *Baidu* (хятад хэлнээс орчуулдаг) гэх мэт олон төрлийн машин орчуулгын программыг дэлхий даяараа идэвхтэй хэрэглэсээр байна. Хойшид ч улам боловсонгүй болох нь эргэлзээгүй.

Орчин цагийн техник технологийн хөгжил дэвшилтэй уялдаад орчуулгын онолд бас олон шинэ үзэл санаа, арга барил бий болж, улмаар тухайн дэвшүүлж буй үзэл санаатай холбоо бүхий шинэ нэр томъёо, ойлголт бий болсоор байгаа билээ. Мөн орчуулгын зах зээлд үйлчилгээ үзүүлдэг компаниудын менежментийн төлөвлөлт, зорилгоо хэрхэн тодорхойлох, түүнчлэн орчуулагчдыг ирээдүйд хэрхэн ямар арга барилаар бэлдэх, орчуулгын зах зээлд мэргэжлийн орчуулагчдын эзлэх байр суурь, орчуулгын ажлын үнэлэмж зэрэгт тодорхой өөрчлөлт гарч байна.

Бид энэхүү өгүүлэлдээ орчин цагийн орчуулгын ертөнцөд гарч буй дээрх өөрчлөлт шинэчлэлийн талаар товч дурдахын зэрэгцээ монголчуудын уламжлалт орчуулгын арга барилтай хослуулж болох эсэх талаар өөрсдийн бодлоо дурдахыг зорьсон болно.

Орчуулгын шинжлэх ухаан нь орчуулгын практик үйл ажиллагааны үр дүнд баяжиж шинэчлэгдэж байдаг ухаан бөгөөд эргээд орчуулгын практик үйл ажиллагааны ирээдүйн чиг хандалга, зорилго, захиалагчийн хүсэл сонирхол хэрхэн өөрчлөгдөж байгаа, цаг хугацааны хувьд хэрхэн өөрчлөгдөж болохыг орчуулгын онол тодорхойлж өгдөг зүй тогтолтой буюу орчуулгын онол ба орчуулгын практик үйл ажиллагаа хоёр хоорондоо шүтэлцэн оршиж байдаг гэдгийн баталгаа хэмээн үздэг. Сүүлийн 20-30 жилийн хугацаанд орчуулгын салбарт өмнө нь байгаагүй дуу дүрсийн орчуулга (*audiovisual translation, transcreation*), сурвалж хэлний эхийг баримтлан шинэ бүтээл туурвих (*transcreation*), дуу авианы дүрслэл (*audio description*) гэх мэт өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой орчуулгын салбарууд бий болсон нь ерөөс орчуулга гэж юуг хэлэх вэ гэдэг үндсэн ойлголтыг дахин эргэж харахад хүргэсэн төдийгүй Финляндын Турку Их Сургуулийн профессор Ив Гамбие-ийн хэлснээр “Урьд өмнө орчуулгын онол ба практикт хэрэглэж байсан тогтсон нэр томъёо ба ойлголт эдүгээ шинэ өөр нэр томъёогоор солигдох эсвэл огт хэрэглэгдэхээ

<sup>10</sup> Ph.D., МУИС, ШУС, ХУС, Монгол хэл хэлшинжлэлийн тэнхим, ORCID: 0009-0001-7764-2314

больжээ. Үүний шалтгаан нь орчин үед цаасан орчуулгын хэлбэрээс цахим хэлбэрт шилжих үйл явц ажиглагдаж байна” (2016) гэж тэмдэглэжээ.

Монголчууд өнө эртний цагаас нааш уйгур, согд, санскрит, хятад, төвөд, манж хэлнээс ном судар орчуулж ирсэн арвин баялаг туршлагатай ард түмэн. Үүний нэгэн тод жишээ бол Тэнгэрийг Тэтгэсэн хааны (1736-1796) үед буюу 1741-1742 оны хооронд Жанжаа хутагт Ролбийдоржийн удирдлагаар олон мэргэд оролцон зохиосон «Мэргэд гарахын орон нэрт тогтоосон даяг оршвой» хэмээх төвөд-монгол нэр томъёоны толь бичиг юм. “Мэргэд гарахын орон” хэмээх толь бичиг нь 1.Билиг барамид; 2.Мадхьямик; 3.Авидхарма; 4.Винай; 5.Тогтсон таалал; 6.Тарни; 7.Учир шалтгаан; 8.Дуун ухаан; 9.Урлахуйн ухаан; 10.Тэжээхүй ухаан; 11.Шинэ хуучин дохионы аймаг гэсэн 11 бүлэгтэй судар юм.

«Мэргэд гарахын орон» хэмээх энэхүү нэр томъёоны толь бичиг гарахаас өмнө Монгол орноо XIII- XIV зуунаас «Алтан гэрэл судар», «Бодичарияаватара», гэх мэт олон судар ном төвөд хэлнээс монгол хэлээр орчуулагдсан нь арвин хэдий ч тухайн цаг үеийн монгол орчуулагчид харилцан адилгүй нэр томъёо хэрэглэж, өөр өөрийн арга барилаар орчуулж байсан учир тодорхой үг ба тогтсон ойлголтын утга санаа алдуурах, гажих, бүрхэг болох, салаа утгаар ойлгох зэрэг тохиолдол нийтлэг байжээ. Уг толь бичигт орчуулга хийхдээ баримтлах зарчмуудыг жишээлбэл, мэдэхүйеэ хялбар үгсээр утга лугаа үл харшилдуулан орчуулах, үгэнд баригдаж угийн утгыг явцууруулахгүй байх, эсвэл олон үг нэмж, утгыг бүрхэг ойлгомжгүй болгох, орчуулах боломжгүй тохиолдолд харь хэлний үгээр авах, энэтхэг, төвөд тусгай нэрийн зүйлийн аль нэгийг нэмж авах гэх мэтээр маш тодорхой өгүүлсэн байдаг. Хэрэв үгийн чанад утга буруу, андуу ташаа ойлгогдохоор байвал санскрит, төвөд үгийг дангаар эсвэл монгол үгийн хамт авч хэрэглэж хэмээсэн байдаг. “Мэргэд гарахын орон” нэртэй төвөд монгол нэр томъёоны толь бичиг гарснаар хоёр хэлнээс орчуулах явцад гарч байсан эндүү ташаа зүйл байхгүй болсон гэж хэлж болно. Учир нь “Мэргэд гарахын орон” төвөд монгол нэр томъёоны толь бичиг хэвлэгдсэнээс хойш монгол орчуулагчид бүгд нэгдсэн нэр томъёо хэллэг хэрэглэж орчуулж байсан төдийгүй эдүгээ ч төвөд хэлээс монгол хэлээр орчуулахдаа тэрхүү уламжлалт орчуулгын арга барил буюу “Мэргэд гарахын орон”-ыг баримтлан орчуулдаг. Тиймээс Бурханы шашны ойлголт ухагдахуунуудыг он цагийн саалтад гажуудуулахгүй байх, монгол орчуулагчид нийтээр тогтсон нэг нэр томъёогоор орчуулдаг байх, орчуулгын онол арга барилд суралцаж буй шинэхэн орчуулагчдыг сургахад үнэ цэнтэй гарын авлага болж байсан нь тодорхой юм. «Мэргэд гарахын орон» нэр томъёоны толь бичгийн 11 бүлэгт Бурханы шашны таван их ухааны орон: 1. Дуун ухаан; 2. Шалгадаг ухаан; 3. Урлахуй ухаан; 4. Тэжээхүй ухаан; 5. Дотоод ухаан ба таван бага ухааны орон: 1. Зохист аялгуу; 2. Илт өгүүлэх нэр; 3. Найруулах ухаан; 4. Дуурайл бүжиг; 5. Одон зурхай ухааны нэр томъёо ойлголтуудыг багтаасан байдаг учир орчин цагаар бол хэлшинжлэл, гүн ухаан, технологи, анагаах ухаан, Бурханы шашин гэх мэт шинжлэх ухааны ямар ч судар номыг орчуулахад төвөгтэй зүйл гардаггүй.

Энэ талаар төвөдөч профессор Л.Хүрэлбаатар «Монгол орчуулгын товчоон» (1995) бүтээлдээ 1714 онд хэвлэгдсэн монгол «Үлгэрийн далай»-н 40 бүлгээс дараах жишээг хэрхэн орчуулсан талаар харьцуулжээ. Үүнд, төвөд эхийн үгчилсэн орчуулгад: “...нэгэн модчин өчүүхэн сүхийг амандаа зууж...” гэдгийг Гүүш Цоржийн орчуулгад: “...нэгэн модоч хүмүүн, нэгэн **шаах ойл барьж айсуу ажгуу**”, орос орчуулгад: “С другого берега реку переходил плотник, **державший в зубах топор**”. Энэ гурван орчуулгын тухайд доктор Л.Хүрэлбаатар тэмдэглэхдээ: «Энэ гурван орчуулгыг харьцуулан үзэхэд төвөд эхийн үгчилсэн орчуулга, орос орчуулга хоёр бараг нийлж байна. Харин Гүүш Цоржийн орчуулгын зарим хэсэг дээр нэлээд өвөрмөц ялгаа харагдаж байна. Нэгд, усаар гарч явсан хүн ойлыг амандаа зууж явсан учир үг асуутал түүнийгээ усанд унагаж эс олсон тухай өгүүлж байна. Гэтэл Гүүш Цоржийн орчуулгад нэгэн модчин хүн, нэгэн шаах ойл барьж айсуу гэжээ. Энд тэрхүү ойлыг амандаа зууж явсан тухай огт өгүүлсэнгүй. Энэ бол Гүүш Цоржийн өөрийн үзэмжээр өөрчилсөн зүйл байна. Учир нь юун

гэвэл ойлыг амандаа зууж явсан тухай өгүүлсэн этгээд дүрслэлийг монгол уншигчдад хүргэхэд гартаа барьж яваагаар орчуулах нь илүү зохимжтой байсан байна. Иймэрхүү маягаар улс үндэстэн бүрийн ахуй амьдрал, ёс заншлын өвөрмөц байдалд тохируулан хувиргасан зүйл зөвхөн Гүүш Цоржийн орчуулгад ч төдийгүй, Цахар гэвши Лувсанцүлтэм, Дай гүүш Агвандампил зэрэг орчуулагчдын бүтээлд нэгэн адил үзэгдэж байгаа юм» хэмээн тэмдэглэсэн байдаг.

Орчин цагт өдрөөс өдөрт техник технологи маш хурдацтай хөгжиж байгаатай холбоотой шинээр маш олон ойлголт ухагдахуун бий болж буй. Тэр бүхний зүй тогтлыг тайлбарлаж таниулах, орчуулахад хэл бичгээр дамжуулж илэрхийлэх нь тодорхой. Гэтэл шинээр үүсэж, байнга солигдож өөрчлөгдөж байгаа ойлголт ухагдахуунтай харьцуулахад хүн төрөлхтний хэл бичиг (хувирч хөгждөг хууль жамтай боловч басхүү хараахан) богино цаг хугацаанд мэдэгдэж танигдахгүй болтлоо өөрчлөгддөггүй онцлогтой, нөгөө талын аливаа ойлголт ухагдахууныг илэрхийлэх хэлний арга хэрэгсэл улс үндэстэн болгоны хэлэнд «Мэргэд гарахын орон» нэр томъёоны толь бичгийн нэгэн адил эртнээс нааш тогтсон, ямар ч ойлголт ухагдахууныг илэрхийлж чадахуйц баялаг арга барилтай байдаг. Чухам иймээс оросын хэлшинжээч-орчуулагч доктор В.Н.Комиссаровын тэмдэглэснээр хэнд, юунд зориулж, ямар учраас орчуулж байгаа, тухайн орчуулгыг ямар хүрээлэлд ашиглах вэ гэдгийг шийдэхэд эртнээс нааш тогтсон уламжлалаа барьж орчуулсан зүйл нь уншигч этгээдэд танил хийгээд ойлгомжтой байдаг гэжээ. Тиймээс мэргэжлийн зарим орчуулагч, орчуулгын онол судлаач эрдэмтдийн тэмдэглэж байгаагаар орчуулгын салбарт шинээр хүч түрэн орж ирж буй шинэ ойлголт ухагдахуун, үг хэллэг нь орчуулгын ухааныг хөгжүүлэх баяжуулах бус харин ч эсрэгээрээ орчуулгын ухааны мөн чанарыг сулруулах, ойлгомжгүй болгох, үнэгүйдүүлэх вий гэсэн болгоомжлол төрүүлж байна гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, орчуулга зүй ба түүнтэй холбоотой орчин нөхцөл, шаардлага, техник технологи өөрчлөгдөж байгаа нь бодит явдал мөн боловч орчуулгын үйл ажиллагааны үндсэн ойлголт, зорилго өөрчлөгдөөгүй хэмээн онцлон тэмдэглэж байна. Энэ талаар В.В.Сдобников (2018): «В XVI веке Мартин Лютер и его противники отстаивали абсолютно разные подходы к переводу священного Писания, при этом и тот, и другие писали гусиными перьями на пергаменте или на бумаге. В XIX веке все переводчики пользовались одними и теми же инструментами, но насколько разными были подходы к переводу И.И.Введенского и, скажем, А.А.Фета! Так что же изменилось с тех пор? Если говорить о соотношении подходов к осуществлению перевода и средств осуществления перевода, то равным счетом ничего не изменилось» (монголчилбол: XIX зуунд Мартин Лютер болон түүнийг эсэргүүцэгчид Ариун сургаалыг орчуулахдаа хоорондоо адилгүй огт өөр өөр арга барил баримталж байсан хэдий ч аль аль тал нь ялгаагүй илгэн цаас эсвэл цаасан дээр галууны өдөөр бичиж байсан. XIX зууны бүх орчуулагчид бичгийн адил хэрэгсэл ашигладаг байсан ч И.И.Введенский, А.А.Фет нар орчуулгын тухайд илт зөрүүтэй бодол санаатай байв. Тэгвэл түүнээс хойш чухам юу өөрчлөгдсөн бэ гэвэл орчуулга хийх арга барил болон орчуулга хийх хэрэгслийн тухайд юу ч өөрчлөгдөөгүй) гэжээ.

Орчуулгын онолд сүүлийн үед хэлний нутагшил (*language localization*) хэмээх ойлголт ухагдахууны талаар нэлээдгүй бичиж ярих болсон төдийгүй энэхүү нэр томъёогоор нэрлэсэн орчуулгын үйлчилгээ үзүүлэх нь их болсон байна. Уг нэр томъёог: «*Language localisation (or language localization) is the process of adapting a product's translation to a specific country or region. It is the second phase of a larger process of product translation and cultural adaptation (for specific countries, regions, cultures or groups) to account for differences in distinct markets, a process known as internationalization and localization*» (монголчилбол: Хэлний нутагшил гэдэг нь аливаа орчуулгын бүтээгдэхүүнийг тухайлсан улс орон, эсвэл, бүс нутгийн онцлогт тохируулж нутагшуулахыг хэлнэ. Энэ нь орчуулах гэж буй бүтээгдэхүүн болон (тодорхой улс орон, бүс нутаг, соёл, бүлгүүдийн) соёлын хөрсөнд нь суулгах хоёр дахь харьцангуй өргөн хүрээ бүхий үйл явц юм. Үүнээ олон улсын хийгээд нутагшуулах үйл явц гэж нэрлэгддэг янз бүрийн зах зээлийн

ялгааг харгалзах хэрэгтэй болдог) хэмээн тодорхойлсон байна. Энэ нь орчуулгын арга онолд урд өмнө байгаагүй орчуулгын шинэ арга барил уу гэвэл хараахан тийм биш юм. Жишээлбэл, оросын алдарт зохиолч А.С.Пушкиний «*Загас ба загасчны үлгэр*»-ийг академич Ц.Дамдинсүрэн 1935 онд монгол хэлээр орчуулахдаа монгол шүлгийн тогтолцоонд оруулж, монгол уншигчдад ойлгомжтой байхыг харгалзаж монгол ахуйтай тун адил төстэй болгож өөрчилсөн ажээ. Жишээлбэл, орос эхэд: «*Не хочу быть черной крестьянкой. Хочу быть столбовою дворянкой*» гэснийг монголоор орчуулахдаа: «*Харц язгуураа сольж, Тайж болохыг хүснэ. Хамжлага тариачнаа байж, Ноён болохыг хүснэ*» гэж орчуулах болсон шалтгаан нь «...*столбовая дворянка*» гэдэг хувьсгалаас өмнөх Орос оронд байсан зэрэг ямба монголчуудад ойлгомжгүй болох учир монголчуудын эрх ямба, зэрэг дэвийн ойлголтоор орлуулан орчуулжээ. Мөн «*Они жили в ветхой землянке. Ровно тридцать лет и три года*» гэдгийг монгол хэлээр орчуулахдаа: «*Хар усан ундтай. Хад чулуун нөмөртэй. Газрын агуйд хоргодож. Галын илчинд шүтэж. Гучин жил тэнэж. Дөчин жил суув*» хэмээн орос хэлний *ветхой землянке* (нүхэн гэр буюу нүхэн сууц) гэдгийг *Хар усан ундтай. Хад чулуун нөмөртэй. Газрын агуйд хоргодож* хэмээн монгол уншигчдад ойлгогдож дүрслэгдэхээр орчуулжээ. Мөн *Ровно тридцать лет и три года* (гучин гурван жил гэсэн утгыг) хэмээхийг *Гучин жил тэнэж. Дөчин жил суув* гэж 70 жил болгон орчуулсан нь хэлний хэрэглээний нийцэл (*прагматическая адаптация*) хэмээх ойлголт ухагдахууны талаас орчуулсан гэж үзэж болох юм. Учир нь суурин ахуй соёлтой ард иргэдийн сэтгэлгээг ус өвсний сайныг дагаж нүүдэллэдэг мал аж ахуй эрхэлдэг нүүдэлчин ардын хэлээр орчуулахад нэг газраа гучин гурван жил Энэ нь угтаа хэлний нутагшил (*language localization*) мөн бөгөөд орчуулгын онол практикт хэдийнээ 1930 оны үед америкийн эрдэмтэн Ч.Моррис анх гаргаж тавьсан үзэл юм. Үүнээс харвал угтаа нэг нэр томъёог нөгөөгөөр сольсон төдий явдал бөгөөд хэлний нутагшил гэдэг нэр томъёог зохиосон нь орчуулгын онол практикт цоо шинэ арга барил бий болгосон зүйл огт биш харин хэлний хэрэглээний нийцэл гэдгийг мэдээгүй, олж үзээгүйтэй холбоотой юм.

Ер нь орчуулгын явцад тулгардаг улс үндэстэн хоорондын соёл боловсрол, нийгэм журмын бүтэц, сэтгэлгээний өвөрмөц ялгаатай талууд хойшид ч оршсоор байх болно. Жишээлбэл, орчуулгын зах зээлд үйл ажиллагаа эрхэлдэг Fridge хэмээх орчуулгын компани Украин улсын *Верховная Рада* эсвэл ОХУ-ын *Председатель Совета Министров* гэдгийг англиар орчуулахад төвөгтэй нэр томъёонууд хэмээсэн байдаг. Эхний Украин улсын *Верховная Рада* гэдэг нь Украин улсын засгийн газрын бусад улс орноос ялгаатай өвөрмөц бүтэц бүрэлдэхүүний нэр. Англиар *Supreme Council ~ Supreme Board* гэж үгчилж орчуулж болох мэт боловч англи хэлтэй уншигчдад ойлгомжгүй болно гэж үздэг. Тиймээс хамгийн зөв арга бол латин үсгээр *Verchovna Rada* гэж бичээд хаалтад (Parliament) гэж орчуулах нь украинчуудын *Верховная Рада* бол англи хэлтэй хүмүүсийн ойлголтоор бол *Parliament* юм. Харин орос хэлний *Председатель Совета Министров* буюу *Сайд нарын Зөвлөлийн дарга* гэдгийг англиар *Prime Minister* гэж орчуулж болох боловч ОХУ-ын *Премьер министр* буюу *Ерөнхий сайд* гэдэгтэй давхцадаг. Гэхдээ энэ асуудал бол *language localization* гэдэгтэй холбоогүй хэмээн дурджээ.

Цаашилбал, улс орон бүрд харилцан адилгүй илэрхийлдэг урт богино, хүнд хөнгөн гэх мэт хэмжээсийг орчуулахгүй орхивол уншигчдад ойлгомжгүй, тодорхойгүй байх нь мэдээж хэрэг. Жишээлбэл, Хятад, Орос, Америк улсын урт богинын хэмжээг харьцуулж үзвэл: хятад: *li* = орос: 500 м = америк: 1,640.5 фут; хятад: *yi* = орос: 33.33 м = америк: 109 фут гэх мэтээр харилцан адилгүй тоо гарна. Үүнийг орчуулалгүй тухайн эх хэлний хэмжээсээр нь тавивал уншигч хүнд хэр төвөгтэй ойлгомжгүй байх нь тодорхой.

Шинжлэх ухаанд шинэ ойлголт ухагдахуун, чиг хандлага, арга барил бий болох нь зайлшгүй зүй тогтолтой зүйл боловч орчуулгын онол ба практик үйл ажиллагаанд янз бүрийн чамин нэр томъёо оноох нь уг салбарын олон талт асуудлыг шийдэхэд нэмэр багатай юм. Учир нь орчуулгын практик үйл ажиллагааг орчуулгын онолтой хольж хутгах эсвээс орчуулгын онолд

хэдийнээ шийдээд ирсэн зүйлийг уншаагүй, мэдээгүйгээс болж өнөөдрийн хүн төрөлхтнийг нийтэд нь хамраад байгаа соёлын даяаршил, техник технологийн хурдацтай хөгжил хувьсалтай орчуулгын салбар хэрхэн уялдаа холбоотой хөгжих вэ гэдэг асуудал бүрхэг тодорхойгүй болох хандлагатай болж байгааг олон улсын мэргэжлийн орчуулагчид онцлон тэмдэглэж байна.

### ДҮГНЭЛТ

Орчуулга зүйн салбарт шинээр маш олон ойлголт ухагдахуун буй болж байгаа нь орчуулгын онолд хэдийнээ тогтсон үзэл санаатай нийцэж байгаа эсэхийг магадлах нь цаашдын хөгжил дэвшилд шууд нөлөөлнө. Нөгөөтээгүүр алив зүйл шинэчлэгдэж хөгждөг жам хуультай. Гэхдээ шинийг бүтээхэд хоосон орон зайн дээр бүтээдэггүй тул уламжлал ба шинэчлэлийг хослуулах нь орчуулга зүйд бодитоор тулгараад байгаа асуудлыг шийдэхэд хамгийн зөв арга зам юм.

### НОМ ЗҮЙ

1. Хүрэлбаатар, Л. (1995). *Монгол орчуулгын товчоон*. (Сонгодог орчуулгын зарчим, уран чадварын асуудалд). Улаанбаатар.
2. Ив Гамбие (2016). *Перевод и переводоведение на перекрёстке цифровых технологий*. «Вестник Санкт-Петербургского университета. Язык и литература».
3. Сдобников, В.В. (2018). *Новые тенденции в переводоведении*. Казанский вестник молодых учёных. Педагогические науки. Перевод в XXI веке: вызовы эпохи и перспективы развития. Стр., 72-79. Казань.



## АНАГААХЫН НЭР ТОМЬЁНЫ ОРЧУУЛГЫН АСУУДАЛД: МОНГОЛ-АНГЛИ-ЯПОН 15 ЦУВРАЛ ТОЛЬ БИЧГИЙН ЖИШЭЭН ДЭЭР

Б.Төмөрхуяг<sup>11</sup>

**Abstract:** *The translation of medical terminology requires a high level of precision due to its direct relevance to diagnosis, treatment, and medication use. Inconsistent terminology usage and variations in transliteration may lead to professional misunderstandings. This study examines the challenges of standardizing medical terminology translation based on the experience of compiling a 15-volume Mongolian–English–Japanese Medical Dictionary. The study employed surveys, document analysis, and focus group discussions. The Mongolian-English-Japanese 15-volume Medical Dictionary served as the primary research material. A survey was conducted via Google Forms in February 2025, with six structured questions answered by 13 authors.*

*The findings indicate that major challenges include inconsistent term usage across existing dictionaries, variations in transliteration practices, and the difficulty of directly translating certain specialized concepts into Mongolian. Some terms require explanatory translation, while others may necessitate standardized transliteration.*

*The study highlights the need for institutional regulation and the development of unified standards for medical terminology translation in Mongolia.*

**Түлхүүр үг:** *толь бичиг, анагаахын нэр томьёо, орчуулгын оноолт, галиг*

### УДИРТГАЛ

Толь зохиогчид бид нэр томьёо үүсгэхдээ асар болгоомжтой хандах хэрэгтэй. Нэр томьёо нь тухайн салбарын ухагдахууныг оновчтой, нэг утгатай, мэргэжлийн хүрээнд хэрэглэгдэх үгээр илэрхийлдэг онцлогтой. Реформатский (1989) нэр томьёог ойлголтыг бүрэн, зөв тодорхойлсон, гол төлөв ганц утгатай, хязгаарлагдмал хэрэглээ бүхий мэргэжлийн үг (Рецкер Я.И, 1989) хэмээн тодорхойлсон бол Герд (1979) шинжлэх ухааны ойлголтын үндсэн шинжийг хадгалсан хэлний нэгж гэж үзжээ. Орчуулагч нь шинжлэх ухаан, техникийн хэлний өндөр мэдлэгтэй байхаас гадна эх хэл, орчуулж буй хэлний өндөр чадвартай байх ёстой (Рецкер, 1989)

Анагаахын нэр томьёоны орчуулга нь хамгийн ярвигтай. Өвчний шинж тэмдэг, онош, эмчилгээ, жор гээд нэр томьёоны орчуулгын нэг ч алдаа гаргах учиргүй. Нэр томьёоны орчуулгын ялимгүй алдаа нь нөхөж баршгүй хохиролд хүргэнэ. (Хайновская, 2008) Анагаахын нэр томьёоны олон арван толь бичиг манай оронд хэвлэгдэн гарчээ. Тэдгээр толь бичигт тусгагдсан зарим нэр томьёоны орчуулгын оноолтын зөрүү, галигийн ялгаа, тайлбарын олон янз байдал ажиглагддаг.

Иймээс анагаахын нэр томьёоны жигд, стандартчилсан орчуулгыг боловсруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэхүү хэрэгцээнд тулгуурлан, анагаахын нэр томьёоны хөгжилд хувь нэмрээ оруулах зорилгоор АШУҮИС-ийн БиоАС-ийн Гадаад хэлний тэнхимийн багш нар анагаахын Монгол-Англи-Япон 15 цуврал толь бичиг зохиолоо. 2021 оны 11 сараас эхэлсэн тус төслийн санаачлагч нь Нагояа Их Сургуулийн эмерит профессор Хамажима Нобуюүки юм. Япон улсын анагаахын оюутнуудын дунд түгээмэл хэрэглэгддэг нэгэн сурах

<sup>11</sup> PhD, АШУҮИС, БиоАС-ийн Гадаад хэлний тэнхим, ORCID: 0000-0003-0161-6942

бичиг байдаг нь 15 цуврал бүхий “Medical Disease: An Illustrated Reference Guide” юм. Бидний хамтран хэрэгжүүлж буй төсөл нь дээрх сурах бичигт тусгагдсан, олон эрхтэн тогтолцоог хамарсан нарийн мэргэжлийн үг хэллэг, нэр томьёо бүхий Монгол- Англи -Япон 15 цуврал толь бичиг бүтээх байв. Эдгээр цувралын англи, япон хэлний орчуулгыг япон мэргэжилтнүүд оноосон юм. Уг төслийн анагаахын монгол нэр томьёог оноох ажлын хэсэгт Гадаад хэлний тэнхимийн 13 багш болон АШУҮИС-ийн Анагаах Ухааны Сургуулийн мэргэжлийн тэнхимийн багш нар, мэргэжлийн эмч, багш нар оролцсон.

Монгол Улсад анагаахын нэр томьёоны орчуулгын асуудлыг хөндсөн судалгаа хийгдсэн боловч гурван хэлний харьцуулсан толь бичиг бүтээх явцад тулгарсан бэрхшээл, стандартчиллын асуудлыг системтэй авч үзсэн судалгаа хомс байна. Иймд энэхүү судалгаа нь анагаахын нэр томьёоны орчуулгын бодит туршлагад тулгуурласан, стандартчиллын чиг хандлагыг тодорхойлох оролдлого болсноороо шинэлэг талтай юм.

**Судалгааны зорилго:** Анагаахын Монгол-Англи-Япон 15 цуврал толь бичиг зохиоход олж авсан ажлын туршлагаа нэгтгэн дүгнэх, анагаахын нэр томьёоны орчуулгын оноолтыг сайжруулах.

**Судалгааны арга:** Судалгаанд асуулга, баримтын арга, бүлгийн ярилцлага зэрэг аргыг хэрэглэсэн. Монгол-Англи-Япон 15 цуврал толь бичиг нь судалгааны баримт, эх сурвалж болсон. Асуулгыг 2025 оны 2 дугаар сард тус толь бичгийг бүтээхэд оролцсон багш нарын дунд Google Form ашиглан цахим хэлбэрээр авав. 6 асуулт бүхий асуулгыг боловсруулан авсан ба 17 зохиогч оролцсон болно. Бүлгийн ярилцлагыг тэнхимийн 13 багшийн дунд хэд хэдэн удаа хийж тэмдэглэл хөтлөв.

Анагаахын Монгол-Англи-Япон 15 цуврал толь бичиг нь хоол боловсруулах эрхтэн тогтолцоо (1), зүрх судасны тогтолцоо (2), чихрийн шижин, бодисын солилцоо, дотоод шүүрэл (3) амьсгалын эрхтэн тогтолцоо (4), цус судлал (5), дархлаа судлал ба халдварт өвчин (6), тархи, мэдрэл судлал (7), бөөр судлал (8), эмэгтэйчүүд (9), гэмтэл согог судлал (11) нүд судлал (12), чих, хамар, хоолой судлал (13), арьс судлал (14) эх барих (10), хүүхдийн өвчин судлал (15) чиглэлээр хийгдлээ. Анагаахын нэр томьёог орчуулахдаа бид гол төлөв дүйлгэх, харь үг буюу нэр томьёог яг хэвээр нь авах (зээлдэх), утгачлан орчуулах, шинээр нэр томьёо зохиох, галигчлах зэрэг аргыг хэрэглэсэн.

Монгол–Англи–Япон 15 цуврал анагаахын толь бичиг боловсруулах үйл явцад тулгарсан асуудлыг тодруулах зорилгоор 17 зохиогчоос асуулга авч, бүлгийн ярилцлагын үр дүнг нэгтгэн шинжиллээ. Нэг зохиогч дунджаар 1600–1700 нэр томьёо боловсруулсан бөгөөд оролцогчдын 61.5% нь 4–6 сарын хугацаа зарцуулсан байна. Энэ нь толь бичиг боловсруулах ажил ихээхэн цаг хугацаа, судалгаа шаардлагийг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын 76.9% нь толь бичиг бүтээх явцад хүндрэл тулгарсан гэж хариулжээ. Гол бэрхшээлүүд нь дараах байв. Үүнд:

1. Ижил нэр томьёог өмнөх толь бичгүүдэд өөр өөрөөр орчуулсан зөрүү их байсан. Жишээ нь: lymphoma - тунгалгангар, лимфом (Ж. Раднаабазар 1997), тунгалгийн эсийн хавдар, лимфом (Ө.Цолмон С.Наранчимэг), тунгалгийн зангилааны хорт хавдар (М.Шагдарсүрэн 2010); cholangitis - цөсний хүүдийн үрэвсэл (Ж. Раднаабазар 1997), цөсний сувгийн үрэвсэл; холангит (Ө.Цолмон С.Наранчимэг), цөсний цоргоны үрэвсэл; цөсний сувгийн үрэвсэл (М.Шагдарсүрэн 2010); холангиит буюу цөсний замын үрэвсэлт өвчин (Буньжавын Оргил 2017); муома- булчингийн хавдар (Ж. Раднаабазар 1997), булчингийн хоргүй хавдар, миом (Ө.Цолмон С.Наранчимэг), булчингар, умайн булчингийн хавдар (М.Шагдарсүрэн 2010), миома буюу булчингийн эдийн хоргүй хавдар (Буньжавын Оргил 2017);

2. Латин, грек, англи гаралтай нэр томъёог галиглахдаа бичлэгийн ялгаа гарсан Тухайлбал, Орост анагаахын боловсрол эзэмшсэн мэргэжилтнүүд мөн орос эх сурвалжаас нэр томъёог авч ашиглаж байгаа толь зохиогчид "h" орсон үгсийг "г"-ээр галиглан буулгасан бол баруунд боловсрол эзэмшсэн болон сүүлийн үеийн толь бичиг, сурах бичиг зохиогчид "х"-ээр галиглан буулгасан тохиолдлууд байна.
3. Шууд дүйцүүлэн орчуулах боломжгүй, тайлбарлан орчуулах шаардлагатай нэр томъёо их байсан. Ялангуяа цус судлал, дотоод шүүрэл, чих хамар хоолой гэсэн салбаруудад тайлбар их шаардсан. Жишээ нь: ataxia telangiectasia - атакси телеангиэктази, судас өргөсөх, судас тэлэх өвчний үеийн тэнцвэргүйдэл, хөдөлгөөн зохицуулга алдагдал, autoimmune hemolytic anemia - дархлалын шалтгаант цус задралын цус багадалт (аутоиммун цус задралын цус багадалт) balanced fibrinolysis- фибрин хайлах тогтолцооны тэнцвэрт байдал; oxygen affinity -хүчилтөрөгч гемоглобинтой холбогдох, acute promyelocytic leukemia differentiation syndrome - цочмог промиелоцитийн лейкоемийн АТРА эмчилгээтэй холбоотой үүсэх хүндрэл
4. Монгол хэлэнд орчуулж хэрэглэж болох, мэргэжлийн бус хүнд ч ойлгогдохоор орчуулж болох үгийг латин, орос хэлнээс авч хэрэглэсэн үгээр хэрэглэж заншсан гэсэн шалтгаанаар тэр хэвээр нь орчуулах явдал оршиж байна. Энгийн жишээ дурдвал, artery-артери (тараагуур судас); vein-вен (хураагуур судас )
5. Шинжлэх ухааны нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нэршлээр нь ойлгогдоод байгаа боловч эх хэл дээр буулгахад хэт уртдах, эсвэл нуршуу болох тохиолдол элбэг байв. Жишээ нь:band 3- улаан эсийн мембран дээр байрлах "band 3"уураг; HLA haploidentical transplantation- лейкоцитийн антиген нь тохирсон цусан төрлийн донорын үүдэл эсийг шилжүүлэн суулгах
6. Хэл, сэтгэхүйн ялгаанаас үүдэлтэйгээр зарим тохиолдолд хэлний хэмнэх зарчим алдагдах явдал элбэг байлаа.Жишээ нь: acute suppurative thyroiditis - бамбай булчирхайн цочмог идээт үрэвсэл; adrenal medulla - бөөрний дээд булчирхайн тархилаг давхарга; blood urea nitrogen- цусан дахь (сийвэнгийн) шээсний азот
7. Олон үгийг мэргэжлийн хүмүүс оросоор хэлээд заншсан байсан тул монгол оновчтой үгийг онооход болон монголоор хэрэглэсэн тохиолдол, эх сурвалжийг олоход зарим зохиогчид нэлээд судалгаа хийж цаг заваа зарцуулсан.
8. Анагаахын салбар бүрд орчуулахад хүндрэлтэй үг, хэллэг тохиолдож байсан. Жишээ нь: rugger-jersey bone shadow- ясны сүүдэр; circumcaval ureter- шээсний сүвний амсар буруу байрласан эмгэг; continent urinary diversion- шээс ялгаруулах;

### ХЭЛЦЭМЖ

Энэхүү судалгааны үр дүнгээс харахад анагаахын нэр томъёоны орчуулгын зөрүүтэй байдал нь зөвхөн хэл шинжлэлийн асуудал бус, мэргэжлийн салбарын практикт шууд нөлөөлөх эрсдэлтэй асуудал болох нь харагдлаа. Нэр томъёоны орчуулгын олон өөр хувилбар, галигийн зөрүү нь оношилгоо, эмчилгээний болон эмнэлэг, эрүүл мэндийн салбарын аливаа асуудалд тодорхой хүндрэл учруулж болзошгүй.

Гадаадын судлаачид нэр томъёоны нэгдсэн стандарт, нэгдмэл тогтолцоог чухалчилдаг (Герд, 1979; Рецкер, 1989). Манай судалгааны үр дүн болон 3 хэлний 15 цуврал толь бичиг зохиох явц нь анагаахын нэр томъёог салбар хоорондын хамтын ажиллагааны үндсэн дээр жигдлэх шаардлагатайг харуулж байна.

Түүнчлэн зарим нэр томъёог шууд орчуулах боломжгүй тохиолдолд тайлбарлан орчуулах, эсвэл стандартчилсан галиг ашиглах нь зүйтэй боловч энэ нь албан ёсны зохицуулалт

шаардсан асуудал юм. Иймээс анагаахын нэр томъёоны нэгдсэн бодлого, стандарт боловсруулах нь тулгамдсан асуудал хэвээр байна.

### СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

1. Нэг зохиогч дунджаар 1600–1700 нэр томъёо англи хэлнээс монгол хэл рүү онооход оролцогчдын 61.5% нь 4–6 сарын хугацаа зарцуулсан байна.
2. Судалгаанд оролцогчдын 76.9% нь нэр томъёоны оноолтын зөрүү, өмнөх толь бичгүүд болон эх сурвалжууд дахь ялгаатай орчуулга нь гол хүндрэл болсон гэж үзжээ. Ялангуяа ижил нэр томъёог өөр өөрөөр орчуулсан тохиолдол их байсан нь стандарт боловсруулахад хүндрэлтэйг харуулж байна.
3. Зарим нэр томъёог 1–3 үгээр дүйцүүлэн орчуулах боломжгүй, утгыг бүрэн илэрхийлэхийн тулд тайлбарлан орчуулах шаардлагатай байв. Энэ нь анагаахын салбар тус бүрт өөр өөрөөр ажиглагдсан ба шинэ тутам хөгжиж буй салбарын нэр томъёоны орчуулгын оноолтод онцгойлон анхаарах шаардлагатайг харууллаа.
4. Латин, грек, англи гаралтай нэр томъёог галиглахдаа өмнөх уламжлал харилцан адилгүй байв. Энэ нь галиглах асуудлыг нэг мөр болгох шаардлагатайг харуулж байна.
5. Анагаахын нэр томъёоны толь бичиг зохиохдоо нарийн мэргэжлийн эмч, хэл шинжээч, нэр томъёо судлаачид хамтран ажиллах нь илүү оновчтой шийдэлд хүргэж байгааг судалгаа харуулав.

### ДҮГНЭЛТ

1. Монгол–Англи–Япон 15 цуврал анагаахын толь бичиг нь Монгол Улсад хэвлэгдсэн анхны гурван хэлний анагаахын толь бичиг болсон нь онцлох ач холбогдолтой.
2. Тус цуврал толь бичгийг бүтээснээр анагаахын хэд хэдэн салбар өөрийн толь бичигтэй болсон.
3. Анагаахын нэр томъёо нь гол төлөв латин, грек үгийн үндэснээс бүтдэг, дэлхийн олон улсад ижил үгийн язгууртай нэршлээр нэрлэгддэг. Иймд оношилгоо, эмчилгээний ямар нэг алдаа, будилаанаас сэргийлэхийн тулд зарим нэг орчуулахад хүндрэлтэй нэр томъёог англи эхээс нь шууд галиглан хэрэглэхийг санал болгож байна.
4. Англи үгийг галигчлан, үсэгчлэн буулгахдаа бүх нийтээр дагах журмыг мэргэжлийн байгууллагаас гаргах шаардлагатай.
5. Анагаахын нэр томъёог орчуулахад гардаг гол хүндрэл нь нэр томъёог толь бичгүүдэд олон янзаар нэрлэсэн явдал. Анагаахын нэр томъёоны орчуулгын оноолтыг боловсронгуй болгохын тулд нэр томъёо бүтээх анагаахын нэр томъёоны үндэсний хороог байгуулан салбар бүрийн мэргэжилтнүүдийг татан оруулж асуудлыг шийдвэрлэх зөв алхам болно гэж үзэж байна.
6. Анагаахын нэр томъёоны нэгдсэн стандарт боловсруулахгүйгээр орчуулгын зөрүүг арилгах боломж хязгаарлагдмал байна. Иймд үндэсний хэмжээнд анагаахын нэр томъёоны бодлого тодорхойлох, галигийн журам батлах, мэргэжлийн хяналтын тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай гэж үзлээ.

### НОМ ЗҮЙ

#### Монгол хэл дээр:

- Буньжав, О. (2017). *Анагаахын нэр томъёоны латин-англи-орос-монгол товч тайлбарт толь*.  
Догсүрэн, Ч. (1988). *Монгол нэр томъёо оноох, толилох, жигдлэх асуудалд*. Улаанбаатар.  
Мөнхцэцэг, И. (2020). *Нэр томъёоны орчуулга судлал*. Улаанбаатар.

- Мөнхцэцэг, И. ба бусад (2024). *Нэр томьёо судлалын толь бичиг*. Улаанбаатар.
- Нямдаваа, П. (2014). Анагаах ухааны монгол нэр томьёог төлөвшүүлэх асуудалд. *Монгол нэр*.
- Өнөрбаян, Ц. (2008). *Толь бичгийн хөгжлийг үечлэх асуудалд. томьёо судлал-90 олон улсын хурлын эмхэтгэл*. Улаанбаатар.
- Раднаабазар, Ж. (1997). *Анагаах ухааны англи-орос-монгол толь*.
- Раднаабазар, Ж. (2014). Монгол анагаах ухааны нэр томьёо, түүний хөгжил. *Монгол нэр томьёо судлал-90 олон улсын хурлын эмхэтгэл*. Улаанбаатар.
- Соёмбо нэвтэрхий толь: *Хэл шинжлэл*. (2017).
- Төмөрхуяг, Б (2021) Анагаахын нэр томьёоны орчуулгын асуудалд. *Орчуулга зүй 2021, No09(559)*
- Цолмон, Ө., & Наранчимэг, С. (2010). *Анагаахын ба сувилахуйн ухааны англи-монгол-орос толь*.
- Шагдарсүрэн, М. (2010). *Анагаах ухааны англи-монгол толь*.

#### Гадаад хэл дээр:

- Jakobson, R. (1959). On linguistic aspects of translation. In R. A. Brower (Ed.), *On translation* (pp. 232–239). Harvard University Press.
- Simon, E., & Mittelholz, I. (2017). Evaluation of dictionary creating methods for under-resourced languages. In *Proceedings of the conference* (pp. 246–254). <https://doi.org/10.1007/978->
- Sood, M., Gera, J., & Kaur, H. (2022). Creation, evaluation, and optimization of a domain-based dictionary. *Journal of Intelligent & Fuzzy Systems*, 43(5), 6123–6136. <https://doi.org/10.3233/jifs-220110>
- Герд, А. С. (1979). Проблемы становления и унификации научной терминологии. *Вопросы языкознания*, (1).
- Рецкер, Я. И. (1989). *Теория и практика перевода с английского языка на русский*. Москва.
- Самойлов, Д. В. (n.d.). О переводе медицинского текста. <http://www.practica.ru/Articles/medical.htm>
- Солнцев, Е. М. (2010). Общие и частные проблемы перевода медицинских текстов. *Вестник МГЛУ*, (9).
- Хайновская, Т. С. (n.d.). Особенности перевода медицинских текстов. <https://elib.bsu.by/bitstream/123456789/102527/1/290-291.pdf>



## ДИПЛОМАТ ОРЧУУЛГЫН ХИЧЭЭЛИЙГ ЗААХ АРГАЗҮЙ, ШИНЭ БОЛОМЖУУД

Д.Долгорсүрэн<sup>12</sup>

**Abstract:** *Teaching a diplomatic translation class requires focusing on precision, politeness, cultural nuance, and the ability to convey sensitive information without causing conflict. Effective instruction combines linguistic accuracy with an understanding of international relations, protocol, and the strategic use of language to achieve its goals. Entering a career in diplomatic translation can be a very rewarding experience for students. Translation is essential for spreading information and ideas, and our diplomatic translation courses are crucial for becoming efficient and effective in communicating across different cultures. Diplomatic translators work closely with diplomats in foreign affairs, and these translators must exercise the utmost discretion and professionalism. They help others understand issues related to a country's political, economic, security, and military interests. Diplomatic translators are needed in numerous settings, and their knowledge of current affairs and political issues is crucial. Diplomatic translators play a significant role in promoting political relations and facilitating communication within foreign affairs. The need for diplomatic translation is high, and the role is key for important decisions. This paper aims to assess the importance of diplomatic translation courses and provide a guide on the structure and teaching of a diplomatic translation class, based on academic knowledge and industry practices. It also studies how to teach that the diplomatic world is governed by a strict hierarchy and that translators must exercise a high level of discretion.*

**Keywords:** *Euphemism, ambiguity Management, strategic use of diplomatic language used in negotiations, Back Translation*

Улс орнуудын харилцаа, хамтын ажиллагаа эрс идэвхжиж, албан болон албан бус дипломат элч төлөөлөгчид нь соёл дамнан олон чиглэлээр хамтран ажиллах болсны улмаас өнөө цагт дипломат орчуулгын хэрэгцээ шаардлага улам нэмэгдэж байна. Улс төр, эдийн засаг, аюулгүй байдал, батлан хамгаалахын асуудлаар мэдээлэл солилцож, зөвшилцөн шийдвэр гаргахын тулд нөлөө бүхий гүрнүүд өндөр дээд түвшинд харилцахад тэднийг болон олон улсын байгууллага, дипломат төлөөлөгчдийн газруудыг холбох гол гүүр нь дипломат орчуулагч болдог. Технологийн хурдацтай дэвшлийн ачаар өндөр дээд түвшний буюу дипломат орчуулгын чанарыг сайжруулах шинэ боломжууд нэмэгдэж, дипломат албаныхан, дипломат төлөөлөгчийн газрууд, элчин сайдууд мэдээ мэдээллийг олон түмэнд цаг тухайд нь хүргэх боломжтой болж байгаа хэдий ч орчуулгын чанарын асуудал анхаарал татаж байгаа тул орчуулгын хичээлийг заах аргазүйг шинэчлэн сайжруулж, технологийн дэвшлийн ачаар гарч ирж буй боломжуудыг ашиглах шаардлага зүй ёсоор гарч ирж байна.

Хиймэл оюун ухаан, цахим орчуулгын янз бүрийн апп ашиглан орчуулгыг хийх болсон хэдий ч дипломат орчуулгын онцлог гол шинж болох хүндэтгэлийн эрхэмсэг үг хэллэгийн донж маягийг зөв тохируулан хэрэглэх чадамж нь зөвхөн мэргэжлийн дипломат орчуулагчдад л байдаг. онцгой чадамж юм. Тиймээс ирээдүйд дипломат албанд ажиллахаар олон улсын харилцаа, гадаад албаны чиглэлээр мэргэшин суралцаж буй оюутан суралцагчдад дипломат үг хэллэгийг заах,

<sup>12</sup> Доктор (PhD), МУИС, УТСОУХНУС. Олон Улсын Харилцааны тэнхим, 0000-0003-1470-5303

ойлгуулах, зөв хэрэглэж хэвшүүлэхэд дипломат орчуулгын хичээлийг мэргэжлийн чухал хичээл болгон заах нь зайлшгүй чухал бөгөөд ихээхэн практик ач холбогдолтой юм.

Өнөө цагт бараг бүх хүн англи хэлээр ярьж ойлголцож, уншиж бичиж орчуулж чаддаг, бараг л төгс болсон гэгцгээж байгаа боловч үнэндээ хүндэтгэлийн, зөв боловсон, эрхэмсэг, ёсорхог үгээр товч бөгөөд тодорхой илэрхийлж, дипломат хэв маягаар ярьж, хэлж, бичиж, ойлголцож, орчуулж чаддаг хүн нь тун цөөн байна. ГХЯ болон холбогдох газар агентлагууд, олон улсын байгууллагууд зохих түвшинд олон улсын гол хэлээр орчуулга хийж чаддаг байх шаардлагыг ажилтнууддаа тавьдаг. Энэ шаардлагыг хангасан мэргэжлийн чадварлаг дипломат ажилтан тийм хангалттай олон биш байна. Ялангуяа Монгол улсын гадаад харилцаа сүүлийн арваад жилийн хугацаанд эрс идэвхжиж, гадаад айлчлалуудын тоо олширч, харилцаа хамтын ажиллагааны хүрээнд олон олон салбарыг дамнасан үйл ажиллагаа явуулж, яриа хэлэлцээ хийж, гэрээ хэлэлцээр байгуулж буй энэ цаг үед тухай тухайн түвшинд тохирох мэргэжлийн болоод хүндэтгэлийн үг хэллэгээр орчуулга хийх шаардлага зайлшгүй болж байгаа юм.

МУИС-ийн нэг чухал бүрэлдэхүүн сургууль болох Улс Төр Судлал, Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургуулийн (УТСОУХНУС) оюутнууд “Дипломат Орчуулга” гэсэн хичээлийг 1-2 улиралд судалж байгаа нь тун ч хангалтгүй хугацаа юм. Дипломат орчуулгын хичээлийн ач холбогдол, заах арга зүйн талаар зөв ойлголттой байхын тулд юуны өмнө “дипломат” гэсэн үгийн уг үндэс, гарлыг судалж, тодорхой мэдэх нь зүйтэй юм. Францын нэрт дипломат Франсуа де Калиер<sup>13</sup> (1645-1717) нь XIV Луйс хааны гадаад бодлогын зөвлөхүүдийн ахлахаар ажиллаж байх үедээ бичсэн “*Хаант улсуудтай яриа хэлэлцээ хийх урлаг*” хэмээх алдарт номдоо “дипломат” гэсэн грек хэлний diploma-албан бичиг баримт, хавтас гэсэн утгаар ойлгодог байсан үгийг одоо орчин цагт хэрэглэж байгаа “олон улсын харилцаанд холбогдох” гэсэн утгаар анх ашиглажээ. Мэргэжлийн өндөр түвшинд бичигдсэн уг ном Францын дипломат ажиллагааны тогтолцоог тодорхойлох онолын бүтээл болжээ. Уг бүтээл хэвлэгдсэн үеэс хойш “дипломат” гэсэн үг нь онолын үндэстэй, ёс зүйн өндөр дээд зарчимд тулгуурласан салбар шинжлэх ухааны нэр хэмээн тооцогдох болжээ.

Орчуулгыг хэрэглээний хувьд ерөнхийд нь:

- ❖ Энгийн түвшний – General /casual or everyday/
- ❖ Бизнесийн буюу ажил хэргийн түвшний – Business or Formal
- ❖ Мэргэжлийн түвшний – Academic or Professional
- ❖ Дипломат түвшний – Diplomatic or High level гэж авч үзэж болно.

Харилцааны гол хэрэглүүр болох аливаа хэлний хувьд тухайн хэлээр яригч, бичигчийн үг яриа, үг сонголт нь хүн хооронд, мөн олон улсын харилцаанд томоохон нөлөө үзүүлдэг. Энгийн түвшний буюу өдөр тутамд хэрэглэгддэг үг хэллэгийг, ялангуяа хар ярианы, этгээд үг хэллэгийг албаны болон дипломат түвшинд хэрэглэвэл тун зохисгүй, доромж, дорд байдлыг үүсгэдэг. Ямар түвшинд аль үгийг ямар хэлбэрээр нь сонгож хэрэглэж байгаагаас хамаарч харилцаа цаашид хэрхэн өрнөх, эсвэл хумигдах эсэх нь шийдэгддэг. Тийм учраас мэргэжлийн орчуулагчид аливаа үг хэллэг, өгүүлбэр, яриа хөөрөө, илтгэл лекц, ном зохиол, бүтээл зэргийг нэг хэлнээс нөгөө хэлнээ орчуулж хөрвүүлэхдээ аль түвшинд нь орчуулахаас хамаарч тохирох өнгө аяс бүхий үг хэллэг, нэр томъёог сонгодог. Жишээлбэл: “*НҮБ гэж юу вэ?*” гэсэн энгийн асуулт тавилаа гэж бодъё. НҮБ-ын талаар ойлголтгүй, юу болохыг нь мэдэхгүй балчир хүүхдэд эсвэл том хүн байлаа гэж бодъё. Тэдэнд НҮБ буюу UN гэсэн үгийг орчуулж хэлэх боллоо гэхэд Н, Ү, Б гэсэн гурван

<sup>13</sup> François de Callières, a prominent French diplomat, writer, and member of the *Académie française* under Louis XIV. He is best known for authoring *De la manière de négocier avec les souverains* (1716), a foundational text on modern diplomacy that emphasized confidence, negotiation, and the role of the resident ambassador over deception.

үгийн товчлолыг нь, эсвэл НҮБ-ыг байгууллагынх нь хувьд тайлбарлах эсэх тухай биш, зүгээр л дээрх асуултыг англи хэл рүү дээрх 4 түвшин тус бүрээр нь хэрхэн буулгаж болохыг авч үзье.

\* \* \*

- *What is the UN?* – Энгийн (General or everyday)
- *What does the UN mean?* – Ажил хэргийн (Business or formal)
- *What does the UN stand for?* – Мэргэжлийн (Academic or professional)
- *What does the UN represent?* – Дипломат буюу Өндөр түвшний (Diplomatic)

\* \* \*

Дээрх дөрвөн өгүүлбэр бүгд “*НҮБ гэж юу вэ?*” гэсэн асуулт боловч өөр өөр түвшний хандлагыг илэрхийлж байна. Монгол хэлнээ ижил бууж болох дээрх асуултууд англи хэлтэнд нэлээд ялгаатай сонсогдоно. Учир нь тухайн асуух өгүүлбэрт үйл үг, угтвар үг, нэр үг хэр голлож буй эсэхээс зэрэг зиндаа, мэргэжлийн түвшний ялгаа нь гарч орчуулахад илэрдэг. Эндээс үүдэн дипломат орчуулга нь бусад орчуулгаас хэрхэн ялгардаг болохыг түүхэн болон хэл шинжлэлийн үүднээс тайлбарлая.

Эрт дээр үеэс эзэн хаадын орд өргөө, ихэс дээдсийн хүрээлэлд, одоо үед элит болон улс төр бизнесийн өндөр дээд албаныхны хүрээнд хэрэглэгддэг, тухайн хүрээллийнхний дунд яригдаж хэлэгддэг байсан, хүндэтгэлийн аяс бүхий эрхэмсэг ёсорхуу үг хэллэг буюу дипломат үг хэллэгээр тэр давхаргынхан нь өөр хоорондоо ойлголцож, ярьж хэлэлцэж, аливааг илэрхийлж, өндөр түвшний орчуулагч нь ч мөн дипломат үг хэллэгээр нь орчуулж, хэлмэрчилж байгааг дипломат орчуулга гэж үздэг. Дипломат орчуулга нь энгийн, ажил хэргийн, албаны, эрдэм шинжилгээ, сургалтын болон мэргэжлийн түвшний орчуулгаас дараах шинжүүдээр эрс ялгардаг.

Үүнд:

- Товч бөгөөд тодорхой, цөөн үгээр, аль болох нэр үгээр илэрхийлдэг. (Жишээ нь: “*Чимээгүй болно уу!*” гэвэл “*Silence, please!*” гэнэ. Үйл үгээр бус нэр үгээр илэрхийлнэ.)
- Эерүүлж буюу зөөллөж, дундыг баримталсан үг хэллэг голлодог. (Жишээ нь: “*Таны буруу!*” эсвэл “*Та буруу ярьж байна.*” гэвэл орчуулахдаа “*You are wrong.*” гэхийн оронд “*I would have to disagree*” гэж болно. Энэ нь арай ширүүн сонстож мэднэ гэх юм бол “*I think we have different perspectives.*” гэх мэтээр зөөлрүүлж орчуулдаг.)
- Дипломат албаныхны дунд зөвхөн хэрэглэгддэг мэргэжлийн нэр томъёо, үг хэллэг олонтой. (Жишээ нь: *exequatur*<sup>14</sup> - *консулын газрыг нээж ажиллуулах зөвшөөрөл* гэсэн утгатай энэ үгийг хуулийн болон эрх бүхий бусад чиглэлийн байгууллагуудад аливаа шийдвэр тогтоол, захирамжийг гүйцэтгэх, хэрэгжүүлэх гэсэн утгаар хэрэглэдэг.)
- Сэтгэл хөдлөлийн өнгө аяс, төсөөлөл, ургуулан бодох зэрэг нь илрэх ёсгүй.
- Тэмдэг нэр буюу аливааг шинж байдлаар нь ялгаж харьцуулж, дүрсэлсэн үг хэллэгээс зайлсхийдэг.
- Субъектээс илүү объект рүү чиглэдэг.
- Шууд бус тойруу байдлаар илэрхийлдэг.

Дипломат орчуулга гэж тусдаа юм байхгүй, бусад төрлийн орчуулгатай л адилхан гэж үздэг, дипломат орчуулгын онцлогийн талаар өнгөц ойлголттой хүмүүс байдаг. Энгийнээр тайлбарлавал, дипломат үг хэллэг, бичиг баримт, яриа хэлэлцээг хамгийн байж болох дээд түвшинд эерүүлж, хүндэтгэлийн ёсорхуу үгээр эвлэг боловч албархуу маягаар илэрхийлэхийн

---

<sup>14</sup> An exequatur (Latin, literally "let it execute") is a legal document issued by a sovereign authority that permits the exercise or enforcement of a right. In international diplomacy, an exequatur is a patent issued by a head of state recognizing someone as a consul of a foreign sovereign state. The exequatur recognizes the consul as a member of the receiving state's diplomatic corps, and guarantees the rights and privileges of consular office.

тулд тийм утга бүхий үг хэллэгийг голлон ашиглаж, тийнхүү харилцаж байгаа нь л чухамдаа дипломат хэв маягийг харуулдаг учраас яг тэр онцлог байдлыг нь хэвээр хадгалан хэл хооронд орчуулж байгаа нь дипломат орчуулга юм. Дипломат орчуулагчийн хувьд харилцаа хандлага, зан төлөв чухал байдаг. Орчуулагч орчуулж байгаа хэлээ тун сайн мэдэх ёстой нь мэдээж хэрэг боловч зөвхөн гадаад хэлийг төгс эзэмшлээ гээд дипломат орчуулагч болохгүй. Орчуулгыг сайн хийх эсэх нь орчуулагчийн зан төрхөөс хамаардаг. (В.И.Попов, 2003)

Олон улсын харилцааны гол хэл болох англи хэлний хувьд аливаа үг хэллэг, яриа хэлэлцээ, илтгэл зэргийг дипломат түвшинд болгохдоо нэр үг, нэрийн холбоо үг голлосон өгүүлбэрээр өндөр дээд түвшний шинжийг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, хэдий чинээ нэр үг давамгайлна төдий чинээ тухайн зүйл дипломат түвшнийх болно гэсэн үг. Жишээлбэл: “*Хэн ч төгс биш, алдаж онож байж сурдаг.*” гэсэн өгүүлбэрийг англи хэл рүү буулгая. Энгийнээр “*No one is perfect. You learn by making mistakes and trying to correct it.*” Эсвэл “*Nobody is perfect, we learn by making mistakes.*” Энэ 2 өгүүлбэрт үйл үг давамгайл байгаа тул энгийн түвшнийх. Түвшнийг нь дээшлүүлж, ажил хэрэгч, академик болгоё гэвэл “*No one is perfect, we learn from the mistakes we make.*” Энэ мэтчилэн янз бүрээр орчуулж болох юм. Харин дипломат орчуулгаар үүнийг “*No one is perfect, true learning results from trial and error.*” гэж буулгана. Утгын хувьд илүү оновчтой болгож “*true*” гэсэн үгийг нэмснээс гадна *learning, results, trial, error* гэх зэрэг нэр үгсийг сонгож хэрэглэсэн байна. “*Results*” гэсэн үг мэдээж энд үйл үгийн үүргээр орсон, тэгэхдээ энэ үг яг энэ байдлаараа бас нэр үг болж чаддаг. Нэг ёсондоо дипломат орчуулагчид аливааг илэрхийлэхдээ тухайн өгүүлбэрт үйлийн эзэн, үйл үг, тусагдахуун зэрэг нь аль болох харагдах байдлаа өөрчлөлгүйгээр нэр үг болж чаддаг тийм үгсийг сонгож хэрэглэдэг гэж ойлгох нь зүйтэй.

Нэмж хэдэн жишээ авъя.

- Eye contact is essential maintaining a good rapport. – Хүн рүү харж ярьдаг байх нь сайн харилцаатай байхад амин чухал байдаг.
- Most of the students were reticent about answering questions. – Оюутнуудын олонх нь асуултад хариулахдаа дурамжхан байсан.
- Due to his reticence, little is known about the ambassador’s personal life. – Ярих дургүй байдаг учраас элчин сайдын хувийн амьдралын талаар бага мэдэцгээдэг.
- I am not sure how to approach the problem. – Уг асуудалд хэрхэн хандахаа мэдэхгүй байна.
- The word “politics” is derived from a Greek word meaning “city”. – “Улс төр” гэсэн үг нь “хот” гэсэн утгатай грек үгнээс гаралтай.
- It is a distraction for me. Can you step outside the room? – Надад саад болоод байна. Та өрөөнөөс гарчихгүй юу?
- Silence, please! – Чимээгүй болно уу!
- The UN leadership lauded the EU initiative. – НҮБ-ийн удирдлага нь Европын Холбооны санаачилгыг магтан сайшаалаа.
- Will he take umbrage if the Prime Minister is not invited to the reception? – Ерөнхий сайдыг тэр хүлээн авалтад урихгүй бол уурлах юм болов уу?

Англи хэлний өгүүлбэрт нэр үгийн хэлбэрээр орсон олон хэллэгүүд нь хүндэтгэлийн өндөр дээд түвшний буюу дипломат түвшний шинжийг илтгэдэг бөгөөд тэдгээр нь монгол хэлнээ үйл үг эсвэл үйлт нэрийн хэлбэрээр буудаг гэдгийг бичгийн хэл болон дипломат хэлээр орчуулга хийж буй хэн бүхэн ямагт санаж байх ёстой. Зөвхөн ганц үг дээр ч ялгаа тод илэрнэ. Жишээ нь: “*мэдэх*” гэсэн үгийг англи хэл рүү орчуулъя: энгийнээр “*to know*”, арай түвшин ахиулаад “*aware*”, академик түвшинд “*be familiar with*” гэж болно, харин дипломат түвшинд “*au fait*” буюу бүр тодруулбал “*be au fait with*” гэсэн үгийг хэрэглэдэг. Энэ мэт жишээ маш олныг дурдаж болно.

Дипломат орчуулгын хичээлийг зааж байгаа багш бид бүхэн орчуулгын үндсэн зарчмыг оюутнуудад ойлгуулахын зэрэгцээ нягт нямбай, эелдэг боловсон байх, олон соёлын ялгааг зөв

ойлгож, мэдрэмжтэй хүлээцтэй хандаж, эмзэг мэдээлэл сэдвийг хөндсөн үед зөрчилдөөн үүсгэлгүй мэдээллийг дипломат маягаар хэрхэн дамжуулах буюу орчуулах аргыг зааж, дипломат түвшинд орчуулга хийж байгаа орчуулагч ямагт дипломат байх ёстойг, дипломат орчуулагчийг дипломат ажилтан гэж үздэгийг сануулж, өндөр түвшний орчуулга хийж сургахыг хичээн ажилладаг. Дипломат түвшинд орчуулга хийж байгаа орчуулагчийг дипломат орчуулагч гэдэг бөгөөд тийм орчуулагчид бол олон улсын харилцаа, дэлхий дээр өрнөж буй гол үйл явдлууд, дипломат ёслол, ёс горим, дэлхийн улс орнуудын түүх, соёл, харилцааны талаар өргөн мэдлэгтэй байж, хүндэтгэлийн эрхэмсэг ёсорхуу үг хэллэгийг чадварлаг хэрэглэн орчуулдаг байх ёстой.

Дипломат орчуулгын хичээлээр оюутнууд дипломат түвшний үг хэллэг голлосон бичвэр уншиж, шинэ үг хэллэг тогтоож, элчин сайд дипломатуудын яриа, хэлсэн үг, илтгэлийг сонсож, зэрэгцэж болон дагаж орчуулах нь их өгөөжтэй туршлага болдог. Энгийн өдөр тутмын бус харин эрхэмсэг хүндэтгэлийн үгээр орчуулж дадсанаар өндөр дээд түвшинд мэдээлэл солилцох, байр сууриа илэрхийлэх, үзэл баримтлал болон соёлыг түгээх ирээдүйн ажил мэргэжилд нь чухал ач холбогдолтой. Тиймээс дипломат орчуулгын хичээлийн цагийг багасгаж, тоог нь цөөлж, сонгон судлах хичээл болгох биш, харин ч мэргэжлийн заавал судлах хичээл болгож, тэнхимд заах цагийг нь нэмэгдүүлэх нь зүйтэй юм.

УТСОУХНУС-д суралцагсад нь “Дипломат орчуулга”-ын хичээлээр англиас монгол, монголоос англи хэл рүү бичгийн болон хурлын аман орчуулга хийдэг. Тэдэнд сурч мэдсэнээ бодит практик орчинд хэрхэн хэрэглэх арга замуудыг дараах энгийн боловч зайлшгүй чухал үг хэллэгийг тогтоолгох байдлаар ойлгуулдаг.

1. Эелдэг, эерүүлсэн утга бүхий хэллэгүүд: *I am afraid. It appears. With all due respect – Учлаарай, бололтой, гүнээ хүндэтгэн*
2. Зөвшилцөж тохиролцоход тус болох зөөлөн, аядуу үг хэллэгийг голлон хэрэглэнэ.
3. Англи хэлнээ нэр үг, монгол хэлэнд үйл үг нь голлоно гэдгийг сануулна.
4. Дипломат баримт бичигт гол төлөв ордог “гүнээ хүлцэл өчье”, “энэ завшааныг ашиглан . . .”, “. . . – ийн ялдамд”, “. . . -х завшаан тохиов” гэх зэрэг заавал хэрэглэж заншсан тогтсон онцлог хэллэгүүдийг цээжлүүлдэг.
5. Үгийн олон салаа утгыг, мөн олон улсын харилцааны гол хэл болж байсан бусад хэлнээс англи хэл рүү орсон үг хэллэгүүд, латин, грек, франц хэлнээс англи хэл рүү орсон нэр томъёо, үгс, товчилсон үгсийг цээжлүүлэхийн зэрэгцээ тэдгээрийн үндсийг үгийн гарал судлалын үүднээс тайлбарладаг.

Дипломат орчуулгын хичээлийг үр дүнтэй заах нэг гол арга зүй бол бичгийн болон аман орчуулга хийх явцад гардаг найруулгын болон найруулгын бус алдааг сайтар ойлгуулах явдал байдаг. Найруулгын бус алдаа гэдэгт 1. Баримтын, 2. Логикийн, 3. Хэл зүйн, 4. Гоо зүйн алдаа багтана. Найруулгын алдаа нь: 1. Үг буруу сонгосон, 2. Үг илүүдсэн эсвэл дутсан, 3. Үг сонголт буруу буюу яруу хэрэглүүрийг оновчгүй сонгосон, 4. Нэг үгийг буюу нэг үндэстэй үгийг олон давтсан, 5. Үгийн өнгө аяс гажсан зэрэг алдаа байдаг.<sup>15</sup> Дипломат орчуулагчдын хэлний чадвар сайн байдаг тул тэдний хувьд найруулгын бус алдаа гаргах магадлалтай. Баримтын, учир зүйн, гоо зүйн алдаа нь хэл зүйн алдаанаас илүү ноцтой үр дагаварт хүргэдэг. Тийм учраас орчуулах чадвар - **A translation skill per se** (i.e. analytical, research, methodological, cultural, translation criticism, professional, specialization, dictionary, research, translation methods application, etc.); бичгийн болон аман орчуулга хийхтэй холбоотой ерөнхий чадварууд - Translation and interpreting related **general skills** related indirectly to translation (that is, educational, ideological, general knowledge, personal, inductive, deductive, organizational, cloud computing, marketing, etc.). ыг суулгахын тулд shadowing technique буюу үг хэллэг, өгүүлбэр, цогцолбор зэргийг яг дагаж дуурайн давтах аргаар дипломат үг хэллэг, зэрэг дэв, хэргэм цол, албан тушаалыг цээжлүүлэх,

<sup>15</sup> <http://www.asuu.mn/medleg/tuuh-niigem/172/1007200015>

мөн хиймэл оюун ухааны тусламжтай Practice English with AI зэрэг олон апп, орчин үеийн аргуудыг өргөн хэрэглэх бүрэн боломжууд байна.<sup>16</sup> Ялангуяа хурлын аман орчуулгын дадлыг суулгахын тулд оюутнуудад дагаж хэлдэг shadowing technique аргаар хичээл заахад 60 гаруй оюутнуудын ихэнх нь тус аргаар заасан үг хэллэгүүдийг богино хугацаанд сайн тогтоож, хэрэглээг нь ойлгож, зөв ашиглах болсон үр дүн гарсан. Тэгэхээр дээрх аргуудыг ашиглан дипломат орчуулгын хичээлийн заах аргыг улам боловсронгуй болгох боломжтой юм.

## ДҮГНЭЛТ

Дипломат орчуулагч нь цаг үеийн байдал, олон улсын түүх, соёл, улс төрийн асуудлын талаар өргөн мэдлэгтэй байдаг тул олон улсын улс төрийн харилцааг дэмжих, гадаад харилцааны салбарт харилцаа холбоог хөнгөвчлөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Дипломат орчуулгын хэрэгцээ бүхий л үед өндөр байсаар ирсэн бөгөөд шийдвэр гаргахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Дипломат орчуулга нь академик мэдлэгийн зайлшгүй нэг хэсэг болж байгаа тул дипломат орчуулгын хичээлийн ач холбогдлыг үнэлж, уг хичээлийг орчин үед ямар арга зүйгээр заах, өмнөх арга зүйг орчин үеийн ямар арга барилаар шинэчлэх боломжийг авч үзлээ. Үүнд

- Дипломат орчуулга дахь найруулгын болон найруулгын бус алдааг тодруулах нь дипломат баримт бичгийн болон яриа хэлэлцээ, цаашлаад гэрээ хэлэлцээрийн гол утга санаа, агуулгыг нөгөө хэлнээ үнэн зөв буулгасан эсэхийг нягтлахад, үнэн зөв орчуулахад тустай.
- Өндөр дээд түвшинд хийгдэж байгаа орчуулгын чанарыг сайжруулах, улс хоорондын харилцааг эерэг нааштай байлгахад дипломат орчуулгад ашиглах орчин үеийн технологи, хиймэл оюун ухааны стратегийг ашиглах боломжтой болсон нь дипломат орчуулгын хичээлийг заах арга зүйг шинэ шатанд гаргах нэг хувилбар болж байна.
- Дипломат маягаар орчуулах стратегийн боломжит олон хувилбарыг хэрэглэх нь дипломат бичиг баримтын болон үг ярианы утга санааг алдагдуулахгүй байх практик ач холбогдолтой.
- Дипломат орчуулга гэдэг бол уран зохиолын, нийгэм улс төрийн болон бусад төрлийн орчуулгаас ялгаатай гэдгийг ойлгуулах нь энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийн бас нэг гол зорилго байлаа.
- Өндөр дээд түвшинд, олон улсын болон дээд хэмжээний уулзалтууд, төрийн хүлээн авалт дээр аман орчуулга хийх, хурын орчуулга хийх, эсвэл дипломат баримт бичиг, гэрээ хэлэлцээрийг орчуулах орчуулгын арга стратегийг орчин үеийн чиг хандлагад суурилсан судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, заах аргыг AI болон бусад апп-ын тусламжтайгаар сайжруулах нь орчуулгын чанарыг дээшлүүлэх, илүү сайжруулах эрдэм шинжилгээний ач холбогдолтой юм.

### Ном зүй

Andrew Gilies., “*Translation Practice Explained: Consecutive Interpreting*”, London and New York, 2019

Г.Гүрбазар., “*Орчуулгын онол, дадлагын үндэс*”, УБ, 1996

Д.Долгорсүрэн., “*Соёл ба үнэт зүйлсийг үл хэрэгссэнээс үүдэн орчуулгад гарч ирэх гажуудал*”, Орчуулгазүй, 2021, №09 (559)

<sup>16</sup>[https://www.google.com/search?q=shadowing+technique&oq=shadowi&gs\\_lcrp=EgZjaHJvbWUqBwgCEAA YgAQyBggAEEUYOTIHCAEQABiABDIHCAIQABiABDIHCAMQABiABDIHCAQQABiABDIHCAUQAB iABDIHCA YQABiABDIHCAcQABiABDIHCAgQABiABDIHCAkQABiABNIBCTQ0NTZqMGoxNagCCLA CAQ&sourceid=chrome&ie=UTF-8](https://www.google.com/search?q=shadowing+technique&oq=shadowi&gs_lcrp=EgZjaHJvbWUqBwgCEAA YgAQyBggAEEUYOTIHCAEQABiABDIHCAIQABiABDIHCAMQABiABDIHCAQQABiABDIHCAUQAB iABDIHCA YQABiABDIHCAcQABiABDIHCAgQABiABDIHCAkQABiABNIBCTQ0NTZqMGoxNagCCLA CAQ&sourceid=chrome&ie=UTF-8)

В. И. Попов., “*Орчин үеийн дипломат ажиллагаа: онол практикийн асуудал*”, 2003,  
Malika Zafarova., “*Shadowing as an effective method in language learning: theory, practice, and implementation*”; Academic Journal of Science, Technology and Education | ISSN 3041-7848 July 20257. Volume 1 Issue 3. The National University of Uzbekistan.  
TRANSLATOR’S CHARTER (*Approved by the Congress at Dubrovnik in 1963, and amended in Oslo on July 9, 1994*), The International Federation of Translators  
<http://www.asuu.mn/medleg/tuuh-niigem/172/1007200015>  
<https://www.google.com/search?q=shadowing+technique&oq=shadowi&gs/sourceid=chrome&ie=UTF-8>  
[https://ailearna.com/onboarding-quiz-native?utm\\_source=google&utm](https://ailearna.com/onboarding-quiz-native?utm_source=google&utm)



## ОРЧУУЛГЫН СУРГАЛТАД ХИЙМЭЛ ОЮУНЫГ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭХ НЬ

М.Амартайван<sup>17</sup>

**Abstract:** In recent years, a wide range of artificial intelligence (AI)-based translation tools has emerged. Technological advancements have significantly transformed the concept of translation, inevitably exerting considerable influence on both the translation market and translation pedagogy. This raises an important question: Which types of translators are likely to be replaced by AI? In order to address this question, it is essential to develop a proper understanding of AI—an outcome of scientific and technological innovation—and to apply it appropriately within the field of translation. Just as human translators differ in their abilities, AI-generated translations also vary in quality.

At present, there remains a gap in effectively teaching the skills required for the AI era. On the one hand, AI-driven machine translation is likely to further specialize and differentiate the field of translation. On the other hand, there is a significant risk that overreliance on technology may reduce individuals to mere “technological dependents.”

The primary objective of translation education is to cultivate individuals capable of translating independently. While AI systems are trained on accumulated data, it is equally important for us to gather knowledge about AI, critically engage with it, and use it to inform problem-solving. Incorporating both AI-assisted and non-AI-based courses into the curriculum may provide valuable opportunities to better understand the respective strengths and limitations of each approach. Finally, this study will outline several key considerations for the responsible use of AI in translation.

**Keywords:** translation tools, human translation, machine translation, AI translation, prompt

### ХИЙМЭЛ ОЮУН БА ОРЧУУЛГА

Нэгэн цагт хэвлэмэл толь ашиглаж, хожмоо цахим толь голдуу ашигладаг болсон бол одоо машины орчуулга, тэр дундаа хиймэл оюуны орчуулга ашиглах боломж хэмээх шинэ үүд хаалга багш, орчуулагч, судлаачдын өмнө нээгдлээ. Бидний орчин буй энэ цагт хиймэл оюуны орчуулгын олон янзын төхөөрөмжүүд ар араасаа цувран олны хүртээл болсоор байна. Цөөн хэдийг нь тухайлан дурдъя. Монголд оюуны өмчийн эрхээ баталгаажуулсан, Перфект Технологи ХХК-ийн ухаалаг маус. Монгол хэлээр ярихад бичвэр болгон хувиргана. Олон хэлээр орчуулна. Кириллээс монгол бичгээр хөрвүүлнэ. Зургаас бичвэрийг танина. Мөн Gogo Goods shop-оос санал болгож буй олон хэлнээс орчуулагч ухаалаг чихэвч, ухаалаг нүдний шил. Нүдний шил нь дуудлага авна. Хөгжим сонсоно. Энэ мэт нь хиймэл оюун ашигласан төрөл бүрийн бүтээгдэхүүн энгийн хэрэглээнд хэрхэн ойр болж, түгэн дэлгэрч байгаагийн илрэл юм.

Үүнээс гадна 2022 онд ChatGPT олон нийтэд нээлттэй болсноор бүтээлч хиймэл оюуны эрин эхэлсэн бөгөөд, нэгэн үе зөгнөлт зохиолд л гардаг байсан хиймэл оюун эдүгээ хүмүүсийн өдөр тутмын амьдралд аажмаар нэвтэрч байна. Иймд өнөө цагт хиймэл оюуныг үнэн зөв таньж мэдэж, хэтийн ирээдүйд бэлдэхийн тулд чин сэтгэлээс чармайн суралцах шаардлагатай болжээ. Хүний орчуулгын үнэ цэнийг хэт өргөж хиймэл оюуны орчуулга яагаад ч гүйцэхгүй мэтээр алгуур хандан тайван суух нь нэн осолтой байж мэднэ. Технологийн хөгжлийн үрээр хялбархан

<sup>17</sup> ОУУБИС, Солонгос хэл соёлын тэнхимийн багш, магистр

орчуулж болдог боллоо гэсэн ойлголт олон талаар орчуулагчид нөлөөлнө. Орчуулагчийн оролдлого чармайлтыг бодитоор хүлээн зөвшөөрөх хүн цөөрч, энэ нь цаашдаа орчуулгын хөлс үнэлгээнд ч нөлөөлөх болно. Түүнчлэн орчуулгад суралцаж байгаа нэгэнд ч сөрөг нөлөөтэй. Орчуулгад суралцах нь зөвхөн орчуулахад тустай биш атал “Хиймэл оюуны эринд орчуулгаар суралцаж юугаа хийдэг байна аа?” гэж басамжилж ч магадгүй. Юутай ч технологийн давшилт орчуулгын тухай ойлголтыг өөрчилж, орчуулгын зах зээл, сургалтад ч дунд болоод урт хугацаанд багагүй нөлөөлөх нь зайлшгүй болжээ. Мэргэжлийн орчуулагчийн хувьд хиймэл оюун, машин төхөөрөмж ашиглан ажлаа хугацаанд нь дуусгаж чадсандаа баяртай байж болох хэдий ч, танин мэдэхүйн хүчир үйлийг даван туулахдаа мэдэрдэг тэрхүү баясал бахдалыг төдийлөн мэдрэхээ болино гэдгийг анхаарахгүй орхиж болохгүй. Асуудлыг бүрэн шийднэ гэж найдалтгүй (이상빈, 2024) хэдий ч энэ асуудалд ул суурьтай анхаарч, өөрсдийн ажил мэргэжлийн ирээдүй, ур чадвартаа санаа тавих нь зүй ёсны хэрэг юм.

Мөнхчимэг(2025) орчуулгын чанарын үнэлгээний тухай өгүүлэлдээ “Машин орчуулгын чанарыг үнэлэхдээ орчуулсан материал нь эх бичвэрийн санаа, зорилго, утгыг зөв дамжуулж байгаа эсэхийн гол хэмжүүр болгож үздэг. Орчуулгын чанарыг үнэлэх нь орчуулгын салбарын хөгжилд чухал төдийгүй орчуулсан материал нь чанартай байж, зорилтот уншигчдын шаардлагыг хангана. Нэн ялангуяа, орчуулгын чанарыг үнэлэх нь хууль, эмнэлэг, техникийн болон уран зохиолын орчуулгын салбарт чухал ач холбогдолтой. Жишээ нь, хууль зүйн орчуулгад орчуулгын алдаа үүсэх нь хуулийн дүрмийг буруу ойлгуулах, эрх, үүрэг, хуулийн шийдвэр зэргээс үүдэлтэй үр дагаварт хүргэж болзошгүй. Эмнэлгийн орчуулгад буруу мэдээлэл нь буруу оношилгоо эсвэл эмчилгээний алдаа гаргах, бүр үхэлд хүргэж болно. Уран зохиолын орчуулгад алдаа гарвал тухайн бүтээлийн утга болон утга зохиолын үнэ цэнэ буурах эрсдэлтэй” гэж үзсэн байна. Түүнчлэн “хэт нарийн агуулгатай, эсхүл хууль бус үйлдэл, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүний эрх, терроризм, хорлон сүйтгэх ажиллагаа зэрэг мэдээллийн төөрөгдөл үүсгэхүйц, бусдад хохирол учруулах агуулгыг орчуулахгүй байх автомат тохиргоог чаг GPT алгоритмд оруулсан байдаг”-ийг дурджээ.

Найруулгын өөр нэгэн хэлбэр болох албан бичгийн орчуулгад тусгай компьютерын программ хэрэглэх боломжтой гэж Энхчимэг(2023) үзжээ. Тэрээр “эх хэрэглэгдэхүүний хувьд нэг хэвийн стандартчилсан маягтай байдаг, хүний сэтгэлийн хөдлөлийн өнгө аяс бараг илэрдэггүй, өөрийн тодорхой нэр томьёо, нэрийн цогц их хэрэглэдэг байдлыг харгалзан албан бичгийг орчуулахад “CAT(Computer - Assisted Translation) tool” ашиглах нь сүүлийн үеийн цаг хугацаа, эдийн засгийг хэмнэх арга техник болох бөгөөд албан бичиг баримтын сан бүрдүүлэх хэрэгтэйг онцлоод, орчуулгад тусалдаг компьютерын программ болох CAT Tool-ын хамгийн гол онцлог нь ТМ(Translation Memory) буюу орчуулах эх болон орчуулсан эхийг хамтад нь хадгалаад дата баазыг үүсгэдэг. Ингэснээр дахин шинэ текстийг орчуулах үед хадгалагдсан орчуулах эхтэй ижил төстэй өгүүлбэрийг автоматаар илрүүлж орчуулгад тусалдаг. Мөн албан бичгийн хэлбэрт оруулж эхийг хэвлэхэд бэлэн болгодог. Албан бичгийн орчуулгын хувьд ихэвчлэн нэг загварыг олон удаа ашиглах тохиолдол их гардаг учраас CAT Tool ашигласнаар цаг хугацаа, эдийн засгийн хувьд хэмнэлттэй” гэсэн байна. CAT Tool нь давтагддаг, төстэй өгүүлбэрийг автоматаар орчуулж орчуулгын илэрхийллийн нэгдмэл чанарыг хангаж ажлын бүтээмжийг нэмэгдүүлдэг бөгөөд Trados Studio, Smartcat, Maestra AI зэрэг хэрэглүүрүүд хиймэл оюун ашигладаг бол, MemoQ нь төрөл бүрийн үйлдлийн системтэй зохицон ажилладаг учраас хамтарсан орчуулгад зохимжтой гэдэг.

Тэгвэл Мягмарсүрэн(2025) хэрэглэгчийн үүднээс машины орчуулга цаг зардал хэмнэх давуу талтайг өгүүлээд, судалгааныхаа үр дүнг толилуулсныг хураангуйлбал, монгол-англи, англи-монгол хүний болон машины орчуулгын чанарыг харьцуулан судлахад хүний орчуулга (4.25) машиныхаас (3.18) нэг бүхэл нэгжээр илүү чанартай байж, уран зохиолын орчуулгыг хүн

буюу мэргэжлийн орчуулагч илүү үнэн, зөв, 5 түвшингээр ангилахад мэргэжлийн орчуулагчийн монгол-англи уран зохиолын орчуулгын чанар III-V, машиных II-III, англи-монгол уран зохиолын орчуулгад хүнийх II-V, машиных II-IV түвшинд байсан бол мэдээллийн орчуулгад хүн, машины орчуулгын чанарын түвшин ижилхэн IV-V түвшинд байжээ. Гэхдээ ахлах курсийн оюутнуудыг оролцуулж, хиймэл оюуны үнэгүй хувилбарыг ашигласнаа дурдсан байгааг энд анхаарах хэрэгтэй ажээ.

Дээрх судалгаануудаас үзэхэд “Хиймэл оюун ашигласан орчуулгын ямар төхөөрөмжүүд гарав?”, “Ашиглахгүй байж болох уу?”, “Ашиглахгүй гэвэл ямар боломжийг алдах вэ?” зэрэг асуултуудыг өөрөөсөө үе үе асуугаад үзэхэд гэмгүй. Олон хүний сонирхдогчлон “Хиймэл оюун орчуулагчийг орлох уу?” гэдэг хэт ерөнхий асуултын оронд “Хиймэл оюун ямар орчуулагчийг орлох вэ?” гэж нарийсган асууж сайтар тунгаан бодох шаардлага урган гарч байна. Асуултын хариуг олохын тулд шинжлэх ухаан, шинэ технологийн үрээр бүтсэн хиймэл оюуныг орчуулгад зохих түвшинд хэрэглэж зөв таньж мэдэх хэрэгтэй юм.

### **Орчуулгын сургалтад хиймэл оюун хэрэглэх ямар нөлөөтэй вэ?**

Сун Ёньсогийн хүний хэрэгцээнд хиймэл оюун хүч түрэн орж ирж буй өнөө цагт орчуулга зааж буй солонгос багш нарын санаа бодлыг асууж ярилцахад хэлсэн дараах өгүүлбэрүүд эрхгүй нэгийг бодогдуулна. *“Цаг хэмнэхийн тулд судалгаа хийх, англи үгийн утгыг нягтлахад л ашигладаг.”*, *“Хэрэглэвэл өөрийгөө голох юм шиг санагддаг. Урам хугарах байх.”*, *“Муухан орчуулагчаас сайн орчуулж байгааг үзээд цаашид хэр сайжрах бол гэхээс их эмээж байна.”*, *“Яаралтай. Хиймэл оюун хэрэглээд ч хамаагүй хурдан орчуулж өгөөч гэж яаруулдаг нь дарамттай санагддаг.”*, *“Ажил ховордсон.”*, *“Амархан ажил орж ирэхээ больсон.”*, *“Үнэхээр шилдэг орчуулагч нар л үлдэх байх.”*, *“Эрэлт хэрэгцээ илт буурахаар байгаа.”* Энэ мэтээр хүнээр хийлгэх орчуулгын ажлын хүрээ хумигдаж байгаа нь багш, орчуулагчдын сэтгэл санаанд шууд дарамт болж, сөргөөр нөлөөлж эхэлжээ. Тийм ч учраас орчуулгын сургалтад, даалгавар хийхэд хиймэл оюун ашиглахыг гол төлөв дараах байдлаар хориглосон байна. *“Даалгавар хийхдээ хиймэл оюун хэрэглэж байгаа нь мэдрэгдсэн.”*, *“Бодож сэтгэх чадвар хумигдах учраас даалгаварт хэрэглэхийг эсэргүүцэж байна.”*, *“Хоёр жил суралцах хугацаа хайран. Машины орчуулгыг төгссөн хойноо хэрэглэхэд болно.”*, *“Эхийг судлахад ашиглаж болно. Орчуулгаа өөрөө хий. Хиймэл оюун ашиглаж орчуулбал оноо хасна.”*, *“Эхний хичээл дээр өөрсдөө орчуулж чаддаг байх ёстой гэж анхааруулдаг.”*, *“Эхнээсээ хиймэл оюуны орчуулга харуулж та нар үүнээс илүү орчуулах ёстой гэдэг.”* (송연석, 2024) Хүн хүний орчуулах чадвар харилцан адилгүй шиг, хиймэл оюуны орчуулгууд ч харилцан адилгүй. Орчуулгад хиймэл оюун хэрэглэх эсэх талаар ч багш, оюутны санал ихэд зөрүүтэй гарч болзошгүй. Судлах хэрэгтэй.

Орчуулгын даалгаврыг гүйцэтгэхдээ хиймэл оюун хэрэглэсэн эсэхийг мэдэж болох уу? Мэдээж зарим нэг арга бий. Нэн тэргүүнд багш нь оюутныхаа түвшнийг мэдэж байгаа тохиолдолд тухайн оюутны хэрэглэхээргүй үг хэллэг, дүрэм, найруулгаас хиймэл оюун хэрэглэсэн байж болзошгүйг мэдэж болно. Эргэлзээтэй тэдгээр үг, илэрхийлэл, дүрмийг яагаад сонгосныг оюутнаар яриулж, ямар толь бичиг ашиглаж хэдэн үе шаттай яаж орчуулсныг нь тодруулан лавлаж болно. Бас орчуулгын эхний хувилбар, зассан хувилбар, эцсийн хувилбар өгөхийг шаардана. Шууд эцсийн үр дүнг авчирвал хиймэл оюун ашигласан байх магадлалтай гэж үзнэ. Оюутныхаа түвшнийг сайн мэдэж авахын тулд хичээлийн цаг дээр төстэй эхийг орчуулуулсан байвал сайн. Тэгээд ангид орчуулж байснаасаа эрс ялгаатай бол эргэлзэж болно. Ворд файл дээр track change ашиглан үг илэрхийллээ засаарай, эсвэл гүүгл документ дээр орчуулгаа хий, зассан хувилбаруудыг харьцуулж харна гэж оюутанд урьдчилан зааварлана. Иймэрхүү аргууд байж болох боловч эцсийн дүнд багшийн ачаалал улам нэмэгдэж, багш оюутандаа үл итгэснээр

сургалтын үйл явц, үр дүнд сөргөөр нөлөөлөх нь дамжиггүй. Хамгийн гол нь багш өөрөө яагаад хиймэл оюун ашиглуулахгүй байгаа шалтгаанаа маш тодорхой хэлж тайлбарлах ёстой болно.

Гэвч цаашид нэг нь хэрэглэснээ нууж, нөгөө нь яаж илрүүлэх вэ, яаж хэрэглүүлэхгүй байх вэ гэж аргаа барж суух уу? Муур хулгана болж тоглосоор байх уу? Нэгэнт оюутан залуус хэрэглээд эхэлсэн, багш хэрэглээгүй хоцорсон байж болзошгүй. “Муу нуухаар сайн илчил” гэдэг. Хиймэл оюуныг танихын тулд юуг орчуулуулдаг ямар алдаа оноог олж харсан, хэрхэн заавар өгвөл илүү сайн үр дүн гарч байна гэх зэргээр ний нуугүй ярилцах хэрэгтэй. Таньж мэдэхгүй хэр нь сохроор муулж, буруу дүгнэж болохгүй. Багш шийтгэж хашраах биш, зааж зөвлөх үүрэгтэй учраас орчуулгын хичээлийн цаг дээр ч хиймэл оюуныг цуг хэрэглэж, давуу ба сул талыг нь сайн хэлэлцэж ярилцах нь нэн чухал. Оюун мэдлэгээ уралдуулан янз бүрээр ахин дахин хэрэглэж, туршлагаа хуваалцах явцад хэзээ яаж хэрэглэх зохистойг аль аль нь сайн мэддэг болно. Зөв чиг баримжааг олно. Яагаад зөв чиг баримжаа авах ёстой вэ? Эхлээд хиймэл оюуны орчуулга гэж амархан танигддаг байсан, яваандаа танихад бэрх болсон, удалгүй танигдахаа байвал яах вэ? Машины орчуулга, хиймэл оюуны орчуулга нэг хэсэг тааруухан гэгдэж гологдож байсан нь үнэн. Бас нэлээд хэрэгцээтэй эд байна, муухан орчуулагчаас дээр юм гэгдэх болсон нь ч үнэн. Тийм ч учраас хаашдаа л хүмүүс хэрэглэх нь тодорхой болсон үед хэрэглэж үзэхгүй, хэрэглүүлэхгүй гэж хүчилж, гэжүүдэлсээр байх зөв үү?

Нэг талаар хиймэл оюунд суурилсан машины орчуулга нь орчуулгын салбарыг улам нарийсаж, ялгарахад нөлөөлнө. Түргэн хэрэглээний кофе ууж үзсэн хүмүүсээс кофенд дурлан шимтэгчид төрж, улмаар дээд зэрэглэлийн үрийн кофены хэрэглээ нэмэгдсэнтэй адилтгаж болох юм. Орчуулгын мэргэжилтэн төрөл бүрийн орчуулах төхөөрөмжийг маш чадварлаг хэрэглэж сурах ёстой. Энэ нь эмч хүн өвчтөнөө эдгээхийн төлөө сайн багаж хэрэглэлийг ашиглаж сурахад зориуд цаг гаргадагтай агаар нэг. Хэрэглэгч найдвартай зүйлийг хүсдэг. Хурдан шуурхай, үнэн зөв орчуулахын тулд машин техниктэй сайн харьцдаг байх учиртай. Орчуулагч дор бүрдээ үр өгөөжийг дээшлүүлэх аргыг эрж хайж ёстой. (이노신 외, 2016) Нөгөө талаар зөв орчуулах арга ухаанаас, мэдлэг чадвараас, уншиж, бичих, сэтгэн бодохоос хөндийрвөл тэр чигээрээ “техникийн боол” болох том аюул нүүрлэнэ.

### **Орчуулгын сургалтад хиймэл оюуныг хэрхэн зохистой хэрэглэх вэ?**

Хиймэл оюун мэт технологи ба орчуулагчийн харилцааг хамтран амьдрах(symbiosis) гэдэг ойлголтоор тайлбарлах нь зүйтэй байж болох юм. Хүн, техникийн харилцааг яаж авч үзэхээс орчуулга зааж байгаа багшийн сургалтын арга өөрчлөгдөнө. Энэ харилцаа орчин нөхцөлөөс хамааран өөрчлөгдөж, хүмүүст тааламжгүй харилцаа ч үүсэж болзошгүйг харгалзах нь хиймэл оюуны эринд орчуулгын сургалтыг зөв зүгт чиглүүлнэ. Одоогийн байдлаар хиймэл оюуны эринд нийцсэн ур чадварыг зааж сургаж чадахгүй байгаа. Энэ нь зөвхөн орчуулгын сургалтын асуудал биш хүмүүнлэгийн ухаан, бүр цаашилбал хуучин арга барилаас салж чадахгүй байгаа дээд боловсролын асуудал гэж үзэж болно. Байдгаараа хичээж орчуулгын ур чадварыг зааж сургалаа гэхэд хиймэл оюун ба технологийн хөгжлийн улмаас хэрэглэх боломжгүй болбол оюутан сурагчид юу гэж бодох вэ? Багш хэдий сайн санааны үүднээс зааж сургавч цаг үе хурдтай өөрчлөгдөхөд оюутан сурагч санаандгүй хохирол амсаж болохоор болжээ. Нарийн арга барил, тухайлсан мэдлэг нэг бүрийг чухалчлалгүй, том зургаар алсыг харж суурь ур чадварыг сайжруулах нь оюутнуудад илүү тустай. Нөгөөтээгүүр насаараа орчуулга хийж амьдрах хүн хэр олон байгаа вэ гэдгийг ч бодуштай. (이상빈, 2024)

Хиймэл оюуныг зөв таньж мэдэхийн тулд, наанадаж танимхайрахын тулд хэрэглэж үзэх зайлшгүй шаардлагатай болно. Ялангуяа орчуулгын сургалтад ашиглах бол багш өөрөө орчуулгын төрөл бүрийн эхийг орчуулах, засах, хувилбар санал болгох зэрэг олон янзын даалгаврыг заавар асуултаа өөрчилж, лавшруулах аргаар хиймэл оюунд өгч, гүйцэтгэлийн чанар,

онцлог, алдаа оноог няхуур ажиглаж судлах нь зүйтэй. Ингэснээр илүү дутуугаа мэдэж авч, хиймэл оюуныг дутуугаа нөхөхөд ашиглах боломж бүрдэнэ. Харин давуу талаа аль болох хадгалж, улам сайжруулахыг хичээвэл зохино.

О Бриен машин техник хүнийг гүйцэх гэж байгаа биш, хүний танин мэдэх хязгаарыг даван туулахад тусалж байгаа гэх “хүн төвтэй хиймэл оюун (human-centered AI)” гэдэг ухагдахуунд тулгуурлаж, хүний орчуулга ба машины орчуулга гэж зааглаж ялгахын оронд машин техникээр хүний чадварыг нэмэгдүүлж, хүн төвтэй “өргөтгөсөн орчуулга (augmented translation)” хийхийг санал болгож байжээ. Хиймэл оюуныг зохих хэмжээнд ашиглан орчуулсан үр дүн үүргээ гүйцэтгэсэн бол хэрэглэгчийн хувьд хүн орчуулсан уу, машин орчуулсан уу, яаж орчуулсан гэдэг нь огт чухал биш байж ч болно. Тэгэхээр чанарт л голлон анхаарах шаардлагатай. Хэрхэн заавар өгөхөөс хамаарч ChatGPT-ээр орчуулгыг хүссэнээрээ дахин боловсруулж, илэрхийллийн өнгө аяс ба хэрэглээг нягталж, судлах цагийг хэмнэн хэрэглэгчийн хүссэн үр дүнд хүрэх боломжтойгоороо давуу талтай. Иймд хэрэглэх чадвараа сайжруулах нь зүйтэй. (송연석, 2024)

Харин яагаад зохистой хэрэглэх ёстой вэ? Мэдээж дэлгэцийн хамаарал гэдэг шиг хиймэл оюунаас хамааралтай болж болохгүйг багш, оюутны аль аль нь ухамсарлах хэрэгтэй. Хиймэл оюунд хөтлүүлж удирдуулах биш ямагт эзэн нь байж, санаачилгыг гартаа авч, чиглүүлэхийг чармайвал зохино. Хиймэл оюун хүртэл “сурч” байгаа цагт хүн бид алгуурлаж залхуурч болохгүй.

Тийм бол орчуулгын сургалтад хиймэл оюуныг зохистой хэрэглэх ямар санаанууд байж болох вэ? Судлаач И Санбинь *орчуулгын сургалтыг шинэчлэх үндсэн таван чиглэлийг* санал болгожээ. Үүнд:

1. *М хэлбэрийн мэргэжилтэн бэлдэх.* Нэг л салбарын I хэлбэрийн мэргэжилтэн, ижил төстэй салбарт ч зохих мэдлэг чадвартай T хэлбэрийн мэргэжилтэн бэлддэг байсан үеүд ард хоцорч, аливаа шинэ салбарт хэзээд бие даан суралцдаг тал талын мэдлэг чадвар бүхий M хэлбэрийн мэргэжилтэн чухал боллоо. Техник технологи асар хурдан өөрчлөгдөж байгаа энэ цагт төгсөөд юу хийх нь тодорхойгүй бол нэг л зүгт зүтгүүлэх нь эрсдэлтэй.

2. *Орчуулгын сургалтын хөтөлбөрийг өөрчилж, цаг үетэй нь нийцүүлэн хялбаршуулж, шинэчлэх.* Зарим хувийн сургуульд бичил мэргэжил гэж үүсгэн мэргэжил хоорондын зааг ялгааг сааруулахыг зорьж байна. Тэр бүү хэл чөлөөт мэргэжил байж болохыг ч санаачилж эхэллээ. Орчуулгын сургалт тэнхимийн түвшинд төдийгүй сургуулийн түвшинд өөрчлөгдөх цаг иржээ. Урьд нь юу сураад хаана ажиллахыг заадаг байсан бол одоо хэрэгтэй үед нь хүссэн зүйлээ бие даан сурахад нь туслах хэрэгтэй болж байна. Хөтөлбөрийн агуулгад “яагаад” гэдгийг тодорхой тусгаж, хөрвөх чадварыг онцлох шаардлагатай.

3. *Дадлага зонхилсон хичээлээс аль болох татгалзаж, агуулгын давхардлыг багасгах.* Түгээмэл хэрэглэж болох, машины орчуулгатай уялдаа бүхий хичээлд л дадлагын хэлбэрийг хадгалж, бусад хичээлийн хэлбэрийг өөрчлөх ёстой. Их сургуульд мэргэжлээс үл хамааран бичих чадварыг хөгжүүлэх нь зүйтэй. Орчуулгын чадварт хэт анхаарч, бичгийн чадварыг хайхардаггүй байсан тал бий. Бичих, найруулах чадварыг гойд сайжруулахгүй бол машинд ажлаа алдах цаг ирж магадгүй.

4. *Орчуулгын мэргэжлийн өөр мэргэжилтэй хослуулах.* Орчуулгыг дагнасан мэргэжлээр сургахын оронд өөр мэргэжилтэй хослуулах уялдуулах талаар бодолцох цаг иржээ.

5. *Багш өөрчлөгдөх.* Үнэндээ энэ хамгийн хэцүү нь. Магадгүй оюутнаасаа илүү ихээр шинэ зүйлд суралцах шаардлагатай болж байна. Нэг л чадвараа дээшлүүлэхэд хамаг анхаарлаа хандуулалгүй, олон чадварт суралцах нь юу юунаас чухал болж байна. Танхимд юу зааж байгааг тэнхим нь ч мэдэхгүй байх тохиолдол элбэг. Давтах нэрийдлээр мэддэг зүйлтэйгээ зууралдах хэрэггүй. Сургуульдаа, сургууль хооронд судалгаа шинжилгээг эрчимжүүлэх чухал. Өөр хэлний мэргэжилтэн, өөр орчуулгын мэргэжилтний байдлыг соргоогоор ажиглаж гарц гаргалгааг хамтдаа эрэлхийлэн оюун бодлоо уралдуулах цаг иржээ. (이상빈, 2024)

Эдгээрээс дүгнэхэд багш, оюутан хоёулаа хурдтай өөрчлөгдөж буй цаг үеэ мэдэрч, зогсолтгүй бодож тунгаан, хөрвөх чадвартай байхын тулд тал талын мэдлэг чадвартай болохыг эрмэлзэх хэрэгтэй болжээ. Дөрвөн жил сурснаараа дөчин жил зүтгүүлдэг үе улирсан гэсэн үг. Орчуулгын сургалтын зорилго нь бие даан орчуулах чадвартай хүнийг бэлтгэх. Хиймэл оюун цуглуулсан өгөгдлөөр сурч байгаа бол бид ч хиймэл оюуны талаар өгөгдөл цуглуулж асуудлыг хэлэлцэж шийдэх нь зүйтэй.

Хэлний чадвараа сайжруулахад хиймэл оюуныг үр өгөөжтэй ашиглаж байгаа жишээ ч цөөнгүй. Тухайлбал ярих чадварыг “илэрхийлэл давтах, өгүүлбэрийн бүтэц давтах, мэдэхгүй үг хэллэг асуух, дүрд тоглох, тодорхой нэг сэдвийн хүрээнд ярилцах, ярианы шалгалтад бэлдэх” (EstellEnglish, 2024), бичих чадварыг “notes апп ашиглан эх хэлээрээ өдрийн тэмдэглэл хөтлөөд сурч байгаа хэлээрээ орчуулуулах, хариуг хуулж бичихдээ үг дүрмийн хэрэглээг сайн анзаарах, ингэснээр өөрийн хэрэглэх өгүүлбэрийг хам сэдвээр нь сурах” (Bookplanet.mn, 2026) гэх мэт аргуудаар хөгжүүлж болох ажээ.

Хиймэл оюуны эрин үед өөр аргаар, сонирхолдоо хөтлөгдөн давтаж, гүнзгийрүүлж болох агуулгаар “даалгавар өгөх” шаардлагагүй ч гэж үздэг эрдэмтэн бий. Өөрийн мэдлэг чадварын түвшнийг таньж мэдэх боломжтой бол сургуулийн үнэлгээ ч зайлшгүй хэрэгтэй юү? “Чиний л төлөө” гэдэг нь үнэхээр чиний л төлөө мөн үү? Ирээдүйг хэлж таамаглаж чадах уу? Бодож сэтгэдэг хүн ирээдүйгээ, аз жаргалаа өөрөө бүтээнэ. (ТВС, 2026) Үнэхээр үнэлэх хэрэгтэй гэвэл явцыг чухалчилж үнэл. Хэрэглэсэн гэдгээ хэл, яаж асууж заавар өгснөө хэл, юу гэж бодож байгаагаа хэл. Хичээж заасан ч хиймэл оюуныг зөв ашигладаг, буруу ашигладаг, хэт их ашигладаг оюутан байсаар л байна. Ухаантай хүүхэд илүү хурдан, сайн ашигладаг нь эхнээсээ ажиглагдаж эхэлжээ.

Сургалтын хөтөлбөрт зориудаар хиймэл оюун хэрэглэдэг хичээл, хэрэглэдэггүй хичээлийг зэрэгцүүлэн оруулснаар аль алиных нь давуу, сул талуудыг илүү сайн ойлгож ухаарах боломж бүрдэх талтай. “Машины орчуулгын талаар мэдлэг чадваргүй бол мэргэжлийн орчуулагч гэж үзэхэд бэрх болж байна. Өнөөгийн машины орчуулгын сургалт бидний хүсэл зорилгоос ангид үйлчилж орчуулгын ач холбогдол, орчуулагчид хандах хандлагыг доройтуулж ч болзошгүй. Орчуулгын үр дүн чухал. Гэхдээ орчуулга хийх явцдаа хэлний чадвараа сайжруулж, соёлын харилцааны чадвараа тэтгэх нь оюутанд илүү чухал байдаг. Машины орчуулгад хэт найдах нь суурь чадварыг ч алдагдуулах эрсдэлтэй. Нэг хоёр цаг махаа идэж орчуулах агуулгыг хэдхэн хоромд илүү сайн үр дүнгээр харж болж байхад махаа идье гэх хүн хэр байгаа вэ? Энэ бол зүгээр нэг итгэл, ёс зүйн асуудал биш. Машины орчуулгыг хориглох нь түр зуур аргацаасан л арга. Харин машины орчуулга байгааг ч умартан хичээлд оролцох орчныг бүрдүүлж чадвал оюун санаанд ч өгөөжтэй. Өөрөөр хэлбэл үр дүн биш үйл явцыг голлосон сургалтын хөтөлбөр боловсруулах шаардлагатай. Төхөөрөмж хэрэглэвэл өөрт тавгүй сэтгэгдэж, хэрэглээд ч нэмэргүй дээ гэж мэдрэгдэхээр тийм л хичээл хэрэгтэй.” (이상빈, 2024) Нэг хичээлд хиймэл оюуны тусламжтайгаар, нөгөө хичээлд хиймэл оюунгүйгээр орчуулга хийж үзсэнээр орчуулгын үйл явц илүү тодорхой болж, хэн нэгнийг хиймэл оюун хэрэглэлээ гэж хардаж сэрдэх үндэсгүй болохоос гадна хиймэл оюуныг чухам хэдийд хэрхэн үр ашигтай хэрэглэж болохыг олж мэдэх боломжийг яагаад бүрдүүлж болохгүй гэж?

Эцэст нь хиймэл оюуныг хэрэглэхдээ анхаарах зарим зүйлийг өгүүлье.

**Хиймэл оюуныг хэрэглэхэд анхаарах зүйлс**

Хэрэглэх, суралцах явцдаа Сун Гил-ёны санал болгосончлон “хийлгэж болох ажлаа ялгаж, хурдан даалгах”, “хожсон цаг хугацааг өөртөө хөрөнгө оруулах” нь зүйтэй. (이혜성의 1% 복클립, 2026)

Хиймэл оюуныг сайн ашиглахын тулд промпт буюу зааврыг зөв өгөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл зүгээр л үгээр хайдаг хайлтын системтэй адилгүй учраас товч тодорхой асуух, илэрхийлэх чадвар тун чухал. Аль хэлнээс аль хэлээр, ямар найруулгаар орчуулах, үр дүнг ямар форматаар гаргахыг тодорхойлж өгнө. Эхнээсээ та бол ийм түвшний ийм мэдлэг чадвартай орчуулагч гэж дүр оноовол илүү үр дүнтэй. Жишээг өгч болно. Бас юу хийж болохгүйг зааварлаж болно. Тухайн даалгавар гүйцэтгэхэд хэрэгтэй зүйлийг тодруулж болно. Мэдэхгүй бол “мэдэхгүй” гэж хариулж болохыг урьдчилж анхааруулна. Хүмүүс заавар өгөхдөө хэт ерөнхий байх, зонтекст буюу нөхцөл байдлыг орхигдуулах нь элбэг. Мөн эхний хариултаас эхлээд сохроор итгэж болохгүй. Заавруудаа сайжруулж хүссэн үр дүндээ хүрнэ. Цуврал заавруудыг цогцоор нь үйл явц гэж хүлээж ав. Олон удаа зааварлаж үзэж байж л эзэмших чадвар гэдгийг мартаж болохгүй. (Easy digital & AI Mongolia, 2026). Харьцангуй дэлгэрэнгүй зааварлах жишээ үзүүлье. Жишээ: “Та солонгос хэлний дунд түвшний мэдлэгтэй мэргэжлийн орчуулагч. Дараах агуулгыг албан бичгийн найруулгаар орчуулна уу. Ингэхдээ монгол албан бичгийн загварт оруулж нэг хуудсанд багтаана. Орчуулсны дараа үндсэн 10-15 үг хэллэгийг орчуулгад хэрэглэсэн дарааллаар цуг харуулаарай. Орчуулгыг ворд файлаар авъя.”

Хиймэл оюуны орчуулгад hallucination буюу төөрөгдөл байдгийг ямагт санаж, хариу, боловсруулалтад нь сохроор бүрэн итгэж болохгүй. Эх сурвалжийг, агуулгыг сайтар нягталж дадах ёстой. Байхгүй зүйлийг байгаа мэт, бурууг зөв, худлыг үнэн мэт хариулах тохиолдол бий. Үүнээс сэргийлэхийн тулд өмнөх хэсгийн тодорхой зааварлах, дүр оноох, хэмжээ хязгаарлалт тогтоох зэрэг аргыг марталгүй ашигла. (애플테크 퀴즈 뉴스, 2025)

Хиймэл оюун нь хэрэглэгчид тал засдаг. Таны саналыг дэмжиж байгаа нь тан шиг ойлгосных биш, мэдэрснийх биш. Тэгж программчлагдсаных гэдгийг бүү март.

Соёл, сэтгэлгээний ялгаанаас болж заримдаа үгчилж орчуулаагүй нь дээр тохиолдлыг хиймэл оюун ихэвчлэн ялгахгүй. Ийм агуулгыг орчуулах чадвартай бол таны давуу тал болно.

Буруу орчуулсан бол хиймэл оюуныг буруутгах биш, та өөрөө хариуцлага хүлээнэ.

Хувийн мэдээлэл, байгууллагын нууц зэргийг дэлгэхгүй, алдахгүй байхыг анхаар. Өөрөөр хэлбэл бичиж буй үг өгүүлбэр, оруулж буй баримт мэдээллээ хянамгай сонгох хэрэгтэй болно. Яагаад гэвэл хиймэл оюун амьдралаас суралцаагүй, таны оруулсан мэдээ мэдээллээс суралцаж байгаа. Мэргэжилтнүүд үнэгүй хувилбарт мэдээллийг хиймэл оюуны сургалтад ашиглаж болзошгүйг сэрэмжлүүлдэг.

Эцэст нь өөрийн хэрэглээг ухаалгаар хязгаарлаж, хиймэл оюунаас хэт хамааралтай болохоос зайлсхий. Ямар ч тохиолдолд бодож тунгаах, хийх ёстойгоо хийхээс бүү залхуур. Ур чадвараа доройтуулж байгаа бол буруу хэрэглэж байгаагийн дохио.

**ДҮГНЭЛТ**

Хиймэл оюунд суурилсан олон төхөөрөмж, хэрэглүүрээс ажил мэргэжилдээ таарамжтайг сонгон хэрэглэх нь орчуулгын хурдыг нэмэгдүүлж, зарим тохиолдолд чанарыг сайжруулж байгааг харгалзан боломжийн хэрээр зохистой хэрэглэж, давуу болон сул талыг зөв таньж мэдэх шаардлагатай болжээ. Энд бид хиймэл оюуныг орчуулгын сургалтад ямар зааг хязгаартай, хэрхэн зохистой ашиглах талаар хэлэлцэх эхний алхмыг хийлээ. Дараа дараагийн судалгаанд илүү гүнзгий, тодорхой асуудлыг бодит жишээгээр хэлэлцэж, зохих шийдлүүдэд хүрч, орчуулгын

сургалтаар зогсохгүй аливаа орчуулгын чанарыг сайжруулахад хувь нэмрээ оруулсаар байх нь бидний эрхэм зорилгын нэг байх нь дамжиггүй.

Товчхондоо сургалтад хиймэл оюуныг ашиглах нь хориглох биш, яаж зохистой хэрэглэхийг шийдэх асуудал. Хиймэл оюуныг хэрэглүүлэхгүй гэвэл хиймэл оюун хэрэглэж болох даалгавар өгөхгүй байх хэрэгтэй. Хэрэглэж үзээгүй хүн байдаг, харин ганцхан удаа хэрэглэсэн хүн байдаггүй гэдэг. Иймд хиймэл оюуныг зөв таньж мэдье гэвэл хэрэглэх нь зайлшгүй бөгөөд, тийнхүү хэрэглэх явцдаа бодитоор сайн муут нь таньж мэдсэнээр ямар тохиолдолд яаж хэрэглэхээ шийдэж, сургалтад хэрхэн тусгаж болохыг нарийн төлөвлөх боломжтой. Багш өөрөө бас оюутнаа хиймэл оюунд хөтлүүлж удирдуулах биш ямагт эзэн нь байж, санаачилгыг гартаа авч, үлгэрлэн чиглүүлэхийг чармайлтай.

### НОМЗҮЙ

- Мягмарсүрэн, Т. (2025). Хүн ба машины орчуулгад хийсэн шинжилгээ. *Орчуулгазүй. Vol.12*, 54-65, doi: 10.22353/TS20250106.
- Мөнхчимэг, О. (2025). Машин орчуулгын чанарын үнэлгээнд хиймэл оюуны аргачлалыг ашиглах боломж ба үр нөлөө. *Орчуулгазүй. Vol.12*, 25-33, doi: 10.22353/TS20250102.
- Энхчимэг, С. (2023). Монгол-солонгос албан бичгийн орчуулгын асуудалд. *Орчуулгазүй. Vol.11*, 84-89, doi: 10.22353/TS20230109.
- 이노신 외. (2016). 통번역의 미래지평: 인공지능과 소통형 융합통번역 연구. *번역학연구(JTS). Vol.17(2)*, 10.15749/jts.2016.17.2.003.
- 이상빈. (2024). AI 시대의 도전과 대학의 통번역 교육. *T&I REVIEW. Vol.14(2)*, doi: 10.22962/tnirvw.2024.14.2.003.
- 송연석. (2024). AI 시대의 번역 교육 – 통번역대학원 한영과 교수자 심층 면접조사를 중심으로. *번역학연구(JTS). Vol.25(32)*, doi: 10.15749/jts.2024.25.3.002
- Bookplanet.mn. (2026). Chatgpt-д их ид шид байгаа шүү, зөв ашиглаж сурвал: <https://www.facebook.com/reel/1464986498554582>
- EstellEnglish. (2024). 챗 GPT 4o 미쳤습니다! 무섭게 실력이 느는데 왜 안하세요? (꿀팁 6 개): [https://www.youtube.com/watch?v=\\_3lhVCMSGzc&list=WL](https://www.youtube.com/watch?v=_3lhVCMSGzc&list=WL)
- TBC. (2026). AI 보다 먼저 가르쳐야 할 것은 따로 있다? | 부모 공감 토크콘서트 (With 김상욱 교수): <https://www.youtube.com/watch?v=U4fwugv9nYY>
- Easy digital & AI Mongolia. (2026). Промпт бичих замаар хиймэл оюунаас (AI) илүү сайн хариулт авах нь, Шилдэг 5 дүрэм: <https://www.youtube.com/watch?v=gQfMQiqJmhA&list=WL&index=113>
- 애플테크 퀴즈 뉴스. (2025). AI 환각률(Hallucination Rate): 구글과 오픈 AI vs 딥시크 비교: <https://bookshelf-journey.tistory.com/>
- 이해성의 1% 북클럽. (2026). AI 시대, 사라질 직업과 생존 전략 | 경쟁에서 벗어나 나만의 일을 찾는 법 | 송길영 작가: <https://www.youtube.com/watch?v=-j1lucVGZes>



## МОНГОЛ ХЭЛНИЙ ХЭЛЦИЙГ ХЯТАД ХЭЛНЭЭ ОРЧУУЛАХАД ТҮГЭЭМЭЛ ХЭРЭГЛЭГДЭХ АРГУУД

Ц. Ичинхорлоо<sup>18</sup>

**Abstract:** The idioms and expressions of any language are closely tied to the lifestyle, customs, historical characteristics, and indeed the cultural mentality of the nation to which they belong. As such, how to render them into other languages has long posed a considerable challenge.

In this study, we sampled over 100 Mongolian idioms and conducted a comparative analysis to determine which translation methods, when applied to rendering them into Chinese, produce the most accurate and natural results.


The research revealed that three methods, namely adaptive translation, equivalent translation, and semantic translation, are broadly applicable in both pedagogical and practical contexts when translating Mongolian idioms into Chinese. Among these, equivalent translation, which involves rendering source-language idioms through target-language counterparts that differ in imagery yet convey the same meaning, was found to be the most effective approach.

**Түлхүүр үг:** хэлц үг, дүйцүүлэн орчуулах, дүрслэл, монгол, хятад хэлнээ

Аливаа хэлэнд ард түмний аман ярианд тодорхой цаг хугацаанд үргэлж хэрэглэгдэн заншсан, аливаа юмыг цовоолог бөгөөд бодитоор дүрслэн зүйрлэж, утга санааг нь товч авсаархан бүрэн төгөлдөр илтгэдэг хэвшсэн холбоо үгс байдаг. Ийм үгсийг бид хэлц үг хэмээн нэрлэдэг.<sup>19</sup> Эдгээр үгс нь маш өргөн дэлгэр санааг иж хураангуй, цомхон илтгэдгээрээ бусад нийлэмж үгнээс ялгаатай.

Хэлц үг нь ард түмний дунд аман болон бичгээр дамжин уламжлагдаж, тухайн үндэстнийхээ аж амьдрал, оюун сэтгэлгээ, ёс заншил, зан үйл, хэл соёлын онцлогийг үргэлж хадгалан оршиж байдгаараа онцлогтой юм. Ийм учраас хэлц нь үгийн сангийн бусад нэгжээс тогтсон байрлал, бүтцээрээ ялгарч өгүүлбэрийн дайтай хэрэглэгдэж, дүгнэлт эргэцүүлэл агуулж, тухайн хэлнийхээ түүхэн хөгжлийн явцад тогтвортойгоор оршин тогтнож байдаг.

Үгийн сангийн хувьд монгол, хятад 2 хэлний хэлц хэллэгийг дараах байдлаар ангилан харвал:



<sup>18</sup> Ph.D, МУИС, ББС, Гадаад хэлний тэнхим, ORCID: 0000-1+234-5678-9101

<sup>19</sup> Аким, Г. (1984). Орчуулгын санг уудлахад. Улаанбаатар., хуу-21

Дээрх 2 бүдүүвчийг зэрэгцүүлэн харвал орчин цагийн монгол хэлэнд олдмол утга бүхий өвөрмөц хэлцийг хэвшмэл хэлцээс нь ялгаж тусгайлан авч үздэг нь ажиглагдав. Учир нь хаана ч үл давтагдах монгол сэтгэлгээ гагцхүү монгол өвөрмөц хэлцэд л бүрэн туссан байдагтай холбоотой. Түүнчлэн Монгол, Хятад хэлний хэлц үгийн төрөл зүйл, ангилал, ач холбогдол нь өөр хоорондоо төсөөтэй ч утга, дүрслэл, зүйрлэл, бичгийн өнгө аяс нь ялгаатай байна. Энэ нь тухайн 2 үндэстний амьдрал ахуй, ёс заншил, түүх, хэл соёл зэрэгтэй ихээхэн холбоотой.

Ийнхүү аль ч хэлний хэлц үг, хэллэгүүд нь тухайн үндэстнийхээ аж байдал, зан заншил, түүхэн онцлог болоод тухайн улс үндэстний соёл сэтгэлгээтэй нягт холбоотой байдаг тул өөр бусад хэлнээ орчуулахад чухамхүү яаж буулгах вэ гэдэг нь нэлээд төвөгтэй байсаар ирсэн.

Эрдэмтэн судлаач Д.Дашдаваа “Хэлц үгийн бүрэлдэхүүнд үг орохлоороо бие даасан утгаа алдаж, гагцхүү тухайн нийлэмж нь л нэгдмэл утга илэрхийлдэг. Ийм чөлөөт нийлэмж үгийг ч утгаар орчуулах хэрэгтэй.”<sup>20</sup>, судлаач Н.Нансалмаа “Өвөрмөц хэлц болон хэвшмэл хэлцийг орчуулахын тулд юуны өмнө үг хэллэг, хэлцээр ямар тод, содон санаа илэрхийлж байгааг орчуулагч эх зохиолыг задлан шинжлэх явцад зөв зүйтэй тогтоож, дараа нь утгыг тохируулах үүднээс ямар аргаар орчуулах зүйтэй болохоо шийдвэл зохино.”<sup>21</sup> хэмээнээс үзвэл аливаа хэвшмэл хэлцийг орчуулах явцад энэ нь нэгдмэл утга бүхий үгийн сангийн бие даасан нэгж болохыг анхаарах нь зүйтэй гэлтэй.

Аль нэг хэлний хэвшмэл хэлцийг шууд үгчилж орчуулах нь зохисгүй бөгөөд үгчлэн орчуулснаас илэрхийлэх утга нь алдагдахад хүрдэг. Энэ тухай эрдэмтэн зохиолчид өөр өөрийн гэсэн санаа бодолтой байдаг. Тухайлбал, эрдэмтэн судлаач Чой. Лувсанжав “Гадаадын хэлц үгийг гагцхүү өөрийн бэлэн хэлц үгээр орчуулж болно.”<sup>22</sup>, зохиолч, орчуулагч М. Цэдэндорж “Гагцхүү хуулбарлан орчуулах хэрэгтэй”<sup>23</sup> гэжээ.

Бид энэ удаад монгол хэлний хэлц үгийг хятад хэлнээ буулгахад орчуулгын ямар аргуудыг сонгон авч ашиглавал тухайн орчуулга оновчтой, амьдлаг болж чадах вэ гэдгийг тодорхойлохыг зорьсон. Судалгааны явцад бид монгол хэлний хэлцийг хятад хэлнээ орчуулахад сургалт практикт өргөн ашиглаж болохуйц орчуулгын дараах аргуудыг онцлон авч үзэв.

### 1. Зохиомжлон орчуулах арга:

Энэ нь монгол хэлний дүрэм ёсыг зөрчихгүйгээр уншигчдад буруу ойлголт өгөхгүй, монгол хэлний хэлцийн зүйрлэл дүрслэлийн онцлогийг тэр хэвээр нь хадгалж орчуулах арга юм. Өөрөөр хэлбэл, монгол хэлний хэлц бүрийг махчлан орчуулах биш харин монгол хэлний өвөрмөц болон хэвшмэл хэлцийн утга санааг зөв оновчтойгоор дахин илтгэж гаргахдаа хятад хэлний үгийн сан, хэл зүй, найруулга зүйн онцлогийг тусгах, хятад шүлгийн зэрэгцүүлэл, үсэг хязгаарлах, айзам хэмнэл тааруулах зэрэг онцлогт тохируулан орчуулж байгаа явдал юм. Тухайлбал, Өвчингүй бол жаргал, өргүй бол баян /病则福, 无连债则福/, “Сүсэг байвал бурхан холгүй, сүх байвал түлээ холгүй” /虔诚不怕佛祖远, 有斧不愁没紫烧/, “Хүний газрын бурхнаас, өөрийн нутгийн чөтгөр дээр” /他乡之佛不如自家之鬼好/, “Далай ч бас усаар дутдаг юм, дагина ч бас эрээр дутдаг юм /大海也缺盐之时, 仙女也有无夫之苦/, “Хэл хавтгай, хэрэг бөөрөнхий /舌是扁的, 话是圆的/, “Буянгүй хүний идэх нь их, бодолгүй хүний унтах нь их /无福之人饭量大, 无忧之人磕睡多/, “Мөнгө цагаан, нүд улаан /银是白的, 眼是红的/, арван тавны сар сайхан, атар газрын цэцэг сайхан, аав ээжийн сургаал сайхан /十五的月亮是——漂亮, 原野的花朵是——美丽, 父母的教训是——美好/, унтах гэдэг үхэхийн хагас, унгах гэдэг баахын хагас, уурлах гэдэг

<sup>20</sup> Д.Дашдаваа Орчуулах эрдэм., Улсын хэвлэлийн газар. УБ хот, 1987 он., Хуу-8

<sup>21</sup> Н.Нансалмаа. Үгийн сан судлал. УБ хот. 2013 он

<sup>22</sup> Аким, Г. (1984). Орчуулгын санг уудлахад. Улаанбаатар., хуу-23

<sup>23</sup> Төмөрцэрэн, Ж. (1974). Монгол хэлний үгийн сангийн судлал. УБ.

галзуурахын хагас /睡觉是死亡的半，放屁是大便的半，生气是发狂的半/, далайд усч сайн, нойронд сэргэг сайн, номд мэргэн сайн /水手对海好，经醒对睡好，明智对书好/, “Үгүй гэгч үгний мухар, үхнэ гэгч амины мухар /穷仍语之来，死仍命之来/ гэх мэт.

Ийнхүү монгол хэлний хэлцийг хятад хэлнээ зохиомжлон орчуулах явцад үг өгүүлбэр нь хялбар, товч авсаархан байхын зэрэгцээ хятад яруу найргийн үгийн тоо хязгаарлах, зэрэгцүүлэл хэрэглэх, айзам хэмнэл тааруулах зэргийг анхаарч орчуулах нь чухал бөгөөд хэлбэр нь гол санаандаа үйлчилж байх ёстой. Уран дүрслэл, яруу найргийг хэт анхаарваас утга өөрчлөгдөх буюу уг орчуулга төгс орчуулга болж чадахгүйд хүрнэ. Гагцхүү агуулга болоод утга санааг зөв оновчтой байлгахыг нэн тэргүүнд тавих нь зөв юм. Энэ аргаар монгол хэлний ардын аман зохиол, зүйр цэцэн үг, сургаал үг, оньсого зэргийг хятад хэлнээ орчуулахад өргөн ашиглаж болно.

## 2. Тэнцүү утгатай хэлц үгээр дүйцүүлэн орчуулах арга

Судалгааны явцад нийгэм улс төр, шинжлэх ухаан, аж ахуйн сэдэвтэй хэлц үгийг орчуулахад тэдгээр зохиолын үзэл санаа агуулгыг зөв оновчтой, товч тодорхой гаргахыг чухалчилдаг тул заримдаа хятад хэлний тэнцүү утгатай хэлц үгээр дүйцүүлэн орчуулах нь нэн тохиромжтой болох нь ажиглагдав. Энэ аргаар орчуулсан хэлцийг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

### а) Ижил дүрслэлтэй, тэнцүү утгатай хэлцээр дүйцүүлэн орчуулах.

Ийм аргаар орчуулагдах монгол хэлний хэлц цөөнгүй тааралдаж байна. Өөрөөр хэлбэл, дүрслэл болон утга нь яв цав таарах хэлцүүд 2 хэлнээ байгаа тул үүнийг бид орлуулан дүйлгэж орчуулж болно. Үүнээс бид хөрш зэргэлдээ орших 2 орны хэл соёлын харилцан нөлөөлөл оршсоор байгааг үгүйсгэх аргагүй хэмээн ажиглаж болно. Тухайлбал, “Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа гэгчээр би түүнийг бага байхаас нь л мэдэх юм.”<sup>24</sup> гэсэн өгүүлбэрт “Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа” хэлцийг хятад хэлний “人看起效，马看蹄走”, “Сайн эм бэргэн мэт, сайн бэргэн эх мэт”/良妻如嫂，老嫂比母/, “Саваагүй нохой саранд хуцна” /狂犬吠白/, “Эдгэвэл эмчээ мартах, эрд очвол ээж ааваа мартах” /好了疮疤忘了疼，娶了媳妇忘了娘/, “Эр хүн нэг үгтэй, эр морь нэг ташууртай” /君子一言，驷马难追/, “Сонссон мэргэнээс үзсэн тэнэг дээр” /耳听为虚，眼见为实/, “Зуу сонсохоор нэг үз.” /百闻不如一见/ гэх мэт. Түүнчлэн “Дорж нэгэнт гучин хэд насалсан боловч гон бие гозон толгой явсаар байна.”<sup>25</sup> Үүнийг хятад хэлнээ “道尔吉已经三十多岁了，但到现在为止仍过着身单影只的单身生活。” гэж буулгавал “Гон бие гозон толгой”-г “身单影只” гэдэгтэй утга яв цав тохирч байна. Мөн “Оргих гал өөдөө, урсах ус уруугаа” гэгчээр хэн хүний хийморь дэгжин хөгжиж бадрахыг хүсэхгүй байх вэ дээ.”<sup>26</sup> гэсэн өгүүлбэрт “Оргих гал өөдөө, урсах ус уруугаа”-г хятад хэлний “水往低处流，人高处走”-тай утга дүрслэл нь яв цав нийцэж байгаа тул дүйцүүлэн орчуулж болно.

### б) Дүрслэл нь ялгаатай ч тэнцүү утгатай хэлцээр дүйцүүлэн орчуулах.

Энэ аргаар хэлцийг орчуулахад тухайн хэлцийн утга санаа яв цав таарах хэдий ч монгол, хятад үндэстний соёл сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзэлтэй холбоотойгоор дүрслэл зүйрлэлүүд нь өөр өөр байх бөгөөд түүнийг дүйцүүлэн орчуулах нь орчуулагчийн чадамжаас ихээхэн шалтгаална. Тухайлбал, “Ямар ч хэрэг явдлыг хэлэхдээ дээр нь дэл, доор нь сүүл нэмээд тун ч сонирхолтой болгочих юм.”<sup>27</sup> гэсэн өгүүлбэрт “Дээр нь дэл, доор нь сүүл нэмэх” гэдэг хэлцийг хятад хэлнээ “添枝加叶”-тэй дүйн орчуулж болно.

Ийнхүү утга санаа бүрэн дүйвч дүрслэл зүйрлэл нь нь зөрүүтэй байгаагаас харвал монгол, хятад 2 ард түмний ахуйд зохицсон дүрслэлийг илтгэхийн сацуу тухайн улс үндэстний соёл

<sup>24</sup> Ч.Лодойдамба. Тунгалаг тамир романы хэсгээс

<sup>25</sup> Ч.Лодойдамба. Тунгалаг тамир романы хэсгээс

<sup>26</sup> Ч.Лодойдамба. Тунгалаг тамир романы хэсгээс

<sup>27</sup> Ч.Лодойдамба. Тунгалаг тамир романы хэсгээс

сэтгэлгээний онцлогийг илтгэж байна. Өөрөөр хэлбэл, Монголчууд нь өдөр тутамд эрхэлдэг мал ахуйтайгаа холбогдсон буюу “дэл, сүүл”-ийг ашигласан байхад хятад хэлнээ “мөчир, навч”-тай дүрслэн илэрхийлсэн байна. Энэ мэт жишээг дурдвал, “Хүний гараар **могой** бариулах”-借刀杀人 /хятад: **Хутга** зээлээд хүн алах/, “Нэг сумаар хоёр **туулай** буудах” -一箭双雕 /хятад: **Нэг сумаар 2 бүргэд агнах**/, “**Тай** газар доороос, **гахай** модон дотроос” -天有不测风云, 人有朝夕祸福 /хятад: **Тэнгэрт гэнэтийн үүл бүрхэх, хүнд гэнэт азгүйдэл тохиох**/, “**аз** таарах”-机不可失, 时不再来 /хятад: **Боломж ганц удаа тохиох**/, “**Хүн** хэдий ухаантай ч хэлэхээс нааш мэдэхгүй, **цаас** хэдийн нимгэн ч чичихээс нааш цоорохгүй” -灯不挑亮, 话不说不明 /хятад: **Дэнлүү асахгүй аваас гэрэлтэхгүй, үг хэлэхгүй аваас тодорхой бус**/, “Дуутай **тэнгэр** бороогүй, цуутай **хүүхэн** хуримгүй” -干打雷不下雨 /хятад: **Бороо үгүй аваас аянга үгүй**./ “**Бөөсөнд** хутга дайх-杀鸡用牛刀 /хятад: **Тахиа алахад үхэр хутга**/, “**Арван хуруу** тэгш”-十全十美 /хятад: **10-уулаа тэгш, төгс сайхан**/, долоо дордож нэг сэхэх-九死一生 /хятад: **9 үхэж 1 төрөх**/ гэх мэт.

### с) Дүрслэлгүй бүтсэн тэнцүү утгатай хэлцээр дүйцүүлэн орчуулах

Монгол хэлний зарим зүйрлэл дүрслэлгүй нийлэмж утга санааг хятад хэлнээ орчуулахдаа илэрхийлэх утга санааг илүү тод товойлгож чадахуйц хэлц үгээр /成语/ дүйцүүлэн орчуулах нь зохистой. Тухайлбал, “Би чамд **сайхан сэтгэлээр** хандаж байхад харин чи надад уурлаж байна уу”<sup>28</sup> Үүнийг хятад хэлнээ “我在**好心好意**地给你指出, 你却生我的气。” Мөн “Чи **олиц солиц** юугаа яриад байгаа юм бэ? ”<sup>29</sup> хэмээснийг хятад хэлнээ “你在**胡言乱语**些什么?” гэх мэт зүйрлэл дүрслэлгүй нийлэмжүүдийг утга дүйцэх хэлцээр /成语/ дүйн орчуулсан жишээг дурдвал, “Сүүдрээ үзэж шүүрс алдах”-顾影自怜, “Хорвоод хосгүй”-举世无双, “Шидээ үзүүлнэ гээд шившгээ үзүүлэх”-弄巧成拙, “Хоосон сүрээс хорин хүн айх”-无兵之, “Арга мухардах”-陷入绝境, **гар** хоосон-两手空空, ичих нүүрээ элгэндээ наах-丢面子, гар хумхих-罢手, үлбэгэр, сул дорой, хийморьгүй- 无精打采, аажуу тайван, уужуу тайван- 慢条斯理, зуун задгай, жаран хагархай- 乱七八糟, гэх мэт.

### 3. Утгачлан орчуулах арга:

Энэ нь дээр дурдсан хоёр аргаас арай өөр арга бөгөөд хэлц үгийн бүтэц, дүрслэл, найруулга зэргийг голлон анхаарах биш харин тухайн хэлцийн үндсэн утгыг үндэслэн утгачлан орчуулах явдал юм. Утгачлан орчуулахад орчуулга нь маш амьдлаг болох бөгөөд тухайн хэлц үгийн утгыг сайн ойлгож зохистой үгээр орчуулдаг тул утга нь бүрэн төгс гардаг. Тухайлбал, “**Ажилсаг хүн амаргүй, жороо морь жаргалгүй** гэгчээр Дорж бүтэн өдрийн турш ажилдаа яарсаар л байдаг.”<sup>30</sup> - “道尔吉天到晚忙于工作, 真是**个闲不住的人**。”, “Урт хормой хөл ороох, урт хэл хүзүү ороох” /进谗者害自己/, “Хэл ам сугалах” /问长问短/, нүүр алдахгүй /两面讨好/, “Амташсан хэрээ арван гурав эргэх” /越吃越想吃/, “Дээгүүр зантай” /自高自大/ гэх мэт.

Энэ аргаар монгол хэлний хэлцийг хятад хэлнээ орчуулахад юуны өмнө орчуулагчаас ихээхэн ур чадвар шаардах ба монгол, хятад үндэстний соёл, сэтгэлгээг сайтар нэвтэрсэн байхыг шаардана. Тэрээр хятад хэлний хэлц хэллэг нь ихэвчлэн үлгэр домог, түүхэн үйл явдлаас үүсэлтэй байдаг тул энэ талын өргөн мэдлэг, мэдээлэлтэй байхыг шаардана. Учир нь утгачлан орчуулах үед орчуулагдан буух хэлцийн үндсэн утгад нийцүүлж байж зөв оновчтой орчуулга болно.

<sup>28</sup> Ч.Лодойдамба. Тунгалаг тамир романы хэсгээс

<sup>29</sup> Ч.Лодойдамба. Тунгалаг тамир романы хэсгээс

<sup>30</sup> Ч.Лодойдамба. Тунгалаг тамир романы хэсгээс

## ДҮГНЭЛТ:

Энэ удаад бид монгол хэлний 100 гаруй хэлц үгийг түүвэрлэн авч хятад хэлнээ буулгах явцад орчуулгын ямар аргыг сонгон ашиглавал тухайн орчуулга оновчтой, амьдлаг болох эсэхийг харьцуулан судалсан.

- ✚ Монгол, хятад хэлний хэлц үгс нь хэлзүйн хувьд хэлбэржиж бэхэжсэн, тогтмол бүрдүүлбэртэй, бүхэлдээ нэгэн өвөрмөц утгыг илэрхийлэх бөгөөд тухайн ард түмнийхээ соёл сэтгэлгээний тусгал болдог тул эдгээрийг зөв зохистой, “тэнцвэртэй орчуулах” нь зүйтэй. Хэлц үгийг орчуулах олон арга байдаг хэдий ч судалгааны явцад тухайн үндэстний соёл сэтгэлгээг таньж мэдээд “ижил сав”-ны утгаар нь дүйцүүлэн орчуулсан нь түгээмэл ажиглагдаж байна.
- ✚ Судалгааны явцад монгол хэлний хэлцийг хятад хэлнээ орчуулахад сургалт практикт өргөн ашиглаж болохуйц зохиомжлон, дүйцүүлэн, утгачлан орчуулах аргууд өргөн ажиглагдаж байв. Эдгээрээс дүрслэл нь ялгаатай ч тэнцүү утгатай хэлцээр дүйцүүлэн орчуулах арга нь хэлц үгийг нөгөө хэлнээ буулгахад нэн тохиромжтой арга юм гэж үзэв.
- ✚ Монгол, хятад 2 үндэстнүүд хөрш зэргэлдээ зэрэгцэн оршиж нийгэм эдийн засгийн хувьд харилцан хамааралтай байдаг ч хэл соёл, ёс заншил нь өөр тул 2 хэлний хэлцэд шингэсэн ертөнцийг үзэх үзэл, дүрслэл нь ч харилцан адилгүй байгааг “дүрслэл нь ялгаатай ч тэнцүү утгатай хэлц”-ээр дүйцүүлсэн орчуулах нь зүйтэй. Тухайлбал, усан толгой-猪腦子/*гахайн тархи*/, нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино.-一传十, 十传百/1 нь арав болж, 10 нь зуу болох/, эр үхэр сааж, элгэн тараг бүрэх-缘木求鱼/модонд авирч загас гуйх/
- ✚ Орчуулахад дан ганц үгийн утгыг мэдэх нь хангалттай биш. Аль ч хэлний хэлц хэллэгийг орчуулах явцад бид харилцан үл давхцах соёлын ойлголтуудыг сайтар судалж мэдсэн байх шаардлагатай. Мэдлэг дутсанаас хэт “махчлан орчуулах” нь хэлц үгийн мөн чанарыг алдагдуулж нууцлаг далд, уран яруу утга санааг нь бүрхэгдүүлж харилцаанд үл ойлголцлыг бий болгох муу талтай. Иймд монгол хэлний хэлц хэллэгийг хятад хэлнээ орчуулахдаа 2 үндэстний түүх, хэл соёл, ёс заншил, аж төрөх онцлогийн талаар зохих мэдлэгтэй байх нь чухал гэж үзэв.

## НОМЗҮЙ

1. Базаррагчаа, Ц. (2002). *Монгол хятад хэлний орчуулгазүй*. Улаанбаатар.
2. Бадамдорж, Д. (2001). *Монгол хэлний утга судлал*. Улаанбаатар.
3. Дашдорж, Ө. (2013). *汉语熟语词典 / Хятад, Монгол хэлний хэлц үгийн толь*. Улаанбаатар: Артсофт ХХК.
4. Төмөрцэрэн, Ж. (1974). *Монгол хэлний үгийн сангийн судлал*. Улаанбаатар.
5. Аким, Г. (1984). *Орчуулгын санг уудлахад*. Улаанбаатар.
6. Аким, Г. (1982). *Монгол өвөрмөц хэлцийн товч тайлбар толь*. Улаанбаатар.
7. Лодойдамба, Ч. (1962). *Тунгалаг тамир роман*. Улаанбаатар



## СОШИАЛ МЕДИА ОРЧИНД ХЭРЭГЛЭГДЭЖ БУЙ АНГЛИ ХЭЛНИЙ ЯРИАНЫ ҮГСИЙН БҮТЭЦ БА ОРЧУУЛГЫН ДҮЙЦЭЛ

Т. Мягмарсүрэн<sup>31</sup>

**Abstract:** *The purpose of this study is to investigate English words used in social media and analyze how their meanings are translated into Mongolian in terms of equivalence. The research data consist of 93 words collected from Facebook, Instagram, and TikTok, formed through clipping, blending, and back-formation. The study employs a mixed-method approach combining qualitative and quantitative analysis. The selected words are analyzed based on their word-formation processes, translation strategies, and types of equivalence. The theoretical framework of the study is based on formal and dynamic equivalence, semantic and communicative translation, as well as classifications of equivalence. The findings reveal that 88% of clipping-based words show partial equivalence, while 61% of blending words demonstrate partial equivalence and 29% show zero equivalence. In contrast, 50% of back-formation words exhibit full equivalence in translation. These results indicate that social media expressions are rarely translated through direct equivalence; instead, they rely on meaning, usage, and cultural context. Therefore, the study concludes that translation in social media is not form-based but predominantly dynamic and communicative in nature.*

**Түлхүүр үг:** *Үг бүтэх арга, орчуулгын утга, дүйцэл, дүйцлийн төрөл*

### СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Хэл тогтмол хувьсаж байдаг нь хэлний өөрийнх нь онцлог юм. Сүүлийн үед цахим орчинд англи хэлний ярианы хэл эрчимтэй хөгжиж, шинэ үг хэллэгүүд өргөн хэрэглэгдэх болсон. Ийнхүү сошиал орчинд шинээр бүтэж байгаа англи үг, хэллэгийг судлаачид ажиглан судалсаар байна. Ерөөс хэлний хувьсалд шинэ үг бүтэх процесс нь ихээхэн чухал юм (Aitchison, 2003). Англи хэлний ярианы хэлэнд шинээр үүсэж идэвхтэй хэрэглэгдэж байгаа үгс үеэр таслах /clipping/, үе нийлүүлэх /blending/, үгсийн аймаг шилжих /conversion/ зэрэг аргаар гол төлөв бүтэж байгаагийн зэрэгцээ үсгээр товчлох /acronyms/, үг давтах /reduplication/, үе салгах буюу урвуу үг бүтэх /backformation/ зэрэг аргаар бүтэх нь бас элбэг байна. Эдгээр үгс нь уламжлалт үг нийлэх /compounding/ дагаврын аргаар үүсэхээсээ илүүтэйгээр үгийг товчлох, нийлүүлэх, задлах гэсэн аргаар ихэвчлэн үүсэж байна. Энэ нь орчин үеийн цахим орчны англи хэлний үгс бүтцийн хувьд өмнөх өмнөхөөсөө илүү “жижгэрч” байгааг харуулж байна (Trigás Pereira, 2021). Иймээс ийм замаар үүсэж байгаа англи үгсийг монгол хэлэнд хэрхэн орчуулан буулгаж байгааг судлах нь зүйтэй. Ингэж аль нэгэн хураангуйлах арга замаар үүсэн бий болж байгаа англи хэлний үгсийг зөв танин мэдэж монгол хэлээр оновчтой орчуулахын тулд уг үг хэллэгийн бүтэц бүрэлдэхүүнийг мэдэж байх шаардлагатай юм. Үгийг үндсээр нь зөв таних нь оновчтой орчуулга хийхийн нэгэн үндэс болох тул үг бүтэх аргыг судлах нь сайн орчуулга хийхэд чухал нөлөөтэй (Өлзий, 2019).

<sup>31</sup>Доктор, дэд профессор, ОУУБИС, Англи хэлний тэнхим

Судлаачид англи хэлний үг бүтэх арга болон орчуулгын асуудлыг олон талаас нь авч үзсээр байна. Тухайлбал David Crystal (2001) интернэт орчны хэлний өөрчлөлтийг судалж, шинэ үгсийн үүсэлд технологи гол нөлөөтэйг онцлон судалсан бол Jean Aitchison (2003) хэлний хувьсалд шинэ үг бүтэх процесс чухал болохыг тэмдэглэжээ. Судлаач Ц.Өлзий (2019) үгийг буруу таньж шууд орчуулга хийвэл орчуулга алдаатай болох сөрөг нөлөөтэй тул үг бүтэх аргыг судлах нь чухал болох талаарх саналаа дэвшүүлжээ. Жишээлбэл: англи хэлний *brunch* гэдэг үг нь *breakfast + lunch* гэсэн хоёр тусдаа үгээс нийлж бүтсэн үг бөгөөд үүнийг шууд галиглан *бранч* гэж орчуулбал утга нь ойлгогдохгүй, *өдрийн хоол /lunch/* гэж дангаар нь ойлговол өдрийн хоол нь 10-14 цагийн хооронд иддэг хоол болчихно, *өглөөний цай /breakfast/*-тай адилтгаж арай боломгүй, бас зууш, хөнгөн хоол гээд андуурчаж бас болохгүй. Тиймээс уг үгийн бүтцийг нь анзаараад үзвэл өглөөний цай ба өдрийн хоолны дундах хоол буюу *оройтож иддэг өглөөний хоол* гэж зөв ойлгох юм. Энэ мэт хураангуйлсан хэлбэрээр бүтсэн англи үгсийг сошиал медиа орчинд хэрхэн орчуулан буулгаж байгаа талаарх судалгаа ховор байна. Иймд энэхүү судалгааны ажлаар дээрх үг бүтэх аргаар шинээр үүсэн бий болж байгаа олон аргууд дундаас үгийн үеийг хувиргаж, дагавар нэмэх, хасах замаар үүсэж байгаа үгс монгол хэлэнд ямар бүтэцтэй болж утга нь хэрхэн орчуулгын дүйцэл ханган ямар арга стратегиар орчуулагдаж байгааг тодорхойлохоор зорив. Тус зорилгын дагуу дараах хоёр зорилтыг тавьсан.

1. Үеэр таслах (clipping), үе нийлүүлэх (blending), үе салгах (backformation) үг бүтэх аргуудыг судлах
2. Эдгээр аргаар бүтсэн үгсийн орчуулгын дүйцлийг үнэлэх

### Сошиал орчны үгсийн нийтлэг үг бүтэх арга

Үеэр таслах (Clipping) арга: Англи хэлний ярианы хэлэнд үг бүтэх үйл явц нь хэлний хөгжлийн чухал хэсэг бөгөөд нийгэм, технологийн өөрчлөлттэй шууд холбоотой (Yule, 2010). Үеэр таслах аргаар бүтсэн үг нь ярианы хэлэнд хялбар, хүмүүсийн хоорондоо хурдан харилцах хэрэгцээнээс үүсдэг. Тиймээс интернэт орчинд товчилсон хэлбэрээр бүтсэн үгс давамгайл хэрэглэгдэж байна (Crystal, 2001). Энэхүү үг бүтэх арга нь үгийн нэг хэсгийг тасалж богиносгосон байдлаар шинэ үг үүсгэдэг. Жишээ нь:

- *advertisement* → *ad* (*зар*)
- *brother* → *bro* (*найз*)

Үе нийлүүлэх (Blending) арга: Энэ арга нь шинэ ойлголтыг товч бөгөөд бүтээлч байдлаар илэрхийлэх хэлний механизм юм. Jean Aitchison (2003) үе нийлүүлэх аргаар үг бүтэх нь хэлний хувьслын идэвхтэй процесс юм гэж үзсэн. Энэ нь хоёр ба түүнээс дээш үгийн үеүүдийг нийлүүлж нэг шинэ үг үүсгэдэг. Тиймээс энэ нь өөр өөр утгатай үгнүүдийн үеийг нийлүүлэх замаар шинэ нэр томьёо үүсгэж байгаа нэг хэлбэр юм. Жишээ нь:

- *Glamping* → *Glam + Camping* (*орчин үеийн тохилог бөгөөд техник технологи бүхий амралтын газар*)
- *Webinar* → *Web + Seminar* (*цахимаар хийдэг семинар, хэлэлцүүлэг*)

Үе салгах буюу урвуу үг бүтэх (Backformation) арга: Энэ аргаар үг бүтэхдээ үгэнд дагавар нэмж залгахгүй, эсрэгээрээ тухайн эх үгэнд залгасан байсан дагаврыг нь хасдаг. Ингэснээр өмнөхөөсөө уг үг нь илүү богино, морфологийн хувьд илүү энгийн бүтэцтэй шинэ үг болж үүсдэг (Nadezda, 2013). Жишээ нь:

- *Commentator* → *Comment*. “*Commentator*”-ын “*ator*” дагавар хасагдаж “*Comment*” гэсэн үг үүссэн. (“*Comment this post!*” → “*Энэ постод сэтгэгдэл бичээрэй!*”)
- *Babysitter* → *Babysit*. “*Babysitter*” (хүүхэд асрагч) үгээс “*-er*” дагавар хасагдаж “*babysit*” (хүүхэд харах) гэсэн үг үүсжээ.

## ОРЧУУЛГЫН ДҮЙЦЭЛ

Орчуулгын хамгийн гол асуудал бол язгуур (SL) ба зорилтот (TL) хэл хоорондын дүйцэл (equivalence)-ийг хангах явдал юм. Энэ ойлголтыг системтэй хөгжүүлсэн гол судлаач бол Южийн Найда юм. Тэрээр орчуулгын онолд формал ба динамик дүйцэл гэсэн орчуулгын хоёр дүйцлийн ангиллыг гаргаж иржээ.

Формал дүйцэл (formal equivalence) нь эх текстийн хэлзүйн бүтэц, үгсийн дарааллыг барьж тухайн үгийг үгчилсэн аргаар орчуулах тул утга нь зорилтот хэлэндээ ойролцоо гарна.

Жишээ нь: *information* → *мэдээлэл*

Динамик дүйцэл (dynamic equivalence) нь тухайн үгийг орчуулахдаа утгыг нь хадгалахыг зорилгоо болгохын зэрэгцээ уншигчид үзүүлэх нөлөөг нь давхар адилхан байлгахыг хичээдэг. Энэ дүйцлийн гол зарчим нь язгуур эхийн үгийн утга нь зорилтот хэлэнд хамгийн ойролцоо дүйцлийг (closest natural equivalent) хангаж орчуулах юм. Ингэснээр зорилтот хэлний уншигчид тухайн үгийн утгыг эх уншигчидтай адилхан хүлээн авч ойлгоно.

Жишээ нь: *What's up?* → *Юу байна?* (Хэрвээ үгчилж орчуулбал “*Юу дээшээ байна вэ?*” гэсэн утгатай болж утга нь гажна.)

Найда (1964) дүйцэл бол тухайн үгийн утга зорилтот хэлэндээ “яг адил” (exact equivalence) буух боломжгүй бөгөөд утга нь ойролцоо л бууна гэж тэмдэглэжээ. Утгын дүйцэл нь ийнхүү яг бүрэн ижил нөлөө бий болгох боломжгүй гэдэг нь соёл, цаг хугацаа, орчин өөр өөр байдагт оршино (Alrymayh, 2024).

Петер Ньюмарк (1981) орчуулгын дүйцэлтэй холбоотойгоор семантик (semantic) ба коммуниктив (communicative) орчуулга гэсэн 2 нэр томъёог бий болгосон. Тэрээр семантик орчуулга нь язгуур хэлний утга зүйн болон өгүүлбэр зүйн бүтцийн хэм хэмжээг сахиж язгуур эхийн хам сэдвийн утгыг зорилтот хэлэнд аль болох ойролцоо дамжуулах оролдлогыг хийдэг бол коммуниктив орчуулга нь эх текстийг уншсан уншигчдад ойлгогдож байгаатай адилхан утгыг зорилтот хэлний уншигчдад бий болгох оролдлогыг хийдэг гэжээ. Тиймээс гол ялгаа нь семантик орчуулга нь утга, бүтцийг чухалчилж язгуур эх (SL)-д илүү суурилах ба үгчлэх гэх мэт шууд аргаар уг үг хэллэгийг орчуулдаг. Коммуниктив орчуулга нь уншигчид ойлгомжтой байлгахыг зорьж зорилтот хэл (TL)-д тулгуурлан чөлөөт орчуулгын аргаар үгийг орчуулдаг бөгөөд үүгээрээ динамик дүйцэлтэй төстэй. Жишээ нь:

Семантик орчуулга: “*She is a bookworm*”. Монгол орчуулга нь “*Тэр номын хорхой.*” Энд *bookworm* гэсэн үгийг шууд утгаар нь орчуулж эх текстэд ойр, соёлын утга нь бүрэн гараагүй байна. “*Time is money.*” Монголоор “*Цаг бол мөнгө.*” Англи өгүүлбэрийн бүтэц, хэлбэр 100% хадгалагдсан, үгчилсэн орчуулга. Иймээс семантик орчуулга нь формал дүйцэлтэй төстэй байна.

Коммуниктив орчуулга: “*She is a bookworm*”. Монголоор “*Тэр их ном унидаг хүн.*” гэж орчуулсан. *Bookworm* гэсэн үгийн утгыг нь тайлбарлан орчуулж *хорхой* гэдэг үгийг орхисноор утга нь уншигчдад ойлгомжтой болж, соёлын ялгаа нь арилсан байна. “*This is lit!*” гэсэн тик ток-д хэрэглэгддэг нэгэн өгүүлбэр монголоор “*Ёстой гоё байна!*” гэсэн утгыг илэрхийлж байна. Хэрвээ “*lit*” гэсэн үгийг шууд утгаар нь орчуулбал “асаалттай” гэж орчуулагдана, гэхдээ утгыг нь чухалчлан орчуулжээ. Энэ нь социал медиад хэрэглэгддэг үг хэллэг коммуниктив орчуулгын дүйцлийг ханган орчуулагдаж байгааг харуулж байна.

Орчин үеийн орчуулгын онолын гол төлөөлөгчдийн нэг Рум (2014) нь орчуулгын дүйцлийг “эн тэнцүү үнэ цэнэ” гэсэн үзэл санаагаар тайлбарласан байх бөгөөд тэрээр нэг хэл дээр хэлсэн зүйлийг нөгөө зорилтот хэл рүү орчуулах үед тэр хэлсэн зүйлийнх нь утга нь ижил буюу адил үнэ цэнтэй байх юм гэж үзжээ. Энэ үнэ цэнэ нь түвшин, хэлбэр, үүрэг функц, эсвэл эдгээрийн хоорондох аль нэг тал дээр илэрч болно гэж үздэг. Иймээс Пим “дүйцлийн парадигм”-ыг хоёр “дэд парадигм”-д хуваасан.

**Натурал дүйцэл** (natural equivalence): Пимийн гаргасан дүйцлийн эхнийх нь “Эн тэнцүү үнэ цэнтэй зүйлс нь хэн нэгэн орчуулга хийхээс өмнө дүйцэл нь байдаг” гэсэн үзэл санаа бөгөөд тэрээр үүнийгээ бодит дүйцэл гэж нэрлэсэн. Энэ нь орчуулга хийхээс өмнө аль хэдийн ижил үнэ цэнтэй, бэлэн дүйцэл А болон Б хэлний аль алинд нь байж байдаг гэсэн санаа юм. Өөрөөр хэлбэл хоёр хэлэнд ижил утга, ижил ойлголттой шууд таарах үг хэллэг угаас аль алинд нь байгаа тул орчуулагч “бодож зохиох” биш, шууд бэлэн дүйцлийг сонгон орчуулдаг гэсэн үг юм.

Жишээ нь: Англи хэлний *water* гэсэн үг монгол хэлний *ус* гэсэн үгтэй утга дүйцнэ. Энэ хоёр үгийн утга нь ижил, хэрэглээ нь ижил. Тиймээс Пимийн аль аль хэлэндээ угаасаа өмнө нь байсан гэж тайлбарлаад байгаа энэхүү мөн чанарын дүйцлийн учир нь нэгд, энэ дүйцэл нь орчуулагчийн шийдвэрээс хамаарахгүй, хоёрт хэл бүрд угаасаа байсан, гуравт бараг бүх хүн ижил орчуулна гэдэгт санаа нь байгаа ажээ.

**Чиглэлийн дүйцэл** (directional equivalence): Энэ бол натурал дүйцлийн нөгөө төрөл нь бөгөөд дүйцлийг өөр нэг өнцгөөс тайлбарласан буюу “Нэг чиглэлд орчуулж дүйцэл бий болгох нь эсрэг чиглэлд орчуулахад яг ижил дүйцэл үүснэ гэсэн баталгаа байхгүй, өөрөөр хэлбэл энэ нь асимметрик (тэгш бус харилцаа) юм” гэжээ. Пим үүнийгээ чиглэлийн дүйцэл гэж нэрлэжээ. Өөрөөр хэлбэл энэ нь А хэлнээс Б хэлэнд орчуулсан үгийг буцаагаад А хэлэнд орчуулахад яг адил дүйцэл үүсэхгүй гэсэн үг юм.

Жишээ нь: Англи хэлний “*home*” гэдэг үгийг Монгол хэл рүү “*гэр*” гэж орчуулж болно. Гэхдээ “*гэр*” гэдгийг буцаагаад англи руу орчуулахад “*home*”, “*house*”, “*ger*” гэх мэт олон хувилбар гарч ирнэ. Тиймээс энэ харилцаа нь тэгш биш, чиглэлээсээ хамаарч өөрчлөгдөж байна гэсэн санаа юм.

Рум (2014) мөн Otto Kade (1968)-ийн орчуулгын дүйцлийг ангилсан ангиллын талаар өөрийн судалгаандаа авч үзжээ. Кэйд үг болон өгүүлбэрийн түвшинд дүйцлийг дараах дөрвөн төрөл буюу загвараар ангилж болно гэж үзсэн байна. Эдгээр нь:

**Нэг-нэгийн дүйцэл** (One-to-one equivalence): Эх хэл дээрх нэг үг, нэр томьёо нь зорилтот хэл дээр яг нэг ижил утгатай үгээр илэрхийлэгдэнэ. Утга, хэрэглээ бараг бүрэн давхцна. Энэ дүйцлийн онцлог нь ихэвчлэн шинжлэх ухаан, техникийн нэр томьёог орчуулахад тохиромжтой, буцааж орчуулахад утга нь өөрчлөгдөхгүй хэвээрээ байдаг оршино.

Жишээ нь: “*This app collects your data.*” гэсэн фэйсбүүкийн пост. Энэ англи өгүүлбэрийг монголоор “*Энэ апп таны мэдээллийг цуглуулдаг.*” гэж орчуулна. Энэ өгүүлбэрт орсон *data* гэсэн англи үг нь *мэдээлэл* гэсэн монгол үгтэй утгын хувьд шууд дүйцэж байна. Социал медиад ийм хураангуйлах аргаар бүтсэн үгс ихэвчлэн технологи, албан ёсны мэдээлэлд илэрдэг.

**Нэг-олон / олон-нэгийн дүйцэл** (‘One-to-several’ or ‘several-to-one’ equivalence): Энэ нь эх хэл дээрх нэг нэгж нь зорилтот хэл дээр олон хувилбартай дүйцэх, эсвэл эсрэгээрээ зорилтот хэлний нэг нэгж нь эх хэл дээр олон хувилбартай дүйцэх тохиолдол юм. Нэг хэлний нэг үг нь нөгөө хэлэндээ олон утга эсвэл олон хувилбартай байна гэсэн үг юм.

Жишээ нь: “*I’m so down for this!*” гэсэн тик токын нэгэн сэтгэгдэл байна. Үүнийг монголоор 1/ “*Би үүнд бэлэн байна.*”, 1/ “*Би зөвшөөрч байна.*”, 3/ “*Надад таалагдлаа.*” гэж орчуулж болно. Энэ өгүүлбэрт орсон *down* гэдэг үг олон утгатай. Алинаар нь орчуулах вэ гэдэг нь тухайн ярианы хам сэдвээс хамаарна. Тиймээс энэ орчуулга нь ойролцоо дүйцлийг хангаж байгаа бөгөөд орчуулагч нь өөрөө сонголтоо хийх шаардлагатай болно. Ийм олон салаа утгатай үгээр илэрсэн үгийг буцааж орчуулахад анхны утга нь алдагдаж болно. Үүгээрээ Найдагийн динамик дүйцэлтэй ижил агуулгатай байна.

**Хэсэгчилсэн дүйцэл** (One-to-part equivalence): Энэ нь эх хэл дээрх утгын зөвхөн нэг хэсэг нь зорилтот хэл дээр дамжиж байгаа, өөрөөр хэлбэл дүйцлийн зөвхөн нэг хэсэг нь л утгаа хадгалж байгаа тохиолдлыг хэлнэ. Өөрөөр хэлбэл А хэл дээрх утгын зөвхөн нэг хэсэг нь Б хэлэнд дамжина. Тиймээс энэ дүйцлийн онцлог нь үгийн утга бүрэн дамжихгүй бөгөөд үүнд соёлын ялгаа ихээхэн нөлөөлөх ажээ.

Жишээ нь: англи хэлний *uncle* гэсэн үгийг монголоор орчуулахад *авга* гэх үү *нагац* гэх үү гэх асуудал гарч ирнэ. Энд *uncle* гэх үгийн 2 утга гарч ирж байгаа буюу энэ үгэнд *нагац/авга* гэсэн 2 утга хоёулаа байна. Англи хэлэндээ энэ үг хүйсийн ялгаа байхгүйгээр *аав ээжийн аль алины эрэгтэй ах дүү, хамаатан садныг* ингэж нэрлэдэг. Гэтэл монгол хэлэнд *аавын талыг авга, ээжийн талын нагац* хэмээн хүйсийн хамааралгүйгээр аль тал нь уу гэдгээр нь ялгаж нэрлэдэг онцлогтой. Тиймээс энд А хэлний үгийн утга Б хэлэнд бүрэн биш гарч хэсэгчилсэн дүйцэл бий болж байгаа хэрэг юм. Түүнчлэн энд 2 хэлний соёлын ялгаа зөрүүтэй байдал хөндөгдөж соёлын утга алдагдахад хүргэж байна.

**Дүйцэлгүй ('One-to-none' or 'nil equivalence')**: А хэлний үг Б хэлэнд ерөөсөө байхгүй. Өөрөөр хэлбэл язгуур хэлний үгийн утгатай тохирохуйц үг хэллэг, ойлголт зорилтот хэлэнд огт байхгүй, ямар ч дүйцэл байхгүй байгаа тохиолдлыг “дүйцэлгүй” гэнэ.

Жишээ нь: англи хэлний *selfie* гэсэн үг хэллэгийг монгол хэлэнд зүгээр л *селфи* гэнэ. Энэ нь шинээр үүсэн бий болсон үг хэллэг бөгөөд дүйцэлгүй тохиолдол юм. Энэ үг нь монгол хэлэнд анх удаа орж байгаа, өмнө нь огт байгаагүй үг, ойлголт тул шууд зээлбэр үг болон монгол хэлэнд орж ирсэн хэрэг юм. Ийм үгсийг гол төлөв галиглах, тайлбарлах аргаар орчуулна.

Хүснэгт 1: Отто Кэйдийн дүйцлийн ангиллын харьцуулалт

Төрөл	Дүйцлийн түвшин	Онцлог
Нэг-нэгийн дүйцэл	Бүрэн	Утга нь шууд тохирно.
Нэг-олон / олон-нэгийн дүйцэл	Ойролцоо	Утга илэрхийлэхэд хам сэдэв чухал.
Хэсэгчилсэн дүйцэл	Хэсэгчилсэн	Утга нь дутуу гарна.
Дүйцэлгүй	Дүйцэлгүй	Шинэ үг, хэллэг үүснэ.

Рум (2014)-ийн үзэж байгаагаар нэг-нэгийн дүйцэл нь бодит шинжтэй бөгөөд энэ нь хоёр чиглэлд ( $A \rightarrow B$ ,  $B \rightarrow A$  хэлэнд буцааж орчуулах) адилхан дүйцэл үүсэх боломжтой харилцаа юм. Харин нэг-олон болон нэг-хэсгийн дүйцэл нь чиглэлийн дүйцлийн шинжтэй байдаг. Учир нь буцааж орчуулах үед эх хэлний анхны үг, хэллэгийг яг хэвээр нь сэргээх боломж бага байдаг. Дүйцэлгүй тохиолдол нь орчуулахад бэрхшээлтэй боловч онолын хувьд чиглэлийн дүйцэлд хамгийн ойр.

### Бүрэн ба бүрэн бус, үл дүйцлийн ангиллын онолын үндэс

Дээрх судлаачдын орчуулгын дүйцлийн талаарх онолын ойлголт, орчуулгын дүйцлийг ангилсан ангиллыг нэгтгэн тус судалгаанд дараах 3 төрлийн ангиллыг бий болгон ашиглаж байгааг Хүснэгт 2-д үзүүлье.

Хүснэгт 2. Дүйцлийн ангилал ба онолын үндэслэл

Дүйцлийн төрөл	Онолын үндэслэл
Бүрэн дүйцэл	Найда (формал дүйцэл), Ньюмарк (семантик орчуулга), Кэйд (нэг нэгийн дүйцэл), Пим (натурал дүйцэл)
Бүрэн бус дүйцэл	Найда (динамик дүйцэл), Ньюмарк (комюникэтив орчуулга), Кэйд (нэг-олон дүйцэл, хэсэгчилсэн дүйцэл, Пим (чиглэлийн дүйцэл)
Үл дүйцэл	Кэйд (дүйцэлгүй), Пим (чиглэлийн дүйцэл)

Тус ангиллыг хэрхэн эдгээр онолын ойлголтод тулгуурлан боловсруулсныг задлан тайлбарлавал язгуур хэлнээс зорилтот хэлэнд орчуулахад бүрэн дүйцэл гэдэг нь утга, бүтэц нь давхцана, буцааж орчуулахад утга алдагдахгүй орчуулагдана. Бүрэн бус дүйцлийн хувьд язгуур эхийн үгийн утгын аль нэг хэсэг дамжина, үүнд соёлын ялгаа нөлөөлөх ба голдуу тайлбарлан орчуулагдах бол үл дүйцэл нь дүйцэх үг байхгүй тул шинэ үгээр орчуулах шаардлагатай болно.

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Бүрэн ба бүрэн бус дүйцэл, үл дүйцэл гэсэн ангиллын дагуу үеэр таслах (clipping), үе нийлүүлэх (blending), үе салгах (backformation) аргуудаар бүтсэн үгсийг цахим орчноос түүвэрлэн шинжилгээ хийв.


Судалгааны хэрэглэгдэхүүн: Судалгаанд фейсбүүкийн пост, сэтгэгдэл, инстаграмын пост зургийн тайлбар, рийл, текст, тик токын видео тайлбар зэрэг эх сурвалжийг ашигласан.

Өгөгдөл цуглуулсан болон боловсруулсан арга зүй: Үеэр таслах аргаар бүтсэн 52 үг, үе нийлүүлэх аргаар бүтсэн 31 үг, үе салгах аргаар бүтсэн 10 үгийг цуглуулж морфологийн задлан шинжилгээ, харьцуулсан шинжилгээ, орчуулгын дүйцлийн шинжилгээ хийв.

## СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ


Сошиал медиа орчинд хэрэглэгдэж буй англи үгсийг судалж, монгол хэлэнд утгыг нь хэрхэн дүйцүүлэн орчуулж байгаад шинжилгээ хийх тус судалгааны үндсэн зорилгын дагуу дараах орчуулгын дүйцлийн шинжилгээ хийв. Шинжилгээг үеэр таслах, үе нийлүүлэх, үе салгах зэрэг бүтсэн арга бүрээр нь ялгаж, цуглуулсан үгсээ ангилан ямар дүйцэл хангагдан орчуулагдсаныг аналитик хэлбэрээр тайлбарлалаа.

График 1. Үеэр таслах /Clipping/ аргаар бүтсэн үгсийн орчуулгын дүйцэл



Үеэр таслах аргаар бүтсэн үгсийг монгол хэлэнд орчуулагдсан байдлыг үзвэл 88% нь бүрэн бус дүйцэл, 12% нь бүрэн дүйцэлтэй байна. Бүрэн дүйцлээр илэрсэн 6 үгийг авиачлан галиглах, үг товчлох, тайлбарлах аргаар орчуулжээ. Жишээ нь: “*Hey bro, what’s up?*” гэсэн өгүүлбэрийг “*Хөөе анд аа*” гэж орчуулсан нь ярианы хэлний сошиал медиа орчинд өргөн хэрэглэгддэг энгийн мэндчилгээний нэг хэлбэр юм. “*Hey bro, what’s up?*” гэсэн энэхүү англи өгүүлбэрийн *bro* гэсэн үг нь *brother* гэсэн үгний эхний үеийг таслан бүтсэн үг бөгөөд шууд утгаараа “*ах/эрэгтэй дүү*” гэсэн утгатай боловч бодит хэрэглээнд “*найз*”, “*анд*”, “*нөхөр*” гэсэн илүү өргөн утгаар хэрэглэгддэг. Иймээс “*bro*”-г “*анд*” гэж орчуулсан нь Найда (1964)-ийн динамик дүйцлийн зарчим юм. Учир нь язгуур хэл дээрх үгийн жинхэнэ хэрэглээний утгыг зорилготой хэлэнд ижил нөлөөтэйгөөр дамжуулжээ. Хэрвээ үүнийг шууд “*дүү минь*” эсвэл “*ах минь*” гэж орчуулбал хам сэдэвт тохирохгүй, утгын зөрүү үүснэ. Мөн энэ орчуулга нь Петер Ньюмаркын коммуниктив орчуулгад хамаарна. Учир нь өгүүлбэрийн гол зорилго нь харилцаа үүсгэж байна. Энэхүү орчуулга нь Otto Kade (1968)-ийн хэсэгчилсэн дүйцлээр орчуулагдаж харилцааны гол утга болох мэндчилгээний санааг хадгалжээ. Энэ орчуулгыг англи хэл рүү эргээд орчуулахад анхны “*Hey bro, what’s up?*” хэллэгийг бүрэн сэргэх боломжгүй байгааг Рум (2014)-ийн чиглэлийн дүйцлээр тайлбарлаж болно. Тиймээс сошиал медиа болон ярианы хэлэнд хэрэглэгддэг үе таслах аргаар бүтсэн үгсийг шууд утгаар нь орчуулахгүйгээр хэрэглээний утгад нь тулгуурлах шаардлагатайг харуулж байна. Мөн ярианы хэлний өгүүлбэрийг орчуулахдаа зарим үгийг орхих, товчилж утгыг нь алдагдуулахгүйгээр илүү ойлгомжтой орчуулж болно.

График 2. Үе нийлүүлэх аргаар бүтсэн үгсийн орчуулгын дүйцэл



Үе нийлүүлэх аргаар бүтсэн үгсийн орчуулгын 61% нь бүрэн бус дүйцэл, 29% нь үл дүйцэл, 10% нь бүрэн дүйцлээр тус тус орчуулагдсан байна. Жишээ нь: “*I get so hangry if I don't eat by noon.*” гэсэн өгүүлбэрийг “*Үд дунд хоол идэхгүй бол би өлссөнөөсөө болоод маш их уурладаг.*” гэж орчуулсан нь орчуулгын онолын хэд хэдэн хандлагатай нийцэж байна. Юуны өмнө “hangry” гэдэг үг нь *hungry* болон *angry* гэсэн хоёр үгийн нийлэмжээр бүтсэн бөгөөд монгол хэлэнд яг дүйцэх үг байхгүй. Иймээс уг үгийг шууд орчуулах боломжгүй бөгөөд утгыг задлан тайлбарлаж орчуулах шаардлага гарч байна. Энэ орчуулга нь Найда (1964)-ийн динамик дүйцлийн зарчмын дагуу язгуур хэл дээрх “hangry” гэсэн үгийн илэрхийлж буй сэтгэлзүйн байдлыг зорилтот хэлний уншигчид ойлгомжтой, адил нөлөөтэй байдлаар дамжуулсан. Өөрөөр хэлбэл, үгийг хэлбэрээр нь биш, утга ба нөлөөгөөр нь дамжуулсан байна. Мөн “hangry” гэдгийг “өлсөөд уурлах” гэж тайлбарлан орчуулснаар зорилтот хэлний уншигчид тухайн утгыг шууд ойлгох боломж бүрдсэн нь Петер Ньюмарк (1981)-ийн комюникатив онолын санааг илтгэж байгааг харуулж байна. Хэрвээ энэ үгийг шууд орчуулбал (“өлссөн-ууртай”) гэвэл ойлгомж муутай болох байв. Энэ үгийн дүйцэл нь Otto Kade (1968)-ийн хэсэгчилсэн дүйцэлд мөн хамаарч байна. Учир нь “hangry” гэдэг үгийн бүх хэлбэрийн онцлог (нэг үгээр илэрхийлэгдсэн байдал) хадгалагдаагүй боловч утга нь тайлбарлагдан орчуулагджээ. Үүнийг мөн Рум (2014)-ийн чиглэлийн дүйцэлтэй холбон тайлбарлаж болно. Өөрөөр хэлбэл, монгол орчуулгаас буцааж англи хэл рүү орчуулахад “hangry” гэдэг анхны үгийг шууд сэргээх боломжгүй. Эндээс үзэхэд сошиал медиа хэлэнд өргөн хэрэглэгдэж байгаа үе нийлүүлэх аргаар бүтсэн үгсийг орчуулахад шууд дүйцэл ховор бөгөөд утгыг тайлбарлах, уншигч төвтэй хандлага илүү үр дүнтэй болохыг харуулж байна. Иймээс орчуулга нь хэлбэрийг хадгалах бус, утгыг нөхцөлд тохируулан дамжуулах динамик үйл явц болохыг батлаж байна.

График 3. Үеэр салгах аргаар бүтсэн үгсийн орчуулгын дүйцэл



Үе салгах аргаар үг бүтсэн үгийн 20% нь үл, 30% нь бүрэн бус, 50% нь бүрэн дүйцэлтэй орчуулагджээ. Жишээ нь: “*He edited the video.*” гэсэн англи өгүүлбэрийн “*Editor*” гэсэн үгийн “-or” дагавар хасагдаж “*Edit*” гэсэн үйл үг болж үе таслах аргаар бүтжээ. Энэ өгүүлбэрийг монголоор “*Тэр бичлэгийг зассан.*” гэж орчуулсан бөгөөд “*Edit*” гэсэн үг монголоор “*засах*” гэж орчуулсан нь утгын хувьд шууд, тодорхой дүйцэж байгаа тул бүрэн дүйцэлд хамаарна. Энэ орчуулга нь Найда (1964)-ийн формал дүйцлийн онолын жишээ юм. Энэ нь язгуур хэлний үг болон зорилтот хэлний үг нь утга, үүргийн хувьд бүрэн давхцаж, нэмэлт тайлбар шаардлагагүйгээр ойлгогдож байгаагаар холбоотой. Түүнчлэн энэ нь Peter Newmark-ын семантик орчуулгын жишээ бас болно. Учир нь орчуулга нь эх үгийн утгыг ягштал хадгалсан бөгөөд хэлбэрийн хувьд ч ойролцоо бүтэцтэй байна. Otto Kade (1968)-ийн дүйцлийн ангиллаар нэг-нэг дүйцэлд хамаарна. Өөрөөр хэлбэл “*edit*” гэдэг үг нь “*засах*” гэсэн ганц тодорхой утгатай дүйцэж

байгаа юм. Үүнийг мөн Рум (2014)-ийн натурал дүйцлийн үзэл санаагаар давхар тайлбарлаж болно. Учир нь уг орчуулга нь хоёр хэлний бодит, шууд дүйцлийг илэрхийлж байна. Үе таслах аргаар үүссэн үгсийн 50% нь бүрэн дүйцэлтэй байгаа нь эдгээр үгсийн утга тодорхой, бүтэц энгийн байгаатай холбоотой байна. Харин ойролцоо болон хэсэгчилсэн дүйцэл 30%-ийг эзэлж байгаа нь зарим үг олон утгатай, эсвэл хам сэдвээс хамааралтай байгааг харуулж байна. Үл дүйцэл 20% байгаа нь соёлын болон хэрэглээний ялгаанаас үүдэлтэй. Энэ нь үе салгах аргаар бүтсэн үгс нь үеэр таслах, үе нийлүүлэх аргаар бүтсэн үгстэй харьцуулахад илүү өндөр түвшний дүйцэлтэй байдаг бөгөөд ихэвчлэн формал, семантик орчуулгын стратегиар орчуулагдаж байна.

## СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгаанаас гарсан үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Сошиал медиа хэлний үгсийн дийлэнх нь бүрэн бус (ойролцоо/хэсэгчилсэн) дүйцлээр орчуулагдаж байна. Энэ нь эдгээр үгс шинэ бөгөөд ярианы болон соёлын онцлогтой үгс тул шууд дүйцүүлэх боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна. Үе нийлүүлэх аргаар бүтсэн үгс хамгийн их үл дүйцэлтэй байгаа нь хоёр үгийн утгыг нэгтгэсэн нийлмэл ойлголтыг агуулсан үгс нь монгол хэлэнд шууд утгаар дүйцэхгүй, тайлбарлан орчуулах шаардлагыг үүсгэж байна. Үе салгах аргаар бүтсэн үгс бусдаасаа хамгийн өндөр бүрэн дүйцэлтэй байна. Энэ нь эдгээр үгс ихэвчлэн үйл үг хэлбэртэй, утга нь тодорхой, бүтэц энгийн байгаатай холбоотой. Үеэр таслах аргаар бүтсэн үгсийг орчуулахад ойролцоо дүйцэл давамгайлж байна. Учир нь үгийн хэлбэр богиноссон ч утга нь өргөжсөн, ярианы хэрэглээ давамгайлсан байдаг. Эдгээр үр дүн нь сошиал медиа орчны англи хэлний үгсийг монгол хэлэнд орчуулах үйл явц нь шууд дүйцлээс илүүтэй утга, хэрэглээ, соёлын нөхцөлд тулгуурласан динамик, коммуниктив шинжтэй процесс болохыг нотлон харуулж байна.

Судалгааны үр дүнд тулгуурлан нэгд, орчуулгыг эхлэн суралцаж байгаа суралцагчдын үг бүтэх аргыг таних чадварыг нь хөгжүүлэх, хоёрт, үл дүйцэлтэй үгсийг зөвхөн галиглаж орчуулах биш монгол хэлэнд байгаа утга дүйцэхүйц үгээр аль болох орчуулах, эсвэл шинэ үг бүтээх зэрэг бүтээлч аргаар орчуулах, гуравт, суралцагчдад орчин үед төрөлх хэлээ оновчтой зөв хэрэглэж занших талаар зааж сургах шаардлагатай байгааг харуулж байна.

Судалгааны хязгаарлагдмал тал: Энэхүү судалгаанд фэйсбүүк, инстаграм тик ток платформоос жишээ авсанаар өгөгдлийн эх сурвалж хязгаарлагдсан, авсан жишээний тоо харьцангуй бага буюу энэ нь нийт хэлний хэрэглээг бүрэн төлөөлж чадахгүй, хам сэдвийн ялгаа бүрэн тусгагдаагүй буюу зарим үгсийн утга хэрэглээнээс хамаарч өөрчлөгдөж болох ч бүх нөхцөлийг хамраагүй, эцэст нь дүйцлийг ангилах ангилал гаргасан нь тодорхой хэмжээнд судлаачийн субъектив хандлага гарсан байж болох зэрэг хязгаарлалтууд бий.

Цаашдын судалгаа: Илүү олон платформ, илүү их өгөгдөл ашиглах, орчуулгын нөлөөг судлах боломжтой.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Aitchison, J. (2003). *Language Change: Progress or Decay?* Cambridge University Press.
- Alrymayh, A. N. (2024). Historical Overview of Equivalence in Translation Studies. *European Journal of Language and Culture Studies*, Vol. 3 No. 6, 8-15.
- Crystal, D. (2001). *Language and Internet*. Cambridge University Press.
- Kade, O. (1968). Zufall und Gesetzmässigkeit in der Übersetzung [Chance and regularity in translation]. *VEB Verlag Enzyke-lopadie*.
- Newmark, P. (1981). *Approaches to Translation*. Pergamon Press.

- Newmark, P. (1988). *A Textbook of Translation*. Prentice Hall.
- Nida, E. (1964). *Toward a Science of Translating*. Brill.
- Пым, А. (2014). *Exploring Translation Theories*. . 2nd ed. Routledge.
- STAŠKOVÁ, N. (2013). BACK-FORMATION IN THE NEWEST LAYER. *ACTA UNIVERSITATIS CAROLINAE PHILOLOGICA 3 / PRAGUE STUDIES IN ENGLISH XXVI*, 31–60.
- Trigás Pereira, I. (2021). New Trends in Word-Formation Processes in English: an Analysis of the Latest OED Entries. *Universidade da Coruña*.
- Yule, G. (2010). *The Study of Language*. Cambridge University Press.
- Өлзий, Ц. (2019). Англи хэлний шинэ үг бүтээх аргууд.



**НЭР ТОМЬЁОНЫ ОРЧУУЛГЫН АСУУДАЛД**  
(Төмөр замын салбарын нэр томьёоны жишээгээр)

**Х. Цацрал<sup>32</sup>**

***Abstract:** In recent years, Mongolia has experienced intensive railway construction, the implementation of numerous strategic projects, and the expansion of the railway sector. The introduction of advanced foreign technologies has further underscored the urgent need for the precise translation of specialized railway terminology. This article aims to explore the methodologies used in translating railway terms into Mongolian and to identify the most frequently employed translation methods through specific technical examples. Furthermore, it emphasizes that the translation process requires close cooperation with railway professionals to ensure terminological accuracy.*

***Түлхүүр үг:** толь бичиг, нэр томьёог жигдлэх, дагаврын арга, нийлмэл үг, үгийн сан*

**УДИРТГАЛ**

Шинжлэх ухаан, техник технологи улам хурдсаж буй өнөө үед олон тооны шинэ ухагдахуунууд төрөн гарч түүнийг даган шинэ нэр томьёо бий болж байна. Эдгээр нэр томьёог эх хэлнээ буулгаж хэрэглэх шаардлага улс орнуудын өмнө тулгамдсан асуудал болж байна. Энэ талаар эрдэмтэн судлаач О. Шинэбаяр “Инженерчлэлийн салбарт төрөл бүрийн тоног төхөөрөмж багаж хэрэгсэл орж ирэх нь зах зээлийн эдийн засгийн шилжилт, шинжлэх ухаан техникийн хурдацтай уялдан улам бүр нэмэгдэж байгаа бөгөөд үүнтэй холбоотой техник технологийн нэр томьёог орчуулах, шинээр бий болгох, түүний тайлбар, тодорхойлолтыг мэргэжлийн түвшин, олон нийтийн хэрэглээнд тохируулан гаргах шаардлага тулгарч байдаг” (О. Шинэбаяр, 2016:12) хэмээн тэмдэглэсэн байна.

Төмөр замын салбар нь бусад салбаруудтай харьцуулахад харьцангуй ууган салбарын нэг хэдий ч тус салбарын нэр томьёоны судалгаа хамгийн бага боловсорсон сэдэв хэвээр байна. Монгол улсын нэр томьёоны комисс “Төмөр замын нэр томьёоны Орос-Монгол толь бичиг” (1959), Л. Сүрэнхүү “Төмөр замын зам барилгын нэр томьёоны Англи-Орос-Монгол толь бичиг” (1978), Г.Цээлэйнамсан, “Төмөр замын нэр томьёоны Орос-Монгол толь” (2021), Д. Дашзэвэг, О. Бадамсэд, Д. Чинзориг нарын “Төмөр замын зам барилгын нэр томьёоны Англи-Монгол-Орос толь бичиг” (2014), Стандартчиллын үндэсний төвөөс гаргасан “Төмөр замын нэр томьёоны тайлбар, тодорхойлолт” (2013) зэрэг баримт бичиг нь олны хүртээл болсон байдаг. Төмөр замын салбарын англи монгол нэр томьёог тусгайлан харьцуулан шинжилсэн нь өнөө хир бараг үгүй байгаа нь төмөр замын салбарын нэр томьёог жигдлэх, гадаад хэлнээс зөв орчуулан оноох асуудал нь тус салбарын хувьд чухал болжээ.

Төмөр замын техникийн нэр томьёоны талаар дараах судалгаа, стандарт бий. Үүнд:

- MNS 6387-1:2013 - "Төмөр зам. Зам, замын аж ахуйн нэр томьёо, тодорхойлолт" стандарт нь төмөр замын зам болон замын аж ахуйн холбогдох нэр томьёо, тодорхойлолтыг агуулдаг.

<sup>1</sup>Магистр, ТЗИС, Нийгэм хүмүүнлэгийн ухааны тэнхим, <https://orcid.org/0009-0003-1805-5659>

- MNS 6387-2:2013 - "Төмөр замын автоматик ба телемеханикийн нэр томьёо, тодорхойлолт" стандарт нь төмөр замын автоматик болон телемеханикийн салбарт хэрэглэгддэг нэр томьёо, тодорхойлолтыг багтаасан байна.
- MNS 6387-3:2013 - "Төмөр зам. Хөдлөх бүрэлдэхүүний нэр томьёо, тодорхойлолт" стандарт нь хөдлөх бүрэлдэхүүнтэй холбоотой нэр томьёо, тодорхойлолтыг тусгажээ.
- MNS 6387-4:2016- "Төмөр замын тээврийн удирдлага, зохион байгуулалтын нэр томьёо, тодорхойлолт" стандарт нь төмөр замын тээврийн удирдлага, зохион байгуулалтын чиглэлийн нэр томьёог тодорхойлжээ.

Мөн “Төмөр замын нэр томьёоны Англи-Монгол-Орос толь бичиг” (2014) хэвлэгдсэн бөгөөд энэ нь төмөр замын салбарын мэргэжилтнүүдэд зориулсан нэр томьёоны тайлбар толь юм. Эдгээр стандарт, толь бичиг нь төмөр замын техникийн нэр томьёог нэг мөр ойлгож, хэрэглэхэд чухал үүрэгтэй.

Бид судалгаандаа төмөр замын салбарын мэргэжилтнүүд өргөн хэрэглэдэг Д. Дашзэвэг, О. Бадамсэд, Д. Чинзориг нарын 2014 онд гаргасан “Төмөр замын зам барилгын нэр томьёоны Англи-Монгол-Орос толь” бичгийн орчуулгын жишээг түүвэрлэн зэрэгцүүлэн жишиж, зарим жишээгээр тодотгон өөрсдийн саналаа дэвшүүлээ.

Төмөр замын нэр томьёог орчуулан хэрэглэхдээ монгол хэлний үг бүтэх ёсыг дагаж мөрдөх нь албан бичиг боловсруулах шаардлагад нийцэх ба цаашид монгол хэлний нэр томьёог оноон жигдлэхэд чухал гэж үзэж байна.

Төмөр замын салбарын нэр томьёог жигдлэх, оноон тогтоох асуудалд цаашид дараах зарчмуудыг зайлшгүй харгалзах шаардлагатай юм. Нэр томьёо судлаач Ч.Догсүрэн өөрийн бүтээлдээ монгол хэлэнд нэр томьёог тогтооход баримтлах үндсэн хэд хэдэн зарчмууд байдгийг дурдаад. Үүнд:

- Монгол бичгийн болон ярианы хэлэнд байсан уламжлалт үгсийг тэр хэвээр нь буюу шууд утгаар нь хэрэглэх
- Монгол хэлний үгсийн сан дахь түүхэн ба хуучирсан үгийг шинэ утгаар нь сэргээн хэрэглэх
- Монгол бичгийн болон ярианы хэлний зарим үгийн утгыг шилжүүлэн хэрэглэх
- Монгол хэлнийхээ үг бүтэх аргыг ашиглан шинэ нэр томьёо бий болгох  
а/ дагаврын аргаар хэлбэржүүлэх  
б/ дан үгийг нийлэмж үг, нийлмэл үг болгох  
в/ үг хураах
- Нутгийн олон аялгууны үгээс оновчтой заримыг нь авч хэрэглэх
- Гадаад хэлний буюу олон улсын чанартай нэр томьёог хуулбарлан орчуулах
- Гадаад хэлнээс зонхилон олон улсын чанартай нэр томьёог зээлдэн авах (Ч.Догсүрэн, 1988:12) гэж өгүүлжээ.

### **Төмөр замын техникийн нэр томьёо дагаврын аргаар үүсэх нь**

Аливаа хэлний үүсмэл үг нь үүсмэл бус үгээс олон бөгөөд хэлэнд шинэ үг үүсэх хэдэн түгээмэл арга байдаг бөгөөд судлаачид монгол хэлний хувьд залгавраар шинэ үг үүсэх арга зонхилдог гэж үздэг. ( Г.Томтогтох, 2012: 95 )

Дагавар нь дангаараа бие даасан утгагүй, үгийн үндсэнд шинэ утга оруулах буюу үг хоорондын харилцааг илтгэх үүрэгтэй юм.

Төмөр замын техникийн нэр томьёонд “-гч” дагавар нь үйлийн эзэн, эсвэл, тухайн үйлийг гүйцэтгэх мэргэжлийн нэр, мөн үйл хөдлөлийг гүйцэтгэх багаж, тоног төхөөрөмжийн нэрийг үүсгэж байна.

Жишээ нь:

**Auto regulator**- авто тохируулагч

**Bogie turntable**- тэргэнцэр эргүүлэгч

**Snubber** - доргион намжаагч

**Dispatcher**-галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагч

**Yardmaster**- сэлгээний удирдагч

“-уур, -үүр” дагавар нь багаж хэрэгслийг нэрлэн мөн идэвхтэй хэрэглэгдсэн байна.

Жишээ нь:

**Ammeter**-гүйдэл хэмжүүр

**Gas heater turnouts**- суман шилжүүлгийн хийн халаагуур

**Multiple roll crusher**- олон булт бутлуур

**Storage battery (accumulator)** -зай хураагуур

**Vibragraph** –доргио, чичрэг тэмдэглүүр

“-вч” дагавар нь мөн багаж хэрэгсэл, эд анги, тоног төхөөрөмжийн нэр үүсгэх үүрэгтэйгээр ихэвчлэн ордог байна.

Жишээ нь:

**Bogie center plate** -тэргэнцэрийн өсгийвч

**Clamping plate** -хавчих даравч

**Connection coupling**- холбох залгавч

**Journal box**- авагддаггүй эргэвч, холхивч

**Rail flow detection**-зам төмрийн гэмтэл илрүүлэгч

“-лт” дагавар үйл явц заасан үг үүсгэх ба мөн тус дагаврын тусламжтай нийлмэл үгээр бүтсэн нэр томъёо цөөнгүй байна.

Жишээ нь:

**Axle load**- тэнхлэгийн даралт

**Creepage**- зам төмрийн гулсалт

**Emergency braking**- яаралтай тоормослолт

**Shift of wheel**- дугуйн шилжилт

**Wasted motion**-хоосон явалт



Дээрх графикаас харахад төмөр замын мэргэжлийн, инженер техникийн нэр томьёонд багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмж заасан “–уур, үүр ” дагавар бүхий нэр томьёо элбэг болохыг харуулж байна.

### Үг нийлэх аргаар буюу нийлэмж үгээр нэр томьёо бүтэх нь

Нийлэмж үгээр нэр томьёо үүсгэх тухайд уг нийлэмж үгийн бүрэлдэхүүнд орж байгаа үг нэг бүрийг нягтлан сайтар сонгож, нийлээд гаргаж байгаа утгыг нь сайтар тунгааж оноолдуулахыг хэлдэг.

Тус арга нь энгийн үгтэй адил юмс үзэгдэл, ухагдахууныг нэрлэдэг боловч энгийн үгнээс илүү дэлгэрэнгүй байдаг учир тус салбарын нэр томьёо бүтэхэд багагүй хэрэглэгддэг. Гэвч тухайн нэр томьёог бүрэн илэрхийлж байгаа гээд тухайн ухагдахууныг тайлбар мэтээр оруулах нь зохисгүй юм. Энэ нь нэр томьёо товч, ойлгомжтой байх зарчмаас гажна.

Монгол хэлний нэрлэх хэрэгцээг гагцхүү дагаврын аргаар хангах бололцоогүй учраас үг бүтээх өөр арга зайлшгүй шаардагддаг .Энэ шаардлагаас үүдэж үг нийлэх арга бий болсон байна. Хэл зүйн хувьд төмөр замын техникийн нэр томьёоны ихэнх хувь нь үг нийлэх аргаар бүтсэн байна.

*Жишээ нь:*


**Ballasting train-** чигжээсний галт тэрэг

**Lead rail-** холбогч зам төмөр

**Repair wagon-** засварын вагон

**Sealing layer** -нягтруулах жийрэг

**Wheelset slide** -хос дугуйн чирэг



Сонгон авсан нэр томьёоны бүтцийг хэл зүйн үүднээс судлахад төмөр замын техникийн нэр томьёоны ихэнх хувь нь үг нийлэх аргаар бүтсэн байна.

### Нэр томъёог орчуулах аргууд

Нэр томъёог зөв оноон тогтооход нэр томъёог орчуулах аргуудыг эзэмших нь чухал. Төмөр замын нэр томъёог орчуулахад дараах аргууд түгээмэл хэрэглэгдэж байна. Үүнд:

#### *Дүйлгэн орчуулах арга*

Дүйлгэх гэдэг нь нэг хэлний нэрлэсэн ухагдахууныг нөгөө хэлэнд байгаа үг хэллэгтэй яг тааруулан буулгахыг хэлнэ. Эх хэлний үг хэллэгийг өөр хэлээр орчуулан хөрвүүлэхэд хэлэнд нь үүрэг болон хэлбэрээр дүйцсэн үг байхгүй тохиолдолд хэлбэрээр нь бус үүргийг нь харгалзан ойролцоо үгээр дүйлгэх аргыг хэрэглэдэг (Д.Туул, Г.Туяа, Ц.Тунгалаг, 2012:35). Нийлэмж нэр томъёоны бүтцэд дүйлгэн оноосон нэр томъёо цөөнгүй байдаг. Нэр томъёоны үгчилсэн орчуулга нь зарим тохиолдолд утга төгс үг бүтээж чаддаггүй. Иймд тухайн үгийн хам сэдэв, ашиглагдах нөхцөл, утгыг нь ойлгож байж тухайн утгыг илэрхийлж чадахуйц үгээр дүйлгэн орчуулах шаардлагатай болдог. Тухайлбал, үгсийн сангийн үүднээс таарч тохирох үгийг сонгон авч орчуулах юм.

*Жишээ нь:*

**A fault condition**- гэмтлийн нөхцөл, аваарын горим

**Angle cock**-төгсгөлийн кран (вагоны)

**Fixed buffer stop**- төмөр замын хөдөлгөөнгүй тулгуур

**Protected level crossing**- төмөр замын хаалттай гарам

**Running line**-гол зам

*Жишээ өгүүлбэр:*

**A fault condition** occurs when one or more electrical conductors short to each other or to ground.

**Аваарын горим нь** нэг буюу хэд хэдэн цахилгаан дамжуулагч хоорондоо хүрэх эсвэл газардуулга болсон үеийн горим юм.

Trains are prohibited from standing on the **running line** without authorization from the dispatcher.

Галт тэргийг галт тэрэгний диспетчерийн зөвшөөрөлгүйгээр **гол зам** дээр зогсоохыг хориглоно.

#### *Хуулбарлах буюу үгчлэн орчуулах арга*

Эх хэлний үгийг загварчлан буулгахыг хэлнэ. Үгчлэн орчуулахад юуны өмнө үг үгээрээ буусан монгол үг тухайн юм үзэгдэл, ойлголтыг цаад хэлээр байгаа үгийн дайтай төлөөлж байгааг сайтар ажиглах хэрэгтэй.

*Жишээ нь:*

**Freight wagon**- ачааны вагон

**Hazard warning light**- аюулаас сэрэмжлүүлэх гэрэл

**Internal combustion engine**- дотоод шаталтат хөдөлгүүр

**Rolling stock**- хөдлөх бүрэлдэхүүн

**Technical speed** -техникийн хурд

*Жишээ өгүүлбэр:*

Routine maintenance of **freight wagons** is essential to prevent mechanical failures during long-distance transit.

Холын зайн тээвэрлэлтийн явцад механик эвдрэл гарахаас сэргийлэхийн тулд **ачааны вагоны** ээлжит засвар үйлчилгээг тогтмол хийх нь чухал.

Regular maintenance of the **internal combustion engine** ensures a longer service life for the train.

**Дотоод шаталтат хөдөлгүүрийн** засвар үйлчилгээг тогтмол гүйцэтгэх нь зүтгүүрийн ашиглалтын нөөцийг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл болдог.

### **Галигчлан буулгах арга**

Нэр томъёог орчуулахад галигчлан буулгах арга нэлээд өргөн хэрэглэгддэг бөгөөд энэ нь орчуулж буй хэлэнд дүйх, тохирох оновчтой үг байхгүйн үндсэн дээр цаад ухагдахууныг тодотгон, тэмдэглэж байгаа ухагдахууныг товч тодорхой хадгалах үүднээс хэрэглэх болсон гэж үздэг. Энэ арга нь цагаан толгойн үсгийн галигийг харгалзан өөр цагаан толгойн тухайн галигт тохирох үсгээр буулгах явдал юм.” Галигчлан буулгах арга нь тухайн хэлний үгийн санг шинэ үгээр баяжуулах эерэг талтай ч жирийн уншигчдын санаанд бодит утгаараа буухгүй байх тохиолдол бий” (Д.Туул, Г.Туяа, Ц.Тунгалаг, 2012:32).

Төмөр замын нэр томъёоны хувьд ийм үг олон байдаг ба орос мэргэжилтнүүдтэй энэ салбарт олон жилийн турш хамтран ажилласан учраас салбарын мэргэжилтнүүд ийм төрлийн нэр томъёог төвөггүй ойлгож хэрэглэж ирсэн онцлогтой.

*Жишээ нь:*

**Ballast**- балласт

**Dispatcher**- диспетчер

**Cistern ( tank wagon )** - цистерн вагон

**Machine and mechanism**- машин механизм

**Transporter wagon**- транспортер вагон

**Wagon depot**- вагон депо

*Жишээ өгүүлбэр:*

The safety valves of the **tank car** must be inspected before every loading cycle.

Ачилт бүрийн өмнө **цистерн вагоны** хамгаалалтын хавхлагуудыг заавал шалгах ёстой.

The damaged industrial wagons were sent to the **wagon depot** for a complete overhaul.

Гэмтэлтэй үйлдвэрийн вагонуудыг иж бүрэн засварт оруулахаар **вагон депо** руу илгээв.

### **Тайлбарлан орчуулах арга**

Тайлбарлан орчуулах аргыг дээрх аргуудаас нэр томъёо орчуулагдахгүй тохиолдолд хэрэглэдэг. Шинжлэх ухааны хэлэнд тайлбарлах аргаар буюу хэд хэдэн үгээр илэрхийлж утга санаа нь төгс гардаг үгс байдаг. Ганц үгээр бүрэн дүүрэн утга илэрхийлэх боломжгүй тохиолдолд энэхүү орчуулгын аргыг ашигладаг.

*Жишээ нь:*

**Dump car-өөрөө буулгагч вагон**

**Railcar**- дотоод шаталтат өөрөө явагч вагон, автотрисыг голчлон зорчигчийн, шуудангийн тээвэрт өргөн хэрэглэдэг.

**Driving wagon /Motor wagon**- Төмөр замаар өөрөө явагч тусгай хөдлөх бүрэлдэхүүний нэгж

**Ballasting train**- Замын их засварын үед шаардлагатай шороо, чулуу чигжээсний материал ачсан тусгай галт тэрэг.

*Жишээ өгүүлбэр:*

The **dump car** is used for transporting iron ore from the mine.

**Өөрөө буулгагч вагоныг** уурхайгаас төмрийн хүдэр тээвэрлэхэд ашигладаг.

The railway company introduced a new self-propelled diesel **railcar** to serve the low-density rural lines

Төмөр замын компани ачаалал багатай орон нутгийн шугамуудад шинэ дотоод шаталтат **өөрөө явагч вагоныг** нэвтрүүллээ.

Тайлбарлан орчуулах арга нь үгчлэн орчуулахтай уялдан гарч ирдэг. Үгчлэн орчуулах аргын нэг хэлбэр болох зээлдэх буюу хуулбарлан орчуулах аргын үед “тэг” утгатай гадаад үгийг хөрвүүлэх хэлэнд буулгадаг. Энэ үед “тэг” утгатай гадаад үгийг хөрвүүлэх хэлэнд орчуулах арга нь “тайлбар зүүх” арга болно. Уг тайлбар нь тухайн үйлийн утга/үүрэг хэлбэрийн талыг бүрэн тусгасан эх хэлнийх нь утгыг тодорхой илэрхийлсэн тайлбар байх шаардлагатай юм. (Д.Туул, Г.Туяа, Ц.Тунгалаг, 2012:37)

Нэр томьёог зөв ойлгож, орчуулахад мэргэжлийн бус үг хэллэгээс нэр томьёог ялгаж өгдөг утгазүйн онцлогуудыг мэдэх хэрэгтэй. Үүнээс хамгийн чухал нь тухайн нэр томьёо болон тухайн хам сэдэв хоорондын харилцан уялдааны онцлогууд юм.

Нэр томьёо нь нэг бус хэд хэдэн утгатай байж, тэр ухагдахууныхаа хүрээнд ганц утгатай байх хандлагатай байдаг.

*Жишээ нь:*

**Gauge (1)**- хэмжих багаж, шалгах хэрэгсэл

**Gauge (2)**- төмөр замын хоёр зам төмрийн хоорондох зай (цариг)

Жишээ өгүүлбэр:

The engineer used a pressure **gauge** to monitor the system.

Инженер системийн ажиллагааг хянах зорилгоор даралтын **хэмжигч багаж** ашигласан.

The **standard gauge** is 1435 mm.

Стандарт **төмөр замын цариг** нь 1435 мм-ээр тогтоогдсон байдаг.

## ДҮГНЭЛТ

- Монгол улсад төмөр замын шинэ бүтээн байгуулалт өрнөж, төмөр замын сүлжээ өргөжин хөгжиж, шинэ техник технологи нэвтэрч байгаатай уялдан төмөр замын нэр томьёо ч нэмэгдэж шинэчлэгдэж байна. Үүнээс шалтгаалан төмөр замын салбарын гадаад нэр томьёог монгол хэл рүү орчуулан буулгах хэрэгцээ шаардлага цаг үетэйгээ уялдан нэмэгдсээр байна.
- Төмөр замын техникийн нэр томьёог зөв хэрэглэх нь аюулгүй ажиллагаа, оновчтой харилцаа, стандартын дагуу ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг тул буруу орчуулга, буруу ойлголт нь төмөр замын осол, гэмтэл, буруу ажиллагаа, санхүүгийн хохирол үүсгэхээс гадна хууль эрх зүйн зөрчилд хүргэж болзошгүйг алхам тутамдаа харгалзах нь зүйтэй.
- Тус салбарын нэр томьёог улам боловсронгуй болгох, сан хөмрөгийг бүрдүүлэхэд салбарын мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж шинжлэх ухааны ул суурьтай, тооцоотой судалгааг хийх хэрэгтэй байна.
- Төмөр замын нэр томьёог орчуулан хэрэглэхдээ монгол хэлний үг бүтэх ёсыг дагаж мөрдөх нь албан бичиг боловсруулах шаардлагад нийцэх ба цаашид монгол хэлний нэр томьёог оноон жигдлэхэд чухал гэж үзэж байна.

## НОМ ЗҮЙ

- Дашзэвэг, Д., Бадамсэд, О., & Чинзориг, Д. (2014). *Төмөр замын зам барилгын нэр томъёоны Англи-Монгол-Орос толь бичиг, УБ “Ган зам” хэвлэлийн үйлдвэр*. Улаанбаатар.
- Догсүрэн, Ч. (1988). *Монгол нэр томъёог оноох, томилох, жигдлэх асуудалд*. Улаанбаатар.
- Томтогтох, Г. (2012). *Хэл шинжлэлийн удиртгал*, Улаанбаатар.
- Туул, Д., Туяа, Г., & Тунгалаг, Ц. (2012). *Орчуулгын онол, дадлагын үндэс*. Улаанбаатар.
- Стандарт хэмжил зүйн үндэсний төв. (2013). *Төмөр замын нэр томъёоны стандартчилал*. Улаанбаатар.
- Шинэбаяр, О. (2016). *Нэр томъёоны тодорхойлолтын тухайд*. Улаанбаатар.
- ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн. (2016). *Хэрэглээний хэл шинжлэл Боть I (16)*. Улаанбаатар.



## УРАН ЗОХИОЛЫН ОРЧУУЛГЫГ ОНДООШУУЛАХ БА ИДЭЭШҮҮЛЭХ АРГЫН ҮҮДНЭЭС СУДЛАХ НЬ

(Д. Нацагдоржийн “Үзэгдээгүй юм” өгүүллэгийн жишээн дээр)

Г. Мөнхтөгс<sup>33</sup>

**Товч утга:** Уран зохиолын бүтээл нь тухайн хэл соёлын өвөрмөц онцгой талыг яруу сайхан өнгө аясаар илэрхийлж уншигч хүнд хүргэдэг билээ. Тэр дундаа үл давтагдах уламжлалт соёл сэтгэхүй, аж ахуйг илэрхийлсэн туурвилууд нь хойч үед үлдэх хийгээд улс дамжин эл соёлыг түгээн сурталчлах чухал ач холбогдолтой юм.

Монголын орчин үеийн уран зохиолын эцэг Д. Нацагдоржийн 1933 онд бичсэн “Үзэгдээгүй юм” өгүүллэг нь уламжлал хийгээд цаг үеийн байр байдлыг уран зохиолын өнгө аясаар дамжуулан үнэн бодитой харуулж өгсөн нь өнөө үед түүх, соёл, сэтгэхүйг нэгэн дор таниулж буй үнэт эрдэнэ юм.

Орчуулгын үйл нь тухайн уран яруу найруулга, соёлын өвөрмөц байдлыг зорилтот хэлний уншигчдын сэтгэл хийгээд сэтгэхүйд хамгийн ойр буулгах юм.

“Үзэгдээгүй юм” өгүүллэгийн англи хэл дээрх орчуулга нь Америкийн орчуулга судлаач Лоуренс Венутийн дэвшүүлсэн Ондоошуулах (Foreignization) аргаар эх хэлний соёл, аж ахуй байдлыг хэрхэн хадгалсан, Идээшүүлэх (Domestication) аргаар зорилтот хэлний уншигчдад эх зохиолын сэтгэлгээг хэрхэн ойртуулсныг тод харуулжээ.

**Түлхүүр үг:** Орчуулагчийн үл үзэгдэх байдал, Соёлын элемент, Лоуренс Венутигийн орчуулгын арга

### ОРШИЛ

Орчуулга нь зөвхөн нэг хэлнээс нөгөө хэл рүү үг, өгүүлбэрийг хөрвүүлэх төдий үйл явц биш бөгөөд хоёр өөр соёл, сэтгэлгээний гүүр болж холбодог урлаг юм. Монголын орчин үеийн уран зохиолын ноён оргил Д.Нацагдоржийн бүтээлүүд гадаадын олон хэлээр орчуулагдан түгсэн байдаг. Түүний “Үзэгдээгүй юм” өгүүллэг нь 1930-аад оны Монголын нийгэм дэх хувьсгалын эсэргүү бослого, ард түмний аж байдал, шинэ хуучин цагийн тэмцлийг уран сайхны аргаар илэрхийлсэн шилдэг бүтээл юм.

Энэхүү өгүүллэгийг англи хэлнээ “Things That Had Never Been Seen” нэртэйгээр буулгасан нь барууны уншигчдад Монголын түүх, ахуйн дүр зургийг таниулах чухал ач холбогдолтой байв. Англи хэлний багш, судлаачдын хувьд үндэсний уран зохиолоо гадаад хэлнээ хэрхэн орчуулсныг орчин үеийн орчуулгын онолоор дүгнэх нь чухал юм. Тиймээс энэхүү судалгааны зорилго нь Лоуренс Венутийн “Идээшүүлэх” (Domestication) болон “Ондоошуулах” (Foreignization) гэсэн хоёр үндсэн аргын хүрээнд уг өгүүллэгийн орчуулгын онцлог, соёлын элементүүдийн шилжилтийг тодруулахад оршино.

<sup>33</sup> Магистр, Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль, Англи хэлний тэнхим

## ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Америкийн орчуулгын онолч Лоуренс Венути өөрийн "Орчуулагчийн үл үзэгдэх байдал" (The Translator's Invisibility: A History of Translation, 1995) хэмээх алдартай бүтээлдээ орчуулгад хэрэглэгддэг үндсэн хоёр аргыг тодорхойлсон.

**Идээшүүлэх арга (Domestication):** Энэ нь гадаад соёлын элемент, үг хэллэгийг зорилтот хэлний (англи хэлний) уншигчдад ойлгомжтой, энгийн, унаган мэт болгож хувиргах арга юм. Өөрөөр хэлбэл, зохиолчийг уншигч руу ойртуулж, уншихад саадгүй, ойлгомжтой найруулгыг үүсгэдэг. Венути үүнийг барууны соёлын "давамгайлал" бөгөөд эх бичвэрийн соёлын өвөрмөц байдлыг харуулдаггүй хэмээн шүүмжилдэг.

**Ондоошуулах арга (Foreignization):** Эх бичвэрийн соёлын болон хэлний харь шинж чанарыг хадгалж үлдэх арга юм. Уншигчийг зохиолч руу, буюу гадаад соёл руу хөтөлдөг. Энэ аргыг ашигласнаар орчуулга нь уншихад бага зэрэг хөшүүн эсвэл өвөрмөц санагдаж болох ч тухайн үндэстний ахуй соёлыг дэлхий дахинд үнэн зөвөөр таниулах ач холбогдолтой гэж Венути үздэг. (Venuti, 1995)

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгаанд харьцуулсан анализ (Comparative Descriptive Analysis) буюу эх хэл дээрх бичвэр (Source Text - ST) болон зорилтот хэл дээрх бичвэр (Target Text - TT)-ийг зэрэгцүүлэн судлах аргыг ашиглав. Д.Нацагдоржийн "Үзэгдээгүй юм" өгүүллэгийн монгол эхийг болон англи орчуулгыг нэгжийн түвшинд (өгүүлбэр, үг хэллэг) задлан шинжилж, соёлын өвөрмөц үгс (Culture-Specific Items) хэрхэн орчуулагдсаныг Венутийн дээрх хоёр аргаар ангилан тайлбарлалаа.

## СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ

Энэхүү судалгаанд Ондоошуулах (Foreignization) болон Идээшүүлэх (Domestication) аргуудын үүднээс уламжлалт нэршил, байгаль газарзүйн онцлог үгс, шашин зэрэгтэй холбоотой үгсийн задлан шинжлэв.

### **Ондоошуулах (Foreignization) аргын хэрэглээ:**

Орчуулагч монгол ахуй, соёл, газар зүй, нийгмийн гарал үүслийг заасан зарим үгсийг англи хэл рүү шууд авиагаар нь (transliteration) эсвэл монгол утгыг нь алдагдуулахгүйгээр хадгалан үлдээсэн нь Венутийн "Ондоошуулах" аргын төгс жишээ болжээ.

- **Уламжлалт орон сууц**

Эх бичвэрт: "Тун чиг янзтай цагаан гэрүүд..." (Үзэгдээгүй юм, 1933)

Орчуулгад: "...there are a few smart-looking white ger..." (Things that had never been seen, 2021, p. 19)

Орчуулагч "гэр" гэдэг үгийг "tent" эсвэл "yurt" (түрэг гаралтай үг) хэмээн идээшүүлэхийн оронд "ger" гэж шууд авсан байна. Мөн олон тооны дагавар (gers) залгахгүйгээр дангаар нь үлдээсэн нь гадаад хэлний бичвэр доторх монгол үгийн онцлогийг зориудаар мэдрүүлэх Ондоошуулах арга юм.

- **Газар зүйн нэршил ба байгалийн дүрслэл:**

Эх бичвэрт: "Хангайн сайхан нуруунаас гарсан Идэрийн сайхан гол..." (Үзэгдээгүй юм, 1933)

Орчуулгад: "The lovely River Ider came from the lovely ridges of the hangai..." (Things that had never been seen, 2021)

"Хангай" гэдэг үгийг "mountain" эсвэл "forest" хэмээн идээшүүлэхийн оронд "hangai" хэмээн шууд галиглан буулгасан байна. Энэ нь гадаад уншигчдад монгол газар зүйн өвөрмөц тогтоцын ойлголтыг өгөх давуу талтай бөгөөд англи хэлний бичвэр дотор гадаад үг оруулах (foreignizing) алхам болжээ.

- **Үндэсний хувцас, хэрэглэл:**

Эх бичвэрт: *"Хөх даалимбан дээлийг өмсөж, шар ногоон дурдан бүсийг ороосон бөгөөд гээгэггүй, орос эсгий малгайг хэлтгий тавьжээ."* (Үзэгдээгүй юм, 1933)

Орчуулгад: *"He's dressed in a blue cotton deel, tied with a yellow-green silken belt; he has no queue, but wears a Russian-style felt hat at a jaunty angle."* (Things that had never been seen, 2021)

Энд "дээл" гэх үгийг "gown" юм уу "robe" гэж орчуулахын оронд "deel" хэмээн хадгалсан байна. Мөн манж чин улсын үеийн уламжлал болох "гээг" гэдэг үгийг англи хэлний түүхэн үг болох "queue"-ээр буулгасан нь зохиолын үйл явдал өрнөж буй цаг үеийн (1930-аад он) дүр төрхийг уншигчид ондоошуулах аргаар хүргэсэн хэрэг юм.

- **Авиа дуурайх үг (Onomatopoeia):**

Эх бичвэрт: *"Болд хүү тас тас гуядан, жолоог дугтран, хөндлөн сууж хонины хойноос алхуулна."* (Үзэгдээгүй юм, 1933)

Орчуулгад: *"The young man, Bold, strikes the horse's rump with his whip, tass tass, jerks the reins..."* (Things that had never been seen, 2021)

Монгол хэлний "тас тас" хэмээх чимээ дуурайсан үгийг англи хэлний "crack" эсвэл "smack" гэх мэт үгсээр нутагшуулж болох байсан ч, орчуулагч "tass tass" хэмээн дуудлагаар нь буулгажээ. Энэ нь зорилтот уншигчийн чихэнд монгол талын чимээг яг тэр хэвээр нь сонгох гэсэн маш тод "ондоошуулах" шийдэл юм. Гэвч нөгөө талаар харь хэлний уншигчид тухайн чимээ дуурайсан утга санааг ойлгох нь эргэлзээтэй.

- **Нийгмийн давхарга, цол хэргэм:**

Эх бичвэрт: *"Гонгор тайж"* (Үзэгдээгүй юм, 1933)

Орчуулгад: *"Gongor taiji"*. (Things that had never been seen, 2021)

"Тайж" гэх язгууртны хэргэмийг lord эсвэл noble гэхийн оронд taiji хэмээн үлдээсэн нь түүхэн нэршлийг алдагдуулаагүй байна.

- **Идээшүүлэх (Domestication) аргын хэрэглээ: Ойлгомжтой байдлыг хангах нь**

Орчуулагч хэдийгээр монгол ахуйг хадгалахыг зорьсон ч зарим шашин, гүн ухааны болон нийтлэг ахуйн хэллэгүүд дээр Венутийн "Идээшүүлэх" аргыг ашигласан байдаг. Хэрвээ бүх үгийг харьшуулбал бичвэр уншихад хэт түвэгтэй болох эрсдэлтэй тул англи уншигчдад ойлгомжтой байлгах үүднээс зохицуулалт хийжээ.

- **Шашны нэр томьёо:**

Эх бичвэрт: *"Очир там гэж ярилцдаг мөн шиг байна."* (Үзэгдээгүй юм, 1933)

Орчуулгад: *"To look at him, it would seem that he's talking about the worst hell."* (Things that had never been seen, 2021)

Буддын шашны "Очир там" (Vajra Hell) хэмээх гүнзгий ойлголтыг "the worst hell" буюу "хамгийн муу там" хэмээн хялбарчилан англи хэлнээ нутагшуулсан байна. Энэ нь англи хэлтэй уншигчдад буддизмын нарийн ухагдахууныг тайлбарлахгүйгээр шууд аймшигт нөхцөл байдлыг ойлгуулах давуу талтай байв. Мөн түүнчлэн эх бичвэр дэх "дарь эх" гэдгийг "Tara" гэж шашны нэрээр нь галиглахын оронд *"the one they call the goddess"* хэмээн нийтлэг "охин тэнгэр" гэсэн утга руу нутагшуулжээ.

- **Ерөнхийлсөн утгаар буулгах нь:**

Эх бичвэрт: "Дөрвөн зүйлийн малууд энд тэнд сүрээглээд..." (Үзэгдээгүй юм, 1933)

Орчуулгад: "The animals are clustered here and there..." (Things that had never been seen, 2021)

Монгол хэлэнд "дөрвөн зүйлийн мал", "таван хошуу мал" зэрэг нь онцгой чухал ойлголт боловч орчуулгад шууд "The animals" хэмээн ерөнхийлөн буулгасан нь уншигчдад илүү амар хүлээж авахад зориулагдсан юм.

- **Шашны болон сүм хийдийн ойлголт**

Эх бичвэрт: "Чавганц хөгшид, лам мам нар нийлж навсайж савсайлцан..." (Үзэгдээгүй юм, 1933)

Орчуулгад: "The old nuns and monks get together in a straggle..." (Things that had never been seen, 2021)

Монголын буддын шашны "лам, мам" гэх үгсийг "lama" гэж галиглахын оронд барууны Христийн шашны санваартнуудыг нэрлэдэг "monk" (лам), "nun" (гэлэнмаа) хэмээх үгсээр шууд нутагшуулсан нь гадаад уншигчийн тархинд шууд "шашны мөргөлтнүүд" гэсэн ерөнхий ойлголтыг өгөх давуу талтай. Чингэхдээ хөгшин настангууд хийгээд лам хүмүүс гэх ойлголтыг нэгэн утгаар авч зохиолын эсрэг дүрүүд бүгд хөгшин эр, эм лам нар хэмээх ойлголтыг үүсгэжээ.

- **Мухар сүсэг, шашны зан үйл**

Эх бичвэрт: "...атга шороо тарнидуулан өвөртөлсөөр..." (Үзэгдээгүй юм, 1933)

Орчуулгад: "...they make incantations over handfuls of earth, which they put into their pockets..." (Things that had never been seen, 2021)

"Тарнидах/Тариндуулах" буюу маань мэгзэм унших үйлдлийг "chanting mantras" гэж буддын шашны нэр томъёогоор орчуулж болох байсан. Гэвч орчуулагч барууны илбэ шид, мухар сүсгийн зан үйлд түгээмэл хэрэглэгддэг "incantation" (шившлэг) гэдэг үгийг сонгосон нь англи хэлний уншигчдад уг үйлдлийн "бүтэшгүй, мухар сүсгийн шинж чанартай" болохыг өөрсдийнх нь хэлний мэдрэмжээр ойлгуулах шийдэл болжээ.

- **Зэвсэг болон эд өлгийн нэршил**

Эх бичвэрт: "...эрэмдэг зэрэмдэг буу сэлэм, эвэр хулсан нум сум, бялуу шийдэм хүртэл барилан..." (Үзэгдээгүй юм, 1933)

Орчуулгад: "...their shoddy bayonets and their bows and arrows of reed and horn, their clubs and cudgels..." (Things that had never been seen, 2021)

"Бялуу" (мухар мод/зэвсэг) болон "шийдэм" гэх монголчуудын эртний гардан тулааны зэвсгийн нэрийг англи хэлтнүүдийн эрт үеэс хэрэглэж ирсэн модон зэвсгүүд болох "clubs and cudgels" хэмээн уншигчийн танил соёл руу хөрвүүлэн нутагшуулсан байна.

## ДҮГНЭЛТ

Ондоошуулах (Foreignization) болон Идээшүүлэх (Domestication) аргууд нь орчуулгын явцад ашиглагдах давтамж нь эх бичвэрт тухайн соёлын өвөрмөц үгс (Culture-Specific Items) үгс хэр олон давтамжтай ашиглагдсан эсэхээс шууд хамаардаг аж.

Д.Нацагдоржийн "Үзэгдээгүй юм" өгүүллэгийн англи орчуулгыг Лоуренс Венутийн онолын үүднээс задлан шинжилж үзэхэд "Ондоошуулах" (Foreignization) арга нь илүү давамгайлж буюу түлхүү ашиглагджээ.

Орчуулагч эх бичвэрийн соёлын өнгө аясыг хэрхэн хадгалсан болон зорилтот уншигчид хэрхэн нийцүүлснийг судлахад **Ондоошуулах арга 60%, Идээшүүлэх арга 40%**-ийн харьцаатайгаар зонхилж байна.

Лоуренс Венути нь "Ондоошуулах" аргыг эрхэмлэдэг бөгөөд энэ нь зорилтот хэлний (Англи хэлний) соёлын түрэмгийллийг сөрж, эх соёлын (Монгол соёлын) онцлогийг дэлхий дахинд үнэн зөвөөр таниулах ач холбогдолтой гэж үздэг (Venuti, 1995). Энэхүү орчуулгад орчуулагч яг л Венутийн онолын дагуу Ондоошуулах аргыг үндсэн арга барилаа болгож, зохиолын соёлын дархлааг маш сайн хамгаалж үлдээхийг зорьсон аж.

Орчуулгын үйлд аль нэг аргыг нь сонгон давуу ашиглаваас утга санаа бүрэн гарахгүй байх, зохиолчийн өгүүлэмжээс хазайх эрсдэл ажиглагдаж байгаа тул ондоошуулах аргыг эх хэлний соёлын өвөрмөц үг хэллэгийг (Culture-Specific Item) болон идээшүүлэх аргыг тайлбарлавал зохих үг хэллэг, өгүүлэмжид ашиглавал зохилтой хэмээн тунгаана.

## НОМ ЗҮЙ

### Англи хэлээр

1. Venuti, Lawrence. (1995). *The Translator's Invisibility: A History of Translation*. London and New York: Routledge.
2. Munday, Jeremy. (2016). *Introducing Translation Studies: Theories and Applications*. Routledge.
3. Simon, Wickhamsmith. (2021). *Suncranes And Other Stories*. Columbia University Press.

### Монгол хэлээр

1. Нацагдорж, Д. (1933). *Үзэгдээгүй юм*. (Монгол эх бичвэр).
2. Чимэдцэеэ, М. (2013). "Үгчлэх утгачлах, идээшүүлэх ондоошуулахын" шүтэлцээ. Орчуулга зүй.
3. Бат-Эрдэнэ, Г. (2018). *Монголын уран зохиолын орчуулгын онол, практик*. Улаанбаатар.

## SUMMARY

This study examines literary translation through the approaches of foreignization and domestication, using D. Natsagdorj's short story "*Uzegdeegui yum*" and the English translation ("*Things That Had Never Been Seen*") as a case study.

The paper argues that literary works reflect the unique cultural identity, traditions, and worldview of a nation, and translation serves as a bridge connecting different cultures. Natsagdorj's story, first published in 1933, is highlighted as an important work that vividly portrays Mongolian society, culture, and the tension between tradition and modern change.

Using Lawrence Venuti's translation theory, the study analyzes how cultural elements in the story are transferred into English. It finds that foreignization—preserving original cultural terms such as *ger*, *deel*, and place names—is widely used to maintain Mongolian cultural authenticity. At the same time, domestication is applied in certain cases, especially for religious concepts and general expressions, to make the text more accessible and understandable for English readers.

Through comparative analysis of the Mongolian original and its English translation, the research concludes that foreignization is the dominant strategy (about 60%), while domestication accounts for around 40%. This balance allows the translation to both preserve cultural uniqueness and ensure readability.

Overall, the study emphasizes that effective literary translation should combine both approaches: foreignization to retain cultural identity, and domestication to aid comprehension.



УРАН ЗОХИОЛЫН ОРЧУУЛГА ДАХЬ ӨГҮҮЛБЭРИЙН МЭДЭЭЛЛИЙН  
БҮТЭЦ, ТҮҮНИЙГ ВЕКТОРЫН ЧАНАРЫН АНАЛОГ ЗАГВАРААР  
ШИНЖЛЭХ НЬ

Б.Удвал<sup>34</sup>  
Д.Алтанхуяг<sup>35</sup>

**Abstract:** In this paper, the sentences were selected from the works “Solitude” (2018) translated by Kenneth Lindy and “Gantsaardal” (1972) by S. Erdene, and a comparative analysis was conducted based on the information structure of sentences. In any language, the information structure of a text is determined by the Theme–Rheme (given - new) order within the sentence. In English, the thematic progression is typically positioned at the beginning of the sentence, followed by the rhematic (new) information, as explained by M.A.K. Halliday. In contrast, in the relatively flexible word order of Mongolian, the rhematic information consistently follows the thematic information; in other words, the rhematic information develops and expands on the basis of the theme, forming the communicative structure, as noted by D. Erdenesan.

Based on the common features of sentence information structure in the two languages, this study explores the possibility of explaining semantic transformations in translated texts by modeling invariant features through vector-based analogical models.

**Түлхүүр үгс:** Өгүүлбэрийн мэдээллийн бүтэц, М.А.К.Халлидей, онцолбор мэдээлэл, дэвсвэр мэдээлэл,  $a \vec{}$ ,  $b \vec{}$  вектор, шугаман үйлдэл

**1. Монгол хэлний дэвсвэр онцолбор мэдээлэл, тэдгээрийн бүтэц үүргийн  
талаарх онол судалгаа**

Хэл бол мэдээлэл дамжуулах болон харилцахуйн гол хэрэгсэл. Мэдээлэл гэдгийг “Монгол хэлний их тайлбар толь” -д “ямар нэгэн үйл хэргийн тухай аман болон бичгээр дэлгэрэнгүй мэдээлэх явц, мэдээ дамжуулах, түгээх” (<https://mongoltoli.mn/>) гэсэн утгатай үг юм.

Харин харилцааны түвшинд мэдээлэл хэмээх үгийг дараах хоёр утгаар гол төлөв авч үздэг гэж зарим судлаач тайлбарлажээ.

1. Өдөр тутмын энгийн мэдээллийг дамжуулах мэдээлэл энэ нь энгийн утга санаа агуулсан хэд хэдэн өгүүлбэр, эшлэл, цаашилбал бүтэн эх ч байх боломжтой. Жишээлбэл: “Би даарч байна. Тэд маргааш явна.” гэх мэт. Энэ төрлийн мэдээллийн зорилго бол аливаа зүйлийг сонсгох, дуулгах, мэдээлэл дамжуулах зорилготой юм.
2. Бодит байдалд юмс үзэгдэл, хэрэг явдал тэдгээрийн харилцаа холбооны талаар шинэ соргог өргөн хүрээний мэдээлэл дамжуулах, энэ нь мөн хэд хэдэн өгүүлбэр, эшлэл, эх ч байх боломжтой юм. Жишээлбэл: Шинжлэх ухааны нэр томъёоны мэдээлэл гэх мэт. (Эрдэнэсан, 2015)

Хэлээр дамжиж байгаа мэдээллийг хэсэгчлэх, чухалчлах нь тухайн мэдээллийг ойлгомжтой болгож, үнэн зөв дамжуулах зэргээр харилцахуйн түвшинд ач холбогдолтой юм.

<sup>34</sup> Магистр, МУИС, Завхан дахь БМТС, ORCID: 0009-0007-9880-9906

<sup>35</sup> PhD, МУИС, Завхан дахь БМТС, ORCID: 0009-0007-5839-5243

Судлаач Д.Эрдэнэсан “хэл бүрт мэдээллийг чухалчлах, хэсэглэх арга хэлбэр өөр өөр байдаг ч хэлний нийтлэгийн хувьд, үгийн өргөлт, өгүүлбэр дэх үгсийн дараалал бол дэвсвэр мэдээллийг ялгаруулж өгдөг үндсэн хоёр арга мөн гэж тайлбарлаад монгол хэлний үгсийн энгийн сул дараалалд онцолбор мэдээлэл нь ямагт дэвсгэр мэдээллийн ард байрлана” гэжээ. (Эрдэнэсан, 2015) Орчин цагийн монгол хэлэнд мэдээллийн бүтэц, шинэ хуучин мэдээллийн ялгаа заагийн талаарх зарим асуудлыг Б.Пүрэв-Очир, Г.Жамбалсүрэн, Э.Дашдондог, З.Гулиранз, М.Базаррагчаа нарын зэрэг эрдэмтэд өгүүлбэрийн түвшинд судалсан байдаг.

М.Базаррагчаа, Б.Пүрэв-Очир нар мэдээллийн бүтцийн хоёр бүрдүүлбэрийг дэвсвэр ба онцолбор гишүүн гэж нэрлэсэн бол Г.Жамбалсүрэн сэдэх мэдээлэл-шинэ мэдээлэл гэж нэрлэсэн байна. Мэдээллийн бүтцийг өгүүлбэрийн түвшинд оросын судлаач Ч.Ч. Ковтунова “Тема-Рема”-ийн тухай ойлголт нэр томьёо бол өгүүлбэрийн доторх үгсийн байр чөлөөтэй орос мэт хэлэнд дээрх нэр томьёо тохиромжтой, харин өгүүлбэр доторх үгсийн байр харьцангуй тогтвортой хэлэнд “коммуникативная перспектива” (Мэдээллийн харилцааны чиглэл) “коммуникативный фокус”(Мэдээллийн харилцааны онцлол) гэх зэрэг ойлголт нэр томьёо тохиромжтой гэж тэмдэглэсэн нь монгол хэлэнд ч бас учир холбогдолтой юм хэмээн Б.Пүрэв-Очир, З.Гулираанз нар бичсэн байна. (Пүрэв-Очир, Гулираанз, 1993)

“Эх”-ийн мэдээллийн бүтцийн судалгааны талаар Чехийн хэл шинжээч Ф.Данеш, Оросын хэл шинжээчид Н.Д. Митрофанова, Т.Б. Одинцова, Н.Н.Метс зэрэг эрдэмтэд утга зохиолын хэл найруулгын янз бүрийн хэв маяг бүхий “Эх” – ийг судалж тодорхойлсны эцэст эхийн мэдээллийн бүтэц бол түүнийг бүрдүүлэгч нэгжүүдийн мэдээллийн бүтцийн хоорондын уялдаат залгамжит чанараар нөхцөлддөг гээд харин өгүүлбэрийн мэдээллийн бүтэц нь түүний дэвсвэр онцолбор гишүүний харьцаагаар илэрдэг гэжээ.

Тэгэхээр эхийн бүрдүүлбэрүүдийн эхний өгүүлбэрийг суурь өгүүлбэр гэх бөгөөд суурь өгүүлбэр нь дараа дараачийн өгүүлбэрүүдийн мэдээллийн бүтцийг нөхцөлдүүлэх бөгөөд өгүүлбэр бүрийн онцолбор гишүүн дараах өгүүлбэрийнхээ дэвсвэр мэдээлэл болох замаар хоорондоо холбогдож “Эх”-ийн мэдээллийн бүтцийг өргөжүүлэн дэлгэрүүлдэг болох нь харагдаж байна.

Судлаач Б.Пүрэв-Очир, З.Гулираанз нар “Монгол хэлний өгүүлбэр зүйн онол – практикийн зарим асуудал” номдоо монгол хэлний утга зохиолын хэлний найруулгын олон хэв маягт **шугаман цуваа бүтэц, цацраг маягийн бүтэц, үүсмэл дэвсвэр гишүүнтэй цуваа бүтэц** гэсэн гурван хэв маягийн мэдээллийн бүтцийг түгээмэл тохиолддог гэж тодорхойлсноос **шугаман цуваа бүтэц** нь М.А.К.Халлидейн өгүүлбэр дэх мэдээллийн бүтцийн тодорхойлолттой ойролцоо байна.

М.А.К. Халлидей өгүүлбэрээр илрэх мэдээллийн бүтцийг сэдвийн бүтэц (Thematic structure), мэдээллийн бүтэц (informational structure) гэж ангилсан нь Прагийн хэл шинжлэлийн дэгийнхний ангилалтай мөн нийцдэг. М.А.К. Халлидей болон Прагийн дэгийнхний FSP буюу “Functional Sentence Perspective” -ийн талаарх судалгаа нэлээд дэлгэрсэн байдаг.

Монгол судлаачдын монгол өгүүлбэр дэх шугаман цуваа бүтцийг М.А.К. Халлидейн өгүүлбэр дэх мэдээллийн бүтэц (textual metafunction)-тэй зэрэгцүүлэн англи монгол өгүүлбэрийн мэдээлэлд шинжилгээ хийх боломжтой юм. **Шугаман цуваа бүтэц** нь эх болон өгүүлбэрийн онцолбор гишүүд нь дараах цогцолбор болон өгүүлбэрийн дэвсвэр мэдээлэл болдог хэв маяг юм.

Энэ хэв маягийг оросын эрдэмтэн Г.Я. Солганик мэдээллийн бүтцийн гинжин холбоо нэрлээд дараах жишээгээр тайлбарлажээ.

*... Миний өвөг эцгийн жинхэнэ нэрийг Магсаржав гэдэг, харин олны дунд Магсар хурц гэж алдаршсан юм. Хурц гэдэг нь түүний бичгийн эрдэмд боловсорсныг үнэлсэн цол юм. Энэ цолыг Богд хаант монгол улсын засгийн газраас түүнд олгожээ.*

Энэ цогцолбор 3 өгүүлбэрээс бүрдсэн бөгөөд эхний өгүүлбэр дэх дэвсвэр мэдээлэл нь “...Миний өвөг эцгийн нэр” онцолбор мэдээлэл нь “Магсаржав гэдэг, харин олны дунд Магсар

хурц гэж алдаршсан юм” энэ онцолбор мэдээлэл хоёр дахь өгүүлбэрт дэвсвэр болж “бичгийн эрдэмд боловсорсныг үнэлсэн цол” гэсэн шинэ онцолбор мэдээллээр өргөжиж тэр нь дахиад дараагийн өгүүлбэрийн дэвсвэр мэдээлэл болсноор өгүүлбэрүүд хоорондоо цуваа гинжин холбоогоор холбогдсон гэж үзнэ гэжээ.

Д – О – Д – О – Д ... гэх мэт

## 2. Англи хэлний эх ба өгүүлбэрийн мэдээллийн бүтцийн онол судалгаа

‘Functional Sentence Perspective’ буюу өгүүлбэрийн мэдээллийн бүтцийг англи хэлэнд нэлээд эртнээс судалж эхэлсэн байна.

1844 онд ‘The order of words in the ancient languages compared with that of the modern languages’ нэртэй анхны судалгааны бүтээл гарч байсан бол 1751 онд Жеймс Харрис англи хэлний тодорхой буюу тодорхой бус ялгац гишүүний хэрэглээг тайлбарлахдаа өгүүлбэрийн мэдээллийн бүтэц шинэ хуучин мэдээллийн зааг ялгааны талаар мөн дурдсан байдаг. ([https://upload.wikimedia.org/The\\_order\\_of\\_words\\_in\\_the\\_ancient\\_languages\\_compared\\_with\\_that\\_of\\_the\\_modern\\_languages.pdf](https://upload.wikimedia.org/The_order_of_words_in_the_ancient_languages_compared_with_that_of_the_modern_languages.pdf))

Англи хэлний өгүүлбэрийн мэдээллийн бүтэц мэдээллийн дарааллын судалгаанууд дундаас дэвсвэр мэдээллийн талаарх М.А.К. Халлидейн тодорхойлолт илүү их дэлгэрсэн тодорхойлолт юм. Халлидей өгүүлбэрийн мэдээллийн чиглэл, шилжилтийн дарааллыг G+N N+G / G + N + G +N байх боломжтой гэж томъёолсон (Halliday, 1967/1985) нь монгол хэлний дэвсвэр онцолборын дараалалтай ижил байр суурьтай тайлбар юм.

Халлидейн өгүүлбэрийн бүтцийн тайлбарт дараах **гурван өөр зэрэгцээ функциональ бүтэц байдаг.**

1. **Тусах байдал;** Төсөөлөх бүтэц (Transitivity; Ideational metafunction)
2. **Баймж хэлбэр;** Харилцах бүтэц (Mood; Interpersonal metafunction)
3. **Дэвсвэр Онцолбор;** Мэдээллийн бүтэц (Theme–Rheme; Textual metafunction)

Textual metafunction буюу өгүүлбэрээр илрэх мэдээллийг тэрээр сэдвийн бүтэц буюу (thematic structure), мэдээллийн бүтэц буюу (informational structure) гэсэн хоёр бүтцээр тайлбарладаг.

Мэдээллийн энэ хоёр ерөнхий бүтцийг өгүүлбэрийн мэдээллийн гол үндсэн бүтэц гэдэгт Халлидей болон Прагийн судлаачид санал нэгддэг. Харин Халлидейн үзэл онолоор бол өгүүлбэр дискурсын бүтэц зохион байгуулалт буюу хэн хэзээ хэрхэн гэсэн асуултад хариулагдах уялдаат байдлаараа нэгдмэл байх хэдий ч сэдвийн бүтэц, мэдээллийн бүтцээрээ нэгдмэл бус салангид нэгжүүд юм.

Өгүүлбэрийн эхэнд байх сегментийг сэдэв буюу үндсэн санаа (theme) гэж нэрлээд энэ нь тухайн өгүүлбэр юуны тухай болохыг илэрхийлнэ гэжээ. Сэдэв буюу үндсэн санаа (theme) дараах хоёр үүрэгтэй.

1. Өмнөх өгүүлбэртэйгээ холбогдох, өөрөөр хэлбэл өмнөх өгүүлбэрийн дискурс буюу харилцааны процессын уялдаа холбоог хадгалах
2. Дараагийн өгүүлбэртэй холбогдох, өөрөөр хэлбэл дараагийн шинээр үүсэх өгүүлбэрт цааш үргэлжлэх утга санааны уялдаа холбоог хөгжүүлэх

М.А.К. Халлидей, Стивен Хокингийн “A Brief History of Time/ Цаг хугацааны товч түүх” зохиолоос дараах өгүүлбэрийг авч сэдвийн бүтэц (thematic structure), мэдээллийн бүтцийн (informational structure) загвараар задалж тайлбарласан байна.

**Theme/ дэвсвэр** → **rheme/ онцолбор** →  
*In Ptolemy's model provided a reasonably accurate system for predicting the positions of heavenly bodies in the sky,*

*In Ptolemy's model* – гишүүн өгүүлбэрийн түвшинд юуг буюу ямар сэдвийг мэдээлэх гэж байгаагаар тодотгож өгүүлбэрийн эхэнд байрлуулсан тул сэдэв үндсэн санаа буюу (theme) болж байна.

*provided a reasonably accurate system for predicting the positions of heavenly bodies in the sky,* - нь мэдээлэл илгээгч сэдэв үндсэн санааны талаар өгч байгаа шинэ мэдээлэл юм. Энэ хэсэг бол мэдээллийн бүтцийн хамгийн чухал хэсэг яагаад гэвэл тухайн мэдээллийн хамгийн гол мэдээллийг агуулж байна. Ийм учраас rheme буюу шинэ мэдээлэл бүхий хэсэг нь өгүүлэмжийн харилцааны зорилгыг бүрэн биелүүлж чаддаг хэмээн тайлбарлажээ.

### 3. Онцолсон болон үл онцолсон дэвсвэр

Мэдээллийн бүтцийн онцолсон (marked) /үл онцолсон (unmarked) дэвсвэр нь орчуулгын салбарт нэлээд чухал ач холбогдолтой зүйл юм. Учир нь үүнийг зөв ойлгосноор тухайн мэдээлэл илгээгчийн мэдээллийн гүн гүнзгий утга агуулгыг бүрэн ойлгож дамжуулах боломжтой юм. Өгүүлбэр нь өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн, тусагдахуун, гүйцээвэр, тодотгол гэсэн элементүүдээс тогтдог. Халлидейн загварт эдгээр өгүүлбэрийн элементүүдийн хамгийн эхэнд байрлаж байгаа нь дэвсвэр мэдээлэл болдог ажээ.

Мөн дэвсвэр мэдээлэл гүн гүнзгий утга агуулгатай байдаг. Учир нь мэдээлэл илгээгчийн мэдээллийн чиглэлийг тодорхойлж өгдөг гэж зарим орчуулга судлаачид үздэг. (Mona Baker, 2006.p.121)

Аливаа хэлнүүдэд эхийн мэдээллийн бүтэц нь өгүүлбэр доторх дэвсвэр онцолбор мэдээллийн бүтэц зохион байгуулалтаар тодорхойлогддог гэж олонх хэл судлаачид тайлбарладаг. Тэдний тайлбар ихэвчлэн өөрсдийнх нь хамгийн сайн мэддэг хэлнээ суурилсан байдаг. Халлидейн тайлбар бол англи хэл дээр суурилдаг бөгөөд түүний онцолсон, үл онцолсон дэвсвэр мэдээллийн талаарх тодорхойлолт нэлээд түгээмэл бөгөөд олон орны хэл судлаачид өөр өөрийн үндэсний хэлний баримтад онцолсон, үл онцолсон дэвсвэрийн загвараар өгүүлбэрийн мэдээллийн бүтцийг шинжилсэн байдаг.

Үл онцолсон дэвсвэр нь хэлзүйн бүтэц дэх өгүүлэгдэхүүн гишүүнээр ихэвчлэн илэрдэг. Halliday (1994.p.44) Өөрөөр хэлбэр нэр үг, төлөөний үгээр ихэвчлэн илэрч үйлийн эзэн дэвсвэр мэдээлэл болдог. Энэ бүтэц бол нэлээд энгийн хялбар бүтэц бөгөөд англи монгол хэлнээ ижилхэн байдаг.

Жишээ нь:

Хүснэгт 1

Үл онцолсон дэвсвэр	Онцолбор
Даш өвгөн	бол энэ тухай сонсох ч дургүй байлаа.

(С.Эрдэнэ. Ганцаардал.1972)

Хүснэгт 2

unmarked theme	Rheme
Dash	did not want to hear anything about that.

(Kenneth Linden. Solitude. 2018)

Онцолсон дэвсвэр гэдэг нь нэр үг болон тэмдэг нэрээр илэрсэн өгүүлэгдэхүүн гишүүн биш, орон цаг заасан байц гишүүн болон өөр бусад гишүүдээр илэрдэг бөгөөд монгол англи хэлэнд нийтлэг байх тохиолдол бас байдаг.

Жишээ нь:

Хүснэгт 3

онцолсон дэвсвэр	онцолбор
<b>Тэгэвч</b> өдөр хоног өнгөрөх тусам	нүүх суух яриа тасрахаа байж,.
<b>ялангуяа</b> залуу үеийнхэн бол	шинэ газар очиж ямар нэг хот суурин байгуулан шилэн цонхтой байшинд морилж үнээгээ цахилгаанаар саах хүртэл үлгэр шиг юм ярилцах болов

(С.Эрдэнэ. Ганцаардал.1972)

Хүснэгт 4

marked theme	rheme
<b>But</b> as more days and nights passed,	the discussion over whether to move or stay began to break down,
<b>especially</b> when young members	began to tell fairy tale stories about going to a new area and establishing a city of houses with glass windows and milking their cows by electricity.

(Kenneth Linden. Solitude. 2018)


Дэвсвэр мэдээлэл хаана төгсөж онцолбор мэдээлэл хаанаас эхэлж байгааг зааглаж ялгах нь хэл судлаачдын хувьд нэлээд ярвигтай асуудал байсаар байгаа боловч ихэнх судлаачид Халлидейн онцолсон үл онцолсон дэвсвэр мэдээллийн талаарх тайлбарыг хүлээн зөвшөөрдөг. Дэвсвэр мэдээллийн хязгаарыг хэрхэн тогтоох талаар Халлидейн онцолсон үл онцолсон дэвсвэрийн судалгааг өргөжүүлэн олон гишүүнтэй холимог нийлмэл өгүүлбэрт гишүүн өгүүлбэр гол өгүүлбэрийн харьцаагаар тайлбарлаж грек цагаан толгойн  $\alpha^{\beta}$  /  $\beta^{\alpha}$  тэмдэгтүүдийг ашиглан загварчилсан судалгаанууд мөн нэлээд байдаг.

#### 4. Орчуулгын инвариант чанар ба векторын аналог загвар

Инвариант чанар гэдэг нэр томъёо нь математикийн шинжлэх ухаанд хувьсах хэмжигдэхүүнүүдийн үйлчлэлээс үл хамааран хувиралгүй хэвээр хадгалагдан үлдэх чанарыг хэлдэг. Орчуулгын үр дүнд бий болсон орчуулгын бичвэр ба эх бичвэр хоёрт хувиршгүй үлдэх зүйлийг орчуулга судлалд инвариант чанар гэж нэрлэдэг. (Хосбаяр, Төгөлмаа & Ариунаа, 2015) Зохиогчийн илэрхийлж буй санаа, тухайн хэлээр яригч ард түмний соёл нь бичвэрийн утгаар дамжин өөр хэл соёл бүхий уншигчид хүрдэг.

Тэгэхээр эх бичвэр, орчуулгын бичвэр хоёрын утга ижил байх нь инвариант чанар юм. Орчуулгын бичвэр дэх инвариант чанарыг векторын чанарын аналог загваруудад орлуулж өгүүлбэрийн утгын хувиргалыг тайлбарлая.

$a^{\rightarrow} + b^{\rightarrow} = b^{\rightarrow} + a^{\rightarrow}$  энэ томъёо бол аналитик геометрт үйлдлийн дарааллыг өөрчилсөн ч үр дүн өөрчлөгдөхгүй байх чанар юм.



$(OA)^{\rightarrow}$  чиглэлтэй хэрчим бол  $a^{\rightarrow}$  вектор.  $(AC)^{\rightarrow}$  чиглэлтэй хэрчим бол  $b^{\rightarrow}$  вектор.

Тэгэхээр эдгээр коллинеар биш векторуудаар талаа хийсэн параллелограммын диагональ OC нь энэ хоёр векторын нийлбэр гэж тодорхойлогдоно.

$(OB)^{\rightarrow}$  чиглэлтэй хэрчим бол  $b^{\rightarrow}$  вектор.  $(BC)^{\rightarrow}$  чиглэлтэй хэрчим бол  $a^{\rightarrow}$  вектор.

Мөн эдгээр коллинеар биш векторуудаар талаа хийсэн параллелограммын диагональ OC векторын нийлбэр гэж тодорхойлогдоно. Чиглэлтэй хэрчмүүдийн хувьсах хэмжигдэхүүний байрлал өөрчлөгдсөн ч утгын инвариант чанар өөрчлөгдөөгүй.

#### 4.1 Англи, монгол энгийн өгүүлбэрийн харьцуулсан задлал

Орчуулгад хувьсах хэмжигдэхүүн болох өгүүлбэрийн гишүүдийн байр солиход утга өөрчлөгдөхгүй байх тохиолдол дараах жишээнээс харагдаж байна. Орчуулагч өгүүллэгийн эхний хэсгийн энгийн монгол өгүүлбэрийг англи хэлний мөн энгийн өгүүлбэрээр дараах байдлаар орчуулжээ.

*Манайхан хаврын эхээр нутгаа орхин нүүж эхлэв.* (С.Эрдэнэ. Ганцаардал.1972)

*Our people began to move from our homeland at the beginning of spring.*

(Kenneth Linden. Solitude. 2018)

*Манайхан хаврын эхээр нутгаа орхин нүүж эхлэв.*

Энэ өгүүлбэр нь энгийн нийлмэл өгүүлбэр бөгөөд мэдээллийн бүтцийг задлахад Дэвсвэр + Онцолбор гэсэн шугаман цуваа загвараар задарч байна.


*Our people began to move from our homeland at the beginning of spring.*

Англи хувилбарыг мэдээллийн бүтцээр задлахад Халиедейн томьёолсон G+N N+G гэсэн мэдээллийн бүтэц гарч ирж байна. (Halliday, 1967/1985)

Монгол англи өгүүлбэрүүд хоёулаа нэг өгүүлэгдэхүүн, нэг өгүүлэхүүнтэй энгийн өгүүлбэрүүд бөгөөд англи өгүүлбэр SVO бүтэцтэй монгол өгүүлбэр SOV бүтэцтэй байна.

Англи, монгол өгүүлбэрүүдийн дэвсвэр/theme мэдээллүүд ижилхэн үл онцолсон дэвсвэрүүд, өөрөөр хэлбэл, *our people* – англи өгүүлбэрийн subject бол *манайхан* -монгол өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн гишүүн болох нь хэлзүйн дүрмийн хувьд харагдаж байна.

Тэгэхээр монгол англи хэлний энгийн нийлмэл өгүүлбэрүүд нь өгүүлбэрийн бүтэц хэлзүйн дарааллын хувьд ялгаатай хэдий ч дэвсвэр мэдээллийн нийтлэг онцлогоос хамаарч мэдээлэл дамжуулах дараалал нь ижил байгаа тул дээрх хоёр өгүүлбэрийг векторын байр солих чанараар  $|a^{\rightarrow} + b^{\rightarrow} = b^{\rightarrow} + a^{\rightarrow}|$  загварчлан дараах байдлаар тайлбарлаж болох юм.



$(OA) \vec{=} \text{манайхан} -Ma \vec{=} (D_1) (AC) \vec{=} \text{хаврын эхээр нутгаа орхин нүүж эхлэв} -Mb \vec{=} (O_1)$   
 $(OB) \vec{=} \text{our people} -Aa \vec{=} (Th_1) (BC) \vec{=} \text{began to move at the beginning of spring} -Ab \vec{=} (Rh_1)$

Монгол өгүүлбэрийн үндсэн санаа дэвсвэр O цэгээс эхэлж A цэгт хүрээд дууссан бол шинэ мэдээлэл A цэгээс эхэлж C цэгт дуусаж байна тэгэхээр нийлбэр вектор буюу өгүүлбэрийн утга нь үндсэн санаа эхэлсэн O векторын эхлэлээс шинэ мэдээлэл дууссан C цэг хүртэлх чиглэлтэй хэрчмээр дүрсэлсэн вектор тул нийлбэр вектор нь OC юм

Англи өгүүлбэрийн үндсэн санаа theme мөн O цэгээс эхэлж B цэгт дуусаад шинэ мэдээлэл Rh нь B цэгээс эхэлж C цэг дээр дуусаж байна. Энэ хоёрын нийлбэр вектор нь мөн OC юм. Эндээс харахад англи монгол хэлний энгийн хүүрнэх өгүүлбэрийн мэдээлэл дамжуулах чанарыг векторын байр солих чанар болон гурвалжны дүрмээр тайлбарлаж болж байна.

#### 4.2 Олон байц гишүүнтэй энгийн дэлгэрэнгүй монгол өгүүлбэр ба энгийн, холимог, хавсарсан нийлмэл өгүүлбэрээс бүрдсэн англи цуваа өгүүлбэрийн харьцуулсан задлал


Орчуулагч эх бичвэрийн олон гишүүнт энгийн дэлгэрэнгүй өгүүлбэрийг дэлгэрүүлж энгийн, холимог нийлмэл, хавсарсан нийлмэл өгүүлбэрээс бүрдсэн /sentence sequence/ буюу богино текст болгон орчуулжээ. Эх өгүүлбэр болоод орчуулгын хувилбар хоёулаа олон гишүүнтэй олон төрлийн мэдээлэл дамжуулж байгаа дэлгэрэнгүй өгүүлбэр байна.

Хэрэв дэвсвэр онцолбор хоёр ердийн дараалалд, өөрөөр хэлбэл мэдээлэл нь дэвсвэрээс онцолборг өрнөхөөр байрласан тохиолдлыг хэвийн, дундаж тогтсон дараалал гэж нэрлэсэн прагийн хэл шинжээчдийн тодорхойлолтыг судлаач Д.Эрдэнэсан тодруулж энэ тохиолдолд дэвсвэр мэдээлэл нь ердийн дараалал буюу шууд дараалал бүхий өгүүлэгдэхүүн юм уу өгүүлэгдэхүүний бүлгээр илэрдэг бол, онцолбор мэдээлэл нь өгүүлэхүүн юм уу өгүүлэхүүний бүлгээр илэрч болно. Өөрөөр хэлбэл эхний өгүүлбэрийн онцолбор дараагийн өгүүлбэрийн дэвсвэр болж сүлжин байрлаж байна гээд “дэвсвэр мэдээлэл энгийн шугаман дарааллаар өргөжих” хэлбэр хэмээн загварчилжээ. (Эрдэнэсан, 2015)

“Дэвсвэр мэдээлэл энгийн шугаман дарааллаар өргөжих” загвараар дараах өгүүлбэрийг задалж үзье. /зураг 3/

*Даш гэрийн ойр хураасан түлээн дээр сууж урд арын харгуйгаар хаврын зэрэглээн дунд ундуй сундуй явж байгаа хэсэг бөөн мал, ачаа хөсөг ийш тийш давхилдах морьтонгуудыг харж “Хайран нутгаа, хайран нутгаа” гэж харамсан үглэж ус гүйсэн нүдээ цавчлан шүднийхээ завсраар шүлсээ байн байн хаяж хатангир боловч шөрмөслөг гараараа өвөр түрийгээ тэмтчинэ. (С.Эрдэнэ. Ганцаардал.1972)*

Зураг 3




Англи орчуулгын өгүүлбэрийн мэдээллийн бүтцийг ажиглахад прагийн хэл шинжлэлийнхний тодорхойлсны дагуу дэвсвэр онцолбор хоёр ердийн дараалалд байгаа нь монгол эхтэй адил “Дэвсвэр мэдээлэл энгийн шугаман дарааллаар өргөжих” загвараар мэдээллийн бүтцийг задалж болохоор байна. /зураг 4/

*Dash sat by the pile of firewood near his ger. He watched as, almost like a spring mirage, a mass of animals and carts moved haphazardly along the near side of the southern mountain, with horsemen galloping in all directions. Dash saw this and muttered sadly, “My poor homeland, my poor homeland,” blinking his watery eyes. Spitting again and again through the gap between his front teeth, he patted the front of his boots with his skinny yet sinewy arms.*

(Kenneth Linden. Solitude. 2018)

Зураг 4



Англи, монгол хэлний  $NP_1+P+NP_2$  бүтэц дэх харьцаа заасан P нэгжийг хоёр хэлэнд хэрхэн орчуулах талаар хийсэн судалгааны ажлаараа дамжуулан судлаач Ц.Отгонсүрэн орчуулах дараалал буюу аргачлалыг ерөнхий хэл шинжлэлийн үүднээс тайлбарласан бөгөөд энэ нь хэлний шаталсан хэлбэрийг мөчирлөсөн бүтцээр илүү нарийн тайлбарласан байна.


Мөн хэлний гүн болон өнгөн бүтцийн шаталсан хэлбэр, хэлний илэрхийлэгдэх байдал, мэдээллийн урсгалын дараалсан шугаман хэлбэрийн талаар гаднын хэл судлаачид дараах байдлаар тайлбарладаг.

Хэл бол шаталсан бүтэцтэй (Noam Chomsky, 1957; 1965) энэ нь өгүүлбэр зүй болон утгын бүтэц нь шаталсан байдлаар илэрдэг гэсэн бол хэл бол илэрхийлэгдэх байдлаараа шугаман бүтэцтэй (Saussure, 1916) гэж тайлбарласан байдаг. М.А.К. Халлидейн хувьд хэл бол авиа, үг, өгүүлбэрийн түвшинд дотоод бүтэцдээ шаталсан байдаг боловч мэдээллийн урсгал (discourse flow) талаасаа дараалсан шугаман шинжтэй тийм болохоор хэлэнд шаталсан бүтэц ч бий, шугаман бүтэц ч бий гэж тайлбарласан байна. (Halliday & Hasan, 1976)

Дээрх англи орчуулга, монгол эх хоёрыг мэдээллийн бүтцээр задалж загварт оруулахад аль аль нь шаталсан дотоод (internal hierarchical structure) бүтэцтэй харагдаж байгаа хэдий ч мэдээллийн урсгал, мэдээлэл илэрхийлэх хэлбэрээрээ дараалсан шугаман хэлбэрээр илэрч байна.

Мэдээллийн урсгалыг чиглэлтэй хэрчим буюу вектороор дүрсэлж харуулбал дараах байдлаар харагдаж байна. /зураг 5/

Зураг 5



Коллинеар цэгүүд = өгүүлбэрийн дараалал

Чиглэлтэй шулуун = мэдээллийн урсгал

Орчуулга болон эх хувилбарт мэдээлэл хоёулаа **дэвсвэр мэдээлэл + онцолбор мэдээлэл + дэвсвэр + онцолбор ...** гэсэн загвараар сүлжилдэн илэрч байгаа тул векторын коллинеар чанараар тайлбарлаж болох юм. Учир нь нэг чиглэл, шугаман бүтэц, тасралтгүй дараалал бол векторын коллинеар чанарын геометр утга юм.

Эндээс харахад орчуулгын инвариант чанар нь текст хэдий урт болсон ч мэдээллийн үндсэн чиглэл өөрчлөгдөөгүй. Халлейдейн тодорхойлсон theme progression буюу мэдээллийн логик урсгал өөрчлөгдөөгүй байгаагаар илэрч байна.

Хоёр вектор  $a \vec{=} (a_1, a_2)$ ,  $b \vec{=} (b_1, b_2)$  коллинеар байх нөхцөл:  $a_1/b_1 = a_2/b_2$ ; ( $b_1, b_2 \neq 0$ )

## ДҮГНЭЛТ

Энэ ажлаараа бид монгол хэлнээс англи хэл рүү хөрвүүлсэн уран зохиолын орчуулгаас монгол хэл дээрх эхийн энгийн өгүүлбэр болон олон гишүүнт энгийн өгүүлбэрийн мэдээллийн бүтцийг шугаман цуваа загвараар, англи орчуулгын холимог болон хавсарсан нийлмэл өгүүлбэрээс бүрдсэн богино хэмжээний текстийг М. А. К. Халлидейн өгүүлбэр дэх мэдээллийн бүтэц (textual metafunction), Прагийн хэл шинжээчдийн тодорхойлсон мэдээлэл нь дэвсвэрээс онцолборт өрнөхөөр байрласан хэвийн, дундаж тогтсон дараалал, монгол судлаачдын мэдээлэл энгийн шугаман дарааллаар өргөжих загвараар задалж үзэхэд англи монгол өгүүлбэрийн мэдээллийн логик урсгал ижил байна.

Мөн хоёр хэлний нэг өгүүлэгдэхүүнтэй энгийн өгүүлбэрийн мэдээллийн урсгалыг векторын байр солих чанараар  $a \vec{+} b \vec{=} b \vec{+} a \vec{}$  загварчлан тайлбарлах боломжтой бол олон гишүүнтэй дэлгэрэнгүй өгүүлбэрийг векторын коллинеар чанараар тайлбарлах боломжтой юм.

Орчуулгын заах арга зүйн хувьд оюутанд дэвсвэр мэдээлэл ба онцолбор мэдээллийн тохиромжтой харьцааг хадгалах, зааг ялгааг нь зөв тогтоож сурахад нь чухал бөгөөд үүний үр дүнд оюутан дамжуулсан мэдээллийг, орчуулж буй хэлнээ зөв дарааллаар ойлгомжтой байрлуулж сурах юм.

Энэ судалгааны ажил цаашдаа хиймэл оюун ухаанд монгол хэлний найруулга зүйн зохистой хувилбар, монгол хэлний мэдээлэл дамжуулах хэлбэрүүдийн онцлогийг зөв өгөгдлөөр програмчлах ажилд хувь нэмэр оруулах боломжтой юм.

## НОМ ЗҮЙ

1. Пүрэв-Очир Б. Гулираанз З. (1993). Монгол хэлний өгүүлбэрзүйн онол практикийн зарим асуудал. Улаанбаатар.
2. Эрдэнэсан Д. (2015). Монгол хэлний эхийн онол судалгаа. Улаанбаатар.
3. Отгонсүрэн Ц. (2025). Англи, монгол хэлний  $NP_1+P+NP_2$  бүтэц дэх харьцаа заасан P нэгж тэдгээрийн нийтлэг шинж. Улаанбаатар.
4. Эрдэнэ С. (1972) Нарантогоруу. Улаанбаатар.
5. Susanne Eggins. (2004). An introduction to Systematic Functional Linguistics. New York.
6. Jakobson R.(1996). Structure and Language and its Mathematical aspects, Proceedings of Symposia of Applied Mathematics, American Math Society.
7. Halliday, M.A.K., & Matthiessen, C. (2004). *An Introduction to Functional Grammar* (3rd ed.).
8. Saussure, F. (1916). Course in General Linguistics.
9. [www.wordswithoutborders.org](http://www.wordswithoutborders.org)
10. <https://www.jstor.org/stable/j.ctt17kk81z>
11. <https://mongoltoli.mn/>

[https://upload.wikimedia.org/The\\_order\\_of\\_words\\_in\\_the\\_ancient\\_languages\\_compared\\_with\\_that\\_of\\_the\\_modern\\_languages.pdf](https://upload.wikimedia.org/The_order_of_words_in_the_ancient_languages_compared_with_that_of_the_modern_languages.pdf)



## АМАРБАЯСГАЛАНТ ХИЙДИЙН ГЭРЭЛТ ХӨШӨӨНИЙ МАНЖ- МОНГОЛ БИЧЭЭСНИЙ ОРЧУУЛГЫН ҮГИЙН САНГИЙН ОНЦЛОГ

Э.Жаргалмаа<sup>36</sup>

*Абстракт:* Монастырь Амарбаясгалант, воздвигнутый по указу императора Юнчжэна в 1727 году на левом берегу реки Ивэн у подножия горы Бурэнхан, является одним из выдающихся памятников религиозной и культурной истории Монголии. Строительство монастыря, предназначенного для хранения мощей Первого Богдо гэгэена — Ундура Гэгэена Дзанабазара, было завершено в 1737 году при правлении Цяньлуна. На территории монастыря в Храме истории хранится трёхязычный памятник с маньчжурско-монголо-китайской надписью, увековечивающей историю его основания. Настоящая статья посвящена анализу особенностей перевода маньчжурской и монгольской частей данной надписи. Результаты исследования вносят вклад в изучение маньчжурско-монгольских письменных памятников эпохи династии Цин.

*Түлхүүр үг:* Амарбаясгалант хийд, манж бичиг, монгол бичиг, хэл шинжлэл, сурвалж судлал

### УДИРТГАЛ

Ойр зэргэлдээ нутаглан, түүх, соёлын талаар харилцаатай явж ирсэн үндэстнүүд хэлний талаар ямар нэг хэмжээгээр зайлшгүй харилцан нөлөөлж байдаг. Монгол болон манж түнгүс угсаатны харилцаа холбооны түүхийг археологи, антропологи, түүх, угсаатны зүйн мэдээллээс үзэхэд, хэдэн мянган жилийн турш үргэлжилсэн гэж үзэж байна (Баярсайхан, Энхсүвд 2024: 27-28).

Түүнчлэн, манж түнгүс, түрэг, монгол төрлийн хэлнүүдийг гарлын хувьд холбоотой гэж үзээд Алтай овгийн хэлнүүд хэмээн нэрлэж харьцуулан судалсаар ирсэн түүхтэй. Энэ чиглэлд холбогдох судалгаанд эдгээр хэлийг авиа зүй, бүтээвэр зүй, өгүүлбэр хийгээд эхийн түвшинд холбогдох төрөл бүрийн дурсгалыг хэрэглэгдэхүүн болгон судалж иржээ.

Иймээс энэхүү өгүүлэлд нэг талаас, манж, монгол хэлний орчуулгын харьцуулсан судалгаанд хувь нэмэр оруулах, нөгөө талаас, монгол нутагт буй олон зуун жилийг элээж буй дурсгалыг сурвалж судлалын үүднээс судлан баримтжуулах үүднээс, Сэлэнгэ аймгийн Бүрэн хан уулын энгэр Ивэн голын зүүн биед орших Амарбаясгалант хийдийн гэрэлт хөшөөний

<sup>36</sup> МУИС-ийн докторант, Чингис хаан Үндэсний музей, Судалгаа, сан хөмрөгийн төв, ORCID: 0009-0007-3415-7590

бичээсийг судалгааны хэрэглэгдэхүүн болгож, уг хөшөөний бичээснээс манж, монгол бичээсийг судлах болно. Уг хөшөө нь манж, монгол, хятад, бичээстэй бөгөөд бид үүнээс, нэг дурсгалд гарлын холбоотой гэж үздэг манж, монгол хэл, бичгээр сийлсэн бичээсийг онцолно. Учир нь, тухайн цаг үеийн хэл бичгийн хүмүүсийн үлдээсэн бодит баримтаар дурдсан хоёр хэл, бичгийн харьцуулснаар орчуулгын онцлогийг үгийн сангийн түвшинд тодотгоход хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж байна.

Дайчин улсын Энх-Амгалан хааны гэрээсийг ёсоор болгон Найралт төв хаан зарлиг буулгаж, Тэнгэрийн тэтгэсэн хааны үед буюу 1727-1736 онд, Өндөр гэгээн Занабазарт зориулан анх 40 сүмтэйгээр барьж дүүргэсэн,<sup>37</sup> эдүгээ ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн урьдчилсан жагсаалтад орсон (UNESCO 2014) Амарбаясгалант хийдийг<sup>38</sup> манжийн төрийн бодлогын хэрэгжилт, монголын буддын шашны нэгэн чухал төв, хэлмэгдүүлэлтийн үеийн түүх зэрэг түүхийн дурсгал болохын хувьд; хятад, төвөд, монгол хэв маяг нийлсэн архитектур, буддын шашны дүрслэх урлаг, хийц чимэглэл зэрэг урлаг, уран барилгын чиглэлээр; дурсгалын хадгалалт хамгаалалт, соёлын ландшафтын үнэт өв, сэргээн засварлалт зэрэг соёлын өвийн үүднээс; гэлүгвагийн ёсны хөгжил, буддын шашны зан үйл, боловсрол сургалт гэх мэтээр шашин, философийн талаас; хийд орчмын тахилгат газар, булш бунхан байгууламжийг археологийн гэхчлэн олон шинжлэх ухааны судалж иржээ (Цоодол 2004, Цэдэндамба 2009).

Хэдий тийм боловч манайд тус хийдийн хөшөөний бичээсийг тухайлан судалсан хэл шинжлэл, сурвалж судлалын судалгаа хомс байсаар байна. Түүнчлэн XIX зууны сүүл үед л нэлээд гаргагдахгүй болжээ хэмээн тэмдэглэж байсан (Гэрлээ 2025: 58) бичээс цаг өнгөрөх тусам уг хөшөөний бичээс элэгдэж гаргац нь бүдгэрч байгаа билээ. Ийм учраас, энэхүү өгүүлэлд тус хийдийн хөшөөний монгол, манж бичээсийг харьцуулан орчуулж судлахаар сонголоо.

## СУДЛАГДСАН БАЙДАЛ

Боржигидай мэргэний 41-р үеийн, Хабул хааны 30-р үеийн ач хийгээд засаг ноёны туслагч явсан Галданы 1841 онд зохиосон “Эрдэнийн эрих хэмээх түүх болой” сурвалжид “Жибзундамба бээр Бээжинд залрав. Мөн он Ивэнгийн газар байгуулж буй сүмийг үйлдэж төгссөн тул Гаоцун төгсгөлт хуанди бээр хийдийн нэрийг Амарбаясгалант хийд хэмээн шийтгээд, Гангын хумхын тоот ертөнцийн буяны шүтээн хэмээн бянь бичиг<sup>39</sup> бичиж өгөв. Мөн он жүн ван Данзандоржийг дахиж хошой чин ван өргөмжлөв” хэмээгээд “Бас захиран үйлдэгч түшмэлийн гуйсныг соёрхож хөшөө чулуу босгож бичиг сийлж үйлийн учрыг тэмдэглүүлэв”, “хоёрдугаар он улаагчин могой жил (1737) Жибзундамба

<sup>37</sup> Галдан туслагчийн “Эрдэнийн эрих” сурвалжид “Найралт төвийн тавдугаар он (1727), зарлигаар сайд гаргаж хүүгийн мөнгө арван түмэн лан өгч илгээж, түүний язгуурын суусан Хүрээний газартаа их хийд үйлдэж хуврагуудыг чуулж ном хэлэлдэн гүрэм үйлтгэн, Далай лам, Банчин эрдэнийн баруун этгээд оронд оршсон ёсчлон болгов. Тэнгэрийн тэтгэсний тэргүүн он (1736) хийд үйлдэж төгссөн тул, би хийдийн нэрийг Амарбаясгалант хийд хэмээн сэтгээд Гангын хумхын тоот ертөнцөсийн буяны шүтээн хэмээн бянь бичиг бичиж өгөв” (Гэрэлбадрах 2015: 257) хэмээн уг хийдийн бүтээсэн тухай түүхэн баримтыг дэлгэрэнгүй тэмдэглэсэн буй.

<sup>38</sup> Хийдийн нэрийн хувьд Амар, Баясгалан гэх хоёр хүүхдийн нэр гэж тогтсон домог монголчуудын дунд буй.

<sup>39</sup> Бянь бичиг - Гарчиг, найруулга, зохиомж хэмээсэн утгатай 編 хятад үг ажээ.

хутагтад шагнаж үйлтгүүлсэн Амарбаясгалант хийдийн гэрэлт хөшөө чулуунд зарлиг сийлсэн нь” гээд хөшөөний монгол бичээсийг дурдсан буй (Гэрэлбадрах 2015: 256, 257).

Түүнээс хэдэн арван жилийн дараа Монгол орноор 1876-1879, 1892-1893 онд хоёр удаа аялсан оросын монголч эрдэмтэн, аялагч, тухайн үеийн Оросын Эзэн хааны Газарзүйн нийгэмлэгийн гишүүн А. М. Позднеев өдрийн тэмдэглэл хөтлөхдөө Амарбаясгалант хийдийн хөшөөний бичээсийн тухай дүрслэн өгүүлсэн буй (Гэрлээ 2025: 28-32).

БНСУ-ын Чой Дон гуэн (최 동 권) хятад, манж, монгол бичээсийг уншиж, солонгосоор орчуулан тайлбарлаж өгүүлэл хэвлүүлжээ (2006).

Харин хөшөөний бичээсийн монгол хэлээр гарсан, манж монгол бичээсийн орчуулгын харьцуулсан судалгаа хараахан үгүй байна.

## ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Страленбергийн эхлүүлсэн Алтай овгийн хэлний онолыг А. М. Кастрен (A. M. Castrén), В. Шотт (W. Schott) нар хэрэглэснээс хойш, Г. Рамстедт (G. J. Ramstedt), Н. Поппе (Nicolas N. Poppe) тэргүүтэй олон эрдэмтэн хөгжүүлсэн нь эдүгээ үргэлжилсээр буй. Тус онолын дагуу, бүр эрт Өвөг Алтай хэл байсан бөгөөд түүнээс *Монгол хэлнүүд*, *Манж-Түнгүс хэлнүүд*, *Түрэг хэлнүүд* гэсэн томоохон бүлэг хэлнүүд салбарлаж, тэдгээрээс цааш мөчирлөн хөгжсөн гэж үздэг ба сүүлийн үед Солонгос, Япон хэлийг нэмж оруулж буй (Poppe 1965, Котвич 1962, Даваасүрэн 2005, Rachewiltz, Rybatski 2010).<sup>40</sup> Энэ үүднээс, төрөл хэлний ижил болоод ялгаатай талыг тодруулан судлахын тулд харьцуулах аргыг хэрэглэдэг (Нансалмаа 2011). Түүнчлэн гэрэлт хөшөөний хадмал бичээс нь орчуулгын харьцуулалд чухал хэрэглэгдэхүүн болдгийг Ш. Эгшиг онцлон тэмдэглэсэн буй (2013: 87-92). Мөн тус өгүүлэлд сурвалж судлалын онолын гадаад, дотоод хэлбэрийг судлах *задлаг* шинжилгээний арга зүй, албан бичгийн хэлийг нэг язгуурын хэлний хүрээнд харьцуулах (Henning 2004) аргыг ашиглалаа.

## СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Энэхүү судалгаанд А. М. Позднеевын тэмдэглэл (1896: 28-32); (хөшөөний бичээсийн гэрэл зураг, кирилл хөрвүүлэг, Гэрлээ 2025. 49-50), Галдан туслагчийн “Эрдэнийн эрих хэмээх түүх болой” (Гэрэлбадрах, Ж., 2006, 2007, 2012, 2015) нэрт түүхэн сурвалжийг ашигласны дээр судалгааны хэрэглэгдэхүүнийг М.Баярсайханы цуглуулга дахь Амарбаясгалант хийдийн хөшөөний гэрэл зураг болон Үндэсний Төв Архивын М-87 дугаартай манж баримтын хөмрөгөөс 1-р дансны 27 а дугаартай хадгаламжийн нэгж (Д-1, ХН-27а: манж бичээс 47 мөр, монгол бичээс 46 мөр), Чингис хаан үндэсний музейн сан хөмрөгт хадгалагдаж буй хуулбар үзмэр (манж бичээс 18 мөр, монгол бичээс 18 мөр, хятад бичээс 15 мөр, хөшөөний өндөр 320 см, бичээстэй хэсгийн өндөр 150 см, өргөн 85 см) баяжуулав.

<sup>40</sup> Үүний зэрэгцээ бас тус онолыг үгүйсгэх чиглэл байдгийг тэмдэглэвэл зохино. Г. Дөрфер (G. Dörfer) нарын эрдэмтэд Алтай овгийн хэлнүүдийн нийтлэг төстэй шинж бол нэг гарал үүсэлтэйгээс шалтгаалсан бус, харин өнө удаан хугацаагаар нутаг савлан сууснаас үүдэлтэй харилцан нөлөөллийн үр дүн гэдэг.

Тус өгүүлэлд хөшөөний бичээсийн гэрэл зураг болон хуулбар үзмэрийг гол болгож, архивын баримт, бусад сурвалжуудтай харгуулан тулгаж, гаргагдахгүй хэсгүүдийг нөхвөрлөн судаллаа.

### **Бичээсийн хэлбэрийн судалгаа**

#### *Бичээсийн дүр байдал*

Амарбаясгалант хийдийн хөшөөний хэлбэр, хийцийн тухайд нийт өндөр 320 см, бичээстэй хэсгийн өндөр 150 см, өргөн 85 см, зузаан 26 см байна. Хөшөөг давхиж буй далавчтай морь дүрсэлсэн дөрвөлжин суурь дээр босгосон бөгөөд бичээсийн дээд хэсэгт уул, үүлэн дунд Дайчин улсын хаадын бэлгэ тэмдэг болсон таван хумстай лууг дүрсэлжээ.

Хөшөөнөө 18 мөр манж бичээс, 18 мөр монгол бичээс, 15 мөр хятад бичээс буй.

А.М.Позднеевын аяллын тэмдэглэлдээ хөшөөний бичээсийн байр байдлыг өгүүлснийг авч үзвэл:

“Манжийн хааны зарлигаар байгуулсан, эрхэм дээд шүтээнтэй Амарбаясгалант хийд монголчуудын сэтгэлд онцгой дээд байр суурьтай. ... Дуган бүр хуралтай, хүрээ даяар хурлын дуу хүнгэнэнэ. Хийдийн төлөвлөлт хааны ердийн сүмээс ер ялгаагүй. Цогчин дуган, Манжийн хааны хүртээсэн, монгол, манж, төвөд<sup>41</sup>, хятад бичээс бүхий хоёр чулуутай асар л онцгой сонирхолтой. “Эрдэнийн эрих”-д бүрнээр нь багтаасан энэ бичвэрийн утга агуулгыг би хэдийгээр андахгүй ч хөшөөг үзэж, боломжтой бол гэрэл зурагт буулгаж, цаасан дээр дардас авьюу гэж санатал тэдгээр асар түгжээтэй, орох боломжгүй байлаа. Асрыг тойрч яваад цонхны хүрээнд наасан хятад цаас нэг газраа урагдсаныг анзаарав. Энэ зайлхайгаар шагайвал хөшөөний монгол бичиг харагдсан нь “Эрдэнийн эрих”-д байдагтай үг үсэггүй таарч байсан бөгөөд миний авсан зураг өдгөө тэр хөшөөний бараг цор ганц гэрэл зураг болжээ. Чулуун дээр сийлсэн монгол бичиг маш жижигхэн тигтэй, он цагийн элээлтэд элж гөлийсөн тул ихэнх хэсэг нь гаргагдахгүй болжээ. Тэр тусмаа цаасан дээр дардас авах тухай саналтгүй. Хятад, төвөд бичиг нь арай дөнгүүр болов уу гэж бодсондоо нөгөө асарт очвол аанай л цоожтой, түүгээр барахгүй цонхны цаас нь бүрэн байлаа”

(Гэрлээ 2025: 58) хэмээжээ. Галдан туслагч 5 жилийн өмнө сийлсэн тодорхой гаргацтай монгол бичээсийг түүхэн сурвалждаа бичиж оруулсантай харьцуулахад, түүнээс хойш 30-50 гаруй жил өнгөрөхөд А. М. Позднеевын бичсэнээр монгол бичээс нь ихэнх нь гаргагдахгүй болтлоо элэгдсэн байжээ. Эдүгээ түүнээс хойш дахиад 100 гаруй жил өнгөрч улам бүр он цагийн уртад бүдгэрч байна.

#### *Бичээсийн хүндэтгэл илэрхийлэх ёс*

Хөшөөний бичээсийн хэлбэрийн талын бас нэг онцлог бол монгол, манж албан бичгийн хүндэтгэл илэрхийлэх ёсыг нарийн баримталсан байдаг. Хүндэтгэл илэрхийлэх ёс нь ялангуяа мөр тэтгэх, бүтэн мөр эзлүүлэх, шинэ мөрөөс эхлэх, мөр дарах зэрэг үгийн байршлаар тодорхой илэрдэг (Мөнх-Учрал 2010, Баярсайхан 2007, 2012). Жишээлбэл, уг бичээс нь манж-монгол-хятад хадмал буюу гурван бичгээр зэрэгцээ бичигдсэн бөгөөд

<sup>41</sup> Төвөд бичээс гэдэг нь хөшөөний ар дээр бичигдсэн маанийн цөөн хэдэн үсгийг хэлсэн бололтой. Түүнээс тухайлсан олон мөр төвөд бичээс үгүй.

манж эхэд *Тэнгэр, Тайзу, Тайзун, Шэнзү өршөөлт хуанди, Гэгээнээр, Зарлигаар, Богд, Хаан эцэг Шизүн төлөвт хуанди, Найралт төв, Тэнгэрийн тэтгэсэн, Өвгөд* зэрэг төр хийгээд шашны хүндэтгэлийн утгатай үгсийг тусгайлан дангаар нь эвсэл шинэ мөрөөс эхлэн бичжээ. Эдгээр нь Э. Мөнх-Учралын судалснаар “Дайчин Улсын Бүгд хууль”-д хуульчлан заасан тэргүүн зэрэгт хүндэтгэл илэрхийлэх тэнгэр, эцэг өвгөд, хааны хамаат үгс байгаа (2010: 86) нь уг хөшөөний бичээсийг хуулийн дагуу сийлсэн болохыг батлан харуулж байна.

Харин эхний үг болох *сэтгэвээс (sedkibesü)* болон хамгийн сүүлийн мөр болох *Тэнгэрийн тэтгэсний хоёрдугаар он зуны тэргүүн сарын шинийн долооноо* хэмээх огноог эх бичвэрээс доош “мөр дарах ёс”-оор бичжээ. Энэхүү уламжлал нь Их Монгол улс, болон Монголын хаант улсуудын үеийн албан бичгийн соёлд өргөн хэрэглэгдэж, хаадын зарлиг, албан захидал, хааны олгосон үнэмлэх бичиг зэрэгт бичгийг хүлээн авагч этгээдийн нэр, цол, тушаалыг бичихдээ мөр дардаг журамтай байсан бөгөөд дөрвөлжин үсгээрх зарлигийн бичгүүдэд зарлигийг хүлээгчээс гадна бичгийн эцэст зарлиг буулгасан огноо, газар орны нэр зэргийг мөр дарж бичдэг байжээ (Баярсайхан 2012).

### Бичээсийн агуулгын судалгаа

Манж, монгол бичээсийн орчуулгын онцлогийг илүү тодруулахын тулд манж, монгол хоёр бичээсийг эрдэм шинжилгээний галигаар галиглан харьцуулбал:

<i>Манж бичээсийн галиг</i>	<i>Монгол бичээсийн галиг</i>
1.           γüniči	1.           sedkibesü
2.   Abqa musei daičing gurun-be γosime karmame. tumen gurun-be uherileme elbeme šun biyai fosoro. aγa silenggi i simeraqûngge daharaqûngge aqû.	2.   Tngri ber biden-ü dayičing ulus-i örüsüen jongkilaju tümen ulus-i nigedkejü ibegen. naran saran-u geyigülküi ba. qur-a sigüderiyin simedkeküi nuγud ülü dayayčid ügei
3.   Taizu	3.   tayizu
4.   Taizung-ni fon-či wargi ba-i dalai lama bančen erdeni	4.   tayizung-un čay-ača örün-e жүг deki dalai blam-a kiged. bančin erdeni
5.   Enduringge erdemu-be buyeme harγašame yaya onγyolo γünin hungkereme dahaha.	5.   degedü erdem-i күсен qalayiju ken ken-dür urida-ača sedkil siγudču dayabai.
6.   Šizu eldembuhe hûwangdi ging hečende fuyjin doro toytobuha manggi dalai lama tumen bači yamulanjifi benjihe jafanjihangge umai layčahaqû. amala	6.   Sizu geyigülügen quwangdi ging qotan-dur tulγur törü toytaysan-u qoyin-a dalai blam-a tümen ber-e-yin činege γajar-ača yamular-a irejü alba bariγsayar yerü tasuruγsan ügei qoyin-a
7.   Šengzu γosin hûwangdi	7.   sengjü örüsüeltü quwangdi
8.   beye amba čooħa γaifi wargi amargi ječen-be nečihiyeme toytobume genehe de. jebzungdamba qütuytu nadan γūsai qalqasa be γaifi	8.   Gegen-iyer yeke čerig abču örün-e umar-a жүг-үн jaq-a kijayar-i töbsidken toytayar-a ögede boluγsan-dur jebzundamba qutuytu doluyan qosiyun-u qalq-a-tan-i abču

9. Yabure gung de hengkilehe manggi  
čohome amba lama fungnefi suwayan  
šajin-de dalabuha. elhe taifin i ninju  
emuči aniya tuweri yamulanjiha de. jai  
aniya ging hečen de aqû oho.
10. Han ama šizung temgetulehe  
hûwangdi hafan taqûrafi qarmatame  
ini gurun de amasi benebufi
11. Kesi dorolon be jiramilame isibuha.  
hûwaliasun tob i sunjači aniya
12. Hesei amban tučibufi ku i menggun  
juwan tumen yan çamafi ini da tehe  
kuren-i bade amba miyoo weilefi  
šabisa be isabufi ging be giyangname  
doro be yabubuha. dalai lama bančen  
erdeni-i wargi bade tere qooli songqoi  
obuha. abqai wehiyehe i suçungya  
aniya miyoo weileme šangyara jaqade.  
bi miyoo i gebu be urgun elhe sy seme  
toytobufi fu io heng ša sere pai biyan
13. arafi buhe. geli qadalame weilebure  
hafasai baiha-be yabubufi. bei wehe  
ilibufi bidhe folofi baita-be ejebuhe. bi  
yûniči abqai banjibuha geren irgen-de  
enteheme banin bi. banin sain aqûngge  
aqû. arbun beye-de enču ojoro ba aqû.  
ba na-de giyalabure ba aqû. terei emu  
adali yûnin-be dahame. ijishûn-i  
yarhûdarangge. ere udhai di wang sai  
tačihyan
14. ilibuha turgun qai. suwayan šajin  
wargi amargi bade selgiyebufi geren  
aiman wesihun fusihûn aqû šurdenume  
yabume hing seme aydaraqûngge aqû.  
amba muru deri tačihyan eke-be  
taryame sain-be dahara-be da obuhabi.  
te monyosoi geren gemu ging bidhe-be  
tačime hûlame fučihi-i doro-de forome
9. yabuqu ordun-dur mörgügsen-iyer tuslan  
yeke blam-a bolyan ergümjilejü sir-a-yin  
šasin-i bariyulbai. engke amuyulang-un  
jiran nigedüger on-u ebül baralqar-a  
irigsen-dür tere qoyidu jil ging qotan-dur  
nirwan üjegülbei.
10. Qayan ečiğe sizung tölöbtü quwangdi  
tüsimej jaruju qamayalan qarajalaju  
tegünü ulus-tur-iyen qoyinaysi kürgegüjü
11. kesig yosulal-i jujayadqaju kürtegebei.  
Nayiraltu töb-ün tabuduyar on
12. Jarliγ-iyar sayid γaryaju küü-yin mönggün-  
i arban tümen lang ögçü ilegejü. tegünü  
ijayur sayuγsan kuren[=küren]-ü γajar  
dayan yeke keyid üyiledcü quwaray-ud-i  
čiyulγaju nom keleldün gürim üyiledken.  
dalai blam-a. bančin erdeni-yin barayun  
eteged oron-dur orosiγsan-i/u yosučilan  
bolγabai. tngri-yin tedkügsen-ü terigün on  
keyid üyiledcü tegüsügsen tula. bi keyid-ün  
ner-e-yi amurbayasqulangtu keyid kemen  
sidkeged g'angg'a-yin qumaki-yin toγatu  
yirtinčüs-ün buyan-u sitügen kemen biyan  
bičig bičijü ögbei. basa jakirun üyiledügči
13. tüsimej-ün γuyuγsan-i soyurqaju kösiy-e  
čilayun-i bosqaju bičig seyiljü üyile-yin  
učir-i temdeglegülbei. bi sedkibesü tngri-  
yin törügülügsen qotala irged-tür bügüde  
möngke mön činar bui. mön činar sayin  
ügegü anu ügei. biy-e düri-dür öber  
boluγdayun ber ügei. γajar oron-dur  
jabsardaqun ber ügei tegünü öberčilen dur-  
a-yi dayaju jokildayulun udaridqui anu ene  
möñ di wang-ud-un suryal bayiyuluγsan  
siltayan bolai. šar-a šasin-i örün-e umar-a  
oron-dur delgeregüjü qamuγ ayimaγ-ud  
erkim dooradus ügei.
14. temečen jörčildüjü čing süsüg-iyer ülü  
itedegčid ügei tegünü nomlal-un tobči anu.  
mayu nigül-i gesegen. sayin buyan-i dayan  
üyiledkü-i ijayur bolγajuqui. edüge  
mongγol-un olan bügüde nom sudur-i  
surulčaju bisilyan burqan-u ünen mör-tür  
itegejü oroldaqu bolbasu tegünü sayin

- dahara oči terei sain-de huwekiyefi  
yendenurengge urunaqû ja ombi.
15. niyalma tome urgunjeme sain-de ibeči  
tedendere. jasei tulergi ba-i fulgiyan  
juse uhei sain salyabun-be ilibume ba  
na elhe nečîn dorgi tulergingge urgun  
sebjen-i kesi fulehun-be alime  
enteheme γoidame oihorilaraqû-be  
dahame inu wesihun aqû semeu. Mini
16. Mafari tulergi aiman be γosime bilume  
gubči bade hûturi isibume tumen  
gurun yooni elhe ofi irgen fusefi ai  
jaqa elgiyen ohobi. ere sy-de dalaha  
niyalma. geren ergengge-be  
huwekiyebume yarhûdame sain banin-  
be hafumbume emu mujilen-i wen-de  
forome gurun booi taifin nečîn-i  
hûturi-be sebjeleme alikini. udtu ohode  
teni
17. Han ama-i geren aiman-be γosime kesi  
isibuha erdemu γûnin-be urgederaqû  
ombi.
18. abqai wehiyehe jai aniya duin biyai iče  
nadan
- üyilen-dür kökeldejü sedkil egüskegdeküi  
inu sayar-ügei kilbar bolumui. kümün büri  
bayasulčan buyan-u jüg-tür debsibesü tedüi  
bui jaγ-a[=j-a] kerem jiq-a-yin γadayadus  
nilqas neyite бүгүдегер buyan-u barilduly-  
a dulduyidču γajar delekei töbsin amur
15. dotuy-a-du. γaday-a-du arad bayar čenggel-  
iyer kisig qayiralal-i oroi-bar sitüjü egüri  
önide ülü bolilaqu-yin tula. mön erkin ügei  
kememeyü. minu
16. ebüged γaday-a-du ayimaγ-ud-i örüsüen  
eyeldüjü бүкү orod-tur qutuγ kürtegejü  
tümen ulus бүрин-e amur boluyad irged  
ürejijü qamuy bodas öng elbeg boljuqui.  
ene süm-e-dür terigülügsen kümün. qamuy  
amitan-i duradqan uduriddun mön činar-i  
sayibar uqayulun. nigen üjegür-tü sedkil-  
iyer soyul jokiyal-tur qandaγulju. ulus ger-  
ün engke töbsin bolqu qutuγ jirγal-iyar  
erkilejü edletügei. eyimü bolbasu
17. qayan ečige-yin qamuy ayimaγ-ud-i  
örüsüen kisig kürtegegsen erdem sedkil-i  
ülü ütegerekü bolumui.
18. tngri-yin tedkügsen-ü qoyaduγar on jun-u  
terigün sar-a-yin sin-e-yin doluyan-a.

Дээрх харьцууллаас энэ удаад, уг бичээсийн орчуулгын онцлогийг үг болон холбоо үгийн түвшинд манж үгчилсэн орчуулгаас зөрүүтэй орчуулсан үгсээс түүвэрлэн тайлбарлая.

**Сэтгэ:** Тус хөшөөний бичээст манж хэлний γûni- (сана-) хэмээх язгуурт үг 5 удаа тохиолдох бөгөөд 4-ийг нь *сэтгэ* – мо. *sedki* (ма. *γûniči* - мо. *sedkibesü*; ма. *γûnin hungkereme* - мо. *sedkil siγudču*; ма. *bi γûniči* - мо. *bi sedkibesü*; ма. *γûnin-be urgederaqû* - мо. *sedkil-i ülü ütegerekü*; ма. *yendenurengge* - мо. *sedkil egüskegdeküi*) хэмээх язгуурт үгээр, 1 удаа тохиолдох ма. *γûnin-be* - мо. *dur-a-i* (*дурыг*) хэмээх үгээр орчуулжээ. Ш. Чоймаа ХIII, ХIV зууны үеийн монгол хэлэнд одоогийн “*бодох, санах*” хэмээх үгийн оронд зөвхөн “*сэтгэх*” хэмээх үг хэрэглэдэг байсныг өгүүлсэн буй (1990). Тэгвэл, тус хөшөөний монгол бичээсээс ХVIII зууны эхэн хүртэл монголчууд *сэтгэ*- хэмээх үгийг эдүгээгийн *бодох, санах* гэх үгийн утгаар идэвхтэй хэрэглэсээр ирсэн хэмээн үзэж болохоор байна. Харин *бодох, санах* хэмээх үгийг тийм ч идэвхтэй хэрэглэдэггүй байсан бололтой.

**Бээр:** Орчин цагийн монгол хэлнээ *тэр бээр, би бээр* гэж хэрэглэдэг *бээр* хэмээх үгийг ХIII, ХIV зууны үед түгээмэл хэрэглэдэг байсныг мөн судлаачид бүртгэн тодорхойлсон ба тус үг нь өгүүлбэрийн ямар ч гишүүний хойно ганц *бээр* хэлбэрээр орж, уг үгийн утгыг тодотгон ордог байжээ. Тухайлбал, Ш. Чоймаа “МНТ-д бээр хэмээх үг

нийт 75 удаа тохиолдох бөгөөд утгаар нь 1. өгүүлэхүүний илтгэгч болох буюу өгүүлбэрийн логик өргөлтийг илтгэнэ, 2. *ber* (бээр) сул үгийн ихэнхийг хүч нэмэгдүүлэх сул үг ч-ээр сольж ойлгож болдог” (2025: 187-194) хэмээн бичжээ. Хөшөөний бичээст ма. *Abqa musei* гэснийг үгчлэн орчуулбал мо. *tingri biden-ü* гэх бөгөөд хөшөөний бичээст *Tingri ber biden-ü* хэмээн бичсэн нь *бээр* хэмээх үгийг XVIII зуунд ч мөн үгийг тодотгогч утгаар хэрэглэсээр байсныг гэрчилж байна. Мөн бичээст ма. *ojoro ba aqû, giyalabure ba aqû* хэмээхийг мо. *boluγdayun ber ügei, jabsardaquun ber ügei* хэмээн орчуулсан бөгөөд манж хэлний *ba* хэмээх үгийг *бээр* хэмээн орчуулах уламжлалыг бусад баримттай тулган үзэж нягтлан үзэх хэрэгтэй болов уу.

**Богд:** Манж хэлний *enduringge* хэмээх үгийг *дээд* хэмээн орчуулдаг бөгөөд “*богд*” хэмээх нь монгол хэлнээ *дээд ламтан* гэсэн утгатай, XIII зууны бичгийн дурсгал болох “Тахимдуу бичиг”, “Махагалын магтаал”-д тохиолддог билээ. Харин ма. *enduringge* -ийг *богд* хэмээх үгээр орчуулдаг бөгөөд хөшөөний бичээст ма. *enduringge erdemu* - мо. *degedü erdem* хэмээн орчуулжээ. *Enduringge* хэмээхийг “Дайчин гүрний Дотоод яамны монгол бичгийн гэрийн данс”-д *богд, хувилгаан* хэмээн 2 янзаар орчуулсан бөгөөд эдүгээ ма. *enduringge*-ийг мо. *богд*, ма. *endurin*-ийг мо. *хувилгаан* гэж орчуулдаг билээ.

**Олон:** Ма. *geren* - мо. *olan* манж бичгээр *geren* хэмээх нь олон буюу цөөний эсрэг утгатай үгийг заах бөгөөд олныг заах утгатай *qamuy* буюу *хамах, цуглуулах* гэх утгатай үгээр орчуулжээ.

**Даргалуулах:** ма. *dalabuha* – мо. *bariyulbai* - *даргалуулах, тэргүүлүүлэх* гэх утгатай үгийг шашны эрх мэдлийг захируулав, мэдүүлэв гэх утгаар *баруулав* хэмээн оруулсан бололтой.

**Хамгаалах:** ма. *qarmatame* – мо. *qatayalan qarayaljaju* үгчлэн орчуулбал хамгаалж, хамгаалан гэх ба энд *хамгаалан харгалзаж* хэмээх ойролцоо үгээр хоршин орчуулжээ.

**Аваачих ~ илгээх:** ма. *γatafi* - мо. *ögçü ilegejü* манж хэлнээ аливаа юмыг авч одохыг *γatafi*- (аваачих) гэх бөгөөд монгол бичээст *өгч илгээж* гэж орчуулсан нь монгол, манж үндэсний сэтгэлгээний онцлог, ялгааг илтгэсэн байна. Го. Зоригтын дурдсанчлан, тухайн хоршоо үгэн дэх бүрдүүлбэр нь 1. Дангаар бие дааж хэрэглэгдэж байгаа эсэх, 2. Илтгэх утга санаа нь ил тод мэдэгдэж байгаа эсэх /бахь байдаг г.м./, 3. Үг бүтээх чадамж нь хэр байгаа, 4. Холбоо үг үүсгэх чадамжаар хир зэрэг байгаа, 5. Монгол бусад хэл аялгуунд байгаа эсэх зэргээр шалгуур хийж монгол хэлний ормол үгсийг ялган үзэх нь зүйтэй (1999: 27-41) гэжээ. Энэ нь зөвхөн сэтгэлгээ бус, монголчуудын орчуулгын онцлогийг илтгэж байна гэж үзэж болох мэт.

**Газар:** ма. *bade* – мо. *γajar dayan* - Газар хэмээх нь монгол хэлэнд нутаг орон гэсэн нэг л утгатай. Манжаар газрыг *ba* гэнэ. Хөшөөний бичээст 12 удаа *ba* (газар) тохиолдох бөгөөд ма. *ba-i* - мо. *jüig deki*, ма. *tulergi ba-i* – мо. *γadayadus*, ма. *baçi* – мо. *γajar-aça*, ма. *bade* – мо. *γajar dayan, oron-dur*, ма. *ba na de* – мо. *γajar oron-dur*, ма. *bade* – мо. *orod-tur*. Энэ үг газар гэхээс гадна явдал гэсэн утгатай. Хуучны бичээч нар энэ үгийг *явдал* гэсэн утгаар хэрэглэсэн зарим тохиолдлыг ялгаж салгахгүй *газар* хэмээн хутган орчуулж хэрэглэж байснаас яваандаа монгол хэлний газар гэх үг манж хэлнийх шиг хоёр утгатай болж аль ч утгаараа аман яриа ба бичигт нэгэн адил хэрэглэгдэх болжээ.

**Хийд ~ сүм:** Тус хийдийг Амар баясгалант хэмээн нэрлэсэн тухай бичээст буй бөгөөд ма. *urgun elhe sy*, мо. *amurbayasqulangtu keyid* хэмээн бичжээ. Манж бичгээрх ма. *urgun elhe sy*-г үгчлэн орчуулбал *баяр, амгалан (амар) сүм* гэж орчуулжээ. Харин монгол бичээс *амар баясгалант хийд* хэмээн бичжээ. Хөшөөний бичээснээ ма. *sy* гэх үг 2 удаа гарах бөгөөд түүнийг *хийд, сүм* хэмээн орчуулжээ. Харин ма. *tiyoo* гэж 3 удаа тохиолдох ба түүнийг мо. *keyid* (хийд) хэмээн орчуулжээ. *tiyoo* нь 廟 (miao) гэх хятад үгийг манж бичгээр тэмдэглэсэн хэрэг юм. *Хийд* нь бурханы шашны лам нар үе залган суух орон байрыг нэрлэх үг бөгөөд ХIII зууны үеийн дурсгал Хубилай хааны зарлигт тэмдэглэсэн бөгөөд *kheta* хэмээх санскрит үгээс гаралтай гэж үздэг (Төмөртоогоо 2018: 296).

**Гин хот:** Мөн бичээснээ ма. *ging hecen de* - мо. *ging qotan-dur* хэмээн 2 удаа гарч буй үгчлэн орчуулбал *нийслэл хотод* гэх бөгөөд монгол бичээст гин хотод (жин хотод) хэмээн орчуулжээ. Манжийн эхэн үеийн сурвалжуудад нийслэлийг гин, жин хэмээн хятад дуудлагыг баримтлан тэмдэглэсэн бөгөөд ХVIII зууны сүүл үеэс нийслэл хэмээн орчуулах болжээ. Энэхүү гин, жин нь хятад хэлний 京 (jīng) хэмээх үг болно.

**Ном судар:** Манж үгийн толь бичигт, *богд хүний тогтсон хуулийг ном хэмээмүй* гэжээ. Бичээст ма. *ging be giyangname* үгчлэн орчуулбал *номыг тайлбарлан, булаалдан* гэх ба монгол бичээст мо. *nom keleldiin* (ном хэлэлдэн) гэж яруу сайхан орчуулжээ. ма. *doro-be yabubuha*, үгчлэн орчуулбал *төрийг, ёсыг явуулав* гэх ба мо. *gürim üyiledken* (гүрэм үйлтгэн) гэж бурханы шашны номд хамаатуулан засал ном үйлдүүлэн гэх утгаар орчуулжээ. Ма. *ging bidhe be*-г үгчлэн орчуулбал *ном бичгийг* гэх ба бичээст мо. *nom sudur-i* (*ном судрыг*) хэмээн хоршоо үгээр орчуулжээ. Дашрамд дурдахад, *бич-* хэмээх үгийг судлаачид ихэвчлэн *biti-* гэдэг үгнээс гаралтай, орчин цагийн монгол хэлний “бичиг” гэдэг үг нь эртний грек хэлнээс сири, түрэг зэрэг хэлээр дамжсаар монгол хэлэнд ороод эртний монгол хэлнээс жүрчид-манж хэлэнд орсон түүхтэй хэмээн монгол хэлний ормол үг биш харин эсрэгээрээ монгол хэлнээс бусад хэлэд орсон гэж үзсэн байна.

**Газар ~ бээр:** ма. *tumen baçi yamulanjifi benjihe jafanjihangge umai laγcahaqū* хэмээх хэсгийг үгчлэн орчуулбал *түмэн газраас яамлахаар ирж хүрч ирсэн бариар ирсэн нь огт тасарсангүй* гэснийг *tūmen ber-e-yin činege yajar-ača yamular-a irejü alba bariγsayaγ yerü tasuriγsan ügei* хэмээн орчуулжээ. Энд *tumen baçi* гэх үгийн дунд *ber-e-yin činege* хэмээх үгийг тодотгон оруулжээ.

**Алба барих:** Бас манжаар алба барих гэхийг *alban jafanjire* гэх бөгөөд *jafanjihangge* гэснийг *alba bariγsayaγ* хэмээн тодотгон орчуулжээ. Мөн ма. *bade tere qooli songqoi obuha* - мо. *eteged oron-dur orosiγsan-i yosučilan bolyabai* буюу *суу-, агуул-* гэх утгатай үгийг *ориш-* гэсэн язгуураар, *хууль ёсоор, хууль ёсны* хэмээхийг *ёсчлон* хэмээн найруулан орчуулжээ.

**Бие ~ гэгээн, бараан хойд ~ өрнө, умар:** ма. *beye amba čooħa γaifi wargi amargi ječen-be nečihiyete toγtobume genehe de* гэхийг үгчлэн орчуулбал *биеэр их цэрэг авч баруун хойд хязгаарыг төвшитгөн тогтоогоор одсонд* хэмээснийг *Gegen-iyer yeke čerig abču örün-e umar-a jüg-ün jaq-a kijayaγ-i töbsidken toγtayaγ-a ögede boluγsan-dur* гэж орчуулсан ба үүнд *beye* хэмээхийг *гэгээнээр, wargi amargi ječen-be* -г *örün-e umar-a jüg-ün jaq-a kijayaγ-i* хэмээн хоршоо үгээр найруулан бичжээ.

**Одох – өөд болох:** Мөн одсонд, одвоос хэмээхийг өөд болсонд хэмээжээ.

**Огноо:** Мөн хөшөө бичсэн огноог манж бичээст *ma. duin biyai iče nadan* буюу дөрвөн сарын шинийн долоон хэмээснийг монгол бичээст *mo. jun-u terigün sar-a-yin sin-e-yin doluγan-a* (зуны тэргүүн сарын шинийн долоон) хэмээн орчуулжээ.

### ДҮГНЭЛТ

Дээрх ажиглалтаас үгийн сангийн харьцууллаас дүгнэн үзвэл, манж, монгол хэл нь нэг язгуурын хэлэнд хамаарах боловч үгийн сан, найруулга зүйн хувьд өөр өөрийн онцлог шинжтэй болох нь уг бичээсээс тодорхой харагдана. Түүнчлэн хөшөөний манж бичээст мөр тэтгэх, мөр дарах зэрэг монгол бичгийн уламжлалт ёсыг боловсруулан баримталсан нь монголчуудын бичиг үсэг төдийгүй албан бичгийн соёлыг ч мөн авч, боловсруулан хэрэглэж байсныг давхар илтгэнэ.

Харин монгол орчуулгын гол онцлог бол манж хэлний найруулгад авталгүй, монгол хэлний уламжлалт найруулгыг баримтлан утгачлан орчуулсанд оршино. Тухайлбал, манж хэлний *geren* буюу “олон” хэмээх үгийг зөвхөн шууд дүйцүүлэх бус “хотол”, “хамаг”, “бүгд” зэрэг ойролцоо болон салаа утгат үгсээр баяжуулан орчуулсан байна. Ийнхүү тус хөшөөний бичээст үгчилсэн бус, утгад тулгуурласан орчуулгын арга барилыг баримталсан нь тухайн үеийн орчуулгын зарчим, хэл найруулгын онцлогийг тодорхой харуулж байна. Эцэст нь, энэ мэтчилэн өөр олон төрлийн албан бичгийн орчуулгыг харьцуулан судалснаар, манж, монгол сурвалж судлал, манжийн үеийн албан бичгийн орчуулгыг нэхэн судлахад чухал хувь нэмэр болохыг тэмдэглэе.

### НОМ ЗҮЙ

Монгол хэлээр

*Архивын баримт* М-87, Д-1, ХН-27а

Баярсайхан, М., (2007). Монгол, манж албан бичгийн харьцаа, *Acta Mongolica* Vol.7(291). 155-170.

Баярсайхан, М., Монгол албан бичгийн уламжлал дахь хүндэтгэл илэрхийлэх ёсон, “Монголчууд ба монгол бичиг” эрдэм шинжилгээний хурал, 2012.11.12-15

Баярсайхан, М., & Отгонтуул, Т. (1997). *Монгол манж толь бичиг*, Улаанбаатар.

Баярсайхан, М., Энхсүвд Б., (2024). Монгол хэлэнд манж хэлнээс орсон үгс, *Altaica* tom. XX. fasc.3.

Гэрэлээ, Б., (2025). *А. М. Позднеев Монгол ба монголчууд I боть*. Улаанбаатар.

Гэрэлбадрах, Ж., (2006). *Эрдэнийн эрх хэмээх түүх болой*, Улаанбаатар.

Гэрэлбадрах, Ж., (2015). *Галдан туслагчийн Эрдэнийн эрх*, Улаанбаатар.

Даваасүрэн Б. (2005). *Алтай овгийн хэлнүүд*, Улаанбаатар

Котвич В. (1962). *Исследование по Алтайским языкам*. Москва.

Мөнх-Учрал, Э., (2010). Манж албан бичгийн хүндэтгэл илэрхийлэх ёсноос. *Acta Mongolica* Vol.10(342). 77-108.

Мөнхцэцэг, Э., (2023). *XVIII зууны үеийн манж толь бичгүүдийн үгийн сангийн судалгаа*, Улаанбаатар.

- Нансалмаа, Н., (2011). *Хэлишинжлэлийн судалгааны аргазүй*, Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Позднеев А.М. (1896). *Монголия и монголы. Результаты поездки в Монголию, исполненной в 1892-1893 гг.* Дневник и маршрут 1892 года. Том 1.
- Ринчен, Б., (2017). *Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас*, Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган. IX боть, Улаанбаатар.
- Төмөртогоо, Д., (2018). *Монгол хэлний үгийн гаралын толь*, Улаанбаатар: Адмон Принт.
- Цоодол, И., (2000). *Огторгуйн чимэг Амарбаясгалант хийдийн түүхэн шастир оривой*, Улаанбаатар.
- Цэдэндамба, С. ред. (2009). *Монголын сүм хийдийн түүхэн товчоон*. (Улаанбаатар.
- Шархүү, Ц., & Лувсанжав, Чой. (1968). *Манж монгол толь*, Улаанбаатар.
- ШУА-ийн Археологийн хүрээлэн, ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс. (2006). *Дэлхийн өвийн монголын үндэсний хороо, Монгол нутаг дахь соёлын үл хөдлөх өвийн хадгалалт, хамгаалалт*, Улаанбаатар.
- ШУА-ХЗХ (2025). *Монгол, манж хэлний харьцаа, хамаарал*, Улаанбаатар.
- Цоодол, И., (2004). *Огторгуйн чимэг Амарбаясгалант хийдийн түүхэн шастир оривой*, Улаанбаатар.
- Чоймаа, Ш., (1990 оны 8-р сар.). Монголын нууц товчооны “сэтгэх” хэмээх үгийн тухай. *МНТ-ны 750 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурал*. Улаанбаатар.
- Чоймаа, Ш., (2025). “Монголын нууц товчоон”-ы зарим сул үгийн тухай, *Монголын нууц товчоон судлал*, Бүтээлийн чуулган. I боть. Улаанбаатар: Соёмбо принтинг. 187-194-р тал.
- Цэвэл, Я., (2023). *Монгол хэлний товч тайлбар толь* (нэмж дэлгэрүүлсэн тавдугаар хэвлэл)
- Эгшиг, Ш., (2013). *Гэрэлт хөшөөний хадмал бичээс нь орчуулгын харьцуулалд чухал хэрэглэгдэхүүн болох нь*, Орчуулгын уламжлал шинэчлэл эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал, Орчуулга зүй, I боть. Улаанбаатар. 87-92.

Гадаад хэлээр

- Henning, Eckart. (2004). *Die Archivalischen Quellen*. Wien: Böhlau Verlag Köln Weimar.
- Poppe, Nicolas. (1965). *Introduction to the Altaic Linguistics*, Otto Harrasowitz, Wiesbaden.
- Rachewiltz I. de, V. Rybatski. (2010). *Introduction to the Altaic Philology*, HdO, Vol. 20, Brill, Leiden-Boston.
- 최 동 권 (2004 ) (Amarbayasgalant khiid) 비문 연구  
<https://mongoltoli.mn/>  
<http://www.cneas.tohoku.ac.jp>  
[https://whc.unesco.org/en/tentativelists/5947/?utm\\_source=chatgpt.com](https://whc.unesco.org/en/tentativelists/5947/?utm_source=chatgpt.com)

# **ОРЧУУЛГЫН ШҮҮМЖ СУДЛАЛ**



## Д.НАЦАГДОРЖИЙН “ХУУЧИН ХҮҮ” ӨГҮҮЛЛЭГИЙН ОРОС ОРЧУУЛГУУДЫГ ӨНГӨЦ ШИНЖИХҮЙ ДОР...

С.Эрдэнэмаам<sup>42</sup>

*Хураангуй:* Орчин цагийн Монголын уран зохиолоос орос хэлэнд орчуулж эхэлсэн үе, нэн ялангуяа Д.Нацагдоржийн бүтээлүүдээс, тэр тусмаа алдарт “Хуучин хүү” өгүүллэгийн эхэн болон хожуу үеийн зарим орос орчуулгыг харьцуулан шинжилж, утга агуулга, хэл найруулга нь эхтэйгээ хэрхэн таарч тохирч байгаа байдалд дүн шинжилгээ хийж, өөрийн байр суурийг илэрхийлэх зорилгоор энэхүү шүүмж-өгүүллэгийг тэрлэв. Ингэхдээ тэдгээр орчуулгын үнэ цэнийг бууруулах зорилго өчүүхэн ч үгүй бөгөөд, харин монгол хэлний тансаг яруу аялгуу, ахуй соёлын хосгүй нандин өв соёлыг өөр хэлэнд орчуулах ажил нэн хариуцлагатай, зарим тохиолдолд бараг боломжгүй зүйл юм гэдгийг цухас дурдах гэснээ цохон тэмдэглэсүү.

*Түлхүүр үг:* нүүдэлчин ахуй, шалдар булдар, ороо бусгаа, элстэй шанд, буттай цайдам

### УДИРТГАЛ

Монголын орчин цагийн уран зохиолыг орос хэлнээ хөрвүүлсэн түүхийг тоймлон үзвэл “Танин мэдэхүйн үе” (XIX зууны төгсгөл – XX зууны эхэн) болон “Алтан үе” (XX зууны дунд үе) гэсэн үндсэн хоёр шаглалд хувааж болох юм. Энэхүү соёлын буянтай үйлс нь анх шинжлэх ухааны экспедиц, угсаатны зүйн судалгааны дагалдах бүтээгдэхүүн болж эхэлсэн түүхтэй ажээ. Нэрт монголч эрдэмтэн Г.Н. Потанин, А.М. Позднеев нар монгол ардын аман зохиол, туульс, домгийг анхлан орос хэлнээ буулгасан нь дэлхий дахинд “Монгол” хэмээх өвөрмөц сэтгэлгээтэй ард түмнийг таниулах анхны алхам болсон байна. Ялангуяа 1923 онд Б.Я. Владимирцов “Монгол-Ойрадын баатарлаг туульс”-ыг хэвлүүлсэн нь Европын уншигчдад монгол хэлний дүрслэх ур чадвар, баялаг санг гайхуулсан түүхэн үйл явдал байв.

Харин 1921 оны Ардын хувьсгалын дараа Монголын шинэ үеийн уран зохиол цэцэглэн хөгжихөд Оросын орчуулагчид соёлын “хөтөч” болон ажилласан тэрхүү цаг үеийг бид “Алтан үе” хэмээн нэрийдэж байна. Чухам энэ үед шинэ уран зохиолыг үндэслэгч их зохиолч Д.Нацагдоржийн бүтээлүүдийг Л. Сейфуллина, П. Скосырев, А.Твардовский, А. Михайлов, Г.Михайлов, Л.Герасимович, П.Кассьяненко, И.Сельвинский, Н.Тихонов зэрэг гарамгай зохиолч, орчуулагчид барьж авсан юм. Тэд зөвхөн агуулгыг дамжуулаад зогсохгүй, Д.Нацагдоржийн хэлний өвөрмөц хэмнэл, монгол ахуйн гүн ухааныг орос хэлний баялаг сангаар дамжуулан илэрхийлэхийг зорьж байжээ.

Ийнхүү монгол уран зохиолын дээжис орос хэлээр хэвлэгдэн гарснаар дараах гурван том ач холбогдлыг авчирсан гэж үзэж болох юм. Үүнд:

а/. Орос хэл нь тухайн цаг үед дэлхийн гол хэлнүүдийн нэг байсан тул монгол зохиолчдын бүтээл түүгээр дамжин бусад олон хэлэнд орчуулагдах “гүүр”-тэй болж, дэлхийн тавцанд гарах эхлэл тавигдсан;

<sup>42</sup> Доктор, профессор, МУБИС

б/.Нүүдэлчин ахуйн “шалдар булдар”, “ороо бусгаа” мэдрэмжийг суурин иргэншлийн хэлээр тайлбарлаж өгснөөр өөр өөр соёлтой ард түмнүүдийг сэтгэл зүйн хувьд ойртуулж, “сэтгэлгээний эв нэгдэл”-д хөтөлсөн;

в/. И.Сельвинский, Н.Тихонов зэрэг оросын сод найрагчид монгол зохиолуудыг уран сайхны өндөр түвшинд “дахин амилуулсан” нь манай уран зохиолын чансааг олон улсад хүлээн зөвшөөрүүлсэн юм.

Гэвч өнөөгийн өндөрлөгөөс харахад, тухайн ард түмний өвөрмөц соёл, тансаг яруу хэл найруулгыг өөр хэлэнд бүрэн гүйцэд хөрвүүлнэ гэдэг туйлын хүнд сорилт болох нь ажиглагдаж байна. Соёл гэдэг нь тухайн ард түмний амьдралын өвөрмөц хэв маяг бөгөөд, тэрхүү хэв маягийг илэрхийлэгч өвөрмөц үг хэллэгийг орчуулагч хүн өөр хэлэнд хөрвүүлэхдээ соёлын гүн зөрчилтэй тулгардаг хэмээн Их Британийн нэрт онолч Питер Ньюмарк онцлон тэмдэглэсэн байдаг [Newmark, 1988, p. 94].

Зохиолчийн өвөрмөц найруулга, үг сонголтын цаана нуугдах нарийн нандин утга, торгон мэдрэмжийг дамжуулах нь “бараг боломжгүй” зүйл гэдгийг Д.Нацагдоржийн “Хуучин хүү” өгүүллэгийн хэд хэдэн орчуулгыг тулган шинжлэх явцад харж болно. Энэхүү шинжилгээ нь агуу орчуулагчдын нөр их хөдөлмөрийг үгүйсгэж буй хэрэг бус, харин хэл хоорондын соёлын шилжилт, утгын алдагдал болон “орчуулагдашгүй” өнгө аясыг илрүүлэн гаргахад чиглэсэн болно. Энэ дашрамд, Оросын нэрт эрдэмтэн В.Н. Комиссаров тухайн ард түмний ахуй, соёлыг илэрхийлэгч “дүйцэлгүй үг хэллэг”-ийг орчуулахдаа зөвхөн үгийн утгыг бус, түүний цаана нуугдах “соёлын мэдээлэл” (cultural background)-ийг дамжуулах нь хамгийн чухал болохыг сануулсан байдаг билээ [Комиссаров, 1990, с. 148]. Энэхүү санааг Д.Нацагдоржийн “Хуучин хүү” өгүүллэгийн эхэн (1936-1956) болон хожуу (1960-1980) үеийн орчуулагчдын зарим орчуулгын жишээн дээр авч үзье:

<b>Д.Нацагдорж</b>	<b>Л. Сейфуллина</b>	<b>П. Скосырев</b>	<b>А. Твардовскийн редакторласан хувилбар</b>
Хөдөөгийн байдал шалдар булдар, цагийн улирал ороо бусгаа, элстэй шанд, буттай цайдмыг дагаж, хааяа нэг хар гэрээс утаа суунаглана.	Жизнь в степи уныла и однообразна. Времена года сменяют друг друга, погода непостоянна. Вдоль песчаных солончаков и кустарников кое-где вьется дымок над черной юртой.	Скудна и убога жизнь в степи. Времена года сменяются непостоянно. Вдоль песчаных распадков и заросших кустарником лощин лишь изредка вьется дымок над бедной черной юртой.	Жизнь в степи скудна и однообразна. Времена года сменяют друг друга в вечном круговороте. Среди песчаных лощин и скудных зарослей лишь изредка вьется дымок над одинокой черной юртой.

Өгүүллэгийн хамгийн эхний энэ өгүүлбэрийн эдгээр орчуулгыг ажиглахад, Л.Сейфуллина “шалдар булдар”-ыг зөвхөн эдийн засгийн “ядуу” гэсэн утгаар хязгаарлаж, их Нацагдоржийн хэлсэн тэр нэгэн “зохисгүй, эрээвэр хураавар” ахуйн дүр төрхийг гэсэн бол П.Скосырёв “шалдар булдар” гэдэг үгийг цэвэр нийгмийн эмгэнэл, ядуурал тал руу нь хэтэрхий хүндрүүлж буулгажээ. Нацагдоржийн “шалдар булдар” гэдэгт нэг тийм “олиггүй, замбараагүй, жижиг сажиг” гэсэн өнгө аяс байдаг болохоос биш, заавал “өрөвдөлтэй ядуу” (убогая) гэсэн утга голчилдоггүй билээ. Мөн тэрээр “ороо бусгаа” -г “сменяются непостоянно” гэсэн нь зохиогчийн энэхүү алдарт хэллэгийн эрчмийг бүрэн “унтраажээ” гэж хэлж болно, яагаад гэвэл “улирал солигдох” нь байгалийн жам тул “тогтворгүй солигдоно” гэдэг нь утга зүйн хувьд ч сул, дүрслэлийн хувьд ч “ороо бусгаа морь”

шиг догшин шинжгүй байна. Алдарт зохиолч А.Твардовский “шалдар булдар”-ыг “скудна и однообразна” гэжээ. Гэтэл “шалдар булдар” гэдэг бол “нэг хэвийн” гэсэн үг огт биш. Энэ бол эмх замбараагүй, олигтой юмгүй, эрээвэр хураавар байдлыг хэлж буй хэрэг. Твардовский “нэг хэвийн” гэж буулгаснаар их Нацагдоржийн хэлэх гэсэн “зохисгүй, жигд бус” гэх динамик санааг эсрэгээр нь хөдөлгөөнгүй, статик болгож орхисон байгаа нь утга зүйн томоохон “төөрөгдөл” юм. Мөн тэр бээр “цагийн улирал ороо бусгаа”-г “*Времена года сменяют друг друга в вечном круговороте*” гэж маш гоё, сонгодог өгүүлбэрээр орчуулжээ. Гэвч “ороо бусгаа” гэдэг үгэнд байгаа тэрхүү “эмнэг хангал, тааварлашгүй, догшин шинж”-ийг бүрэн номхруулж, “мөнхийн эргүүлэг” гэж буулгасан нь байгалийн зүй тогтол, амар амгалан тал руугаа хазайж, зохиогчийн тэрхүү нийгмийн “ороо бусгаа” байдлыг илэрхийлсэн түгшүүртэй зүйрлэлийг “номхотгоод” гэрийн тэжээвэр амьтан шиг “сүр сүлдгүй” болгочихжээ гэлтэй.

Түүгээр ч үл барам тэрээр орос хүний сэтгэлгээгээр “тал нутагт нэг гэр байх нь ганцаардал юм” гэж төсөөлөөд, “одинокая” (ганц бие) гэдэг үг нэмж хачирласан байна. Энэ нь зохиогчийн санаанд байхгүй “экзистенциал гуниг”-ийг хүчээр тулгаж, Нацагдоржийн бодит, “шалдар булдар” ахуйн зураглалыг романтик болгож өөрчилсөн хэрэг юм. Нэг үгээр хэлбэл, А. Твардовскийн редакторласан хувилбар нь орос хэлний найруулга зүйн хувьд төгс, сонсголонтой өгүүлбэр болсон боловч Нацагдоржийн “зэрлэг” бөгөөд “хурц” бичлэгийн хэв маягийг орос яруу найргийн сонгодог “жааз”-нд хүчээр оруулж хүлсэн байна. “Ороо бусгаа” цаг хугацааг “мөнхийн эргүүлэг” болгон номхотгосон нь нүүдэлчин сэтгэлгээний тэрхүү эрс тэс, тааварлашгүй мөн чанарыг унтрааж, орос уншигчийн тархинд “тайван, гунигтай” талын дүр төрхийг буулгажээ.

Харин хожуу үеийн алдарт орчуулагч Г.Михайлов энэ өгүүлбэрийг “*Облик степи захудалый, круговращение времён года непостоянно...*” хэмээн орчуулжээ. Энд “захудалый” (хоцрогдмол) гэж буулгаснаар “шалдар булдар”-ын нийгмийн утгыг Твардовскийн “нэг хэвийн” гэх утгаас хавьгүй илүү гаргаж иржээ. Мөн нэрт орчуулагч эрдэмтэн Л. Герасимович “*Вид степи невзрачен, смена времён года сумбурна...*” хэмээжээ. “Сумбурна” (эмх замбараагүй, будилаантай) гэдэг үг бол “ороо бусгаа” гэдэг монгол үгний тэрхүү тааварлашгүй, догшин шинжийг орос хэлээр хамгийн дөхөж буулгасан эрдэмтэн хүний ололт хэмээн үзэж болохоор байгаа юм.

Хэдийгээр Л.Герасимович, Г.Михайлов нар “шалдар булдар”, “ороо бусгаа” гэх үгсийн утга зүйн нарийн холбоосыг орос хэлнээ шинжлэх ухаанч түвшинд гаргаж ирсэн ч, Нацагдоржийн хэрэглэсэн “ороо бусгаа” (морь) гэх нүүдэлчдийн ахуй соёлын гүн зүйрлэлийг дүрслэлийн хувьд бүрэн гүйцэд “амилуулж” чадаагүй мэт санагдана. Иймээс эх зохиолын дотоод эрчим, “эмнэг хангал” мөн чанарыг хадгалахын тулд дараах хувилбарыг санал болгож байна:

*Вид степи неказист, а смена времён года необузданна... лишь изредка вьётся дымок над закоптелой юртой.*

Санал болгож буй энэхүү хувилбараа тайлбарлавал:

а/. Өмнөх орчуулагчид “уныла” (гунигтай), “скудна” (ядуу зүдүү) гэх мэт үгс хэрэглэсэн нь хэтэрхий нэг талыг барьсан хэрэг байв. Бид яагаад “неказист” гэдэг үгийг авсан бэ гэвэл, монгол хэлний “шалдар булдар” гэдэг нь харахад нүдэнд тусах зүйлгүй, өнгө зүсгүй, эмх замбараагүй гэсэн утгыг агуулдаг. Орос хэлний “неказист” гэдэг үг нь “харахад гавьтай зүйлгүй ч, цаанаа нэг утга учиртай, эгэл жирийн” гэсэн өнгийг илэрхийлдэг. Энэ нь Нацагдоржийн хэлэх гэсэн “хөдөөгийн байдал нэг л олиггүй” гэх мэдрэмжийг нийгмийн ядуурал руу хэт хазайлгахгүйгээр, бодитойгоор буулгаж байна хэмээн үзсэнийх билээ.

б/. “Ороо бусгаа”-г яагаад “необузданна”-гаар орчуулсан нь дээр гэж үзсэн бэ гэвэл, дээрх орчуулагчид “непостоянна” (тогтворгүй) гэдэг нь цаг агаарын мэдээ мэт дэндүү хуурай хөндий сонсогдож байсных билээ. “Ороо бусгаа” гэдэг үг нь өөрөө “ороо морь” гэдэг утгаас гаралтай, номхроогүй, зэрлэг, догшин шинжийг агуулдаг. Орос хэлний “необузданна” (номхоршгүй, хазаарлагдашгүй) гэдэг үг нь яг энэ “эмнэг” шинжийг гаргаж ирнэ. Энэ нь байгаль дэлхий өөрөө

хэзээ ч хүний хүслээр байдаггүй, догшин, эрчимтэй гэдгийг харуулж, Нацагдоржийн хэрэглэсэн динамик дүрслэлийг амилуулж байгаа хэрэг билээ.

в/. Дээрх орчуулагчид “черная юрта” (хар гэр) гэж шууд үгчилсэн нь орос уншигчдад “хар өнгөтэй гэр” гэж ойлгогдоход хүргэнэ. Гэтэл монгол хэлэнд “хар гэр” гэдэг нь утаанд идэгдсэн, хуучирсан гэсэн ахуйн утгатай. Иймд бид “закоптелая” гэсэн үгийг оноолоо, яагаад гэвэл энэ үг нь “утаа тортог болсон, хөө хуяг суусан” гэсэн утгатай. Энэ нь “хар гэрээс утаа суунаглана” гэсэн дүрслэлийг орос хүний тархинд “өнгө” биш, харин “үнэр, амьдрал, хуучирсан байдал” болгож буулгах хамгийн оновчтой хувилбар хэмээн үзсэн болно.

Одоо өгүүллэгийн хоёр дахь догол мөрийн орчуулгыг харьцуулан үзэцгээе:

Д.Нацагдорж	Л. Сейфуллина	П. Скосырев	А. Твардовский
Дөрвөн зүг цэв цэлийн уйтгартай, цагаан униар тунана. Зуны лүгхийм халуун эсгий гэрийг шарж, малчин хүний сэтгэлийг бухимдуулна.	На все четыре стороны — пустота и тишина, стоит белесый маревом. Душный зной лета накаляет войлочную юрту, угнетая душу скотовода.	На все четыре стороны — унылая пустота, подернутая белым маревом. Изнуряющий зной лета накаляет войлок, томя душу степняка.	На все четыре стороны — безмолвная пустота в белесом мареве. Душный летний зной накаляет войлок, томя душу арарата.

Байгалийн дүр төрхөөс хүний сэтгэл зүй рүү шилжиж байгаа энэхүү догол мөрийн орчуулгуудыг харьцуулан үзэхэд, Сейфуллина “цэв цэлийн” гэхийг “пустота и тишина” (хоосон бөгөөд нам гүм), Твардовский “безмолвная пустота” (аниргүй хоосон) гэж буулгажээ. Гэтэл “цэв цэлийн” гэдэгт зөвхөн аниргүй байдал биш, харин нэгэн хэвийн үргэлжилсэн, уйтгартай орон зайн далайц байгаа хэмээн ойлгож болно. П.Скосырев “унылая пустота” (уйтгартай хоосон) гэсэн нь “уйтгартай” гэдэг санааг нь гаргасан боловч, “цэв цэлийн” гэдэг дүрслэлийн хүчийг дутуу илэрхийлжээ. Харин Твардовский “безмолвная” гэсэн нь тэрхүү хөдөлгөөнгүй, царцсан мэт байдлыг гаргахад дөхсөн байна гэж үзэж болохоор байна.

“Зуны лүгхийм халуун” гэсэн санааг орчуулсны хувьд, “лүгхийм” гэдэг бол зөвхөн халууныг биш, харин агааргүй, хүнд, дээрээс дарсан, бүгчим халууныг хэлдэг нүүдэлчдийн соёлыг илтгэдэг өвөрмөц үг. Сейфуллина, Твардовский нар “душный зной” (бүгчим халуун) гэсэн нь орос хэлэнд ихэвчлэн хот суурин, эсвэл чийглэг газар тохиолддог халууныг хэлдэг үг юм. Скосырев “изнуряющий зной” (тамирдуулам халуун) гэсэн нь арай илүү хүчтэй боловч “лүгхийм” гэдэг үгэнд байх тэрхүү “хүнд, доошоо дарамталсан” мэдрэмжийг бүрэн илэрхийлж чадахгүй байна. Бидний бодлоор бол энэ хэсэгт, орос хэлний “тнёт” (дарамт) эсвэл, “тяжёлый зной” гэдэг утгыг агуулсан “палящий, тягучий зной” гэвэл илүү дөхөх мэт.

Дээрх орчуулагчид бүгдээрээ “... эсгий гэрийг шарж ...” гэхийг "накаляет" (халаах, улайсгах) гэжээ. Энэ нь техникийн хувьд зөв боловч “шарах” гэдэг үгэнд байгаа тэрхүү гал дээр мах шарах мэт, амьд организмыг төөнөж буй тэрхүү “харгис” утгыг жаахан зөөлрүүлчихсэн мэт санагдана.

Мөн “... малчин хүний сэтгэлийг бухимдуулна” гэсэн төгсгөлийн энэ хэсэгт орчуулагчид нэлээд төөрөлджээ. Сейфуллина “угнетая” (дарлах, хавчих) гэсэн нь улс төрийн, эсвэл нийгмийн дарамт шиг сонсогдож байгаа бол, Твардовский, Скосырев нар “томя душу” (этгэл зовоох, шаналгах) гэсэн нь илүү романтик, хайр дурлалын шаналал шиг өнгө аястай болсон шиг санагдана.

Нацагдоржийн “Хуучин хүү”-д байгаль бол зөвхөн дэвсгэр зураглал төдий биш, харин хүнийг хааш нь ч гаргахгүй “бүгчимдүүлж” буй нийгмийн шоронгийн дүрслэл юм. Орос орчуулагчид үүнийг “байгалийн сайхан”, эсвэл “байгалийн хүнд нөхцөл” гэж анхдагч утгаар нь

хүлээж авсан тул “бухимдал” гэдэг үгийг зүгээр л “сэтгэл санаа тавгүйрхэх” (томить душу) төдийхнөөр буулгасан нь утгын алдагдалд хүргэсэн гэж үзэж болохоор байна.

Энэхүү хоёр өгүүлбэрийг зохиогчийн хэлэх гэсэн санаа, хэл найруулгын онцлогт илүү дөхүүлэх үүднээс бид дараах хувилбарыг санал болж байна:

*“С четырёх сторон — бескрайняя, тоскливая ширь в белесом мареве. Тяжёлый зной лета палит войлочную юрту, нагоняя на душу скотовода безысходную досаду”.*

Дээрх орчуулагчдынхаас юугаараа өөр, яагаад гэдгийг тайлбарлавал.

а/. “Цэв цэлийн уйтгартай” гэхийг “бескрайняя, тоскливая ширь” хэмээн авлаа. Учир нь өмнөх орчуулгад байсан “пустота” (хоосон чанар) гэдэг үг нь хэтэрхий “үхээнц”, юу ч байхгүй гэсэн утга руу хөтлөөд байх мэт. Гэтэл “цэлийх” гэдэг нь юу ч байхгүй биш, харин ч хязгааргүй үргэлжилсэн орон зайн далайц юм. Орос хэлний “ширь” гэдэг үг нь яг энэ уудам тал нутгийн цэлийсэн байдлыг илэрхийлэх агаад, “бескрайняя” (хязгааргүй) гэх тодотголтой нийлэхээрээ их Нацагдоржийн хэлсэн тэрхүү нүд алдам, нэгэн хэвийн уйтгарт дүр зургийг амьд болгож байгаа хэрэг хэмээн үзлээ.

б/. “... лүгхийм халуун... шарж” гэснийг “тяжёлый зной... палит” хэмээх саналтай. “Лүгхийм” гэдэг нь агаарын хөдөлгөөнгүй, хүнд, дээрээс дарах мэт халууныг хэлдэг. “Тяжёлый зной” (хүнд халуун) гэж буулгаснаар тэрхүү физик дарамтыг орос уншигчид мэдрүүлнэ хэмээн үзэв. Мөн “накаляет” (халаах) гэдэг нь техникийн үйл явц шиг сонсогддог бол “палит” (төөнөх, шарах) гэдэг үг нь их Нацагдоржийн “шарж” гэсэнтэй утга болон дүрслэлийн хувьд яг дүйх мэт. Энэ нь зөвхөн дулаан биш, харин амьд болгоныг “хөлс гаргаж, бачимдуулсан” тэрхүү “харгис” гэмээр халууныг илэрхийлнэ.

в/. “Бухимдуулна” гэснийг “нагоняя безысходную досаду” гэв. “Томить душу” (шаналгах) гэдэг нь дээр дурдсанчлан хэтэрхий “яруу найргийн” зөөлөн сонсогддог гэж дээр тэмдэглэсэн билээ. Их Нацагдоржийн “бухимдал” бол нийгмийн гацалт, өөрчлөгдөхгүй байгаа ахуйн эсрэг чиглэсэн дотоод бачимдал юм. “Безысходная досада” (гарцгүй бачимдал) гэдэг нь юу ч хийж чадахгүй байгаадаа өөртөө болон орчиндоо цухалдах тэрхүү гүнзгий мэдрэмжийг илэрхийлж, зохиолчийн “Хуучин хүү”-гээр дамжуулан хэлэх гэсэн далд санаа (нийгмийн шүүмжлэл)-г бүрэн гаргаж ирж байгаа хэрэг хэмээн үзлээ.

Өгүүллэгийн гурав дахь догол мөрийн орчуулгуудыг шинжлэн үзвэл:

Д.Нацагдорж	Л. Сейфуллина	П. Скосырев	А. Твардовский
Айлын хаяагаар үхрийн баас үргэлжилжээ. Үүгээр түүгээр хэдэн тугал оодгонон давхина.	Возле жилья тянутся кучи навоза, там и сям скачут телята.	Возле хаты тянутся кучи навоза, там и сям скачут телята.	Эту часть опустил почему-то.

Энд “Айлын хаяагаар...” гэснийг Сейфуллина “Возле жилья тянутся кучи навоза...” хэмээж, “жилье” (сууц) гэдэг ерөнхий нэр томъёо ашигласан нь нэг их хал балгүй сонголт боловч, нүүдэлчин ахуйн “гэр” гэдэг өнгө аясыг бага зэрэг бүдгэрүүлжээ. П.Скосырев “Возле хаты тянутся кучи навоза...” гэж буулгаад, “хата” гэдэг үг ашигласан нь их сонин байна. Энэ нь ихэвчлэн Украин, өмнөд Оросын тосгон, эсвэл шавар байшинг хэлдэг. Монгол гэрийг “хата” гэж буулгасан нь тухайн үеийн уншигчдад ойртуулах гэсэн оролдлого байж болох ч, ахуйн хувьд алдаатай сонголт болов уу. Харин Твардовский энэ хэсгийг орхисон нь найруулгын хэмнэл, эсвэл утга санааны хувьд “үхрийн баас”-ыг чухал биш гэж үзсэн байж болох юм. Гэвч энэ нь монгол ахуйн бодит дүр төрхийг гэсэн хэрэг хэмээн үзүүштэй.

Энэ хэсэгт орчуулагчид “үхрийн баас” (навоз) гэдэг үгнээс илүүтэй, “гэр” буюу “айлын хаяа” гэдгийг хэрхэн буулгах тал дээр ихээхэн төөрөлдсөн бололтой. Их зохиолч маань маш бодитой, нүдэнд харагдахуйц зураглан үзүүлсэн байхад Сейфуллина хэт ерөнхий, Скосырев

Оросын тосгоны ахуй руу “хүчээр” оруулсан (хата), харин Твардовский гоо зүйд нийцүүлэх үүднээс ч юм уу “цэвэрлэхсэн” байна. Энэ дашрамд тэмдэглэхэд, орчуулга гэдэг зөвхөн үг солих биш, соёлыг “гээвэрлэх” ажил гэдэг нь эндээс л харагдаж байна уу даа гэлтэй. Сүүлийн үеийн орчуулгуудад “гэр”-ийг шууд “ger”, эсвэл “yurt” гэж орчуулдаг болсон нь илүү оновчтой байж магадгүй юм. Орчуулагчдын гаргасан “хата” (байшин), эсвэл “навоз” (түүхий баас/ялгадас) гэх мэт үгс нь монгол ахуйн “аргал, хот айл, зэлний хаяа” гэсэн дулаан уур амьсгалыг арай л “хүйтэн” болгоод байна уу даа гэсэн бодол төрсөн учраас бид энэ хоёр өгүүлбэрийг дараах байдлаар орчуулбал агуулга, ахуй соёл, найруулгын хувьд илүү дөхөмтэй байж магадгүй хэмээн үзлээ:

*“Вдоль границ стойбища тянутся гряды коровьего помета. Там и сям весело вскидывают хвосты телята”.*

Яагаад ийнхүү өөрчилснөө тайлбарлавал:

а/. “Айлын хаяагаар ...” гэснийг “Вдоль границ стойбища ...” хэмээн оноов. Учир нь “стойбище” гэдэг үг нь “жилье” (орон сууц) гэснээс нүүдэлчин ахуйг (хот айл, бууц) хамаагүй илүү илэрхийлнэ. “...границ” гэдэг нь яг тэр хүрээ хязгаарыг буюу “хаяа”-г зааж байгаа билээ.

б/. “... баас үргэлжилжээ” гэснийг “тянутся гряды” гэлээ. Яагаад гэвэл “кучи” (овоолго) гэхээр нэг л бохир “харагдаад” байна. Харин “гряды” (эгнээ, нуруу) гэвэл нөгөө хаяагаар доторлосон, үргэлжилсэн байдлыг нь илүү уран гоёор харуулах болов уу хэмээн сэтгэв.

в/. “баас”-ыг “помет” гэдэг үгээр орчуулав. Учир нь “навоз” гэдэг үг орос хүнд шууд л өтөг бууц, бордоо гэсэн хүнд утгыг санагдуулдаг билээ. “Помет” гэвэл арай “цэвэрхэн” буюу байгалийн дүрслэл талдаа орох буй заа.

г/. “... оодгонон давхина” гэснийг “весело вскидывают хвосты” хэмээн дүйлгэх саналтай. Яагаад вэ гэвэл, “... скачут” (үсрэх) гэдэг үгэнд “оодгонох” гэдэг тэр монгол ахуйн аяс байхгүй. Орос хэлэнд тугал сүүлээ өргөж давхихыг “вскидывать хвост” гэдэг бөгөөд энэ нь яг “оодгонох”-той утга дүйх билээ.

Одоо өгүүлэгийнхээ дараагийн өгүүлбэрийн орчуулгыг харьцуулан харцгаая:

Д.Нацагдорж	Л. Сейфуллина	П. Скосырев	А. Твардовскийн редакторласан хувилбар
Хөлд орохоос аваад, үс цайхыг хүртэл нэг голыг өгсөн уруудан нүүж, нэг худгийг эргэн тойрон нутагласаар, энэхүү ертөнцийг эцэслэнэ.	С тех пор как начал ходить и до седых волос, человек кочует вверх и вниз по одной и той же реке, кружит вокруг одного и того же колодца и так заканчивает свой земной век.	С тех пор как встал на ноги и до тех пор, пока волосы не побелели, кочует человек вверх и вниз по одной и той же реке, кружит вокруг одного и того же колодца, пока не закончит свой земной путь.	С самого детства и до седых волос человек кочует вверх и вниз по одной и той же реке, кружит вокруг одного и того же колодца, так и заканчивая свой век.

а/. “Хөлд орохоос аваад...” гэхийг Сейфуллина “С тех пор как начал ходить” хэмээн орчуулсан нь үйл хөдөлгөөнийг заасан тул утга нь зөв боловч, монгол хэлний “хөлд орох” гэдэг тэрхүү хүүхэд бие дааж, амьдралд хөл тавьж буй “соёлын зураглал”-ыг арай бүдгэрүүлсэн санагдана. Энэхүү өгүүлбэрийн эхлэлийг Скосырев “С тех пор как встал на ноги” гэсэн нь “хөлд орох” гэдгийг орос хэлний хэлцээр хамгийн оновчтой буулгасан хувилбар бөгөөд “хүн болох, хөл дээрээ зогсох” гэсэн утгыг давхар агуулж байна. Харин Твардовский “С самого детства” хэмээн

буулгасан нь агуулгыг хэт ерөнхийлж, “насны үе”-ээр сольсон нь Нацагдоржийн хэрэглэсэн “хөлд орох - үс цайх” гэсэн физик, дүрслэлийн эрс тэс ялгаа (контраст)-г ихээхэн сулруулж, уншигчийн төсөөлөн бодох орон зайг хязгаарлажээ.

б/. “...нэг голыг өгсөн уруудан нүүж...” гэсэн үйл явдлын зураглалыг дээрх гурван орчуулагч бүгдээрээ “*верх и вниз*” (өгсөн уруудан) гэж шууд утгаар нь буулгасан байна. Гэвч монгол ахуйд гол өгсөж уруудах нь зөвхөн хөдөлгөөн биш, зуслан, намаржаа, өвөлжөөний хоорондох “амьдралын тойрог” юм. Твардовский өгүүлбэрийг “*заканчивая свой век*” гэж төгсгөсөн нь найруулгын хувьд тун цэгцтэй сонсогдож байна.

в/. “...энэхүү ертөнцийг эцэслэнэ” гэсэн төгсгөлийн орчуулгад нэг сонирхолтой зүйл ажиглагдаж байна. Их Нацагдорж “ертөнцийг эцэслэнэ” гэж бичсэн нь маш гүн утгатай санагдана. Энэ нь зөвхөн үхэх биш, түүний ертөнц нь тэр гол, тэр худаг дотроо л дуусаж байгааг хэлж буй хэрэг болов уу. Орчуулагчид “*земной век*”, “*земной путь*” гэж буулгасан нь орос хэлний Христийн шашны соёлын нөлөө бүхий “энэ насны амьдрал” (хүний амьдрал түр зуурынх) гэсэн өнгө аясыг оруулчихсан мэт сэтгэгдэл төрөгдөж байна. Гэтэл зохиогч энд “ерөөсөө түүний харах ертөнц нь ийм л явцуу” гэсэн экзистенциал мухардлыг илэрхийлсэн болов уу.

Энэ бүхэнд үндэслэн, бид орчуулгын дараах хувилбарыг санал болгож байна:

*“От первых шагов и до седых волос, кочуя то вверх, то вниз по одной лишь реке, кружа вокруг одного лишь колодца, он так и исчерпывает весь свой мир”.*

Зохиогчийн “хөлд орохоос аваад, үс цайхыг хүртэл” хэмээх хэллэг нь хүний бүх насаар хязгаарлагдахгүй, нүүдэлчин ахуйн цаг хугацааны “мөнхийн давтамж”-ийг зааж буй хэрэг юм. Гэтэл А.Твардовскийн “С самого детства” хэмээх ерөнхийлөл нь их Нацагдоржийн дүрслэх ур чадварын нэгэн өвөрмөц тал болох “бие махбодын өөрчлөлтөөр нийгмийн зогсонги байдлыг илэрхийлэх” аргыг бүдгэрүүлж, ердийн нэг намтарчилсан өгүүлэмж болгон хувиргажээ. Энэ нь Комиссаровын дурдсан “соёлын мэдээлэл” орчуулгын явцад гээгдэж буйн нэгэн илрэл юм хэмээн үзсэн учраас ийнхүү өөрчлөн найруулсан болно.

Одоо өгүүллэгийн дараагийн өгүүлбэрийн орчуулгуудын тулган шинжилье:

Д.Нацагдорж	Л. Сейфуллина	П. Скосырев	А. Твардовскийн редакторласан хувилбар
Гавж Жамбал хоймор сууж, бурхан ном гэж буруу зөв чалчих ба зайсан Намжил гаднаас ирж хууль ёс гэж худал үнэн ярихыг сонссоор өдөр сарыг улируулна.	Слушая, как на почетном месте сидит габжа Жамбал и болтает о богах и сутрах, и как заходит зайсан Намжил, рассуждая о законах и порядках, старый сын проводит дни и месяцы.	Слушая, как на почетном месте разглагольствует габжа Жамбал, путая правду с вымыслом в божественных книгах, и как зайсан Намжил толкует о законах, мешая истину с ложью, старый сын проводит дни за днями.	Слушая, как на почетном месте габжа Жамбал толкует о божественных книгах, и как зайсан Намжил рассуждает о законах, мешая истину с ложью, старый парень проводит свои дни.

Эдгээр орчуулгыг харьцуулан авч үзвэл дараах байдал ажиглагдаж бана. Үүнд:

а/. Орчуулагчид “габжа”, “зайсан” гэж шууд галиглан оруулсан нь тухайн цаг үеийн Монголын нийгмийн давхаргыг орос уншигчдад шууд мэдрүүлсэн тун зөв шийдэл хэмээн үзүүштэй.

б/. Твардовскийн хувилбарт “Хуучин хүү”-г “старый парень” (хөгшин залуу) гэж буулгасан нь туйлын оновчгүй болжээ. “Хуучин хүү” бол их зохиолчийн өгсөн ерөнхий нэр,

бэлгэдэл болохоос биш “хөгшин залуу” гэсэн утга биш юм. Харин Сейфуллина, Скосырев нар “старый сын” (хуучин хүү) гэсэн нь эх зохиолын гарчиг болон агуулгатайгаа илүү дүйж байна.

в/. “Буруу зөв чалчих”, “худал үнэн ярих” гэсэн давхар утгыг Сейфуллина “*Болтает о богах*” (бурхдын тухай чалчих) гэсэн бөгөөд энэ нь зөвхөн “ярих” гэсэн утгатай. Нацагдоржийн “буруу зөв” (аливааг ялгаж салгахгүй, утгагүй) гэсэн шүүмжлэлт өнгө аясыг орхигдуулсан байна.

г/. Энэ хэсгийг Скосырев “*Путая правду с вымыслом*” (үнэнийг зохиомол зүйлтэй хутгах), “*Мешая истину с ложью*” (үнэн худлыг холих) хэмээсэн нь маш сайн орчуулга хэмээн үзэх үндэстэй. Нацагдоржийн “буруу зөв”, “худал үнэн” гэж хэлж байгаагийн цаад утгыг буюу ард түмнийг төөрөгдүүлж байгааг нь орос хэлний найруулгаар тун чадварлаг гаргасан гэж дүгнэж болохоор байгаа юм.

д/. Харин Твардовский “буруу зөв”-ийг бүрмөсөн гээж, зүгээр л “*толкует о божественных книгах*” (бурхны ном тайлбарлах) гэсэн нь зохиолчийн нийгмээ егөөдсөн “хурц” өнгө аясыг “мөлийлгөж”, шашны ердийн нэг зан үйл мэт болгож хувиргасан гэж үзэж болохоор байна.

е/. “...өдөр сарыг улируулна” (хугацааны урсгал)-ыг Скосырев л “*проводит дни за днями*” (өдрөөс өдөрт) гэж утгаар нь нэлээн дөхүүлсэн боловч Нацагдоржийн “улируулна” (цаг хугацаа үр ашиггүй өнгөрөх) гэсэн динамик утгыг бүрэн гаргаагүй мэт.

Энэ бүгдийг үндэслэн дээрх өгүүлбэрийг бид дараах маягаар орчуулах саналтай байна. Үүнд:

*“Габжа Жамбал, восседая на почетном месте, мелет всякую чушь о богах и сутрах, а зайсан Намжил, заглядывая с улицы, плетет правду-небылицу о законах и порядках — и под эти речи Хуучин хуу<sup>43</sup> бездумно коротает свои дни и месяцы”.*

Гол дүрийн нэрийг орчуулахдаа Сейфуллина, Скосырев нар “Старый сын” (Хуучин хүү) хэмээн үгчилсэн нь агуулгыг дөхүүлсэн мэт боловч, Твардовскийн “Старый парень” (Хөгшин залуу) гэх хувилбар нь Нацагдоржийн дүрдээ шингээсэн “хуучин нийгмийн үлдэгдэл” хэмээх бэлгэдлийг ахуйн түвшний ердийн нэгэн дүр болгон дордуулжээ хэмээн үзэх үндэстэй. Бидний бодлоор “Хуучин хүү” хэмээх нэр томъёог галиглах маягаар хэвээр үлдээж, тайлбар зүүлт хийх нь Комиссаровын онол дахь “соёлын өвөрмөц онцлогийг хадгалах” зарчимд илүү нийцэх юм.

Бид ийм хувилбарыг яагаад санал болгож байна вэ гэвэл, энэхүү хувилбар нь орчуулгын “хэл шинжлэлийн” болон “соёл судлалын” дүйцэл (equivalence)-ийг нэгэн зэрэг хангахад чиглэгдсэн болно. “Мелет чушь”, “плетет небылицу” зэрэг орос хэлний амьд хэлцийг сонгон авсан нь их зохиолчийн нийгмээ шүүмжилсэн хурц егөөдөл (irony)-ийг “намтарчилсан хүүрнэл” төдийхнөөс салгаж, утга зохиолын шинжлэх ухааны түвшинд “амилуулж” байгаа хэрэг хэмээн үзэж байна. Мөн гол дүрийн нэрийг транскрипцийн аргаар хэвээр үлдээсэн нь түүнийг ердийн нэг “старый парень” бус, монгол ахуйн “соёлын дүр” (cultural icon) болохыг нь баталгаажуулж буй ололт гэж бодно.

Энэ мэтээр өгүүллэгийн бүх өгүүлбэрийг задлан шинжиж, ололттой болон дутагдалтай талын тухайд санаа оноогоо илтгэн, өргөн олон мэргэдээр шүүлгэж болох авч, сэтгүүлийн зай талбар хязгаарлагдмал тул үүгээр товчлов.

## ДҮГНЭЛТ

1. Д.Нацагдоржийн бүтээлүүдийг орос хэлнээ буулгасан эхэн үеийн орчуулагчид түүхэн үүрэг гүйцэтгэсэн боловч, нүүдэлчин ахуйн “шалдар булдар”, “ороо бусгаа” зэрэг дүйцэлгүй үгсийг суурин соёл иргэншлийн хэлээр бүрэн илэрхийлэхэд утгын алдагдал гарч байв. Үүнийг хожуу үеийн эрдэмтэн Г.Михайлов, Л.Герасимович нар шинжлэх ухааны үндэстэй залруулж,

<sup>43</sup> "Старый сын нового времени" гэсэн утгаар хэрэглэжээ. (Орч.).

“захудалый”, “сумбурна” гэх мэт үгийг сонгон оновчтой хэрэглэж ирсэн нь орчуулгын түүхэн дэх том алхам болжээ.

2. П.Ньюмарк, В.Н.Комиссаров нарын онолоор авч үзвэл, эхэн үеийн орчуулгууд зохиолчийн егөөдлийг “намтарчилсан хүүрнэл” болгон зөөлрүүлж байсан бол Л.Герасимович нарын хожуу үеийн бүтээлүүд эх зохиолын дотоод эрчим, хэлний хэмнэлийг хадгалахыг зорьсон байна. Гэвч бидний санал болгож буй “неказист”, “необузданна”, “палиг” зэрэг хувилбар нь тэдгээр эрдэмтдийн шинжлэх ухаанч ололтыг уран сайхны амьд зураглалтай холбосноор соёлын дамжуулалтыг шинэ шатанд гаргахыг зорьсон оролдлогын төдий зүйл болно.

3. “Хуучин хүү” хэмээх нэр бол соёлын код юм. Иймд гол дүрийн нэрийг “Старый сын”, эсвэл “Старый парень” гэж орчуулсан нь дүрийн нийгэм-түүхэн бэлгэдэл, хэв шинжит чанарыг ахуйн түвшний ердийн нэгэн дүр болгон дордуулжээ. Иймд үндэсний өвөрмөц шинжтэй дүрүүдийг транскрипцийн аргаар хэвээр үлдээх нь соёлын “дархлаа”-г хадгалах хамгийн оновчтой шийдэл хэмээн үзэв.

4. Цаашид монгол уран зохиолыг гадаад хэлнээ хөрвүүлэхдээ зөвхөн хэл шинжлэлийн түвшинд бус, нүүдэлчдийн сэтгэлгээний “эмнэг хангал” мөн чанарыг “безысходная досада”, “вскидывать хвост” гэх мэт соёлын нарийн дүйцлүүдээр баяжуулан, уншигчийн тархинд “өнгө биш, үнэр амт”-ыг буулгах нь чухал байна.

**Abstract:**

*Title: A Comparative Analysis of Early and Late Russian Translations of D. Natsagdorj's Short Story "Khuuchin Khuu" (The Old Son)*

*This critical essay aims to conduct a comparative analysis of various Russian translations of the celebrated short story "Khuuchin Khuu" by D. Natsagdorj, a pioneer of modern Mongolian literature. By examining both early and late 20th-century translations, the study evaluates their semantic accuracy, stylistic alignment, and overall equivalence to the source text. The primary objective is to offer a scholarly perspective on how the linguistic nuances and cultural context of the original work are rendered in Russian.*

*It is important to emphasize that this critique does not intend to diminish the historical value of these translations. Rather, it seeks to highlight the immense responsibility involved in translating the rich poetic melody of the Mongolian language and its unique nomadic cultural heritage. The analysis concludes that conveying the profound aesthetic and cultural essence of such works into another language is a formidable task, which, in certain instances, borders on the impossible.*

## НОМ ЗҮЙ

Герасимович, Л. К. (1965). *Литература Монгольской Народной Республики 1921–1964 гг.* Издательство Ленинградского университета.

Комиссаров, В. Н. (1990). *Теория перевода (лингвистические аспекты)*. Высшая школа.

Михайлов, Г. И. (1964). *Монгольская литература*. Наука.

Нацагдорж, Д. (1930). *Хуучин хүү*. (Гар бичмэл болон түүвэр зохиолууд).

Нацагдорж, Д. (1956). *Избранное* (Л. Сейфуллина, П. Скосырев, пер.; А. Твардовский, ред.). Гослитиздат.

Сейфуллина, Л. Н. (1936). *Старший сын*. В кн.: *Современная монгольская литература*. Художественная литература.

Скосырев, П. Н. (1947). *Монгольская литература*. Советский писатель.

Newmark, P. (1988). *A Textbook of Translation*. Prentice Hall.



“А КЮГИЙН ҮНЭН ТҮҮХ” ЗОХИОЛЫН МОНГОЛ ОРЧУУЛГЫН ОНЦЛОГ  
/ХОЛБОО ҮГИЙН ЖИШЭЭГЭЭР/

П.Уянга<sup>44</sup>

Б.Хавар<sup>45</sup>

***Abstract:** Lu Xun, the founder of modern Chinese literature, sharply criticized the weak character of his nation in many works, the most famous of which is "The True Story of Ah Q." The novel depicts the adventures of the main character, Ah Q, who is poorly educated and unemployed, reflecting the common characteristics of not only the Chinese peasants of that time, but also the poor people of the suffering country. The character of Ah Q, a clumsy man, is a criticism of the weakness of the Chinese nation. This novel was translated from Chinese into Mongolian by translator B. Bat in 1952, J. Arthur in 1985, and the Inner Mongolia Educational Committee in 1974, respectively, and made available to the public. In translation, the same text can be translated in several ways by several people. These translations have their own characteristics, compositional tone, and the vocabulary used varies from one to another. In the following article, we compare and study the features of the Mongolian translation of "The True Story of Ah Q" using the example of conjunctions.*

***Түлхүүр үг:** Лү Шюнь А Кю утга зохиол сонгомол бүтээл*

УДИРТГАЛ

Хятадын шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч Лү Шюнь нь олон зохиол бүтээлээрээ өөрийн үндэстний сул дорой хэв шинжийг хурцаар шүүмжилж байсны дундаас хамгийн алдартай зохиол нь “А Кюгийн үнэн түүх” юм. Зохиолд гол баатар болох тухайн цаг үеийн хятадын тариачдын төдийгүй зовж зүдэрсэн орны үгээгүй ядуу ардын нийтлэг шинж төрхийг илэрхийлсэн, боловсрол муутай, тогтсон ажилгүй, А Кюгийн адал явдал дүрслэгддэг. А Кю хэмээх болхи эрийн дүр цаад утгаараа хятад үндэстний сул дорой чанарыг шүүмжилж буй хэрэг юм.

Энэхүү зохиолыг орчуулагч Б.Бат 1952 онд, Ж.Артөр 1985 онд, Өвөр Монголын сурган хүмүүжүүлэх хороо 1974 онд хятад хэлнээс монгол хэлнээ тус тус орчуулж олны хүртээл болгосон байдаг.

Уран зохиолын орчуулга нь хоёр үндэстний хоорондох соёлын солилцоо хийх нэгэн зүйлийн арга бөгөөд монгол хятад хэлнээ харилцан орчуулсан зохиол бүтээлүүд жилээс жилд улам олширч байна.

Орчуулгад нэг зохиолыг хэдэн хүн хэдэн янзаар ч орчуулж болдог. Эдгээр орчуулга нь өөр өөрийн онцлог, найруулгын өнгө аястай, хэрэглэж буй үгийн сангийн хувьд харилцан адилгүй орчуулагдсан байдаг.

“А Кюгийн үнэн түүх” зохиол нь хятадын утга зохиолын сонгомол бүтээл учир тус зохиолыг орчуулсан нь чухал ач холбогдолтой юм. Үүнд:

<sup>44</sup> Ph.D, МУИС, ШУС, ХУС, Ази судлалын тэнхим

<sup>45</sup> Магистр, МУИС

1. Тухайн үеийн хятадын улс төр, нийгэм эдийн засгийн талаарх ойлголтоо гүнзгийрүүлнэ.

Энэхүү зохиол нь тухайн үеийн Хятад улсын хоцрогдсон байдал, феодалын үзэл санаа, ялзарсан дорой байдлыг илчлэн, “А Кю”-гийн дүрээр төлөөлүүлэн хошигносон байдаг. Цагаагчин гахай жилийн хувьсгалын өмнө болон хойно хөдөө тосгоны байдлыг дэвсгэр болгон, хуучин нийгмийн хүнд дарлалыг амсаж, оюун санаа нь гажуудсан А Кю хэмээх хүмүүний дүрийг бүтээж, А Кюгийн зориг санаа нь оюун санааны ялалтын хуулийн төлөөний нэр үг болсон байдаг. Хувьсгалын дараа феодал ангийн ноёрхогчид ноёрхлоо хамгаалахын тулд хүчээр дарангуйлан, оюун санааг нь боолчлох төрийн бодлогыг хэрэгжүүлж, феодалын ёс суртахуун, мунхаг бишрэл болон ардын мунхруулах төрийн бодлогыг ашиглаж байв. Зохиолч өөрийн оршиж байгаа нийгэм, харьцаж байгаа хүмүүн, өөрийн өнгөрүүлсэн хувьсгал зэрэгт анхаарал тавьж, уран нарийн сэтгэмжлэн зохиожээ.

Тухайн үед хоёр улсын харилцаа төдийлөн сайн биш байсан бөгөөд Хятад улс олон талт гадаад харилцааны төрийн бодлого хэрэгжүүлээгүй байсан цаг үе тул хоёр орны бүх талын харилцаа учраа олоогүй байсан юм. Тиймээс монголын уншигчид “А-Кюгийн үнэн түүх” зохиолоор дамжуулан Хятад улсыг ойлгож болно. А-Кю баян айлд хөлсний ажил хийж, олсон мөнгөө мөрийтэй тоглоом, эсвэл архины пүүст үрдгийг бичсэн зэрэг нь тухайн үеийн хятадын нийгмийн ялзарсан байдлыг шууд тусгаж байгаа явдал юм.

2. Хятадын зохиол бүтээлийн хэв маяг, хөгжлийг ойлгохын зэрэгцээ орчуулгын чадвараа дээшлүүлнэ.

Энэхүү зохиол нь хятадын утга зохиолын төлөөлөл тул энэ зохиолыг орчуулах нь тухайн улс үндэстний зохиол бүтээлийн хэв маягийг ойлгож, хөгжлийг нь мэдэхэд дөхөмтэй. Үндэстэн болгон өөрийн соёл иргэншилдээ суурилсан үг хэл, үсэг бичигтэй байлаа. Үндэстний үг хэл, үсэг бичиг нь өөрийн гэсэн хэлж ярих, бичиж туурвих дүрэм журамтай. Уран зохиолоор авч хэлсэн ч тэр нь тухайн үндэстний үг хэл, үсэг бичгийн санг илэрхийлж, зохиомж сэтгэхүй, зохион бичих арга хэлбэрийг шууд тусгаж байдаг.

Монгол, хятадын утга зохиолын орчуулгыг хорьдугаар зууны гучаад он хүртэл авч үзэж болно. Монгол улсад хамгийн анх орчуулсан хятадын орчин үеийн утга зохиолын алдарт бүтээл бол Лү Шюний “Гүн И Жи” өгүүллэг юм. Үүнийг монгол хэлнээ орчуулагч Б.Бат хятад хэлнээс орчуулсан бөгөөд орчуулгыг 1939 оны гуравдугаар сард нийтэлсэн байна. 1956 онд МУ-ын хэвлэлийн хорооноос Лү Шюний туужисын сонгомол бичгийг гаргаж, түүнд “Нутаг” ба “Гүн И Жи” гэсэн хоёр богино зохиолыг сонгон оруулсан байдаг. 1952 оноос эхлэн хятадын их зохиолч Лү Шюний “А Кюгийн үнэн түүх”, “Галзуу хүний өдрийн тэмдэглэл”, “Архины асар дээр”, “Эргэлзэл”, “Хашхирал” болон “Маргааш” зэрэг хорин хэдэн богино зохиолыг монгол хэлэнд орчуулан хэвлүүлж монголын уншигчдын хүртээл болгосон байна. 1955 оноос эхлэн Монгол улсад тусгайлан хятадын уран зохиолын орчуулга хийдэг орчуулагчид төрөн гарч, тэдний шаргуу хөдөлмөрөөр монголын уншигчид олон содон бүтээлүүдтэй танилцсан юм.

3. Үндэстний соёлын харилцааг ахиулна.

“А Кюгийн үнэн түүх” зохиол нь 40 гаруй янзаар орчуулагджээ. Энэхүү зохиолын япон орчуулга гэхэд л арван хэдэн хувилбар бий. Шанхайн кино үйлдвэр 1981 онд Лү Шюний мэндэлсний 100 жилийн ойд зориулж “А Кюгийн үнэн түүх” зохиолоор кино хийсэн байдаг. “А Кюгийн үнэн түүх” зэрэг хятад зохиол бүтээлийг монгол хэлэнд орчуулж буулгах нь монгол ба хятад үндэстний соёлын харилцааг ахиулж байгаа явдал юм.

Зохиол бүтээлд тухайн улс үндэстний амьдралын хэв маяг зан заншил соёл түүх агуулагдаж байдаг тул уран зохиолын орчуулгаар дамжуулан үндэстэн хоорондын харилцааг чангатгаж соёлын солилцоог ахиулдаг. Жишээлбэл, уг зохиолд бичигдсэн Ү Магийн байр суурь, А Кюгийн нийгмийн байр суурь, тэдний хооронд өрнөж байгаа яриа, идээ ундаа зэрэг маш олон зүйлээс тухайн үндэстний идээ ундааны соёл, ураг гэр бүлийн соёл, нийтийн харилцааны соёл зэргийг олж харж болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

“А-Кюгийн үнэн түүх” зохиолыг орчуулсан орчуулагчдын мэргэжлийн түвшин, хэлний мэдрэмж, туршлага чадвар болон хэлний орчин зэргээс шалтгаалаад энэхүү хэлний хэрэглээ нь харилцан адилгүй, ялгаатай байх нь мэдээж юм.

Доор Өвөр Монголын сурган хүмүүжүүлэх хорооны орчуулгыг А<sup>46</sup>, орчуулагч Б.Батын орчуулгыг В<sup>47</sup>, орчуулагч Ж.Артөрийн орчуулгыг С<sup>48</sup> гэж товчлов.

“А Кюгийн үнэн түүх” зохиолын монгол орчуулгын холбоо үгийг харьцуулах нь

Хүснэгт 1. Нэр үг голлосон холбоо үгийг харьцуулах нь<sup>49</sup>

1.行状	үйл хэрэг	өнгөрүүлсэн хэрэг	ажил үйлс
В орчуулгад илүү тодорхой илэрхийлсэн байна.			
2.日光	нарны гэрэл	наран ээвэр	наран тал
А орчуулга нь хамгийн оновчтой байна.			
3.夹袄	давхар цамц	давхар хүрэм	ноорхой хүрэм
.Аль ч утга нь болно			
4.高傲	дээрэнгүй санаа	омгорхог зан	давлиун
В болон С орчуулга “ илүү оновчтой байна			
5.君子	эрдэмтэн сайд	шударга сайн хүн	сайн хүн
“君子” гэдэг үг нь “сайн хүн”, “шударга хүн” гэсэн үндсэн утгатайгаас гадна, эрэгтэй хүнийг заадаг. Тийм болохоор А орчуулгын “эрдэмтэн сайд” гэсэн орчуулга нь нэлээд оновчтой болжээ Учир нь “сайд түшмэл” гэвэл эрэгтэй хүнийг заадаг. <sup>50</sup>			
6.奚落	шоологдон доромжлогдож	шоовдор үзэгдэж	доромжлол
Гурван орчуулгад утга санааг оновчтой илэрхийлсэн байна.			
7.坏人	муу хүн	саваагүй хүн	олиггүй амьтад
“Муу хүн” гэдэг нь хамгийн дөхөм утга юм.			
8.平时	ерийн цаг	энгийн цаг	жирийн үед
Гурван орчуулгад утга ижил оновчтой орчуулсан байна.			
9.敌忾	өшөөрхөх бодол	дайсагнах санаа	өс хонзон
Гурван орчуулгад утга ижил оновчтой орчуулсан байна.			
10.口碑	аман завжинд уягдах гэж	амны зугаа	амны уншлага
“口碑” гэдэг нь ам дамжсан үг гэсэн утгатай тул В орчуулга нь ойролцоо утга илэрхийлж байна.			
11.晦气	гайдсан	муу ёр	аз хийморьгүй
В орчуулга илүү оновчтой байна.			
12.诛心	омгийг хугалах	зүрх сэтгэл	хорон үг

<sup>46</sup> Өвөр Монголын сурган хүмүүжүүлэх хэвлэлийн хороо. “Лү Шүний өгүүллэгийн түүвэр” Хөх хот, 1974 он

<sup>47</sup> Б.Бат. “А-Кюгийн үнэн түүх”, Улаанбаатар, улсын хэвлэх үйлдвэр, 1952

<sup>48</sup> Ж.Артөр. Лу Синь “Галзуу хүний өдрийн тэмдэглэл”, Нэпко хэвлэлийн газар, 2019 он

<sup>49</sup> Б.Хавар. Лү Шүний “А-Кюгийн үнэн түүх” зохиолын монгол орчуулгад хийсэн судалгаа. (магистрын ажил) МУИС 2021 он

“诛心” гэдэг үгийн үндсэн утга нь хүний сэтгэлийг зэмлэх, буруушаах гэсэн утгатай. А орчуулга нь уг үгийн утгатай хамгийн ойр болсон байна.			
13.文章	бичиг зохиол	утга зохиол	ном зохиол
Гурван орчуулга бүгд оновчтой байна.			
14.寂然	чимээгүй	чимээ аниргүй	нам жим
Гурван орчуулга бүгд таарч байна.			
15.奴仆	зарц	шивэгчин	зарц эмэгтэй
Гурван орчуулгад нэг утгыг илэрхийлж байна.			
16.黄昏	шар бүрий	бараг бүрэг	харанхуй
“Харанхуй” гэдэг нь “黑暗” гэсэн санаа тул А болон С орчуулга нь илүү оновчтой.			
17.正经	төв чигч	төв бат	шударга
Гурван орчуулгад уг санааг бүрэн илтгэж байна.			
18.条件	нөхцөл	болзол	болзол
“Нөхцөл”, “болзол” хоёр нь адилхан утгатай тул таарч байна.			
19.缢鬼	гай түйтгэр	муу ёр	чөтгөр шуламс
Гурван орчуулгад уг санааг бүрэн илтгэж байна.			
20.尿布	норгоовч	шээсний даавуу	живх
Тус гурван орчуулгын С орчуулга нь шууд монгол хэлэнд буулгаж, утгын хувьд ч маш оновчтой орчуулсан байна.			
21.男人	бүстэй хүн	хар хүн	эрэгтэй хүн
Гурван орчуулгад уг санааг бүрэн илтгэж байна.			
22.新闻	сонин чимээ	сонин зүйл	шинэ сонин мэдээ
С орчуулга нь хамгийн оновчтой байна.			
23.茶馆	цайн мухлаг	цайн газар	цайны газар
Гурван орчуулгад уг санааг бүрэн илтгэж байна.			

Хүснэгт 2. Үйл үг голлосон холбоо үг<sup>51</sup>

24.摔在地上	хөсөр хаяж	газар хаяж	газар чулуудан
Гурван орчуулгад уг санааг бүрэн илтгэж байна.			
25.动口	ам хөдлөх	амаар хэлэлцэх	ам дуугарах
“动口” гэх үг нь амаар хэлэлцэх, ярьж хэлэлцэх, хэл амаар ярилцах гэсэн утгатай.			
26.满足	бах нь ханаад	санаандаа хүрсэн	ханамжтайяа
.Гурван орчуулга утга нь бүр таарч байна			
27.两手叉在腰间	сүвээгээ тулах	нуруугаа үүрч	ташаа тулан
.С орчуулга нь хамгийн ойролцоо утга юм			
28.咒骂	зүхэж хараах	хараан занаж	харааж зүхэх
“Зүхэх” болон “Хараах” гэсэн үг утга нь ижил юм.			
29.低了头	толгой бөхийж	толгой гудайлгаж	толгойгоо гудайлган
Гурван орчуулгад оновчтой орчуулсан байна.			

Б.Хавар. Лү Шюний “А-Кюгийн үнэн түүх” зохиолын монгол орчуулгад хийсэн судалгаа. (магистрын ажил) МУИС 2021 он

30.恋爱	янаг дурлал	амраглал	хайр дурлал
Гурван орчуулгад оновчтой орчуулсан байна.			
31.欢喜	баяр бахдал	баяр хөөртэй	бах
В орчуулгад “баяр хөөртэй” гэж зөв орчуулсан байна.			
32.诚慌诚恐	чичрэн дагжиж	түгшин дагжиж	түгшин аюумуй
Гурван орчуулгад “айсан, түгшсэн” утгыг илтгэж байна. <sup>52</sup>			
33.打鼾	хамар татах	хурхиран	хурхирах
В,С орчуулга нь илүү оновчтой байна.			
34.而立	тогтнох	тогтох	тогтдог
Гурван орчуулгад оновчтой орчуулсан байна.			
35.抱头	толгойгоо тэврэх	толгойгоо барих	халхалбал
“抱” гэсэн үг нь “тэврэх” үйлдлийг зааж, “头” гэсэн үг нь “толгой”-г заадаг. А орчуулга нь зөв тодорхой байна			
36.礼毕	ялаа хүлээж	буруугаа хүлээж	ёс үйлийг гүйцэтгэж
С орчуулгын утга нь тодорхой байна			
37.拧下	мушгиж таслаад	хугалж	мушгин
А орчуулга дах “таслаад” гэсэн үгийг “аваад” гэж орчуулах нь зохимжтой санагдаж байна.			
38.打定	зориг шууджээ	зориглон тогтов	бүрэн шийдэв
Гурван орчуулгад оновчтой орчуулсан байна.			
39.惊异	ажиг сэжиг	сонирхол	гайхал төрүүлсэн
.С орчуулга нь хамгийн тодорхой байна			
40.出神	гөлрөн сонсож	сөсөө гартал	ухаангүй
А орчуулга нь оновчтой байна.			

Холбоо үг нь хоёр буюу түүнээс дээш үг нийлэн ямар нэгэн утгыг илтгэдэг. Орчуулгын явцад холбоо үгийг орчуулахдаа үг өгүүлбэрийн утгыг гүнзгий ойлгосон байх хэрэгтэй. Хятад хэл нь монгол хэлтэй адилхан үндсэн утга ба салаа утга гэж байдаг тул уг өгүүлбэрт үндсэн утгаар нь хэрэглэсэн эсэхийг сайтар ойлгосон байх нь чухал. “А Кюгийн үнэн түүх” зохиолын гурван монгол орчуулгын холбоо үгийг харьцуулан доорх дүгнэлтэд хүрэв.

1.Хятад, монгол хэл нь адилхан эртний үг хэллэгтэй байдаг. “А Кюгийн үнэн түүх” зохиолд хятад хэлний эртний хэллэг ба битүү утгатай үг нэлээд олон хэрэглэгджээ.

Уг зохиолд ч эдгээр үгийг зүүлт хийж тайлбарласан байдаг. Эдгээр үгийг орчуулахдаа яг утгаар нь оноож орчуулахаар байна. Жишээлбэл, “君子” гэдэг үгийг А орчуулгад “эрдэмтэн сайд” гэж орчуулаад, В орчуулгад “шударга сайн хүн” гэсэн бол, С орчуулгад “сайн хүн” гэж орчуулсан байна. Хятад хэлний “君子” гэдэг үг нь “сайн хүн”, “шударга хүн” гэсэн үндсэн утгатайгаас гадна, эрэгтэй хүнийг зааж байдаг. Тийм болохоор А орчуулгын “эрдэмтэн сайд” гэсэн орчуулга нь нэлээд оновчтой болжээ. Учир нь сайд түшмэл гэвэл эрэгтэй хүнийг заах учраас уг зохиолын утгыг маш оновчтой орчуулж чадсан байна. Зөвхөн сайн хүн буюу шударга сайн хүн гэвэл эрэгтэй эмэгтэй ямар ч хүнийг төлөөлж болно. Тийм учир В орчуулга ба С орчуулгад “сайн хүн”, “шударга сайн хүн” гэсэн нь арай оновчгүй болжээ. Утга зохиолын орчуулга нь дахин бүтээлтийн

<sup>52</sup> Б.Хавар. Лү Шюний “А Кюгийн үнэн түүх” зохиолын монгол орчуулгад хийсэн судалгаа. (магистрын ажил) МУИС 2021 он

явц болохоор уг зохиолын санаа, хэл хэллэгийг бүрэн зөв ойлгуулах ба өөрийн хэлэндээ уран сайхнаар орчуулан хөрвүүлэх нь маш чухал юм.

2.Гурван монгол орчуулгын холбоо үгийн орчуулгаас ажиглагдсан бас нэгэн онцлог нь нэр үг ба үйл үг нийлж бүтсэн холбоо үгийг шууд нэр үг ба нэр үгээр бүтсэн холбоо үг болгож, хятад хэлний зарим нэр үгнээс бүтсэн холбоо үгийг орчуулахдаа нэр үг ба үйл үгнээс бүтсэн холбоо үг болгон хувиргаж байгаа үзэгдэл оршиж байна. Энэ нь зарим үед утгын хувиралт үүсгэж мэддэг. Жишээлбэл “诛心” гэх үгийг А орчуулгад “омгийг хугалах” гэж орчуулаад, В орчуулгад “зүрх сэтгэл”, С орчуулгад “хорон үг” гэж орчуулсан байна. “诛心” гэдэг үгийн үндсэн утга нь хүний сэтгэлийг зэмлэх, буруушаах гэсэн утгатай байдаг. Гурван монгол орчуулгын дундаас А орчуулгын “омгийг хугалах” гэсэн орчуулга нь уг үгийн утгатай хамгаас ойр болж чаджээ.

3.Холбоо үг бол уран зохиолын үнэр амтыг тохируулагч чухал хүчин зүйлийн нэг юм. Тиймээс холбоо үгийн орчуулга буруудах буюу оновчгүй болоход хүрвэл бүхэлдээ зохиолын орчуулгад нөлөөлдөг. Гурван монгол орчуулгын холбоо үгийн орчуулгын хувьд, А орчуулга нь үгийн үндсэн утгыг харгалзуулж орчуулсан нь сайн байна. Гэхдээ А орчуулгын үг хэллэг хэт махчилсан, В орчуулга ба С орчуулга холбоо үгийн орчуулгын хувьд нэлээд адилавтар боловч, С орчуулга нь илүү оновчтой уран орчуулсан байна. В орчуулга нь С орчуулгыг бодвол уг зохиолын үг хэллэгт арай баригдсан буюу зохиолын уран сайхны илэрхийллийг бүрэн дамжуулж чадаагүй байна.

4.Гурван монгол орчуулгын холбоо үгнээс ажиглагдсан бас нэг онцлог нь юмс буюу ямар нэгэн хэрэглэгдэхүүнийг нэрлэн заасан хятад үгийг шууд махчилж орчуулж байгаа жишээ гарч байна. Хятад хэлэнд “电视” гэвэл бид заавал уг үгээр нь махчилж орчуулах албагүй. “电视” гэвэл зүгээр л зурагт, телевиз гэх мэт өөрийн хэлэндээ буюу хэрэглэж байгаа байдлаараа орчуулдаг. Гурван монгол орчуулгад, “尿布” гэдэг үгийг А орчуулгад “норгоовч”, В орчуулгад “шээсний даавуу”, С орчуулгад “живх” гэж орчуулсан байна. Тус гурван орчуулгын С орчуулга нь шууд монгол хэлэнд бууж, утгын хувьд ч маш оновчтой орчуулсан байна. Харин А орчуулгын “норгоовч” гэх үг нь Өвөр Монголын аман аялгуу ба бичгийн хэлэнд төдийлөн хэрэглэгддэггүй, орчуулгын хэллэг байна. Энэ нь зохиолын үг хэллэгийг баригдмал болгосон байна. В орчуулгын шээсний даавуу нь ч хятад үгийн утгыг шууд махчилж орчуулсан байна. Монгол хэлэнд шээсний даавууг живх гэж нэрлэдэг болохоор өөрийн хэлэндээ буулгаж орчуулахыг хичээх хэрэгтэй.

5.Гурван монгол орчуулгад үйл үгийн үйлдлийг дүрсэлж орчуулсан онцлогтой байна. Үйл үг нь ямар нэгэн үйл хөдлөлийг төлөөлөн заадаг. Жишээлбэл, явах үйлийг алхах, гүйх, давхих гэх мэт янз бүрийн явах төрөл хэлбэрээр дүрсэлж болдог. Тус зохиолын орчуулгаар жишээлбэл, “抱头” гэх үгийг А орчуулгад “толгойгоо тэврэх”, В орчуулгад “толгойгоо барих”, С орчуулгад “халхалбал” гэж орчуулжээ. “抱” гэсэн үг нь тэврэх үйлдлийг зааж, “头” гэсэн үг нь толгойг заадаг. Тиймээс “抱头” нь толгойгоо тэврэх үйлийг заана. В орчуулгад “толгойгоо барих” гэж орчуулсан нь тэврэх үйлтэй төсөөтэй ч тэврэх гэвэл ганц хэдэн хуруу толгойд хүрэх биш, толгойгоо тэврэх байдалд толгойн ихэнх хэсэг нь гарт халхлагдана. Харин толгойгоо барих гэвэл тэврэхээс тусдаа үйлдэл болдог. С орчуулгад “халхлах” гэж орчуулсан нь уг зохиолын өгүүлбэрийн орчинд дүрсэлж орчуулсан байна. Толгой тэврэхэд яриангүй толгой гарт халхлагдана. Тиймээс “тэврэх” үйлдлийг “халхлах” гэж дүрсэлсэн байна. Мөн “动口” гэдэг үгийг А орчуулгад хөдлөх гэж орчуулаад, В орчуулгад “амаар хэлэлцэх”, С орчуулгад “ам дуугарах” гэж орчуулсан байна. “动口” гэх үг нь амаар хэлэлцэх, ярьж хэлэлцэх, хэл амаар ярилцах гэсэн утгатай. А орчуулгын “ам хөдлөх” гэсэн нь хятад хэлний “动” ба “口” гэх үгийг салгаж, махчилж орчуулсан байна. Гэвч “ам хөдлөх” гэхээр бас уг утгыг илтгэж болно. Жишээлбэл идэх, хэрэлдэх гэх мэт. Уг зохиолд гарч буй утга нь зүгээр л хэл амаараа ярих, амаар хэлэлцэх гэсэн утгыг илэрхийлж байна. С орчуулгад “ам дугарах” гэсэн нь тийм ч оновчтой биш юм. “Ам дугарах” гэж үг хэлэхийг илэрхийлж болох

боловч, монгол хэлэнд “ам дугарах” гэж төдийлөн илэрхийлдэггүй. Үүнээс гадна, үйл үгийг орчуулахдаа буруу орчуулж байгаа үзэгдэл гарч байна.

6.Хятад хэлний нэг онцлог нь хоёрхон үгтэй холбоо үгээр утга чимж болдог. Жишээлбэл, “孤孀” (бэлэвсэн) гэдэг үг нь шууд энгийн хэрэглээний үгээр бол 寡妇 (бэлэвсэн) гэсэн үг бөгөөд утгын хувьд зөрөөгүй. Гэвч эхний үг нь утга зохиолын хэлийг улам чимж өгдөг байна. Монгол хэлэнд ямар нэгэн утгыг гүнзгийрүүлэх буюу тодотгоход тусгай тодотгол ашигладаг бол харин хятад хэлэнд өөр үгээр илэрхийлж болдог. Ийм үгийг орчуулахдаа, гурван орчуулгад цөм утгачилж орчуулсан байна. Утгачилж орчуулах нь уг зохиолын утгыг хадгалж чаддаг ч, хураангуйлж чадахгүй бол илүү үг олширч, ойлгоход бэрхшээлтэй болдог.

7.Уг зохиолын үг өгүүлбэрийн утгыг буруу ойлгох буюу буруу орчуулах жишээ харагдаж байна. Жишээлбэл, “两手又在腰间” гэх үгийг А орчуулгад “сүвээгээ тулах”, В орчуулгад “нуруугаа үүрч”, С орчуулгад “ташаа тулан” гэж орчуулсан байна. “腰” гэдэг үг нь хүн амьтны сүүжний толгой орчмын хэсгийг заадаг. Монголоор ташаа, мөн сүвээ ч гэж нэрлэдэг. Гэвч сүвээ нь үндсэн утгаараа хүн амьтны цээжний хоёр хажуугийн доод хэсгийг заадаг. Харин “нуруу” гэвэл бүр өөр болно. Тиймээс тус жишээн дэх В орчуулгын “нуруугаа үүрч” гэж орчуулсан нь буруу болсон байна. Өгүүлбэрийн утгыг үндэслэсэн ч ингэж орчуулах нь зохимжгүй юм. Нуруугаа үүрэх ба ташаа тулах хоёр нь хоёр өөр үйлдэл бөгөөд хоёр өөр утгыг илэрхийлж байна.

## ДҮГНЭЛТ

Гурван монгол орчуулгын холбоо үгийн орчуулгаас үзэхэд эдгээр орчуулга нь үг сонголтын хувьд нэлээд чөлөөтэй байна. Адил үгийн сонголттой жишээ байгаа ч, маш цөөн байна. Энэ нь монгол хэлний үгийн сангийн баян тансгийг илэрхийлж байна. Нөгөө талаараа энэ нь гурван монгол орчуулагчийн үгийн санг ч илэрхийлж байгаа юм. Ихэнх үгийг цөм өөр өөрийн сонголтоороо орчуулсан байна. Жишээлбэл “黄昏” гэдэг үгийг А орчуулгад “шар бүрий” гэж орчуулаад, В орчуулгад “бараг бүрэг”, С орчуулгад “харанхуй” гэж орчуулсан байна. “黄昏” гэх үг нь нар шингэхээс өмнөх шар бүрий байдлыг заадаг. Тус үгийг гурван монгол орчуулагч цөм өөр өөрөөр орчуулсан байна. Жишээлбэл, “缢鬼” гэх үгийг А орчуулгад “гай түйтгэр”, В орчуулгад “муу ёр”, С орчуулгад “чөтгөр шуламс” гэж орчуулсан байна. “男人” гэх үгийг А орчуулгад “бүстэй хүн”, В орчуулгад “хар хүн”, С орчуулгад “эрэгтэй хүн” гэж орчуулсан байна. Хэдийгээр өөрөөр орчуулсан ч утгын хувьд ижил байна. Энэ нь гурван монгол орчуулгын тус тусын орчуулгын ерөнхий бүтцэд шууд нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл холбоо үгийг хэрхэн орчуулах, үг сонголтыг яаж хийх нь орчуулгын зохиол ямар болоход шууд нөлөөлдөг.

Эцэст нь дүгнэхэд, “А Кюгийн үнэн түүх” зохиолын гурван монгол орчуулга нь холбоо үгийг орчуулах арга барил, үг сонголтын хувьд нэлээд ялгаатай бөгөөд энэ нь орчуулгын чанар, уран сайхны илэрхийлэлд шууд нөлөөлж байна.

Холбоо үгийг зөв орчуулахын тулд эх хэлний үндсэн ба салаа утга, өгүүлбэрийн орчин, соёл-сэтгэлгээний онцлогийг гүнзгий ойлгох шаардлагатай нь тод харагдаж байна. А орчуулга нь үгийн үндсэн утгад тулгуурласан, харьцангуй оновчтой боловч хэл найруулгын хувьд хэт махчилсан, уран сайхны өнгө сул байна. В орчуулга эх зохиолд хэт баригдсанаас уран сайхны хувиргалтын түвшин харьцангуй сул, харин С орчуулга нь монгол хэлний онцлогт нийцүүлэн илүү уран, уншигчдад ойлгомжтой буулгасан байна.

Иймээс холбоо үгийн орчуулга нь зүгээр нэг үг солих бус, утга зохиолын өнгө аяс, дүрслэл, сэтгэлгээний хэв маягийг бүхэлд нь дамжуулах чухал хүчин зүйл болох нь энэхүү харьцуулалтаар батлагдаж байна.

*Ашигласан материал*

- Артөр, Ж. (2019). А-Кюгийн үнэн түүх. Улаанбаатар.
- Бат, Б. (1952). А-Кюгийн үнэн түүх. Улаанбаатар.
- Бао, Юе Шань. (2000). Хэрэглээний орчуулгын суурь. Хөх хот: Өвөр Монголын өөртөө засах орны хэвлэлийн газар.
- Хавар, Б. (2021). Лү Шюний “А-Кюгийн үнэн түүх” зохиолын монгол орчуулгад хийсэн судалгаа (магистрын зэрэг горилсон судалгааны ажил). Монгол Улсын Их Сургууль, Улаанбаатар.
- Ганжууржав, Б. (1999). Орчуулгын ёсон. Хөх хот: Өвөр Монголын өөртөө засах орны хэвлэлийн газар.
- Дундад улсын үндэстний хэлний орчуулгын төв. (2008). Хятад–монгол шинэ үгсийн толь. Хөх хот: Үндэстний хэвлэлийн хороо.
- Рашдонров, Д. (2000). Орчин цагийн монгол хэлний товч тайлбар толь. Хөх хот: Өвөр Монголын өөртөө засах орны хэвлэлийн газар.
- Төмөртоого, Д. (2004). Орчин цагийн монгол хэл. Улаанбаатар.
- Цэнгэлт, С. (2012). Орчин цагийн хэл шинжлэлийн онолын сонгомол. Хөх хот: Өвөр Монголын өөртөө засах орны хэвлэлийн газар.
- Цэвэл, Я. (2013). Монгол хэлний товч тайлбар. Хөх хот: Өвөр Монголын өөртөө засах орны хэвлэлийн газар.
- 陈章太. (2005). 语言规划研究. 北京: 商务印书馆.
- 陈昌来. (2007). 应用语言学导论. 北京: 商务印书馆.
- 奈达. (1998). 语言文化与翻译. 呼和浩特: 内蒙古大学出版社.



Д.НАЦАГДОРЖИЙН “МИНИЙ НУТАГ” ШҮЛГИЙН СОЛОНГОС  
ОРЧУУЛГУУДЫН УТГА, ДҮРСЛЭЛ, ХЭМНЭЛИЙН  
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Б.Дулмаа<sup>53</sup>

**Abstract:** This study examines three Korean translations of D. Natsagdorj's poem “My Homeland,” focusing on the transmission of meaning, imagery, and poetic rhythm. As a classic work of Mongolian literature, the poem is characterized by rich imagery, repetition structures, and lyrical expression, which present challenges in translation.

Using a comparative analytical approach, this study analyzes lexical choices, figurative language, repetition, and rhythm in the selected translations. The findings show that while all three versions convey the core meaning of the original, they differ in their treatment of stylistic features. The first translation more effectively preserves poetic form and rhythmic repetition, closely reflecting the original's lyrical qualities. In contrast, the second translation prioritizes clarity and explanatory expression, which tends to weaken poetic rhythm. The third translation, covering only part of the text, provides a limited representation and relies on more generalized expressions.

The study concludes that balancing semantic accuracy and formal equivalence is essential in poetry translation and emphasizes the importance of preserving both cultural specificity and poetic aesthetics.

**Түлхүүр үг:** яруу найргийн орчуулга, утга, дүрслэл, хэмнэл, солонгос орчуулга

### УДИРТГАЛ

Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлэг нь Монголын утга зохиолын сонгодог бүтээлүүдийн нэг бөгөөд эх орны байгаль, түүх, соёлын онцлогийг уянгын аргаар илэрхийлсэн яруу найргийн бүтээл юм. Уг шүлэг нь зөвхөн утга санаагаараа төдийгүй дүрслэлийн баялаг байдал, давталт бүхий хэмнэл, уран сайхны хэл найруулгын өвөрмөц онцлогоороо ялгардаг бөгөөд эдгээр шинж нь гадаад хэлнээ орчуулахад тодорхой бэрхшээл дагуулдаг. Яруу найргийн орчуулга нь эх зохиолын утгыг дамжуулахаас гадна түүний уран сайхны хэлбэр, хэмнэл, дүрслэлийг хадгалах шаардлагатай байдаг тул орчуулагчийн зорилго, арга барилаас шалтгаалан өөр өөр хувилбарууд бий болдог. Иймд нэг эх зохиолын олон орчуулгыг харьцуулан судлах нь орчуулгын онцлог, ялгааг илрүүлэхэд онол, практикийн чухал ач холбогдолтой юм.

Судалгааны зорилго нь Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийн солонгос хэлнээ орчуулагдсан гурван хувилбарыг харьцуулан, тэдгээрт эх шүлгийн утга, дүрслэл, яруу найргийн хэмнэл хэрхэн дамжуулагдсан байдлыг тодруулахад оршино. Судалгааны гол асуулт нь эдгээр орчуулга эх шүлгийн утга болон хэлбэрийг ямар түвшинд, ямар хэлбэрээр хадгалж чадсан бэ гэдэгт чиглэнэ. Судалгаанд сонгон авсан орчуулгууд нь дараах гурван ялгаатай онцлог бүхий хувилбарууд болно. Үүнд: нэгдүгээр орчуулга - орчин үеийн утга зохиолын орчуулгын хэв шинжийг баримталсан шинжтэй, хоёрдугаар орчуулга - сургалтын зориулалттай тайлбарлах хандлага давамгайлсан, гуравдугаар орчуулга - солонгосын нийтийн тээврийн орчинд (метроны шилэн хананд) нийтлэгдсэн, эх шүлгийн хэсгийг хамарсан орчуулга зэрэг ялгаатай онцлог бүхий

<sup>53</sup> PhD, МУИС, ШУС, ХУС, Ази судлалын тэнхим, ORCID: 0009-0009-1769-2246

гурван хувилбар гэж үзэж болно. Тус судалгаанд харьцуулсан шинжилгээний аргыг хэрэглэн орчуулуудын үгийн сонголт, дүрслэлийн илэрхийлэл, давталт ба хэмнэлийн онцлог, мөн утга дамжуулалтын ялгааг тодорхойлох гэж оролдсон болно.

## ҮНДСЭН ХЭСЭГ

Яруу найргийн орчуулга нь утга зохиолын орчуулгын хамгийн нарийн төвөгтэй хэлбэрийн нэг бөгөөд эх зохиолын утга санааг дамжуулахын зэрэгцээ түүний уран сайхны хэлбэр, дүрслэл, хэмнэл, аялгууг хадгалах шаардлагатай байдаг. Шүлэгт үгийн сонголт, дүрслэл, давталт, хэмнэл зэрэг нь утга илэрхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг тул эдгээрийг өөр хэлэнд бүрэн дүйцүүлэн буулгах нь хүндрэлтэй байдаг. Орчуулгын онолд утга ба хэлбэрийн дүйцлийг ялган авч үздэг бөгөөд Америкийн хэл шинжлэлч, орчуулгын онолч Южин Найда (Eugene Nida) орчуулгын онолд идэвхт болон хэлбэрийн дүйцлийг ялган авч үзсэн байдаг. Тэрээр идэвхт дүйцэл<sup>54</sup> болон хэлбэрийн дүйцэл<sup>55</sup> -ийг ялган тодорхойлсон юм. Идэвхт дүйцэлд эх зохиолын агуулгыг ойлгомжтой дамжуулахыг чухалчилдаг бол хэлбэрийн дүйцэлд эхийн бүтэц, хэлбэр, уран сайхны онцлогийг хадгалахыг зорьдог.

Орчуулга нь нэг хэлээр илэрхийлэгдсэн санаа, агуулгыг нөгөө хэлний бүх хэрэглүүрийг ашиглан бүрэн төгс илэрхийлэх бүтээлч хөдөлмөрийн үр дүн гэж үздэг. Иймээс орчуулга нь зөвхөн хэлний хувиргал бус, харин утга, найруулга, уран сайхны илэрхийллийг цогцоор нь дамжуулах үйл явц юм. Мөн орчуулгын үндсэн зарчим нь эх зохиолын агуулгыг үнэн зөвөөр илэрхийлэх явдал бөгөөд үүнийг хэрэгжүүлэхдээ үгчилсэн хуулбарлалд хэт автахгүй, харин утга, хэлбэрийн оновчтой зохицлыг хангах шаардлагатай. Ялангуяа уран зохиолын орчуулгад зохиолчийн бүтээсэн дүр, уран сайхны орчныг өөр хэлэнд дахин амилуулах онцгой шаардлага тавигддаг бөгөөд энэ нь орчуулгыг энгийн хэл шилжүүлэлтээс ялгах гол шинж болдог(Р.Гүрбазар, 1996:19-22).

Хэл, соёл нь хоорондоо нягт холбоотой мэт боловч тэдгээр нь хүний сэтгэхүйгээр дамжин холбогддог гэж үздэг. Өөрөөр хэлбэл, хэл ба соёлын хооронд шууд бус, харин сэтгэхүйгээр дамжсан холбоо оршдог бөгөөд хүн юмс үзэгдлийг танин мэдэж, ойлгосны үндсэн дээр тухайн ойлголт, ухагдахуунаа хэлээр илэрхийлдэг(Г.Элдэв-Очир, 2013:55-60). Иймээс орчуулгад зөвхөн хэл шинжлэлийн бус, тухайн соёл, сэтгэлгээний онцлогийг хамтад нь авч үзэх шаардлагатай болдог. Мөн яруу найргийг орчуулахад “яруу найртай, утга төгс, мэдэхүйд хялбар” байх гэсэн гурван зарчмыг баримтлах ёстойг судлаачид онцолдог(А.Цэрэнчулуун, 2013:11-30). Өөрөөр хэлбэл, шүлгийн орчуулга нь зөвхөн үг, утгыг дамжуулах төдий бус, түүний найруулга, уран хэллэг, сэтгэл хөдлөлд нөлөөлөх чадварыг бүхэлд нь хадгалах шаардлагатай(Ц.Дамдинсүрэн, 1957:10). Харин Их Британийн орчуулгын онолч Питер Ньюмарк (Peter Newmark) яруу найргийн орчуулгад утга болон уран сайхны хэлбэрийн тэнцвэрийг хадгалах шаардлагатайг онцолсон байдаг(Peter Newmark, 1988:174-176). Иймээс судалгаанд дээрх онолын хандлагад тулгуурлан Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийн солонгос орчуулгуудыг үгийн сонголт ба дүрслэл, давталт ба хэмнэл, мөн утга дамжуулалтын үүднээс харьцуулан шинжилсэн болно.

Үгийн сонголт ба дүрслэлийн онцлог

Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийн эхний хэсэгт Монгол орны байгаль, газарзүйн онцлогийг уран яруу дүрслэлээр илэрхийлсэн бөгөөд үүнийг солонгос орчуулгуудтай харьцуулахад үгийн сонголт, дүрслэлийн дамжуулалт орчуулга бүрд харилцан адилгүй байна. Эх

<sup>54</sup> Идэвхт дүйцэл (dynamic equivalence) – эхийн утгыг зорилтот хэлний уншигчид ойлгомжтойгоор дамжуулах зарчим. Eugene Nida (1964), *Toward a Science of Translating*, Leiden: E.J. Brill, pp. 159–160.

<sup>55</sup> Хэлбэрийн дүйцэл (formal equivalence) – эх зохиолын хэлбэр, бүтэц, үгийн онцлогийг хадгалах зарчим. Eugene Nida (1964), pp. 159–160.

шүлгийн тодорхой дүрслэлүүдийг гурван орчуулгатай зэрэгцүүлэн шинжлэхэд утга, хэлбэрийн ялгаа илүү тод илэрч байна. Жишээлбэл, эх шүлгийн “Өмнө зүгийн манлай болсон элсэн манхан далайнууд” гэх мөрийг нэгдүгээр орчуулгад “남쪽의 으뜸인 모래 바다들이여!” (өмнө зүгийн сүр жавхлант элсэн далайнууд) хэмээн буулгасан нь “모래 바다” (элсэн далай) гэх зүйрлэлийг хадгалсан боловч “манлай болсон” гэх уран сайхны тодотгол бүрэн илэрхийлэгдээгүй. Харин хоёрдугаар орчуулгад “남방을 상징하는 모래 언덕의 바다들” (өмнө зүгийн бэлгэдэл болсон элсэн толгодын далай), гуравдугаар орчуулгад “남쪽을 상징하는 모래 언덕의 바다들” (өмнө зүгийг илэрхийлэх элсэн толгодын далай) хэмээн орчуулж, “상징하는” (бэлгэдэх, илэрхийлэх) гэх үгээр орлуулснаар эхийн “манлай болсон” гэх утгын өнгө аясыг зөөлрүүлжээ. Мөн эх шүлгийн “Хотол олны эм болсон горхи булаг рашаанууд” гэх мөрөнд байгалийн усыг амьдрал тэтгэгч, бэлгэдлийн утгатайгаар дүрсэлсэн байдаг. Үүнийг нэгдүгээр орчуулгад “중생의 약수인 샘물들이여!” (амьд бүхний эмчилгээний чанартай булаг ус) хэмээн буулгасан нь “약수” (эмчилгээний ус) гэсэн үгээр “эм болсон” гэх утгыг харьцангуй оновчтой илэрхийлсэн байна. Харин хоёрдугаар орчуулгад “모든 이에게 약이 되는 시내와 샘과 광천들” (хүн бүхэнд эм болдог горхи, булаг, рашаан) хэмээн орчуулж, утгыг тайлбарлан илэрхийлснээр уянгын товч хэлбэрийг сулруулжээ. Гуравдугаар орчуулгад “모든 이에게 약수가 된 시내와 샘과 광천수들” (хүн бүхний хувьд эмчилгээний ус болсон горхи, булаг, рашаан) хэмээн орчуулсан нь утгад ойртсон боловч өгүүлэмж давамгайлсан шинжтэй болжээ.

Үүнтэй адил “Хүн малын ундаа болсон тойром бүрд уснууд” гэх мөрөнд “тойром бүрд” хэмээх соёл, ахуйн онцлог туссан байдаг. Нэгдүгээр орчуулгад “오아시스” (цөл, хээрийн усан эх үүсвэр буюу баянбүрд) гэж буулгасан нь ойролцоо утга илэрхийлсэн боловч Монгол ахуйн онцлогийг бүрэн тусгаагүй. Харин хоёрдугаар орчуулгад “웅덩이, 늪” (ус тогтсон газар, намаг) гэж орчуулсан нь эхийн утгаас зөржээ. Гуравдугаар орчуулгад “샘물” (булаг ус) зэрэг ерөнхий ойлголт хэрэглэснээр утгын нарийвчлал буурчээ. Түүнчлэн “Хол газраа одсон харгуй дардан замууд” гэх мөрөнд гарч буй “харгуй” нь нүүдэлчин ахуй, уламжлалт зам харилцааг илэрхийлсэн онцлог ойлголт юм. Нэгдүгээр орчуулгад “거침없는 도로들이여!” (саадгүй шулуун замууд) гэж орчуулж, “도로” (авто зам) хэмээх орчин үеийн ойлголтоор буулгаснаар анхны утга өөрчлөгдсөн байна. Харин хоёрдугаар болон гуравдугаар орчуулгад “넓고 단단한 길들” (өргөн, баг бөх замууд) гэж илэрхийлсэн нь “харгуй” гэх уламжлалт утгыг бүдгэрүүлжээ.

“Хүний сэтгэл тэнийсэн уудам амьсгалт талууд” гэх мөрөнд байгалийн уудам орон зайг хүний дотоод мэдрэмжтэй холбосон уянгын, хийсвэр шинжтэй дүрслэл илэрдэг. Нэгдүгээр орчуулгад “가슴을 탁 트이게 해주는 광활한 초원들이여!” (сэтгэлийг уужим болгож, цээжийг онгойлгох өргөн уудам талууд) хэмээн орчуулсан нь утгыг тодорхой хэмжээнд илэрхийлсэн боловч эхийн нарийн өнгө аясыг бүрэн хадгалж чадаагүй. Харин хоёрдугаар орчуулгад “사람의 마음을 펴주는 드넓은 초원들” (хүний сэтгэлийг тэлэх уудам талууд) гэж хөрвүүлсэн нь утгад дөхсөн ч тайлбарлах шинж давамгайлжээ. Мөн “Салхины үзүүрт найгасан соргог нарийн ногоотой” гэх мөрөнд хөдөлгөөн, мэдрэмжийг хослуулсан амьд дүрслэл илэрхийлэгддэг. Нэгдүгээр орчуулгад “산들바람에 하늘대는 가느다란 푸성귀들이여!” (зөөлөн салхинд намилзан хөдлөх нарийн ногоо) гэж хөрвүүлсэн нь хөдөлгөөнийг хадгалсан боловч “салхины үзүүрт” гэх нарийн мэдрэмж бүрэн илэрхийлэгдээгүй. Хоёрдугаар орчуулгад “바람 끝에 흔들리는 싱싱하고 부드러운 푸새” (салхины үзүүрт найган хөдлөх шинэхэн, зөөлөн өвс) хэмээн буулгасан нь утгад ойртсон ч уянгын нягт хэлбэрийг сулруулжээ. Үүнээс гадна “Сүлд тахилга улирсан сүмбэр их овоотой” гэх мөрөнд Монголын шашин, зан үйлтэй холбоотой “овоо” хэмээх соёлын онцлог ойлголт тусгагдсан байдаг. Нэгдүгээр орчуулгад “하늘에 제사 지내던 수많은

오보들이여!” (тэнгэрт тахилга өргөдөг олон овоонууд) хэмээн орчуулж, “오보” (овоо гэж галигласан хэлбэр) хэмээх үгийг хэрэглэснээр соёлын онцлогийг хадгалахыг зорьсон байна. Харин хоёрдугаар орчуулгад мөн адил “오보” (овоо) гэж хэрэглэсэн боловч тайлбар дутмаг хэвээр үлдэж, ойлголтын утга бүрэн гарсангүй.

“Өлгий сайхан ууланд өвгөдийг тавьсан газар” гэх мөрөнд “өлгий” хэмээх үг нь эх орон, төрөлх нутаг, хамгаалал, ивээл гэсэн бэлгэдэлт утга агуулдаг. Нэгдүгээр орчуулгад “포대기처럼 아늑하여 조상들이 묻힌 땅이여!” (өлгий мэт дулаан, тухтай, өвгөдийг нутаглуулсан газар) гэж хөрвүүлсэн нь зүйрлэлийг хадгалсан байна. Харин хоёрдугаар орчуулгад “요람 같은 아름다운 산에 조상들을 모신 땅” (өлгий мэт сайхан ууланд өвгөдийг нутаглуулсан газар) хэмээн орчуулснаар утгад ойртсон боловч хэлбэр сунжруулсан шинжтэй байна.

Дээрх жишээнүүдээс харахад солонгос орчуулгуудад эх шүлгийн дүрслэлийг дамжуулахдаа ялгаатай арга хэрэглэсэн нь ажиглагдана. Нэгдүгээр орчуулга нь зүйрлэл, уран сайхны тодотгол, хэмнэл зэрэг хэлбэрийн шинжийг сайн хадгалсан бол хоёрдугаар орчуулга нь утгыг тайлбарлан ойлгомжтой дамжуулан, уянгын өнгө аясыг тодорхой хэмжээнд сулруулжээ. Харин гуравдугаар орчуулга нь эх шүлгийн зөвхөн эхний хэдэн бадагт хамаарах тул бүхэл бүтэн харьцуулалт хийх боломж хязгаарлагдмал байлаа. Иймээс яруу найргийн орчуулгад утга болон хэлбэрийн тэнцвэрийг хадгалах нь чухал бөгөөд орчуулагчийн зорилго, арга барилаас шалтгаалан эх зохиолын дүрслэл, уран сайхны онцлог харилцан адилгүй түвшинд илэрхийлэгддэг гэж үзэж болно. Гуравдугаар орчуулгын бүрэн эхийг олж үзэх боломж хязгаарлагдмал байсан тул судалгаанд зөвхөн нийтлэгдсэн хэсгийг ашигласан болно.

Давталт ба хэмнэлийн онцлог

Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийн уран сайхны гол онцлогийн нэг нь давталт бүхий бүтэц бөгөөд үүгээр шүлгийн уянгалаг хэмнэл бүрддэг. “Энэ бол миний төрсөн нутаг / Монголын сайхан орон” зэрэг мөрүүд шүлгийн бараг бүх бадгийн төгсгөлд давтагдсанаар утга санааг бататгахын зэрэгцээ уянгын хэмнэл, аялгууг бий болгож, эх оронч сэтгэл, бахархлыг тодотгодог.

Солонгос орчуулгуудыг харьцуулахад давталтыг хадгалах байдал харилцан адилгүй байна. Нэгдүгээр орчуулгад “그곳은 내가 태어난 고향 / 아름다운 몽골” (тэр бол миний төрсөн нутаг / үзэсгэлэнт Монгол) хэмээн орчуулж, эхийн давталтын бүтэц, хэмнэлийг хадгалсан байна. Хоёрдугаар орчуулгад “이는 내가 태어난 고향, 아름다운 몽골 땅” (энэ бол миний төрсөн нутаг, сайхан Монгол орон) хэмээн буулгаж, хоёр мөрийг нэг өгүүлбэрт нэгтгэснээр давталтын хэмнэл сулрах хандлага ажиглагдана. Гуравдугаар орчуулгад “이는 내가 태어난 고향 아름다운 나라 몽골” (энэ бол миний төрсөн нутаг, үзэсгэлэнт Монгол орон) хэмээн хөрвүүлсэн нь давталтыг хадгалсан боловч мөрийн зохион байгуулалт, хэсэглэл өөрчлөгдсөнөөр уянгалаг хэмнэл бүрэн илэрхийлэгдээгүй.

Эндээс нэгдүгээр орчуулга нь эх шүлгийн хэлбэр, хэмнэлийг илүү сайн буулгасан бол хоёрдугаар, гуравдугаар орчуулгад утгыг хадгалах хандлага давамгайлж, давталтын уянгалаг шинж тодорхой хэмжээнд суларчээ. Цувраа болон зэрэгцүүлсэн бүтэц бүхий хэмнэлийг тодорхой жишээгээр авч үзвэл ялгаа илүү тод харагдана. Тухайлбал, “Хэрлэн, Онон, Туулын тунгалаг ариун мөрнүүд / Хотол олны эм болсон горхи булаг рашаанууд” гэх мөрүүдэд газарзүйн нэрсийг дараалан жагсааж, дараагийн мөрөнд тодотгол бүхий хэлбэрээр үргэлжлүүлсэн нь хэмнэлийн жигд урсгалыг бүрдүүлдэг. Нэгдүгээр орчуулгад “헤를렌, 오논, 툄! 맑고 깨끗한 강들이여! / 중생의 약수인 샘물들이여!” (Хэрлэн, Онон, Туул! тунгалаг голууд / амьд бүхний эм болсон уснууд) хэмээн орчуулж, цувраа болон хос мөрийн бүтцийг илүү оновчтой буулгасан байна. Харин хоёрдугаар орчуулгад “헤를렌, 오논, 툄 같은 맑고 깨끗한 강들 / 모든 이에게 약이 되는 시내와 샘과 광천들” (Хэрлэн, Онон, Туул мэт тунгалаг голууд / хүн бүхэнд эм болдог уснууд)

хэмээн орчуулж, “같은” (мэт) гэх үг нэмэгдсэнээр гуравласан цувраа бүтцийн шууд хэмнэл сулран, тайлбарлах шинжтэй болжээ. Гуравдугаар орчуулгад “헤를렌, 오농, 툄 등 맑고 거룩한 강들 / 모든 이에게 약수가 된 시내와 샘과 광천수들” (Хэрлэн, Онон, Туул зэрэг тунгалаг голууд / эмчилгээний ус болсон булаг шанд) хэмээн орчуулж, “등” (зэрэг) гэх үг хэрэглэснээр гуравласан цувраа бүтцийн цохилтот хэмнэл зөөлөрсөн байна.

Мөн “Хөвсгөл, Увс, Буйрын гүн цэнхэр нуурууд / Хүн малын ундаа болсон тойром бүрд уснууд” гэх мөрүүдэд нэрсийн цувраа болон бэлгэдэлт утга бүхий дараагийн мөр хослон, хэмнэлийн жигд урсгалыг бий болгодог. Нэгдүгээр орчуулгад “ஹ்ஸ்ꠘ, 읍스, 보이르! 깊고 푸른 호수들이여! / 사람과 가축의 생명수인 오아시스들이여!” (Хөвсгөл, Увс, Буйр! гүн цэнхэр нуурууд / хүн малын амьдралын ус болсон баянбүрд) хэмээн орчуулж, хос мөрийн бүтцийг хадгалжээ. Харин хоёрдугаар орчуулгад “ஹ்스ꠘ, 오브스, 보이르 같은 깊고 푸른 호수들 / 사람과 가축이 먹는 웅덩이, 늪의 물들” (Хөвсгөл, Увс, Буйр мэт гүн цэнхэр нуурууд / хүн мал уудаг ус тогтсон газар) хэмээн илэрхийлж, утгыг тайлбарлах явцад хэмнэл суларчээ. Гуравдугаар орчуулгад “ஹ்스ꠘ, 오브스, 보이르 등 깊고 파란 호수들 / 사람과 가축의 음료가 된 오아시스와 샘물들” (Хөвсгөл, Увс, Буйр зэрэг гүн цэнхэр нуурууд / хүн малын ундаа болсон ус) хэмээн орчуулан, “등” (зэрэг) хэрэглэснээр гуравласан цувраа бүтцийн хэмнэлийг зөөлрүүлжээ. Түүнчлэн “Орхон, Сэлэнгэ, Хөхийн онц сайн голууд / Уурхай баялгийн охь болсон олон уул даваанууд” гэх мөрүүдэд ижил бүтэц бүхий хоёр мөр дараалан орж, хэмнэлийн жигд байдлыг хадгалжээ. Нэгдүгээр орчуулгад “오르혼, 셀렌게, 후후이! 수려한 강들이여! / 풍부한 자원의 보고인 수많은 산과 고개들이여!” (Орхон, Сэлэнгэ, Хөх! сайхан голууд / баялгийн эх болсон олон уул даваа) хэмээн орчуулан хос мөрийн бүтцийг хэвээр хадгалжээ. Харин хоёрдугаар болон гуравдугаар орчуулгад “같은”, “등” зэрэг үгсийг ашиглан цувраа бүтцийг ерөнхийлснөөр эхийн хэмнэлийн хурц, жигд шинж тодорхой хэмжээгээр суларчээ.

Эдгээр жишээнээс цувраа ба зэрэгцүүлсэн бүтэц нь эх шүлгийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нэгдүгээр орчуулгад сайн хадгалагдан буусан бол хоёрдугаар, гуравдугаар орчуулгад тайлбарлах болон ерөнхийлөх хандлагаас шалтгаалан хэмнэлийн жигд байдал тодорхой хэмжээнд суларсан байна. Өөр нэг онцлог нь гуравласан цувраа бүтэц юм. Шүлгийн “Хөвсгөл, Увс, Буйрын гүн цэнхэр нуурууд”, “Хэрлэн, Онон, Туулын тунгалаг ариун мөрнүүд”, “Орхон, Сэлэнгэ, Хөхийн онц сайн голууд” зэрэг мөрүүдэд гурван газарзүйн нэрийг гуравласан цуваа бүтцээр жагсаасан нь шүлгийн хэмнэлийг жигд, уянгалаг болгодог.

Солонгос орчуулгуудыг харьцуулбал гуравласан цувраа бүтцийн хэмнэлийг хадгалах байдал ялгаатай байна. Нэгдүгээр орчуулгад “ஹ்스ꠘ, 읍스, 보이르!”, “헤를렌, 오농, 툄!”, “오르혼, 셀렌게, 후후이!” зэрэг хэлбэрээр гурван нэрийг шууд дараалуулан жагсаасан нь эх шүлгийн хэмнэлийг шингээсэн байна. Харин хоёрдугаар орчуулгад “ஹ்스ꠘ, 오브스, 보이르 같은...” (Хөвсгөл, Увс, Буйр мэт...), “헤를렌, 오농, 툄 같은...” (Хэрлэн, Онон, Туул мэт...) хэмээн “같은” (мэт) гэсэн үг нэмж хэрэглэснээр гуравласан цувраа бүтцийн хэмнэл суларч, тайлбарласан шинж давамгайлжээ. Гуравдугаар орчуулгад “ஹ்스ꠘ, 오브스, 보이르 등...” (Хөвсгөл, Увс, Буйр зэрэг...), “헤를렌, 오농, 툄 등...” (Хэрлэн, Онон, Туул зэрэг...) хэмээн “등” (зэрэг) гэсэн үг хэрэглэснээр хэрэглэснээр гуравласан цувраа бүтцийг ерөнхийлж, давамжит хэмнэл зөөлөрчээ.

Иймээс гуравласан цувраа бүтэц нь шүлгийн хэмнэлийг бүрдүүлэх чухал бүрэлдэхүүн бөгөөд нэгдүгээр орчуулгад илүү оновчтой хадгалагджээ. Хоёрдугаар болон гуравдугаар орчуулгад тайлбарлах, ерөнхийлөх хандлага давамгайлснаар хэмнэлийн онцлог тодорхой хэмжээгээр суларсан гэж үзэж болно. Шүлэг уянгын, сэтгэлзүйн өнгө аястай урт мөрүүдийн

давталттай. Үүнд, “Хүний сэтгэл тэнийсэн уудам амьсгалт талууд”, “Салхины үзүүрт найгасан соргог нарийн ногоотой” зэрэг мөрүүдэд байгалийн дүрслэлийг хүний дотоод мэдрэмжтэй холбон илэрхийлсэн уянгалаг бүтэц байдаг.

Солонгос орчуулгуудыг харьцуулахад уянгын хэмнэлийг хадгалах байдал харилцан адилгүй байна. Нэгдүгээр орчуулгад “가슴을 탁 트이게 해주는 광활한 초원들이여!” (сэтгэлийг онгойлгож, уужим болгох өргөн уудам талууд) хэмээн орчуулж, эхийн “сэтгэл тэнийх” гэх утгыг сайн дамжуулсан бөгөөд уянгын өнгө аясыг тодорхой хэмжээнд хадгалжээ. Мөн “산들바람에 하늘대는 가느다란 푸성귀들이여!” (зөөлөн салхинд намилзан хөдлөх нарийн ногоо) хэмээн орчуулснаар хөдөлгөөнт дүрслэлийг хадгалсан боловч “салхины үзүүрт” гэх нарийн мэдрэмж бүрэн илэрхийлэгдээгүй. Харин хоёрдугаар орчуулгад “사람의 마음을 펴주는 드넓은 초원들” (хүний сэтгэлийг тэлэх уудам талууд), “바람 끝에 흔들리는 싱싱하고 부드러운 푸새” (салхины үзүүрт найган хөдлөх шинэхэн, зөөлөн өвс) хэмээн илэрхийлсэн нь утгын хувьд ойртсон ч тайлбарласан шинж давамгайлснаар эх шүлгийн уянгын товч, цохилтот хэмнэл суларчээ.

Эндээс харвал уянгын, сэтгэлзүйн өнгө аястай урт мөрүүд нь эх шүлгийн бас нэгэн чухал бүрэлдэхүүн бөгөөд нэгдүгээр орчуулгад оновчтой зөв орчуулсан бол хоёрдугаар, гуравдугаар орчуулгад тайлбарлах болон товчлох хандлагаас шалтгаалан хэмнэлийн онцлог тодорхой хэмжээгээр суларсан байна. Шүлгийн уянгалаг хэмнэлийг бүрдүүлэхэд хөдөлгөөн илэрхийлсэн дүрслэл чухал байр суурь эзэлдэг. Жишээлбэл, “Салхины үзүүрт найгасан соргог нарийн ногоотой”, “Саруул талд яралзсан сонин янзын зэрэглээтэй”, “Жигүүртэн шувуу холоос ирж гангар гунгар донгодсон орон” зэрэг мөрүүдэд хөдөлгөөн, үйл явцыг илэрхийлсэн үгс давтагдсанаар шүлгийн хэмнэл амьд, урсгалтай болдог.

Солонгос орчуулгуудыг харвал хөдөлгөөнт хэмнэлийг хадгалах байдал харилцан адилгүй байна. Нэгдүгээр орчуулгад “산들바람에 하늘대는 가느다란 푸성귀들이여!” (зөөлөн салхинд намилзан хөдлөх нарийн ногоо), “너른 들판에 반짝이는 진기한 신기루들이여!” (өргөн талд гялалзан харагдах сонин зэрэглээ), “철새들이 날아와 재잘거리는 땅이여!” (нүүдлийн шувууд нисэн ирж жиргэх газар) хэмээн орчуулж, хөдөлгөөнийг илэрхийлсэн үйл үгсийг (“하늘대는” – намилзах, “반짝이는” – гялалзах, “날아와” – нисэн ирэх) хадгалснаар эхийн утга, хэмнэлийг сайн дамжуулжээ. Харин хоёрдугаар орчуулгад “바람 끝에 흔들리는 싱싱하고 부드러운 푸새” (салхины үзүүрт найган хөдлөх зөөлөн өвс), “탁 트인 초원에는 번쩍거리는 갖가지 신기루” (өргөн талд гялалзах янз бүрийн зэрэглээ), “철새들 멀리서 날아와 끼룩대는 대지” (нүүдлийн шувууд нисэн ирж дуугарах нутаг) хэмээн орчуулсан нь утгыг хадгалсан боловч өгүүлдэрийн бүтэц сунжирснаар тайлбарлах шинж нэмэгдэж, хэмнэлийг сулруулжээ. Хөдөлгөөн илэрхийлсэн эдгээр дүрслэл нь шүлгийн уянгалаг, амьд хэмнэлийг бүрдүүлэх чухал үүрэгтэй ба нэгдүгээр орчуулгад илүү оновчтой дүрслэгджээ. Хоёрдугаар болон гуравдугаар орчуулгад хэлбэрийн өөрчлөлтөөс шалтгаалан энэ онцлог тодорхой хэмжээгээр буурчээ.

#### Утга дамжуулалтын онцлог

Яруу найргийн орчуулгад эх зохиолын утгыг үнэн зөв дамжуулах нь чухал боловч үгийн шууд дүйцэл тэр бүр боломжтой байдаггүй. Иймээс орчуулагчид утгыг хадгалах, тайлбарлах, зарим тохиолдолд өөрчлөх зэрэг ялгаатай арга хэрэглэдэг. “Миний нутаг” шүлгийн солонгос орчуулгууд нь утга дамжуулалтын хувьд тодорхой ялгаатай байна. Шүлгийн “Хүн малын ундаа болсон тойром бүрд уснууд” гэх мөрөнд гарч буй “тойром бүрд” нь Монголын говь, хээрийн онцлог бүхий усны эх үүсвэрийг илэрхийлэх ба хүн, малын амьдралд чухал үүрэгтэй ойлголт юм. Солонгос орчуулгууд энэ ойлголтыг өөр өөрөөр буулгасан байна. Нэгдүгээр орчуулгад “오아시스” (цөл, хээрийн усан эх үүсвэр буюу баянбүрд) хэмээн орчуулсан нь утгад дөхсөн ч Монгол ахуйн онцлогийг бүрэн илэрхийлээгүй. Хоёрдугаар орчуулгад “웅덩이, 늪” (ус тогтсон газар, намаг) гэж орчуулснаар эх ойлголтоос зөрж, өөр утга илэрхийлжээ. Гуравдугаар орчуулгад “샘물” (булаг

ус) зэрэг ерөнхий ойлголт хэрэглэснээр утгын нарийвчлал буурчээ. Эндээс харахад ахуй, байгальтай холбоотой үг хэллэгийг орчуулахад утга өөрчлөгдөх, ерөнхийлөх хандлага илэрч байна.

“Сүлд тахилга улирсан сүмбэр их овоотой” гэх мөр дэх “овоо” нь Монголын уламжлалт шашин, зан үйлтэй холбоотой, тахилга өргөдөг ариун газар гэсэн соёлын ойлголтыг илэрхийлдэг. Орчуулгыг харьцуулахад, нэгдүгээр орчуулгад “하늘에 제사 지내던 수많은 오보들이여!” (тэнгэрт тахилга өргөдөг олон овоонууд) гэж буулгаж, “오보” (овоо хэмээх галиг) гэсэн үгийг хэрэглэснээр соёлын утгыг хадгалахыг зорьжээ. Хоёрдугаар орчуулгад мөн “오보” (овоо) гэж галигласан боловч нэмэлт тайлбар дутмаг тул утга бүрэн илрээгүй.

“Хол газраа одсон харгуй дардан замууд” гэсэн мөр дэх “харгуй” нь нүүдэлчин ахуй, уламжлалт зам харилцааг илэрхийлсэн онцлог ойлголт юм. Гэвч солонгос орчуулгад энэ утгыг ерөнхийлсөн байна. Нэгдүгээр орчуулгад “거침없는 도로들이여!” (саадгүй шулуун замууд) гэж орчуулж, “도로” (авто зам) гэх орчин үеийн ойлголтыг хэрэглэсэн бол хоёр болон гуравдугаар орчуулгад “넓고 단단한 길들” (өргөн, бат бөх замууд) хэмээн илэрхийлжээ. Ийнхүү “харгуй” хэмээх уламжлалт утга бүдгэрсэн байна.

“Хотол олны эм болсон горхи булаг рашаанууд” хэмээх мөрд байгалийн усыг амьдралыг тэтгэгч, бэлгэдлийн утгатайгаар дүрсэлжээ. Нэгдүгээр орчуулгад “중생의 약수인 샘물들이여!” (амьд бүхний эмчилгээний чанартай булаг ус) гэж буулгаж, “약수” (эмчилгээний ус) гэсэн үгээр бэлгэдлийг харьцангуй оновчтой дамжуулсан байна. Харин хоёрдугаар орчуулгад “모든 이에게 약이 되는 시내와 샘과 광천들” (хүн бүхэнд эм болдог ус) гэж тайлбарласан шинжтэй болж, уянгын нягт хэлбэр суларчээ. Гуравдугаар орчуулгад “모든 이에게 약수가 된 시내와 샘과 광천수들” (эмчилгээний ус болсон горхи, булаг) хэмээн буулгасан нь утгад ойртсон ч өгүүлэмж давамгайлжээ. Иймд бэлгэдэлт хэллэгийг орчуулахад утга ба хэлбэрийн тэнцвэр алдагдах хандлага ажиглагдаж байна.

Мөн “Өлгий сайхан ууланд өвгөдийг тавьсан газар” гэх мөр дэх “өлгий” нь эх орон, төрөлх нутаг, хамгаалал, ивээл гэсэн давхар бэлгэдлийг агуулдаг. Нэгдүгээр орчуулгад “포대기처럼 아늑하여 조상들이 묻힌 땅이여!” (өлгий мэт дулаан, тухтай газар) гэж буулгаж, зүйрлэлийг хадгалсан байна. Харин хоёрдугаар орчуулгад “요람 같은 아름다운 산에 조상들을 모신 땅” (өлгий мэт сайхан уул) хэмээн илэрхийлсэн нь утгад дөхсөн боловч хэлбэрийг сунжруулжээ.

Сонгосон жишээнээс харахад утга дамжуулах явцад соёл, ахуй, бэлгэдэлтэй холбоотой ойлголтуудыг орчуулахад ялгаатай арга хэрэглэгдсэн байна. Нэгдүгээр орчуулга нь утга болон хэлбэрийг харьцангуй тэнцвэртэй хадгалсан бол хоёрдугаар орчуулга нь тайлбарлах хандлагатай, гуравдугаар орчуулгад эх шүлгийн зөвхөн хэсгийг хамарсан тул утга дамжуулалтын харьцуулалт хязгаарлагдмал байв.

## ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаанд Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийн солонгос хэлнээ хөрвүүлсэн гурван хувилбарыг утга, дүрслэл болон яруу найргийн хэмнэлийн үүднээс харьцуулан шинжилжээ. Судалгааны үр дүнгээс үзэхэд эдгээр орчуулга нь эх шүлгийн утга санааг ерөнхийд нь дамжуулсан боловч уран сайхны хэлбэр, дүрслэлийн нарийвчлал, хэмнэлийн хувьд тодорхой ялгаа илэрч байна.

Үгийн сонголт, дүрслэлийн хувьд зарим орчуулгад эх шүлгийн баялаг илэрхийллийг харьцангуй сайн хадгалсан бол нөгөөд нь ерөнхийлөх, тайлбарлах хандлага давамгайлжээ.

Ялангуяа байгаль, газарзүйн нэршил, ахуй, соёлын онцлог бүхий үгсийг орчуулах явцад утгын өөрчлөлт, нарийвчлалын алдагдал ажиглагдана.

Давталт ба хэмнэлийн хувьд эх шүлгийн гол онцлог болсон давтагдсан бүтэц зарим орчуулгад хадгалагдсан боловч өгүүлбэрийн зохион байгуулалт, уртын өөрчлөлтөөс шалтгаалан уянгалаг хэмнэл суларсан байна. Энэ нь яруу найргийн орчуулгад хэлбэрийг хадгалах нь утга дамжуулалттай адил чухал болохыг харуулж байна.

Утга дамжуулалтын хувьд орчуулууд нь эхийн утгыг ойролцоогоор илэрхийлсэн ч зарим ойлголтыг ерөнхийлөх, буруу дүйцүүлэх, эсвэл соёлын онцлогийг бүрэн тусгаж чадаагүй тохиолдол ажиглагдана. Тухайлбал, “тойром бүрд”, “овоо” зэрэг ойлголтыг орчуулахад хүндрэл үүсэж буй нь илэрхий байна. Түүнчлэн гуравдугаар орчуулга нь нийтийн орчинд (метроны орчинд) нийтлэгдсэн, эх шүлгийн зөвхөн хэсгийг хамарсан тул бусад орчуулгатай харьцуулахад шинжилгээний хүрээ тодорхой хэмжээгээр хязгаарлагдмал байна.

Судалгааны үр дүнгээс үзэхэд Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийн солонгос орчуулгад утга болон хэлбэрийн тэнцвэрийг хадгалах нь чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна. Орчуулагчийн зорилго, арга барилаас шалтгаалан нэг эх зохиол өөр өөр онцлог бүхий хувилбартай болж хувирчээ. Цаашид яруу найргийн орчуулгад соёлын онцлог, дүрслэлийн нарийвчлал, хэмнэлийг цогцоор нь авч судлах шаардлагатай байна.

## НОМЗҮЙ

### Монгол хэлээр

Дамдинсүрэн, Ц. (1957), *Монгол хэл бичгийн тухай*, Улаанбаатар, Улсын хэвлэлийн газар.

Гүрбазар, Р. (1996), *Орчуулгын онол, дадлагын үндэс*, Улаанбаатар.

Цэрэнчулуун, А. (2013). “Ертөнцийн гурав”-аас орчуулах гэж оролдсон минь, “Орчуулга зүй”, МУИС, ГХСС-ийн ЭШБ, №2.

Элдэв-Очир, Г. (2013). *Соёлын утгыг орчуулах арга зам*, “Орчуулга зүй”, МУИС, ГХСС-ийн ЭШБ, №2.

### Гадаад хэлээр

Peter Newmark (1988), *A Textbook of Translation*, London: Prentice Hall.

Eugene Nida (1964), *Toward a Science of Translating*, Leiden: E.J. Brill.

유원수, (2006) *몽골어 첫걸음*. 서울:삼지사.



**ФИЛОСОФИЙН ЭХ ЗОХИОЛ ОРЧУУЛАХ ТУХАЙД: ЛОГИК-ФИЛОСОФИЙН  
ТРАКТАТ ЗОХИОЛЫН ЖИШЭЭН ДЭЭР**

**М.Отгонбаяр<sup>56</sup>**

**С.Бүжинлхам<sup>57</sup>**

***Abstract:** This paper argues that the translation of philosophical texts is not a technical exercise but an interpretive act, drawing on the experience of translating Wittgenstein's Tractatus Logico-Philosophicus into Mongolian. Philosophical translation differs from both technical and literary translation. Unlike technical translation, it cannot rely on standardized terminology, since philosophers frequently assign new meanings to ordinary words or repurpose existing terms for their own systems. Unlike literary translation, it must prioritize conceptual precision and the logical structure of the argument over aesthetic effect. As Parks observes, philosophers “use ordinary words in a new, technical sense,” making it impossible to translate without first understanding the thinker's system as a whole. This means that every translational choice reflects a philosophical reading of the source text, and the translator, as Rée argues, “cannot duck the duty of interpretation.” This interpretive dimension is illustrated through two key terms in the Tractatus. The German Satz, which in everyday usage simply means “sentence,” carries an interconnected cluster of meanings in Wittgenstein's text, including proposition, statement, and remark. The choice to render it consistently as “proposition” rather than “sentence” reflects an alignment with the analytic tradition and with Russell's framing of the work as a contribution to logical philosophy. The German Bild, while meaning “picture” or “image” in everyday usage, is the central term of Wittgenstein's picture theory of meaning. Comparison of English and Russian translations reveals that the choice between “картина” and “образ,” or between “the form of representation” and “the pictorial form,” reflects not stylistic preference but divergent philosophical readings of what kind of thing a Bild is in Wittgenstein's philosophical system. Rather than following any single source translation throughout, our Mongolian translation drew selectively on five English and Russian versions according to what each context demanded. This practice is itself evidence that translation is interpretation.*

***Түлхүүр үг:** Хэллэг, зураг, тайлбарлахуй, логик анализ, техникийн нэр томьёо*

**УДИРТГАЛ**

Орчуулга бол зөвхөн нэг хэлний үгийг нөгөө хэлний үгээр орлуулах техник ажил бус, харин орчуулагчаас задлан шинжилгээ, оновчтой сонголт болон тухайн салбарын онол, арга зүйн гүнзгий бөгөөд өргөн мэдлэг шаарддаг бүтээлч үйл ажиллагаа билээ. Энэхүү бүтээлч үйл ажиллагаа нь орчуулах бүтээл философийн аль салбарын, түүхийн аль үеийнх, мөн зохиогчийн бичлэгийн стиль зэргээс хамааран харилцан адилгүй байдаг. Тухайлбал философийн эх зохиолын орчуулгын онцлогийг хэл шинжээч Жералд Паркс “Философийн эх зохиолын орчуулгыг юун түүрүүнд “техникийн” гэгдэх бусад эх сурвалжуудаас тодорхой байдлаар ялгаж болдог. Философийн бичвэрт тусгай нэр томьёо, мэргэжлийн илэрхийлэл ашигладаг боловч тэдгээрийг анагаах ухаан, хууль эрх зүй эсвэл инженерчлэлийн техникийн эх сурвалжуудтай нэгтгэн бүлэглэж болохгүй. Учир нь философичид өөрсдөө шинэ нэр томьёо зохиох, хуучин үгэнд шинэ утга оноох, ерийн хэрэглээний үгийг өөр техник утгаар ашиглах зэргээр хэлийг бүтээлчээр

<sup>56</sup> Ph.D, МУИС, ШУС, ХУС, Философи шашин судлалын тэнхим, ORCID:0009-0008-3250-5448

<sup>57</sup> Магистр, МУИС, ШУС, ХУС, Философи шашин судлалын тэнхим, ORCID: 0009-0001-4983-3586

өөрчилж байдаг.” хэмээн тодорхойлсон байдаг (Parks, 2004, p. 1). Тухайлбал И.Кант “интуици” хэмээх үгийг зөн совин, мэдрэмж гэх нийтлэг утгаар биш харин перцепцтэй холбож, аливаа туршлагыг төрүүлж буй түүхий өгөгдөл гэдэг утгаар хэрэглэсэн байдаг. Гэтэл XX зууны прагматистууд интуицийг соёлд өгөгдмөл зуршлын үр дүн тул мэдлэгийн эх сурвалж хэмээн үзэхээс татгалздаг. Ийнхүү нэг үг, ойлголт философийн өөр өөр уламжлалд эрс ялгаатай утга, функцтэй байх нь цөөн биш тохиолддог.

Эндээс харахад философийн ойлголт, нэр томъёо нь тухайн сэтгэгчийн боловсруулсан онолын баримтлал, сэтгэлгээний онцлогтой салшгүй холбоотой байдгаараа нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нэг мөр утгатай шинжлэх ухааны тогтсон нэр томъёоноос ялгардаг аж. Энэ талаараа зохиогч нь хэн бэ гэдгийг харгалзах шаардлага гардаг уран зохиолын орчуулгатай төстэй. Гэвч уран зохиолын орчуулга нь тухайн “илэрхийллийг бүрэн дүүрэн өөриймшүүлэх” болон “уран сайхны ур дүй”-г эрхэмлэдэг (Gorlée, 2019, p. 78) бол философид ойлголтын чанд байдал ба аргументын логик бүтцийг хадгалахыг тэргүүнд тавьдаг. Тиймээс ч “философийн орчуулгад утга санааны тодорхойгүй байдлаас зайлсхийхийн тулд “хэлбэрийн дүйцэл”<sup>58</sup>-ийн стандартыг баримтлах” (Gorlée, 2019, p. 79) нь түгээмэл байдаг. Философийн орчуулга нь ойлголтын онч тодорхой байдал болон хэлний бүтээлч хэрэглээг зэрэг шаарддаг. Ийнхүү “юуг, хэрхэн” хэлж буйг оновчтой буулгахын тулд орчуулагч тухайн философийн уламжлал, сэтгэгчийн сэтгэлгээний онцлогийг харгалзахын зэрэгцээ зорилтот хэлэнд яаж нутагшихыг бодолцдог. Иймээс философийн бичвэрийг орчуулахдаа ямар бүтцээр, хэрхэн найруулж, нэр томъёог хэрхэн онож буулгах, ямар үгийг сонгох вэ гэдэг нь хэлний чадамж төдийгүй философийн мэдлэг шаардах юм. Орчуулагч биеэ даасан, өөрийн үзэл бодол, үндэслэлээ илэрхийлж буй зохиогч биш боловч сонголт хийж буй тохиолдол бүр нь тухайн бичвэрийг философийн аль уламжлалын хүрээнд, хэрхэн тайлж уншиж буйг илэрхийлэх тул “философийн бүтээлийн орчуулагч нь тайлбарлахуйн (интерпретацийн) үүргээс хэзээ ч бултах боломжгүй” (Rée, 2001, p. 230) юм. Ийм учраас философийн эх зохиолын орчуулгад тайлбарлахуй багагүй хувь эзэлдэг. Гэхдээ тайлбар хийнэ гэдэг нь орчуулагч өөрийн бүтээлч талыг сурталчилж, бичвэрийг хэрхэн тайлж уншиж буйгаа уншигчид тулган тунхаглана гэсэн үг биш юм. Харин ч өөр нэгэн уншигчид уг бичвэрийг өөрийнхөөрөө тайлан унших, эх бичвэртэй бие даан ажиллах “орон зай”-г хэвээр үлдээхийн тулд хянуур ажиллах явдал билээ.

#### *Логик философийн трактатыг монгол хэлнээ орчуулсан тухайд*

Философийн эх зохиолын орчуулгын эдгээр онцлог хэлний тухай философич Людвиг Витгенштейний “Логик-философийн трактат” зохиолыг монгол хэлнээ орчуулж (М.Отгонбаяр), редакторласан (С.Бүжинлхам) бидний ажилд хэрхэн илэрснийг илтгэн тайлбарлах зорилго тавив.

XX зууны философийн хамгийн нөлөө бүхий бичвэрүүдийн нэг болох энэхүү бүтээлд хэл ба ертөнцийн харилцан хамаарлыг логик бүтцээр дамжуулан тайлбарлахыг зорьсон юм. Людвиг Витгенштейний философи үзлийг “эхэн” ба “хожуу үе” хэмээн хуваадаг агаад энэхүү бүтээл нь эхэн үеийнх юм.

2021 онд монгол хувилбар нь хэвлэгдсэн тус бүтээлийг бид эх герман хэлнээс нь орчуулаагүй боловч, англи хэлний хоёр (Ч.К. Огдэн ба Ф.П. Рамсей 1922; Д.Ф. Пийрс ба Б.Ф. МакГүйннэсс 1961), орос хэлний гурван (М.С. Козлова ба Ю.А. Асеев 1994; В.П. Руднев 2005;

---

<sup>58</sup> Нидагийн (Nida, 1964) тодорхойлсноор формал дүйцүүлэлт гэдэг нь эх бичвэрийн бүтэц, хэлзүй болон нэр томъёонд аль болох ойр байхыг эрхэмлэдэг стратеги юм. Харин үүний эсрэгээр динамик дүйцүүлэлт нь орчуулж буй хэлний илэрхийллийн онцлогийг эн тэргүүнд тавьдаг бөгөөд энэ нь орчуулагчид найруулгыг тухайн соёлын хэм хэмжээнд нутагшуулах бололцоог илүү олгодог (Gorlée, 2019, p. 78) аж.

И.Добронравов, Д.Лахути ба В.Н.Садовский 2008<sup>59</sup>) (Витгенштейн, 2021, хууд. V) өөр орчуулгыг зэрэгцүүлэн үзэж, харьцуулах замаар монгол хэлнээ буулгасан юм.

“Трактат өөрөө ямар нэгэн үндэслэл, тайлбаргүй, тунхагласан шинжтэй. 1-ээс 7 хүртэл эрэмбэлэн дугаарласан <sup>60</sup> хэллэгүүдээс бүтсэн, логик, метафизик, эпистемологи, хэлний философи зэрэг философийн олон салбарт хамаарах асуудлыг хөндсөн, зарим тохиолдолд бүр зөрчилтэй тайлбаруудтай бөгөөд философийн хамгийн халуун маргаан, хэлэлцүүлгийн талбар болж ирсэн” (Витгенштейн, 2021, хууд. VIII) гэдгийг харгалзвас уг бүтээлийн орчуулгын аль ч хувилбараас орчуулагч философи тайлбарыг хэрхэн хийж буйг тод харах боломжтой бичвэр юм. Эхэн үеийн Витгенштейн ердийн, өдөр тутмын хэлээр бичсэн байдгаараа философидох явцдаа шинэ ойлголт нэр томьёо зохиож ашигладаг Кант, Хайдеггер, Гуссерль зэрэг философичдоос ялгардаг. Гэвч дохио тэмдэг зүйч (семиотикч) Горлээгийн ажигласнаар тэрхүү ерийн хэл нь “философийн төрөлжсөн мета-хэл рүү огцом шилждэг” онцлогтой (Gorlée, 2019, p. 77). Энэхүү шилжилтийг ойлгохын тулд хэлний түвшний ялгааг зааглая. Ердийн хэл гэдэг нь бодит байдлыг тэмдэглэж, зааж буй объектын хэл юм. Харин мета хэл гэдэг нь энэхүү объектын хэлний тухай хэл юм. Тухайлбал “Цас цагаан” гэх өгүүлбэр нь цасны тухай хэлж буй тул ердийн буюу объектын хэл бол, “Цас цагаан гэдэг нь үнэн өгүүлбэр юм” гэх тохиолдолд энэхүү үнэн өгүүлбэр гэдэг нь объектын хэлний тухай илэрхийлэмж юм. Рассэл ЛФТ-ын удиртгалд “Хэлтэй уягдах олон янз асуудал байдаг. ... Дөрөвт, тухайн баримт(жишээлбэл өгүүлбэр) нь өөр нэг баримттай ямар нэг холбоотой байж сая нөгөө баримтынхаа симбол болж чадах вэ гэх асуулт. Энэ сүүлийн асуулт болбоос Ноён Витгенштейний анхаарлыг татсан логик асуулт юм” (Витгенштейн, 2021, хууд. XIV) хэмээн бичсэнчлэн уг бүтээл нь хэлэнд логикийн үүднээс хийсэн анализ тул энэ бүтээлд хэлний тухай онолын ойлголтууд нэлээд бий. Эдгээр нь нэг талаас “мета-тэмдэг” (Morris 1971, as cited in Gorlee, 2019.105) болох агаад нөгөө талаас Витгенштейний философидолтын техник ойлголтууд юм. Гэхдээ мета тэмдэг бүр техник нэр томьёо авч, техник нэр томьёо бүр мета тэмдэг байдаггүй тул уг илтгэлд бид ерөнхийлөн Витгенштейн хэрхэн нийтлэг хэрэглэдэг үгст онолын, өөр өөр утга оноосонд анхаарлаа хандууллаа.

*Satz* “хэллэг” үү, “өгүүлбэр” үү?

ЛФТ-ыг 2023 онд англи хэлэнд орчуулсан философич М.Бийни “герман хэлэн дэх философийн бичвэрүүдэд буй “*Satz*”-ийн орчуулга маргаан дагуулсаар ирсэн бөгөөд, энэ үг нь философийн хувьд тун ач холбогдолтой тул судлаачид өөрсдийн байр суурийг хатуу баримталдгаас үүдэлтэй” (Beaney, 2025, p. 1) хэмээн онцолжээ. Герман хэлний энэ үг бол өгүүлбэр эсвэл хөгжмийн хэллэг (musical phrase) гэсэн утгатай боловч ЛФТ-д хам сэдвээс нь хамаарч хэллэг/бодомж (*proposition*), өгүүлбэр (*sentence*), мэдэгдэл (*statement*) тэмдэглэл (*remark*) гэх мэт “хоорондоо уялдаатай олон утга”-аар (Beaney, 2025, p. 4) ордог.

Стокхоф, Ван дер Дуэс нар “*Satz* гэх үгийг англи хэлэнд орчуулахад тохирох оносон үг байхгүй” тул “өгүүлбэр” (*sentence*), “*утга бүхий өгүүлбэр*” (*meaningful sentence*), “*мэдэгдэл*” (*statement*), “*тэмдэглэл*” (*remark*) (Stokhof & van der Does 2025, p. 7) зэргээр хам сэдвээс нь хамаарч ялгаатай орчуулахыг санал болгосон байдаг. Тэдний хувьд орчуулга бол “ямагт тайлбарлахуй байдаг” бөгөөд “философийн эх бичвэрийн утга нь хэзээ ч шулуухан тодорхой байдаггүй” (Stokhof & van der Does 2025, pp. 8-9) тул тухайн хэллэгт аль утгаар орсныг тооцон уян хатан хандах нь зүйтэй аж.

<sup>59</sup> И.Добронравов, Д.Лахути нар 1958 онд орос хэлэнд орчуулж хэвлүүлснийг 2008 онд В.Н.Садовский засаж хэвлүүлсэн.

<sup>60</sup> Дашрамд дурдахад энэхүү бүтээл нь ийнхүү эрэмбэлэн дугаарласан хэллэгүүдээс бүрддэг тул эшлэхдээ хэллэгийн дугаарыг дурдаж эшилдэг, Логик-Философийн Трактатыг ЛФТ хэмээн товчилдог нийтлэг туршлагыг уг илтгэлд баримтлалаа.

Монгол орчуулгын эх болгон ашигласан англи болон орос хувилбаруудад уг үгийг хэрхэн орчуулсныг жишээ болгон “4. Der Gedanke ist der sinnvolle Satz” хэмээх дөрөвдүгээр хэллэгийг орчуулсан хувилбаруудыг хүснэгтлэв.

Хүснэгт 1 (Витгенштейн, 2021, хууд. VI)

Орчуулагч(ид)	Он	Орчуулсан хувилбар
Ф.П.Рамсей ба Ч.К. Огдэн	1922	The thought is the significant <i>proposition</i> .
Д.Ф. Пийрс ба Б.Ф. МакГүйннэсс	1961	A thought is a <i>proposition</i> with sense.
М.С. Козлова ба Ю.А. Асеев	1994	Мысль — осмысленное <i>предложение</i> .
В.П. Руднев	2005	Мысль есть осмысленное <i>предложение</i> .

ЛФТ-ийн “Satz”-ыг англи хэлэнд “proposition”, орос хэлэнд “предложение” өгүүлбэр хэмээн ялгаатай орчуулсан байна. Хэл дамнан орчуулж буй бидэнд ч ийнхүү “proposition”-ийг “хэллэг гэх үү, өгүүлбэр гэх үү” хэмээх сонголт мөн адил тулгарсан юм. Логик, математик логикийн бүтээлүүдэд “proposition”-ийг орос хэлэнд “высказывание” хэмээн орчуулсныг манай математикч, логикчид тухайлбал Д.Баттөмөр багш “хэллэг” хэмээн орчуулж хэвшсэн (Д.Баттөмөр, 1999) (М.Отгонбаяр, 2016) туршлагыг даган бид энэ үгийг “хэллэг” хэмээн орчууллаа.

Ф.П. Рамсей ба Ч.К.Огдэн нар *Satz*-г ЛФТ-ийн 2.0201-д “statement” бусад тохиолдолд “proposition” хэмээн ялгаж орчуулсныг дагасан болно. Учир Б.Рассэлийн ЛФТ-ын удиртгал үгэнд бичсэнчлэн бид энэхүү бүтээлийг логик-философийн бичвэр хэмээх талаас нь харж, аналитик уламжлалыг баримтлан, логик утгаар ойлгох нь онол-арга зүйн ач холбогдолтой хэмээн үзсэн юм. Мөн Ф.П. Рамсей болон Ч.К. Огдэн нарын орчуулгын явцад Л.Витгенштейн өөрөө санал зөвлөгөө өгч оролцсон нь тэр үеийн захидал харилцааг цуглуулсан “Логик-Философийн Трактат бүтээлийн англи орчуулгын тухай Ч.К.Огдэнд бичсэн захидал” (Wittgenstein, L. (1973). *Letters to C. K. Ogden With Comments on the English Translation of the Tractatus Logico-Philosophicus*. Oxford: Basil Blackwell) хэмээх бүтээлээс тодорхой харагддаг.

Бид ЛФТ-ийн “2.0201. Нийлмэлийн тухай аливаа баталмал өгүүлбэр нь түүний бүтцийн хэсгүүдийн тухай баталмал өгүүлбэр болон нийлмэл байдлыг нь бүрэн тоочин бичдэг хэллэгүүдэд задардаг” хэмээн орчуулж, “баталмал өгүүлбэр” гэх үгийн дор зүүлт тайлбар бичиж хавсаргасан. Бусад тохиолдолд хэллэг, тухайлбал “4. Сэтгэхүй бол утга бүхий хэллэг мөн” хэмээн орчуулсан.

Монгол хэлний хэллэг хэмээх үг нь ерийн хэрэглээнд “хэлэх үйлийн нэр, хэлэх ярих явдал, явц, хэлэх, бичих арга барил, найруулга, өгүүлбэрээс бага тогтмол утга санаа бүхий үгсийн холбоо” (ШУА) зэрэг хэлзүйн утгатай. Харин логик математикийн талбарт өгүүлбэр буюу “бодомж бол ямар нэгэн юманд тодорхой шинж, харилцаа байгаа эсэхийг батлах юм уу үгүйсгэх байдлаар илэрхийлдэг сэтгэхүйн хэлбэр” (М.Отгонбаяр, 2016, хууд. 16), “хэллэг бол хоёр юм уу түүнээс дээш тооны энгийн бодомжоос логик холбооснуудын тусламжтайгаар бүтдэг (М.Отгонбаяр, 2016, хууд. 78) хэмээн логик бүтцийн үүднээс тодорхойлжээ.

*Bild* “зураг” уу, “дүр” үү?

Орчуулга бол тайлбарлахуй болохыг батлах өөр нэг жишээ бол “Bild” юм. Герман хэлний өдөр тутмын хэрэглээнд уг үг нь “зураг” (*picture*) эсвэл “дүрс” (*image*) гэсэн утгатай. ЛФТ-д энэ ойлголт нь Витгенштейний утгын тухай зураглалын онолын (*picture theory of meaning*) үндсэн тулгуур багана болдог. Утгын тухай зураглалын онолыг ЛФТ-ын 2.12-д дурдсанчлан “Зураг бол бодит байдлын загвар мөн” буюу зураг аливааг тоочин дүрсэлж буйтай адил, хэллэг нь бодит байдлыг төлөөлдөг гэх санаа гэж тоймлон өгүүлж болно. Орчуулгын эх сурвалж болгон ашигласан англи болон орос орчуулгын хувилбаруудад уг ойлголтыг хэрхэн буулгасныг харуулахын тулд “2.15. Dass sich die Elemente des Bildes in bestimmter Art und Weise zu einander

verhalten stellt vor, dass sich die Sachen so zu einander verhalten. Dieser Zusammenhang der Elemente des Bildes heisse seine Struktur und ihre Möglichkeit seine *Form der Abbildung*.” гэх хэллэгийг жишээ болгон авч, хоёрдугаар хүснэгтэд нэгтгэн харууллаа.

Орчуулагч(ид)	Он	Орчуулсан хувилбар
Ф.П.Рамсэй ба Ч.К. Огдэн	1922	2.15. That the elements of the <i>picture</i> are combined with one another in a definite way, represents that the things are so combined with one another. This connexion of the elements of the picture is called its structure, and the possibility of this structure is called <i>the form of representation of the picture</i> .
Д.Ф. Пийрс ба Б.Ф. МакГүйннэс	1961	2.15.The fact the elements of a <i>picture</i> are related to one another in a determinate way represents that things are related to one another in the same way. Let us call this connexion of its elements the structure of the picture, and let us call the possibility of this structure <i>the pictorial form of the picture</i> .
М.С. Козлова ба Ю.А. Асеев	1994	2.15.Определенное соотношение элементов в <i>картине</i> – представление о том, что так соотносится друг с другом вещи. Назовем эту связь элементов картины его структурой, а возможность такой структуры – формой изображения, <i>присущей данной картине</i> .
В.П. Руднев	2005	2.15. То, что элементы <i>образа</i> соединяются друг с другом определенным способом, показывает что, так же соединяются друг с другом вещи. Эта связь элементов образа называются его структурой, а возможность этой структуры – <i>формой отображений этого образа</i> .

Хүснэгт 2 (Витгенштейн, 2021, хууд. VII)

Эндээс харахад англи орчуулгын хоёр хувилбарт “*Bild*”-ыг “*picture*” хэмээн орчуулсан байна. Гэхдээ ЛФТ-ыг герман хэлээс ахин англи хэлэнд 2024 онд орчуулсан Сёрлзын бичсэнээр герман хэлнээ энэ үг нь “*Bilden*” буюу “*хэлбэржүүлэх, хэвшүүлэх, бүтээх*” гэсэн утгатай үйл үгээс гаралтай агаад, динамик шинжтэй ажээ. Тиймээс статик, төлөөлөл гэсэн коннотаци(дам утга) бүхий “*picture*” гэх үгээс илүүтэй “*image*” (Searls, 2024)-г сонгох нь оновчтой хэмээн үзжээ. Орос орчуулгын тухайд М.С.Козлова ба Ю.А. Асеев нар харааны, статик гэдэг коннотаци бүхий “*картина*” гэх үгийг сонгосон бол Руднев англи хэлний “*image*”-тэй илүү ойр, оюун санаалаг, динамик шинжтэй “*образ*” гэх үгээр орчуулжээ. Эдгээр ялгаа нь найруулга зүй, хэлзүйн сонголтоос илүүтэйгээр философийн үзэл хандлагын ялгаа, орчуулагчид Витгенштейний философийг хэрхэн ойлгож буйн илрэл болох нь энэ үгтэй холбоотой “*Form der Abbildung*” гэх үгийн орчуулгаас бүр тод харагдана.

Витгенштейн зургийн элементүүдийн хоорондын тодорхой харилцаа болох “бүтэц” болон бодит байдалтай таарах бололцоот “бүтэц” хоёрыг ялгаж байсан агаад “*Abbildung*” гэх нэр томъёо нь харааны (pictorial) болон математик-логик руу хазайсан (mapping) гэх аль алины утгыг агуулдаг (Torres-Martínez, 2019, p. 16)”.

М.С. Козлова ба Ю.А. Асеев нарын хувьд харааны талыг онцолсон, хуулбар, ижил төстэй байдлыг илэрхийлсэн “*форма изображения картины*” (зургийн дүрслэх хэлбэр) гэдэг утгаар *Form der Abbildung*-г орчуулсан нь хэллэг бол зурагтай яг адил гэх шууд утгыг заахад тохиромжтой аж.

Харин В.П. Руднев “форма отображения образа” (дүрийн тусгалын хэлбэр) гэж ялгаатай орчуулсан байна. Нэг талаас орос хэлний “отображение” гэдэг үгийг “функц” эсвэл “газрын зураг буулгах” гэдэг утгаар ихэвчлэн ашиглах тохиолдол байдгийг бодолцвоос хэллэг нь бодит байдлыг зүгээр нэг тоочиж, дүрсэлдэггүй харин формал, бүтэцчилсэн байдлаар буулгаж зурагладаг гэх санаа бий. Нөгөө талаас марксист философийн тусгалын онолын “отображение” гэдэг ойлголт орос хэлэн дэх философийн ном зохиолуудад их тохиолддог байдгийг бас бодолцох учиртай.

Ф.П. Рамсей болон Ч.К.Огдэн нар “*the form of representation of the picture*” (зургийн төлөөллийн хэлбэр) хэмээх үгийг ашигласнаараа тэд *Abbildung*-ийг *Form*-оос тусдаа нэр үг хэмээн үзэж, хэлбэр гэдэг нь төлөөллийн бололцоо юм гэх санааг илэрхийлжээ. Өөрөөр хэлбэл тэдний хувьд хэлбэр бол модаль, харилцаат ойлголт байна. Д.Ф. Пийрс ба Б.Ф. МакГүйннэсийн “*the pictorial form of the picture*” (зургийн зурган хэлбэр) хэмээн орчуулсан хувилбарт төлөөлөл бол үйл ажиллагаа гэх санаа тод томруун илэрхийлэхгүй агаад энэ нь зураг гэх санаандаа шингэн оржээ. Түүнчлэн зургийн зурган хэлбэр гэх нь энд мета анализ, мета асуудал ярьж буйг тод томруунаар илтгэх аж.

Монгол орчуулгын хувьд Пийрс ба МакГүйннэс нарын орчуулгын хувилбарыг баримталж, 2.15. “Зургийн элементүүд бие биетэйгээ тодорхой аргаар нэгдэж байгаа нь юмс бас бие биетэйгээ тийм холбоотойг харуулдаг. Зургийн элементүүдийн энэ холбоог түүний бүтэц гээ. Энэ бүтцийн бололцоог нь зургийн зурган хэлбэр гээ” хэмээн буулгасан юм. ЛФТ-д буй “*Bild*”-г монгол хэлнээ зураг гэхээс гадна “*дүр*” хэмээн орчуулах тохиолдол байдаг агаад тухайлбал Ц.Гомбосүрэн профессор “Энэ зохиолд өгүүлсэн “дүр” бол өгүүлбэрийн хэсэг бүр нь “юмны байршлын” холбогдох хэсэг тус бүрд тохирохуй мөн” (Ц.Гомбосүрэн, 2010, хууд. 117) хэмээн тайлбарласан нь бий. Бидний хувьд марксист философи тэр тусмаа тусгалын онолд бодит байдлын субъектив хуулбарыг “дүр” хэмээн тайлбарладаг болохыг тооцон, энэ утгаас өөрөөр хэрэглэхийг зорьсон тул “зураг” хэмээн орчуулсан юм. “*Form der Abbildung*”-ийн тухайд “зургийн зурган хэлбэр” гэх давтсан, төлөөлөл гэх үгээ зурагт шингээсэн хувилбарын оронд “зураглах хэлбэр” хэмээн динамик, үйл бүхий хувилбар байвал зохистой байсан байж мэдэх юм. Ийнхүү орчуулга бол бүтээлч үйл явц болох нь орчуулгын багийнхан эргэн лавлаж харахад өөр хувилбар санаанд бууж буй явдал ч бататгах мэт. Гэхдээ энэ нь монгол уншигчийн хувьд танил, үйлдэлд чиглэсэн утга бүхий зураглах хэлбэр гэх хувилбарыг сонгох уу, эсвэл энд логик бүтцийн тухай мета асуудлыг хөндөж буй дохио болох зургийн зурган хэлбэр нь оновчтой юу гэх эргэцүүлэлд хөтлөх аж.

## ДҮГНЭЛТ

Энэхүү илтгэлдээ бид философийн орчуулга нь техникийн орчуулга, уран зохиолын орчуулгаас ялгаатай агаад тодорхой утгаар философи тайлбар болохыг харуулахыг зорилоо. Үүний тулд Логик Философийн Трактат бүтээлд буй “*Satz*”, “*Bild*” хэмээх үгсийн англи болон орос бас өөрсдийн монгол орчуулгын хувилбарыг харьцуулан шинжиллээ.

Уг харьцуулалтаас харахад орчуулгын хувилбарын зөрүү нь хэл найруулгын сонголт төдий бус харин бичвэрийг философийн өөр өөр өнцгөөс тайлан уншиж буйн илрэл аж. Тухайлбал “*Satz*”-ийг “хэллэг/бодомж” (proposition) гэж буулгах нь Витгенштейн бол аналитик уламжлалын төлөөлөгч гэдгийг онцолж буй хэрэг. Харин “*Form der Abbildung*”-ийг логик бүтцийн дүрслэх-төлөөллийн тал “зургийн төлөөллийн хэлбэр” (*the form of representation of the picture*) гэхээсээ зургийн тухай зураг болж буй мета талыг онцолж “зургийн зурган хэлбэр” (*the pictorial form of the picture*) гэж буулгасан юм.

Мөн англи болон орос хэлний орчуулгын өөр өөр эх сурвалжаас аль нэгийг нь онцлон сонголгүй, тухайн хам сэдэвт оновчтой гэж үзсэн хувилбараа ялган баримталж ажилласан болно.

Хэрэв орчуулга нь нэг хэлээс нөгөөд буулгах дамжуулалт төдий бол “нэг” л зөв эх сурвалж байх байсан. Гэтэл ийнхүү ээлжлэн сонгох явц нь тайлбарлахуйн шинжтэй байна.

### НОМ ЗҮЙ

- Beaney, M. (2025). Responding to the ‘Satz’-challenge: A reply to Martin Stokhof and Jaap van der Does. *Nordic Wittgenstein Review*, 14, Beaney 1-13.
- Gorlée, D. (2019). How to wrestle with the translation of Wittgenstein’s writings. In P. Oliveira, A. Pichler, & A. Moreno (Eds.), *Wittgenstein in/on Translation* (pp. 77-125). Campinas: UNICAMP.
- Parks, G. (2004). *The Translation of Philosophical Texts*. Semantic Scholar: <https://www.semanticscholar.org/paper/The-Translation-of-Philosophical-Texts-Parks/ce7d25d7855b819ac1fcc72d2d2770fade6a1a19>-ээс Гаргасан
- Rée, J. (2001). The Translation of Philosophy. *New Literary History*, 32(2), 223-257.
- Searls, D. (2024 оны 2 14). *Translating Philosophy: The Case of Wittgenstein’s Tractatus*. World Without Borders: <https://wordswithoutborders.org/read/article/2024-02/translating-philosophy-the-case-of-wittgensteins-tractatus-damion-searls/>-ээс Гаргасан
- Stokhof, M., & van der Does, J. (2025). The ‘Satz’-challenge: A note on Michael Beaney’s translation of Wittgenstein’s Tractatus. *Nordic Wittgenstein Review*, Stokhof & Van der Does 1-13.
- Torres-Martínez, S. (2019). A semiotic translation of the term “Bild” in both the Tractatus Logico-Philosophicus and The Philosophical Investigations. *Semiotica*, 1-21.
- Wittgenstein, L. (1922). *Tractatus Logico-Philosophicus*. (C. K. Ogden, Орч.) London.
- Wittgenstein, L. (1973). *Letters to C. K. Ogden With Comments on the English Translation of the Tractatus Logico-Philosophicus*. Oxford: Basil Blackwell
- Витгенштейн, Л. (2021). *Логик-Философийн Трактат*. (М.Отгонбаяр, Орч.) Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Д.Батгөмөр. (1999). *Логик бодлого ба хэллэгийн логик*. Улаанбаатар.
- М.Отгонбаяр. (2016). *Логик*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Ц.Гомбосүрэн. (2010). *Хэлний философи ба хэл шинжлэлийн (лингвистик) философи*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.



“ГУРВАН УЛСЫН ҮЛГЭР” СОНГОДОГ ЗОХИОЛЫН ШҮЛГИЙН  
ОРЧУУЛГЫГ ТОЛЬДОХУЙ

Б.Нэргүйжаргал<sup>61</sup>  
Б.Сүмбэр<sup>62</sup>

**Abstract:** 诗歌指的是一种追求灵魂的珍贵表达和文字的优雅的审美潮流，它是一种抒情史诗的写作形式，用简短、有节奏的诗句记录人的思想和想象，创造了一种特殊的体系，并根据语言的结构特点，以固定的篇幅和联系组织诗节。我们坚持到翻译诗歌蒙古诗歌的独特性，必须按照保留中国诗歌独特性的原则上蒙古诗歌形式的基础上进行翻译。

**Түлхүүр үг:** *шүлэг, орчуулга, харьцуулсан судалгаа, Гурван улсын үлгэр*

УДИРТГАЛ

Орчуулга гэдэг нь ерөнхий утгаар нэг хэл дээрх үг, өгүүлбэр, эх бичиг, зохиол бүтээлийг өөр нэг хэл рүү утга санааг нь алдагдуулалгүй дамжуулан хөрвүүлэх үйл явц юм. Хятадын орчин үеийн нэрт орчуулагч, соён гэгээрүүлэгч 严复 Янь Фү (1854-1921) орчуулгын тухай дурдахдаа 信 гэдэг нь бодол санааг зөв оновчтой итгэлтэй байдлаар дамжуулах, нэвтрүүлэх гэсэн утгыг илэрхийлэх бөгөөд орчуулгын хувьд уг зохиол бүтээлийн үзэл санааг нэмж хасалгүй зөв оновчтойгоор өөр хэлнээ буулгах гол зарчмын нэг гэсэн байх бөгөөд 达 нь уг зохиолыг орчуулах явцад хэлбэрт баригдалгүй уншигчдад хүргэх 雅 нь тухайн зохиолын утга санааг яруу сайхнаар илэрхийлэн гаргах үйл явц хэмээсэн байдаг. Энэхүү түүний дурдсан орчуулгын зарчим нь өдгөө хүртэл Хятадад орчуулгын дээд хэмжүүр болсоор байна. Манай орчуулагч, судлаач, эрдэмтэн Р.Гүрбазар “Орчуулга бол эх зохиолын хуулбар, тайлбар, хялбарчлал огт биш. Энэ бүтээлч хөдөлмөр нь аливаа зохиол туурвилыг орчуулж байгаа хэлээр үнэн бодитой илэрхийлэн гаргахын нэр юм. Үүнийг бид орчуулгын үнэн зөвийн зарчим гэж нэрлэж байна” гэжээ. Тэрээр, уран зохиолын орчуулгын үгийн сан, хэлзүйн бусад асуудлыг ерөнхий хэлшинжлэлийн үүднээс авч үзээд, “эх зохиолын агуулга, гоо сайхны үнэ цэнэ, уран сайхны өвөрмөц онцлогийг үнэн зөв, яруу сайхан хэлээр буулгасан орчуулгыг л уран зохиолын орчуулгын онол, практикт төгөлдөр орчуулга гэж үздэг” гэх тодорхойлолт гаргажээ. Энэ нь монгол орчуулгын онолын зарчмыг цэгцлэхэд чухал алхам болсон юм.

Хятад судлаач эрдэмтэн, нэрт орчуулагч М.Чимэдцэеэ “Дэлхий нийтэд тогтсон орчуулгын үндсэн гурван зарчим бий. Үнэнч шударгуу байх, ойлгомжтой тод байх, яруу сайхан байх гэсэн байдаг. Манай эрдэмтэд 1740-өөд оны үед “Мэргэд гарахын орон” хэмээх төвөд-монгол толь бичигт орчуулгын зарчмыг тогтоожээ. Энэ бүтээлд тэрхүү гурван зарчмыг томьёолсон байдаг” гэж цөөн бус удаа онцолж байв.

<sup>61</sup> Ph.D, МУИС, ШУС, ХУС-ийн Ази судлалын тэнхим

<sup>62</sup> Магистр, МУИС, ШУС, ХУС, Ази судлалын тэнхим

Шүлэг гэдэг нь нэг талаар сэтгэлийн нандин илэрхийлэл, үгийн уран хээнцрийг эрэлхийлдэг гоозүйн чиг хандлагыг хэлдэг бол нөгөө талаар хүний уран сэтгэмжээр өгүүлж буй бодол санаа, сэтгэл илэрхийллийг богино, хэмжээст шадар хэсэгчлэн бичиж тусгай тогтолцоо үүсгэн, тухайн хэлний бүтцийн онцлогийн дагуу тогтсон айзам хэмжээ, холбоц бүхий нугалаа зохион байгуулалтай шад, бадаг бүхий уянга, туульсын зохиолын бичлэгийн нэг хэлбэр болдог. Хятадын эртний шүлгийн тухайд Тан улсын яруу найраг төлөөлүүлэн авч үзэх хэрэгтэй. Энэ үеэс Хятадын яруу найргийн сонгодог хэв загвар үүсэж, тэр нь XX зууныг хүртэл уламжилж ирсэн ажээ. Тэр үед Тангийн яруу найраг тодорхой дэг жаягтай болж, гажсан шүлгийг шүлэг гэж үздэггүй байсан ба хэлбэрийн хувьд, тасархай бадаг буюу гүн ухааны дөрвөн мөрт, тигийн шүлэг гэсэн шүлгийн хэлбэрүүд шинээр бий болжээ. Үзэл санааны хувьд тухайн үеийн нийгмийн тэгш бус байдал, өндөр хэмжээний албан татвар, шударга бус явдал, эцэс төгсгөлгүй дайн дажныг эсэргүүцсэн шүлгүүд бичдэг байсан нь Тангийн яруу найраг өндөр хэмжээнд хүртлээ хөгжих гол нөхцөл нь болж байжээ. Инжаннашийн тавдугаар ах Гүннацаг: “Тангийн шүлэг дор таван үг, долоон үгийг ялгахгүй, аливаа найман бадгаар эгшиг үргэлжлэн зэрэглүүлснийг ину хэмжээт шүлэг хэмээмүй. Дөрвөн бадгаар хураангуйлан бичсэнийг нь тасархай бадаг хэмээмүй...”<sup>63</sup> гэсэн байдаг. Монгол яруу найраг нь уран зохиолын энэ төрөл зүйлээс хамгийн эрт үүсэж мөн хамгийн ихээр хөгжсөн монгол өнгө аяс онцлогтой нэгэн төрөл болсон юм. Бид монголын эртний яруу найргийн судалгааны тоймыг шүүхэд, сэтгэлгээ, айзам, айзамт хэл бол яруу найргийг үүсгэсэн үндсэн гурван элемент мөн гэсэн байдаг. Тухайлбал, сэтгэлгээ нь яруу найргийг буй болгосон үндсэн дотоод шалтгаан. Айзам нь яруу найргийн хэлбэрийн үндсэн онцлог. Айзамт хэл нь яруу найргийн үндсэн илтгэвэр гэсэн үг. Монгол шүлгийн онцлог шинжийн тухайд, шүлгийн айзам хэмнэлийг бүрдүүлж байдаг нэг гол зүйл нь холбоц юм. Шүлгийн хоёр болон хоёроос дээш шадыг авианы дуудлага ижил төсөөрхүү байгаагаар нь ижилсүүлэн холбох аргыг холбоц гэж хэлдэг. Хэл хэлний овор төрхөөс уламжлаад шадын толгой холбох, сүүл холбох хоёр гол ёс байдаг. Монгол шүлэгт толгой холбох ёс голлож, сүүл холбох ёс дагалдаж байдаг. Холбоц нь ерөнхийдөө үг давтах, хоёр үгийн төстэй байдлыг ашиглах, гийгүүлэгч орсон байгаагаар нь ижилсүүлэх зэргээр холбосон байж болно. Холбоцыг зэрэгцэх холбоц, салаавчлах холбоц, хаших холбоц зэргээр ангилж болно.<sup>64</sup>

Үүнээс үзэхэд зохиогчийн уран сэтгэмж, үг сонголт, өгүүлэх арга барилын ялгаатай байдлаас харилцан адилгүй өнгө аястай өгүүлэмж урган гардаг. Монгол хятад шүлэг нь зохих хэмжээнд адил төстэй байдал ажиглагдаж байгаа хэдий ч тухайн цаг хугацаа, үндэсний зан заншил, соёл сэтгэлгээний онцлогоос үүдэн ялгаатай тал ч мөн байдаг. Шүлгийн орчуулга нь бусад төрлийн орчуулгаас нэн хүндрэлтэй бэрх байх нь дамжиггүй. Монгол хятад шүлгийн өөр өөрийн онцлогийг харгалзан шүлгийг орчуулахдаа монгол шүлгийн хэлбэрт үндэслэн хятад шүлгийн өвөрмөц онцлогийг хадгалах зарчмын дагуу орчуулах шаардлагатай. Үүнд:

1. Шүлгийн хэлбэр маягийг бүрэн бүтэн байдлыг харгалзан үзэх
2. Шүлгийн айзам хэмнэл болон сүүл холбох
3. Оновчтой тохирсон амьдлаг үг сонгох
4. Илтгэх аргыг оновчтой сонгох

Хятадын эртний үргэлжилсэн үгийн зохиолын түүхэнд Лүе Гуаньжүнгийн туурвисан “Гурван улсын үлгэр” нь нэлээд эрт бүтээгдсэн бөгөөд бүлэг бүр нь нэр бүхий зохиолд тооцогддог онцгой ач холбогдолтой сонгодог бүтээлийн нэг юм. Зохиолд Вэй, Шу, Ү гэх гурван улсын тухайн үеийн улс төр, цэрэг, гадаад харилцааны зөрчилдөөн, эв нэгдлийг дүрслэн өгүүлсэн байдаг ба хэл найруулгын хувьд энгийн цэвэр яруу тансаг, бичгийн хэлэнд хэт баригдаагүй эгэл энгийн

<sup>63</sup> Б.Гэрэлт, Монгол зохиолчдын шүүмж өгүүлэлүүд 1721-1945 (1981) ӨМ-ын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, Хөххот 168 тал.

<sup>64</sup> Г.Галбаяр, (2002) Уран зохиол шинжлэлийн лекц, Улаанбаатар, 132-134 тал.

зэрэгцэн сүлэлдсэн онцлогтой бүтээл юм.

Энэхүү бүтээлийн орчуулагч Д.Болдбаатарын шүлгийн орчуулгын түүврийг авч үзье.

红牙催燕拍飞忙，一片行云到画堂。眉黛促成游子恨，脸容初断故人肠。  
榆钱不买千金笑，柳带何须百宝妆。舞罢隔偷目送，不知谁是楚襄王。 8-р бүлэг

Улаан товшуурын аяс тааруулан нисэх хараацай яарахуйд  
Угалзалсан үүлс нэгэн хэсэг зурмал танхимд ормуй  
Хархан хөмсөг тэнэмэл хөвгүүний хорслыг өдөөж  
Хасын царай хуучин нөхрийн горийг тасалмуй  
Уяхан хайлаасны навч мянган лангийн инээдийг хүргэхүй  
Туяхан бургасны навч зуун эрдэнийн энгэсгийг хэрэглэхгүй  
Бүжиглэж дууссан хойно хулгай нүдээр харах нь  
Бүрхэг шөнийн дунд Чү улсын Сян ванг эрэлхийлэх мэт.

Орчуулга нь монгол шүлгийн толгой холболт, хэм хэмнэлийг тэнцүүлэх үүднээс гол өгүүлэгдэхүүнийг тодорхойлох үгээр толгой холбожээ. Үүнд “游子” гэдгийг “тэнэмэл хүмүүн” гэсэн нь оновчтой бус байна. Харин “хэсүүлч хүмүүн, хэсүүлч хөвгүүн” гэх нь зохимжтой байна. “故人肠” гэдэг нь монгол сэтгэхүйд “элэг зүрхийг таталдуулсан” гэсэн утгатай болохоор “Хасын царай хуучин нөхрийн горийг тасалмуй” гэсэн нь чадамгай дүрслэлтэй орчуулга болжээ.

司徒妙算托红裙,不用干戈不用兵。  
三战虎牢徒费力,凯歌却奏凤仪亭。 9-р бүлэг

Сытүгийн уран арга улаан хормойвчинд найдаад  
Сэрээт жад огт хэрэглэсэнгүй бөгөөд цэрэг бас зарсангүй  
Хулао боомтод гурвуул байлдсан нь хүчээ талаар сүйтгэжээ  
Хундага өргөсөн ялалтын дуу харин Фэн Итинд

Орчуулга нь орчин цагийн монголчууд уншихад ойлгомжтой болох үүднээс “不用兵 цэрэг бас зарсангүй” гэснийг “цэрэг бас хөдөлгөсөнгүй” гэвэл илүү ойлгомжтой болох байх. Учир нь “зарах” гэдэг үг орчин цагийн монгол хэлний аман ярианд “худалдах” гэх утгаар өргөн хэрэглэгдэх болсноор “цэрэг зарсангүй” гэх утгыг “цэрэг худалдсангүй” гэж ташаа ойлголт өгч болзошгүй юм.

束兵秣马去匆匆，心念天言衣带中。  
撞破铁笼逃虎豹，顿开金锁走蛟龙。 21-р бүлэг

Морио бордож зэвсгээ багцлаад үймэн айман одсон нь  
Мутрын зарлиг дээл бүсэнд ахуйг сэтгэлдээ боджээ.  
Барс ирвэс төмөр чингэлгийг сад татаад дутаах мэт  
Бас гүмбараа матар алтан оньсыг дугтран гарахтай зүйрлэж болмуй

Энэ орчуулга нь үг нэмж, толгой холбох аргыг орчин цагийн монгол хэлний найруулгын арга зүйд үндэслэн зарим нэг үг үсгийн байр солих зэрэг аргаар өнөөгийн уншигчид уншихад ойлгомжтой урсам яруу болгожээ. Эх шүлэг нь долоон үсгээр эн тэнцүүлсэн онцлогтой байж монгол орчуулгад шүлгийг тайлбарлан орчуулахдаа монгол шүлгийн толгой холбох аргаар жигдрүүлэхийг хичээжээ. Мөн хэл найруулгын логикийг зохицуулж “барс ирвэс төмөр чингэлгийг сад татаад дутаах мэт, бас гүмбараа матар алтан оньсыг дугтран, гарахтай зүйрлэж болмуй” гэж орчуулсан нь маш оновчтой бөгөөд ойлгомжтой болжээ.

黄祖才非长者俦，祢衡珠碎此江头。  
今来鹦鹉洲边过，惟有无情碧水流。 23-р бүлэг

Ихэс сайдад тэнцэхгүй Хуанзугийн гайгаар  
Эрдэм хэтийдсэн Ни Хэнгийн амь сүйдэв  
Тотит шувууны хажуугаар өдгөө өнгөрөхүйеэ  
Торолгүй урсах усан ажиггүй хоржигноно.

Тус орчуулга нь “珠碎” гэх үг нь “ сувд хагарах буюу бутрах” гэх утгатай. Гэвч шүлэгт хүн нас барахыг зүйрлэж байгаа болохоор, гашуудсан сэтгэлгийн өнгө аясыг илэрхийлжээ. Иймд “сувд хагарах буюу бутрах” гэх шууд утгаар орчуулахад зохимжгүй тул “үхсэн, амь үрэгдсэн, амь нөхөцсөн” гэсэн санааг илтгэхийн тулд “амь сүйдвэй” гэж орчуулжээ. Тухайн орчуулга нь эх зохиолын агуулгад үндэслэн утгачлан орчуулснаар зарим талаар илүү ойлгомжтой болжээ. Даруй “ихэс сайдад тэнцэхгүй Хуанзугийн гайгаар, эрдэм хэтийдсэн Ни Хэнгийн амь сүйдэв” гэх эхний хоёр мөр маш тодорхой ойлгомжтой болжээ.

## ДҮГНЭЛТ

Эртний шүлгийг орчуулна гэдэг нь тухайн орчуулагчаас өндөр мэдлэг, орчуулах ур дүй гэсвэр тэвчээрийг шаарддаг нэн хариуцлагатай тун нарийн мэдрэмж шаардсан ажил бөгөөд үе үеийн орчуулагчид тухайн орчуулгын онол зүйн ганц хоёр зарчимд баригдалгүй, эх зохиолд холбогдох соёл иргэншилд үндэслэн орчуулах, үг өгүүлбэрийн утгыг оновчтой илэрхийлэх чадамжийг анхааран, утгыг тэнцүүлэн орчуулах, хэв маяг, өнгө аясын хувьд эх зохиолын хэл хэллэгийн шинж чанарт ижилсүүлэн орчуулах зэрэг онол зарчмуудыг зөв газар нь тохож задлахыг хичээсэн нь дамжиггүй юм.

“Гурван улсын үлгэр” зохиолд орсон шүлэг нь хятадын эртний Тангийн шүлэг, яруу найргийг төлөөлөх хэв маяг бүхий шүлгүүдийг бодвол ойлгоход харьцангуй хялбар, голчлон үгийг шууд утгаар нь орчуулсан мөн ихэнх тохиолдолд үйл явдлаа хураангуйлан хүүрнэн өгүүлсэн байдаг.

Энэ өгүүлэлд орчуулагч Д.Болдбаатарын орчуулсан “Гурван улсын үлгэр” зохиолын шүлгийн орчуулгын түүврээс орчуулгад эх зохиол орчуулгын утгатай хэрхэн дүйж байгаа мөн хэлбэр, зохиолын уран сайхны илэрхийллийн онцлогийг дамжуулсан байдал түүний орчуулгын арга зүйн талаас судлан авч үзэв. Үүнд:

1. Харьцуулсан аргаар эх шүлэг болоод түүний орчуулгын агуулга, хэл найруулга, уран сайхны илэрхийллийн ялгаатай болон ижил талыг ажигласнаар орчуулгын явцад гарсан өөрчлөлт, хувирлыг илрүүлэх боломж бүрдсэн.
2. Тухайн орчуулсан шүлгийн үг хэллэгт бүтцийн талаас утгачилсан, тайлбарласан аргыг түлхүү хэрэглэсэн болохыг тодруулав.
3. Орчуулагчийн сонголт утга зүй талаас болон мөн орчин үеийн уншигчдад ойлгомжтой байх үүднээс монгол хэлний найруулгын арга зүйд үндэслэн зарим нэг үг үсгийн байр сэлгэх аргаар орчуулгын онцлогийг тодорхойлсон болохыг тогтоов.

## НОМЗҮЙ

Лүө Гуаньжүн. (1973). Гурван улсын үлгэр (хятад хэвлэл), Ардын уран зохиолын хэвлэлийн хороо Тэмгэт. (1975). Гурван улсын үлгэр(уйгуржин монгол). Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо Д.Болдбаатар.(2017). Гурван улсын үлгэр. Улаанбаатар: “Гэгээ паблишинг” хэвлэх үйлдвэр

- Г.Аким.(2017). Орчуулгын санг уудлахад.Улаанбаатар
- Г. Галбаяр. (2002). Уран зохиол шинжлэлийн лекц. Улаанбаатар
- Б.Гэрэлт. (1981). Монгол зохиолчдын шүүмж өгүүллүүд, 1721-1945 ӨМ-ын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, Хөххот
- Хятад соёлын мэдлэгийн толь.(2022). Улаанбаатар: “Адмон принт” хэвлэлийн газар
- 骆海辉.三国演义与中国文化述评, 绵阳师范学院外国语学院副教授; 王海燕, 绵阳师范学院外国语学院讲师,四川绵阳 621000
- 王丽娜、杜维沫.(2006).三国演义的外文译文.小说研究
- 张浩然.(2001).三国演义罗译本评析《外国语言文学》刊
- 郑福天.(1997).唐宋研究.呼和浩特:内蒙古大学出版社



## ЯПОН ДЭЛГЭЦИЙН БҮТЭЭЛИЙН ХАДМАЛ ОРЧУУЛГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

(“Чихиро охин сахиусны ертөнцөөр аялсан нь” анимэгийн жишээгээр)

Э.Тогтуун<sup>65</sup>

Л.Соёл<sup>66</sup>

**Abstract:** This study examines the relationship between spoken Japanese and Japanese subtitles, Chinese subtitles in the animated film *Spirited Away*. Subtitling, as a form of audiovisual translation, operates under time and space constraints that necessitate the selection, compression, and restructuring of linguistic information. While previous research has focused primarily on cross-linguistic subtitling (e.g., Japanese-to-English), the analysis of same-language subtitles remains largely unexplored.

Five key scenes were analyzed: Haku's advice to Chihiro, her parents' transformation into pigs, the contract with Yubaba, the introduction of No-Face, and Chihiro beginning her work at the bathhouse. Comparative analysis of spoken lines and corresponding subtitles revealed consistent patterns: (1) the core meaning of utterances is preserved, (2) redundant, emotional, or pragmatic expressions are frequently omitted, and (3) subtitles are optimized to facilitate viewer comprehension, relying on visual and vocal cues to supplement omitted information.

The findings demonstrate that Japanese subtitles function not merely as verbatim transcriptions but as a form of meaning-oriented linguistic reconstruction. This study contributes a novel perspective to subtitling research by highlighting the process of meaning optimization in same-language subtitles and its implications for audiovisual translation theory. Future research may expand this analysis across additional scenes or works, incorporate quantitative metrics, or investigate the effect of subtitles on viewer understanding and emotional perception.

**Түлхүүр үг:** дэлгэцийн бүтээл, хасалт, хураангуйлал, мэдээллийн агшаалт, задлан шинжилгээ

### 1. Удиртгал

Дэлгэцийн бүтээлийн орчуулгын нэг төрөл болох хадмал бичгийн орчуулга бол цаг хугацаа, орон зайн хязгаарлалтын зарчимд баригдан мэдээллийг дамжуулдаг өвөрмөц онцлогтой хэлний үзэгдэл юм. Ер нь хадмал бичиглэл нь ярианы хэлний агуулгыг дэмжиж өгөх үүрэгтэй гэж үздэг ч, бодит байдал дээр зүгээр нэг сэргээн бичиж байгаа зүйл төдий биш юм. Хадмал орчуулга хийх явцад мэдээллийг сонгох, агшааж хураангуйлах, дахин бүтэцчилэх шаардлагатай болдог. Тус өгүүлэлд японы ярианы хэлийг япон хэлээрх хадмал орчуулга болон хятад хэл дээрх хадмал орчуулгатай харьцуулан, хадмал орчуулга хийх явцад утгыг хэрхэн яаж дахин бүтэцчилж байгааг тодруулахыг зорилгоо болголоо.

Ингэхдээ 「千と千尋の神隠し」 (Сэн то Чихиро но камикакүши, утгачлан буулгавал Чихиро охин сахиусны ертөнцөөр аялсан нь) нэртэй, дэлхий дахинаа алдартай япон анимэг судалгааныхаа объект болгон авч, задлан шинжлэх болно. Тус анимэ нь үг хэллэг, илэрхийллээр баян тансаг, цаашлаад сэтгэл хөдлөлийн илэрхийлэл болон бэлгэдэлт шинж чанар нь маш хүчтэй байдаг тул хадмал орчуулгаас үүдэлтэй өөрчлөлтийг задлан шинжлэхэд тохирсон бүтээл юм.

<sup>65</sup> Ph.D, МУИС, ШУС, ХУС, Ази судлалын тэнхим, ORCID: 0009-0004-9465-0502

<sup>66</sup> Ph.D, МУИС, ШУС, ХУС, Ази судлалын тэнхим, ORCID: 0000-0003-0162-4598

## 2. Сэдвийн судлагдсан байдал

### 2.1 Хадмал орчуулгад холбогдох судалгаа

Хадмал орчуулга гэдэг нь кино, телевизийн нэвтрүүлэг, анимэ зэрэг дэлгэцийн бүтээлийн хэл яриаг бичгийн хэл рүү орчуулан буулгаж, түүнийгээ дэлгэцнээ байршуулдаг үйлдэл болох талаар өмнө дурдсан. Орчуулга судлалд ийм хэлбэрийн орчуулгыг Audiovisual translation (харах сонсох мэдрэмжид тулгуурласан орчуулга)-ын нэг төрөлд багтаан үздэг (Díaz Cintas & Remael, 2007). Audiovisual translation бол дүрс хөдөлгөөн, дуу авиа, үг хэл зэрэг хэд хэдэн элементийг нэгтгэсэн дэлгэцийн бүтээлд хийгддэг орчуулгыг судлагдахуунаа болгодог судалгааны салбар бөгөөд хадмал орчуулга болон дуу оруулгын орчуулгын төрлийг хамардаг.

Хадмал орчуулгад холбогдох судалгаанаас харахад дараах хэдэн өнцгийг тодруулах зорилготой байна. Үүнд:

Нэгдүгээрт, хадмал орчуулгын цаг хугацаа болон орон зайн хязгаарлалттай хамааралтай судалгаа.

Хадмал орчуулга нь бусад төрлийн орчуулга (уран зохиолын орчуулга, албан бичгийн орчуулга)-аас хэд хэдэн ялгарах онцлогтой. Тухайлбал, цаг хугацаа болон орон зайн хязгаарлалттай байдаг. Хадмал бичиг нь тодорхой тогтоосон цагт л дэлгэц дээр гарч ирдэг. Тийм болохоор үзэгч сонсогчид богино хугацаанд тогтож унших боломжтой байхын тулд үсгийн тоог хязгаарлах шаардлагатай. Иймэрхүү хязгаарлалт хийх шаардлагатай болохоор хадмал орчуулга хийхэд эх сурвалжид байгаа мэдээллийг тэр хэвээр нь (бүтнээр нь) орчуулах биш, өгөгдсөн мэдээллийг хураангуйлан товчлох шаардлага гарч ирдэг. Хадмал орчуулгад иймэрхүү мэдээллийг хураангуйлан багасгахыг орчуулгын маш чухал ур чадвар гэж үздэг (Gottlieb, 1992; Shinohara, 2018)

Хоёрдугаарт, соёлын илэрхийллийн орчуулгатай холбоотой судалгаа.

Хадмал орчуулгад соёлын шинжтэй элементийн орчуулга нь чухал асуудал болж байдаг. Дэлгэцийн бүтээлд тодорхой нэг соёлд л байдаг уламжлал, үнэт зүйлсийг олноор багтсан байх ба эдгээрийг хэрхэн яаж орчуулах вэ гэдэг ч бас чухал сэдэв нь болж байдаг. Орчуулга судлалд иймэрхүү тухайн соёлд байдаг өвөрмөц илэрхийллийг “Culture-specific items” (Pedersen, 2011) гэж томъёолдог.

Соёлын илэрхийллийн орчуулгатай холбогдуулахад, хэд хэдэн орчуулгын тактикийг гаргаж ирсэн. Тухайлбал, орчуулга судлалд үгчилсэн орчуулга, утгачилсан орчуулга, соёлын дүйцүүлсэн орчуулга, орчуулахгүй орхих зэрэг аргууд бий гэж үздэг (Baker, 2011). Гэвч, хадмал орчуулгад үг үсгийн тоонд хязгаарлалт хийгддэг учраас, соёлын илэрхийллийг тайлбарласан байдлаар орчуулахад төвөгтэй, хураангуйлан товчилсон орчуулга хийхийг шаардах тохиолдол их гардаг.

Орчуулга бол дан ганц үгийг сольж тавих үйлдэл бус, соёлыг зуучлан дамжуулах үйлдэл мөн гэж үзэх өнцөг бас байна. Орчуулга судлалд “орчуулагч хүн бол ялгаатай соёлуудын хоорондох утгыг зохицуулах үүрэг хүлээдэг” гэж үзэх нь бий (Venuti, 1995). Тэр тусмаа хадмал орчуулгад, дүрс бичлэг болон дуу авианы мэдээллийг нэгэн зэрэг үзүүлдэг болохоор соёлын шинжтэй утга нь хадмал орчуулгаар биш, өөр бусад элементээр хамжин илэрч байж бас болно.

Гуравдугаарт, хадмал орчуулгыг гадаад хэл сурахад ашиглах боломж ба түүнд тулгарах бэрхшээлтэй холбоотой судалгаа.

Гадаад хэл суралцагч нарт хадмал орчуулга хэр ач холбогдолтой вэ гэдгийг тодруулах зорилготой шинжилгээ бас хийгдэж байна. Ийм өнцгийг судлах боломжтой гэдгийг харуулсан судалгаанаас дурдвал Японы судлаач Т.Хосака болон М.Шимада (2017) нарын Японы дэлгэцийн бүтээлүүд дэх дүрүүдийн харилцан яриа болон англи болон бусад хэлээрх хадмал орчуулгыг харьцуулсан дүн шинжилгээ болно.

## 2.2 「千と千尋の神隠し」 (“Сэн то Чихиро но камикакүши”, утгачлан буулгавал “Чихиро охин сахиусны ертөнцөөр аялсан нь”) анимэд холбогдох судалгаа

Тус бүтээлд холбогдох судалгаа нь дараах гурван чиглэлд голчлон хийгдэж байна. Үүнд: Нэгдүгээрт, Хадмал орчуулга болон тэмдэгтийн онолд тулгуурласан судалгаа.

Сүүлийн үед хийгдэж байгаа судалгаагаар, хадмал орчуулга нь дүрс зураглал болон дуу авиагаар илэрхийлэх бүхий л мэдээллийг дахин бүтэцчилж чадахгүй, утгын нэг хэсэг нь устгагдаж байна гэдгийг онцлон тэмдэглэж байна.

Хоёрдугаарт, хэл шинжлэл болон соёлын илэрхийлэлд холбогдох судалгаа.

Энэ чиглэл дээр Ёоко Старт (2007) судалгаа хийжээ. Тэрээр, тус бүтээл дэх япон хэлээрх илэрхийлэл болон соёлын шинжтэй элементүүд нь орчуулагдсан хэлэндээ хангалттай тусгагдах боломжгүй байх тохиолдол байгааг өөрийн судалгаандаа харуулав.

Гуравдугаарт, дүрүүдийн хэлний судалгаагаар дүрүүдийн яриа, хэлний хэрэглээ нь орчуулагдах явцад өөрчлөгдөх боломжтой гэдгийг гаргаж тавьсан байна.

## 2.3 Судалгааны зорилго

Тус анимэний судлагдсан байдлаас харахад тэдгээр судалгааны дийлэнх нь япон хэлнээс англи хэл рүү орчуулсан орчуулгад голчлон анхаарал хандуулж, задлан шинжилжээ. Харин япон хэл дээрх дуу авиа болон япон хэлээрх хадмал орчуулга гэсэн нэг хэлний хүрэн доторх орлуулалт, мөн хятад хэлээрх хадмал орчуулгатай харьцуулсан судалгааг одоогоор олж харсангүй.

Тиймийн учир тус судалгаа нь нэг хэлний хүрээнд хадмал орчуулгаар дахин бүтэцчилэх, түүнийг хятад хэлээрх хадмал орчуулгатай харьцуулах гэдэг өнцгөөс харж хийгдэж байгаагаараа шинэлэг тал болж өгнө гэж харж байна.

## 3. Судалгааны арга

### 3.1 Задлан шинжилгээний талбар

Тус судалгаанд, бүтээлийн хүүрнэлийн хувьд чухал агуулгыг харуулдаг дараах гурван үзэгдлийг объектоо болгоно. Үүнд:

1. Хакү хүү Чихиро охинд зөвлөгөө өгдөг үзэгдэл
2. Чихиро охины аав ээж хоёр гахай болж хувирдаг үзэгдэл
3. Юүбабатай гэрээ байгуулдаг үзэгдэл

### 3.2 Задлан шинжлэх дэс дараалал

1. Дуу авиа болон хадмал бичиглэлийг бичиж оруулах
2. Япон хэлээрх дүрийн яриа, япон хэлээрх хадмал бичиглэл, хятад хэлээрх хадмал орчуулгыг харьцуулах
3. Өөрчлөгдсөн хэсгийг ангилан ялгах (хасаж богиносгох, хураангуйлах, сольж хэлэх зэрэг)
4. Задлан шинжилгээ хийх

## 4. Задлан шинжилгээ

### 4.1 Хакү хүүгийн зөвлөгөө өгдөг үзэгдэл

Энэ үзэгдэл дээр хамгийн чухал мэдээлэл болох “Нэрээ битгий мартаарай” гэдгийг хичээнгүйлэн сануулж хэлнэ.

Харьцуулсан хүснэгт 1. (япон хэлээрх дуу авиа, япон хадмал, хятад хадмал)

Эх яриан текст	Япон хадмал	Хятад хадмал	Өөрчлөлтийн хэлбэр	Задлан шинжилгээ
本当の名前は しっかり隠し ておくんだ よ。 Жинхэнэ нэрээ сайтар нуудаг юм шүү.	本当の名前は しっかり隠し ておくんだ よ。 Жинхэнэ нэрээ сайтар нуудаг юм шүү.	把本命好好藏 起来。  Жинхэнэ нэрээ сайн нуугаарай.	Япон хэлний хүрээнд өөрчлөлт байхгүй. Япон, хятад хэлний хооронд баймжийн өөрчлөлт ажиглагдаж байна.	Япон хэлээрх хадмалд “隠してお くんだよ” (нуудаг юм шүү) гэсэн хичээнгүйлэн анхааруулж захисан үгийг “藏起来” (нуугаарай) гэж энгийн байдлаар анхааруулсан.
名を奪われる と帰り道が分 からなくなる んだろ。 Нэрээ булаалгачихвал харих замаа мэдэхгүй болчихно биз дээ.	名を奪われる と帰り道が分 からなくなる んだろ。 Нэрээ булаалгачихвал харих замаа мэдэхгүй болчихно биз дээ.	名字一旦被夺 走了就会找不 到回家的路  Нэрээ булаалгачихвал гэртээ харих замаа олохгүй шүү.	Япон хэлний хүрээнд өөрчлөлт байхгүй. Япон, хятад хэлний хооронд баймжийн өөрчлөлт ажиглагдаж байна. Өөр үгээр сольж орчуулсан	Япон хэлээрх “...分 からなくなるんだ ろ” (мэдэхгүй болчихно биз дээ) гэж бататган лавлаж асуусан санаа хятад хэлэнд тусгагдаагүй байна. “...мэдэхгүй болчихно биз дээ” гэсэн хэсгийг “... (олохгүй шүү)” гэж өөр үгээр орчуулсан.

#### 4.2 Аав, ээжийн гахай болж хувирдаг үзэгдэл

Энэ хэсгийн үзэгдэлд, бусдын мэдлийн орон зай (хоолны газар) руу дураараа нэвтэрч, эд юм (хоол унд)-ыг зөвшөөрөлгүй авч хэрэглэх нь ямар их хор хөнөөлтэй болохыг харуулдаг.

Харьцуулсан хүснэгт 2. (Япон хэлээрх дуу авиа, япон хадмал, хятад хадмал)

Эх яриан текст	Япон хадмал	Хятад хадмал	Өөрчлөлтийн хэлбэр	Задлан шинжилгээний дүгнэлт
わあ、すごいわ ねえ。 Пөөх, ямар мундаг юм бэ	わあ、すごいわ ねえ。 Пөөх, ямар мундаг юм бэ	好丰富啊  Ямар их (баялаг) юм бэ	Япон хэлний хүрээнд өөрчлөлт байхгүй. Хятад хэлэнд үг нэмсэн.	Япон хэлэнд байхгүй “富” (баялаг) гэх үгийг нэмсэн.
いいわよ、そ のうち来たら お金を払えば	いいわよ、そ のうち来たら お金を払えば	没关系，等一 下有人来再付 钱就行了	Япон хэлний хүрээнд өөрчлөлт байхгүй. Хятад хадмалд үг нэмсэн.	Хятад хадмалд “有人” (хүн нь) гэдгийг нэмж утгыг тодруулсан

Эх яриан текст	Япон хадмал	Хятад хадмал	Өөрчлөлтийн хэлбэр	Задлан шинжилгээний дүгнэлт
いいんだから。 Зүгээр дээ, тэгж байгаад ирэхээр нь мөнгийг нь төлчихвөл болчих болохоор.	いいんだから。 Зүгээр дээ, тэгж байгаад ирэхээр нь мөнгийг нь төлчихвөл болчих болохоор.	Зүгээр ээ, хүн нь ирэхээр мөнгийг нь төлчихөд болно.		
千尋も食べな。 Чихиро ч бас идээрэй.	千尋（ちひろ）も食べな。Чихиро ч бас идээрэй.	千尋也来吃 Чяньшюнь ч бас ирээд идээрэй	Япон хэлний хүрээнд орчуулгад гэсэн бичиглэлийн ард хаалтад дуудлагыг нь нэмж оруулсан. Хятад хадмалд үг нэмсэн.	“千尋”-гийн ард（ちひろ） Чихиро гэж хадаж өгсөн. Хятад хадмал орчуулгад “来” (ирээд) гэдгийг нэмсэн.

### 4.3 Халуун усны эзэн авгайтай гэрээ байгуулдаг үзэгдэл

Санасандаа хүрэхийн тулд тодорхой хугацаанд бас тодорхой хэмжээгээр зайлшгүй ухарч, байдлыг тандах хэрэгтэй гэдгийг харуулдаг.

Харьцуулсан хүснэгт 3. (япон хэлээрх дуу авиа, япон хадмал, хятад хадмал)

Эх яриан текст	Япон хадмал	Хятад хадмал	Өөрчлөлтийн хэлбэр	Задлан шинжилгээ
契約書だよ。 Энэ гэрээ байна.	契約書（けいやくしょ）だよ。 Энэ гэрээ байна.	这是契约书 Энэ гэрээ.	Япон хэлний хүрээнд “гэрээ” гэсэн ханзны ард хаалтад дуудлагыг нь нэмж оруулсан.	Ханз уншиж чадахгүй үзэгчид зориулж “кээякүшо” дуудлагыг нэмсэн.
そこに名前を書きな。働かせてやる。 Наанаа нэрээ бич. Ажиллуулаад өгье л дөө.	そこに名前を書きな。働かせてやる。 Наанаа нэрээ бич. Ажиллуулаад өгье л дөө.	在上面写上名字 我给你工作 Дээр нь нэрээ бич. Би чамд ажил өгье.	Япон хэлний хүрээнд өөрчлөлт байхгүй. Өөр үгээр орчуулсан. Занаж сүрдүүлсэн утга хятад	Япон хэлний “働かせてやる” (ажиллуулаад өгье л дөө) гэдгийг “我给你工作” (би чамд ажил өгье) болгож, занаж сүрдүүлсэн утга баларсан.

Эх яриан текст	Япон хадмал	Хятад хадмал	Өөрчлөлтийн хэлбэр	Задлан шинжилгээ
			хадмалд баларсан.	
<p>贅沢な名だね。今からお前の名前は千だ。分かったら返事をするんだ千。</p> <p>Тансаг нэр байх нь ээ. Одоогоос чиний нэр бол Сэн. Ойлгосон бол хариулаач Сэн.</p>	<p>贅沢な名だね。今からお前の名前は千だ。分かったら返事をするんだ千！</p> <p>Тансаг нэр байх нь ээ. Одоогоос чиний нэр бол Сэн. Ойлгосон бол хариулаач Сэн!</p>	<p>真是奢侈的名字! 从今后你的名字叫小千, 知道了吗? 你叫小千, 知道了就回答我, 小千!</p> <p>Ямар тансаг нэр вэ. Өнөөдрөөс эхлээд чамайг Шяочянь гэнэ. Ойлгосон уу? Чамайг Шяочянь гэж дуудна Ойлгосон бол надад хариулаач, Шяочянь!</p>	<p>Япон хэлний хүрээнд өөрчлөлт байхгүй. Хоёр хэлний хооронд хандлага өөрчлөгдсөн. Үг өөрчлөгдсөн. Хятад хэлэнд үг, өгүүлбэр нэмэгдсэн.</p>	<p>Япон хэлний “贅沢な名だね” (Тансаг нэр байх нь ээ) гэснийг “真是奢侈的名字!” (Ямар тансаг нэр вэ) гэж хадсан.</p> <p>Япон хэлний “今から” (Одоогоос) нь хятад хэлэнд “” (өнөөдрөөс) гэж өөр үгээр буусан. Япон хэлэнд байхгүй “知道了?” (Ойлгосон уу?)”, “你叫小千(Чамайг Шяочянь гэж дуудна)”, “...надад...” зэрэг үг хэллэгийг нэмсэн.</p> <p>Хятад хадмалд охины нэрд “小(Шяо)” гэх хятад хэлний нэрлэх хүүхэд, залуу хүнийг дотночлох утгатай үг нэмсэн.</p>

## 5. ДҮГНЭЛТ

Япон хэлээрх эх яриан текстийг япон, хятад хэлээрх хадмал орчуулгатай харьцуулж үзээд дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Нэг хэл (япон хэл)-ний хүрээнд хийгддэг хадмал орчуулга нь харааны чадвар, унших чадвар сул хөгжсөн тодорхой нэг бүлэгт зориулагдсан байх магадтай.
2. Нэг хэл (япон хэл)-ний хүрээнд дүрийн сэтгэл хөдлөл, баймжийн илэрхийлэлд нэмэгдэх, хасагдах зарчим хэрэглэгддэггүй.
3. Хятад хэлээр хийгдсэн хадмал орчуулгад утгын гол цөм өөрчлөгдөөгүй.
4. Хятад хэлээрх хадмалд дүрийн сэтгэл хөдлөл, баймжийн илэрхийлэл эх ярианаас өөр байдлаар уншигдах өнгө аяс анзаарагдаж байна.

5. Хятад хэлээрх хадмалд эх ярианы текстэд байхгүй үг өгүүлбэрийг нэмсэн нь утгыг тодотгож өгсөн байна.
6. Хятад хэлээрх хадмалд эх ярианы текстийн үг өгүүлбэрийг утга ойролцоо өөр үг өгүүлбэрээр сольж орчуулсан байна.

Хадмал орчуулгыг бол цаг хугацаа, орон зайн хязгаарлалтын зарчимд тулгуурлан хийдэг ч гэлээ зүгээр нэг үсэгжүүлэх үйлдэл биш, утгыг оновчтой тодорхой болгодог үйл явц юм. Нөгөөтээгүүр, сэтгэл хөдлөлийн шинжтэй мэдрэмж, хүмүүс хоорондын харилцааны хандлага, баймжийн утга гээд бодит хэрэглээний шинжтэй мэдээллийн тодорхой нэг хэсэг нь устгагдах, балрах, өөрчлөгдөх зэрэг үзэгдэл гардаг байна. Гэхдээ, эдгээр өөрчлөлт нь дүрс зураглал болон дуу авианы тусламжтайгаар нөхөгдөж байх урьдчилсан тохиргоотой байна. Хадмал орчуулга бол дүрс зураглалыг үзэж сонсох явцад үйлчилдэг хэлний илэрхийллийн нэмэлт, оновчтой хэлбэр юм.

### Ном зүй

- Díaz Cintas, J., & Remael, A. (2007). *Audiovisual Translation: Subtitling*. Manchester: St. Jerome Publishing.
- Shinohara, Y. (2018). *Japanese Audiovisual Translation and Cultural Adaptation*. Tokyo: Hituzi Shobo.
- Gottlieb, H. (1992). A New University Discipline. J. Díaz Cintas-Д, *Translation and the Media* (61-75). London: Routledge.
- Pedersen, J. (2011). *Subtitling norms for television: An Explorative Study*. Amsterdam: John Benjamins Publishing.
- Baker, M. (2011). *In Other Words: A Coursebook on Translation (2nd ed.)*. London: Routledge.
- Venuti, L. (1995). *The Translator's Invisibility: A History of Translation*. London: Routledge.
- Hosaka, T., & Shimada, M. (2017). *A Study on Subtitle Translation: Constraints and Reduction Strategies*.
- Sturt, Y. (2007). Japanese Languages and Culture in Spirited Away. (1-12). Edingburgh: The University of Edingburgh.



# **ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОРЧУУЛГА**



## ХОЛБОО ХАМААРЛЫН ҮҮРЭГ ТҮРЭГ-МОНГОЛ ХЭЛНИЙ НИЙТЛЭГ ХЭВ ШИНЖ ҮҮСЭХЭД НӨЛӨӨЛСӨН НЬ

Рассадин В.И

Орчуулсан: Б.Даваасүрэн<sup>67</sup>

Алтай овгийн хэлний нийтлэгийн тухай асуудал бол бидний мэдэхээр нэг бус үеийн эрдэмтдийн оюуныг чилээж буй асуудал юм (энэ асуудлын талаар [1-4] үзнэ үү). Өнгөрсөн хугацаанд дурдагдан буй хэлнүүд гарлын хувьд төрлийн холбоотой болохыг дэмждэг ба эсэргүүцдэг хоёр үзэл санаа үүсэж хөгжсөн билээ. Түрэг-монгол хэл төрлийн холбоотой болохыг дэмжигчдийн дотор тэр дундаа эдгээр хэлийг зэрэгцүүлэн судалдаг эрдэмтдийн хүрээнд хүртэл түрэг-монгол хэлний нийтлэг хэв шинж гэж тооцогддог үгийн сан, хэл зүй, авиа зүйн түвшинд илэрдэг маш олон нийтлэг шинжийг гарлын хувьд төрөл хэлнүүд гэдгийн баталгаа болно хэмээх үзэл бодол эртнээс нааш баттай тогтжээ. Түүнчлэн алтай овгийн хэлнүүдийг төрөл хэмээн тууштай дэмждэг эрдэмтэд болон эсэргүүцдэг эрдэмтдийн аль аль тал нь энэ хэлний овогт багтдаг ард түмнүүд, тэдний хэл түүхэн он цагийн туршид XIII зуунаас хойш ч хоорондоо харилцаа хамааралтай оршиж ирсэн бөгөөд тус цаг үед харилцан үг зээлсэн зүйл ч бий гэдгийг хүлээн зөвшөөрдөг (жишээлбэл [5]). Цаг үеийн хувьд нэлээд эрт үед хамаардаг нийтлэг үзэгдлүүдийн тухайд гэвэл тус таамаглалыг (орч. алтай овгийн хэлнүүдийг төрөл гэж үздэг онол) дэмждэг эрдэмтэд нэгэн нэгдмэл байх үеийн өвөг алтай хэлнээс уламжилж ирсэн өв хэмээн тооцдог буюу өөрөөр хэлбэл, алтай өвөг хэл үнэндээ нэлээд хожуу үед задарсан гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Тус (орч. алтай овгийн хэлнүүдийг төрөл гэж үздэг) онолыг эсэргүүцэгчид бүх нийтлэг тохирдог үзэгдлүүдийг урт удаан хугацааны туршид бие биедээ нөлөөлсөн явцын үр дүн хэмээн үздэг талаар Н.А.Баскаков тэмдэглэхдээ: «Алтай овгийн хэлнүүд хэв шинжийн хувьд төстэй ба маш эрт цагт тэдгээр хэлнүүд төрөл байсан байх боломжтой хэмээх Л.В.Котвичийн онол нь магадгүй алтай судлалд гарч ирсэн хоёр дах чиглэл болох (орч. алтай овгийн хэлнүүдийг төрөл биш гэж үздэг) үгүйсгэдэг үзэл санаануудын хамгийн үнэмшилтэй нь бөгөөд энэ үзэл санааг дэмждэг зарим төлөөлөгчид (Ж.Клоусон, А.М.Щербак, Г.Д.Санжеев нар) эдгээр хэлийг төрөл байх боломжтойг огт эсэргүүцэж, илэрч буй адил төстэй үзэгдлүүдийг харилцан бие биедээ нөлөөлсний үр дүн хэмээн үздэг» [2, 49 х.,].

Алтай овгийн хэлнүүдийн нийтлэгийн асуудал, тэр дундаа түрэг-монгол хэлний нийтлэгийн асуудал одоо ч шийдэгдээгүй хэвээр байна. Бидний бодоход, үүний шалтгаан нь одоо хүртэл судалгааны тийм ч зөв бус арга зүй хэрэглэж байгаад оршино. Тиймээс ч сүүлийн үед судалгааныхаа арга зүйг дахин нэг эргэж харах, асуудалд өөрөөр хандах талаар дуу хоолойгоо илэрхийлэх нь их боллоо (жишээлбэл, [6-13] үзнэ үү). Үгийн сангийн тооцоолон бүртгэх арга [7-9], энэтхэг-европ хэл шинжлэлийн арга зүй [10-12], хамгийн чухал нь бүх ормол үгийг тогтоогоод, түүн дотроос нийт алтай хэлний уугуул хэлний давхаргыг ялган тогтоох [13, 14],

<sup>67</sup> Ph.D., МУИС, ШУС, ХУС, Монгол хэл хэлшинжлэлийн тэнхим, ORCID: 0009-0001-7764-2314

тохирч байгаа болон зөрж буй үгийн харьцааг тал бүрээс нь нягтлан дүгнэх [6, 23 х.] зэрэг аргыг санал болгож байна.

Алтай судлалын хүрээнд, ялангуяа түрэг-монгол хэлний нийтлэг хэв шинжийн талаар олон жилийн судалгаа шинжилгээ, хайгуулын ажил хийсний сүүлээр бид ч мөн адил алтай судлалыг мухардал, эцэс төгсгөлгүй маргаанаас гаргахын тулд судалгаа шинжилгээнийхээ арга зүйг дахин эргэж харах, хайгуул шинжилгээнийхээ арга барилыг өөрчилбөл зохилтой хэмээх бодолд хүрч байна. Зүгээр зэрэгцүүлэн тогтоох ажлаас тийм ч сайн үр дүн гарсангүй. Алтай овгийн янз бүрийн хэлнүүдэд яг тохирдог хэлний нэгжүүд байгаа нь нийт алтай хэлний үгийн сангийн нөөц байдаг гэдгийн баталгаа хараахан биш юм. Алтай овгийн хэлэнд багтдаг ард түмний эртний хийгээд олон янзын харилцаа хамаарлын үр дүн болсон ормол нэгжүүдийг зайлшгүй ул суурьтай судлах шаардлагатай байна [15, 3 х.].

Ялангуяа эрт цагт түрэг хэлнээс монгол хэлэнд орсон ормол нэгжүүдийг тогтооход ашигладаг арга барил болон шалгууруудыг боловсруулсан А.Рона-Ташийн үзэл санаа, онолыг хэрэглэж болмоор санагдана [13]. Тэрээр, хэрвээ алтай өвөг хэл байсан гэж үзвэл тэр хэл маш эрт цагт задарсан бөгөөд алтай өвөг хэлнүүдийн бие даасан хөгжил хувьслыг маш урт удаан түүхэн хөгжлийн үйл явц гэж үзэх ёстой хэмээн маш зөв зүйтэй тэмдэглэжээ. Жишээлэхэд, хүрэл зэвсгийн үед алтайн ард түмнүүд тэрчлэн тэдний хэл хэдийнээ хөгжлийн хангалттай үе шат туулж чадсан цаг хугацаа бөгөөд тэд хоорондоо олон янзын харилцаа холбоонд орж байсан нь тодорхой юм. Иймээс алтай судлалын шийдэх ёстой асуудал бол зөвхөн хожуу үеэр зогсохгүй мөн өнгөрсөн мянган жилийн хугацаанд орсон үгийг тогтоох ба хожмын нөлөө тусгалыг хасаад, хэрэв нийт алтай хэлний уугуул үгийн сангийн нөөц гэж үлдвэл түүнийг тогтоох явдал юм.

Түрэг-монгол хэлний нийт дундын үгсийн сан нь ихэнхдээ эртний булгар хэлний үед хамаарах эртний түрэг хэлнээс монгол хэлэнд орсон үзэгдэл гэдгийг А.Рона-Таш маш тодорхой үзүүлсэн. Чухал нь үүнийг нотлохдоо салангид үгийг шинжлэн дүгнэх бус эсвэл хэсэг бусад баримт шалтгаануудыг тулгуур болгоогүй харин харилцан нөхөж, баталж өгдөг тогтвортой тохироо ба шалгууруудыг систем тогтолцооны хүрээнд авч үзсэн болно. Жишээлбэл, зохиогчийн зөв зүйтэй тэмдэглэснээр авианы тогтвортой тохироо бүхий түрэг, монгол хэлний өндөр хөгжсөн мал аж ахуйн нэр томьёо нь булгар-түрэг хэлнээс монгол хэлэнд орсон байдгийг зөвхөн z-г ба š-l хууль төдийгүй өөр хэд хэдэн шинжээс харж болно. Тиймээс эртний монгол хэлний (түүнчлэн нийт монгол хэлний) \**ünige* «үнээ», *birayu* «бяруу», *hüker* «үхэр», *uyuray* «уураг», *kimir* «айраг», *dal* «бог малын хашаа хороо» гэх мэт үг түрэг гаралтай юм. Түүнчлэн төмөрлөг боловсруулахтай холбоотой монгол хэлний үндсэн нэр томьёо мөн түрэг гаралтай үгс байдаг. Жишээлбэл, *darqan* «дархан», *qorjoljin* «хар тугалга», *temür* «төмөр», *ayurqai* «уурхай» г.м. Умард Хүннү бут цохигдсоны сүүлээр булгар-түрэгийн овог аймгууд умард хүннүчүүдийн хамт Төв Азиас өрнө зүгт нүүдэллэснийг үндэслэвэл дурдагдан буй холбоо хамаарал м.э. I зуунаас бүр өмнө болж өнгөрсөн гэдгийг бид зоригтой таамаглаж болно. Өөрөөр хэлбэл, өргөн уудам нутаг орныг хамарсан монголчуудын улс төрийн бодлого, түүнчлэн тэдний хэлний нөлөө тусгал их байсан Чингис хааны үеэс мянга илүү жилийн өмнө гэсэн үг.

Үүнээс гадна Дж.Клоусон болон А.Рона-Таш [5,13] түрэг гаралтай үгс монгол хэлэнд эртний түрэг хэлнүүдээс түүхийн харилцан адилгүй цаг үед орж байсан гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг. Чухам тиймээс л авианы нарийн тогтвортой тохирооны хуулийг тогтоох боломжгүй юм.

Тиймээс түрэг-монгол хэлний нийтлэг хэмээн тооцогдож буй хэлний нэгж бүрийг гярхай нягтлан дүгнэх шаардлагатай. Түрэг-монгол хэлэнд тохирдог ижил төстэй талуудыг болж өгвөл их тоогоор олж тогтоогоод, түүнийхээ үндсэн дээр түрэг ба монгол хэл гарал нэгтэй хэлнүүд мэтээр ярьж батална гэвэл алтай судлалын асуудлыг шийдэхэд ямар ч нэмэр болохгүй.

Түрэг-монгол хэлний үгийн сан, хэл зүйн түвшинд бидний илрүүлсэн тохирооноос харахад монгол хэлнээс түрэг хэлэнд орсон зүйл багагүй хувь эзэлж байгааг судалгаа харуулж байна ([15] үзнэ үү). Гэхдээ зөвхөн дундад зууны үед (XIII зуун ба хожуу үе) хамаатай бус

түүнчлэн түүхийн өмнөх үед ч холбогдож байна. Монгол хэлнээс орсон үгийг тодорхойлохдоо бид өөрсдийн боловсруулсан түрэг ба монгол хэлний авианы түүхэн хувьслыг давхар харгалзаж үзсэн шаардлага [15, 5-7 х., үзнэ үү] дээр үндэслэсэн болно. Жишээлбэл, авианы түүхэн хөгжлөөс харахад *\*di* ба *\*ti* үе монгол хэлний *\*di, \*ti* үетэй тохирдог бөгөөд улмаар *\*ji* ба *\*ci* болж хөгжсөнийг мэднэ. Түрэг хэлнүүдэд *di, ti, di, ti* үе хадгалагдаж үлдсэн. Тиймээс ямар нэгэн түрэг хэлний *ji* эсвэл *ci*-тэй үг нь эртний түрэг хэл болон эртний шинжээ хадгалж ирсэн орчин цагийн түрэг хэлэнд *di, ti* эсвэл *di, ti*-ээр тохиолддог. Энэ нь бусад орчин цагийн түрэг хэлнүүдэд анхдагч хэлний *ji, zi* болж хөгжсөн нь монгол хэлнээс орсон гэдгийн дохио юм. Жишээлбэл, алт. *кедьим*, хак. *кечжим* «хэжим» гэдэг нь монгол хэлнээс орсон буюу дун.монг. *kejim* «хэжим» хэмээх үг бөгөөд энэ нь монгол хэлний авиа зүй ба нөлөөтөн хувьсахуйн хуулиар эртний түрэг хэлний *kedim* «хувцас, нөмрөг» (эрт.түр. *ked-* «өмс-») гэдгээс үүссэн үг юм. Орчин цагийн алт. *кийим* «хувцас» < *кий-* «өмс-, нөмөр-», тоф. *кедiм* «хувцас» < *кет-* «өмс-, нөмөр-», хак. *кис-* гэдэгтэй харьцуулна уу. Түүнчлэн орчин цагийн ихэнх түрэг хэлэнд тархасан *карчыгай* «харцгай» гэдэг үг нь эртний *\*qartiγai* < *\*\*qartiγai* гэдгээс үүсэлтэй ду.монг. *qarčiγai* (энэхүү утгаар хэрэглэгддэг орч.цаг.монг. *харцага*, *харцгай*, бур. *харсага*, халим. *харцх* харьцуулна уу) гэх монгол хэлнээс орсон үг бөгөөд энэхүү *\*qartiγai* < *\*\*qartiγai* гэх хэлбэрийг сибирийн түрэг хэлний *картыга* ~ *хартыга* «харцгай» хэлбэртэй зэрэгцүүлж болох ба түрэг хэлнээс нэлээд эрт цагт монгол хэлэнд оржээ.

Цаашилбал. Чуваш хэлнээс бусад орчин цагийн түрэг хэлнүүдийн уугуул түрэг гаралтай үгэнд (лабдаизм) *л*-ших, (ротацизм) *р*-ших хууль байдаггүй өөрөөр хэлбэл, *z* ба *š* тогтвортой илэрдэг. Тиймээс энэхүү зүй тогтлын эсрэг *р* ба *л* гийгүүлэгчтэй үг илэрвэл монгол хэлнээс орсон нөлөө хэмээн үзэж болно. Жишээлбэл, сиб.-түр. *корголчун* «хар тугалга», *калчан* «халзан», *боро* «бор» гэх мэт үг дундад үеийн монгол хэлний дээрх үгтэй утга дүйх *qorγoljin, qaljan, boro* гэдгээс үүсэлтэй. Үүнийг уугуул түрэг хэлний *қорғашын* «хар тугалга», *қаш / қашқа* «морины духан дээрх цагаан зурвас», *боз* «бор **Б**нгө**Ө**-тай харьцуулна уу. Эдгээр үг уугуул түрэг хэлний үг бөгөөд түрэг хэлнээс монгол хэлэнд орсон гэдгийг эсэргүүцэж болох юм. Энэ нь үндсэндээ зөв. Гэхдээ үүний зэрэгцээ түрэг хэлнүүдэд тэр дундаа сибирийн түрэг хэлнүүдэд эдгээр үг нь монгол хэлний авиа зүй ба нөлөөтөн хувьсахуйн хуулиар хувирч буцаж орсон гэдэг ч үнэн.

Энэ мэт үгс ихэнх тохиолдолд илт монгол хэлний үгзүйн бүтэцтэй байдаг. Жишээлбэл, алт. *дыакылта* «даалгавар» < монг. *jaki-* «даалга-, захь-» + монг.хэл. *-lta* дагавар; алт. *көжжүүр* «хөшүүрэг, гөнжүүр, хөшүүр» < монг. *köšigür* «id» < монг. *köši-* «хөш-» + монг.хэл. *-gür* дагавар.

Түүнчлэн хэлбэрийн хувьд XIII зуунаас өмнө цаг үед хамаарах монгол хэлнээс орсон үг байгаа нь ажиглагддаг. Жишээлбэл, бар.-сиб. тат. *мегелей* «бээлий» (эрт.монг. *begelei*, дун.монг. *be'ēlei*, орч.монг. *бээлий* гэдэгтэй харьцуулна уу) алт. *сарбага* «унага» (эрт.монг. *sarbayā*, дун.монг. *sarba'ā*, орч.монг. *сарваа*, бур. *харбаа* «хоёр настай унага» гэдэгтэй харьцуулна уу) куманд: *шыбырган* «шуурга» (эрт.монг. *šiyurγan*, дун.монг. *ši'ürγan*, орч.монг. *шуурган*, бур. *шуурган* «id» гэдэгтэй харьцуулна уу)

Өмнөд сибирийн түрэг хэлнүүд ба якут хэлэнд монгол хэлний дүрслэх, авиа дуурайсан үг, тэмдэг нэрийн үг бүтээх болон байдлын тогтолцоог тусгаж авсан байдаг. Жишээлбэл, тув., тоф., якут: *кылай-* «гялалз-, гялтгана-» – тув., тоф. *кылагар*, якут: *кылыгыр* «гялалза-, гялтгана-»; тув., тоф. *кылас кын-*, якут: *кылас гын-* «гялс хий-»; тув., тоф. *кылас кылас кын-*, якут: *кылас кылас гын-* «хэдэнтээ гялс хий-», тув., тоф. *кылаңна-*, якут: *кылаңнаа-* «гялс гялс хий-» гэх мэт. Дундад үеийн монгол хэлний *gilai-, gilayar, gilās ki-, gilās gilās ki-, gilangna-* зохих жишээ хийгээд орчин цагийн монгол хэлний *гялай-, гялар, гялс хий-, гялс гялс хий-, гялтгана* гэх мэт мөн утгаар хэрэглэгддэг жишээтэй харьцуулна уу. Зарим энэ мэт хэлбэр киргиз ба кыпчаг хэлэнд мөн тохиолддог. Монгол хэлний нөлөө тусгал тун бага учир түрэг хэлнүүд дотроос огуз хэлний бүлэгт энэ мэт үзэгдэл тохиолддоггүй. Монгол хэлний нөлөө тусгал сибирийн түрэг хэлнүүд, киргиз хэлэнд, харин кыпчаг бүлгийн хэлнээс казах, каракалпак хэлэнд ажиглагддаг. Огуз

бүлгийн хэлэнд (Чингис хааны үе хийгээд хожуу цаг үед хамаатай ормол үгийг эс тооцвол) монгол хэлнээс үг ороогүй атал сибирийн түрэг хэлнүүд, киргиз хэл ба кыпчаг бүлгийн хэлэнд гүн гүнзгий нөлөөлсөн байдгаас харахад огузууд (ямар ч байсан дийлэнх хэсэг нь) Дундад Ази руу нүүдэллэснээс хойш Төв Ази болон Өмнөд Сибирийн бүс нутагт монгол хэлний хүчтэй нөлөө тусгал эхэлсэн үйл явц бололтой. Өөрөөр хэлбэл, VII-VIII зууны сүүлээр түрэг, монгол хэл ойртож, бие биедээ урт удаан хугацааны явцад нөлөөлсөн явдал юм.

Монгол хэлний нөлөө хамгийн бага туссан татар, карачаево-балкар (жишээлбэл [16-18]) гэх мэт хэлэнд түрэг, монгол хэлний нийтлэг үг илэрдэг нь эртний түрэг хэлнээс монгол хэлэнд орсон үг болон хожуу цаг үед түрэг хэлэнд орсон монгол үгс эзэлдэгт оршино.

Монгол хэлэнд орсон түрэг хэлний үгийг тогтоох судалгааны ажлаас үзвэл ([19-22] үзнэ үү) А.Рона-Ташийн хэлснээр нийт монгол хэлний шинжтэй тэр мэт үгийн ихэнх нь монгол хэлнүүд задрахаас өмнө эртний түрэг хэлнээс орсон байдаг. Жишээлбэл, монг. *заль* «асаж буй нүүрс», халим. *заль* «дөл», бур. *зали* «цог, гал», хууч.-монг. *jali* «дөл, урам зориг, цог» гэх мэт үгийн тоонд ордог үгс нь эрт.-түр. *jalin* «дөл» < эрт.-түр. *jal-* «дүрэлз-, ас-, шат-»; монг. *арил* «цэвэр бол-, арил-», бур. *арил* «цог, гал», халим. *арл* «цэвэр бол-; алга бол-, яв», хууч.-монг. *aril* «цэвэр бол-; алга бол-» < эрт.-түр. *aril-* «цэвэр бол-» < *ari-* «цэвэр ариун бай-». Эдгээр жишээ бол нэлээд эрт цагт түрэг хэл нийт монгол хэлний түвшинд нөлөөсний баталгаа юм.

Үүнээс гадна бүс нутгийн шинжтэй түрэг хэлний үг илэрдэг буюу ихэвчлэн ойрд-халх, буриад-халх хэлэнд орсон байдаг.

Түрэг хэлнээс ойрд-халх хэлэнд орсон үгийн жишээнд, монг. *эсэн*, халим. *эсн* «эрүүл энх» < эрт.-түр. *esän* «эрүүл энх, гэмтээгүй»; монг. *балдаргана*, *балчиргана* «шүхэртний овог», халим. *балчрһн* «манчин, бонго, хар хорс» < түр. *балтырган* «шүхэртний овог»; монг., халим. *иг* «эрүүл» < эрт.-түр. *ig, jig* «иг, ээрүүл»; монг. *зарам* «шигдэс, хэвэг», халим. *зарм* «шар будаа, хоног амуу; будаа, хэмхдэг амуу» < түр. *жарма, йарма* «шар будаа, хоног амуу» < түр. *жар-, йар-* «цавч-, хагал-, бутал-, хагал-» гэх мэт үг багтана.

Түрэг хэлнээс буриад-халх хэлэнд орсон үгийн жишээнд, монг. *олбог*, бур. *олбог* «дэвсэж суудаг дэсвгэр, ширдэг» < түр. \**олмақ* < түр. \**ол* «суу-» (үгийн гарлын утгыг [21, 54 х.] үзнэ үү); монг., бур. *той* «хурим найр» < түр. *той* «их найр» гэдгийг түр. *той-* «цад-, хана-», *тоқ* «цатгалан» харьцуулна уу.

Нийт монгол хэл задарсан үйл явц харилцан адилгүй байсан хийгээд түрэг хэлний нөлөө тусгал нийт монгол хэл задрах бүхий л явцад байсаар ирсэн гэдгийг энэ мэт түрэг хэлнээс орсон бүс нутгийн шинжтэй ормол үгээс харж болно.

Нийт монгол хэл задарснаас ч хойш түрэг хэл монгол хэлэнд нөлөөлсөөр байсан хийгээд бие даасан монгол хэлнүүд үүссэн үйл явц нь монгол хэл бүр өөрийн гэсэн онцлог бүхий түрэг хэлний нөлөө тусгалыг шингээж авсан гэдгийн баталгаа болдог. Жишээлбэл, халх-монгол хэлэнд өөрийн гэсэн түрэг хэлний онцлогтой байдаг нь *асаг* «амьтны доголсон нь» < түр. *ақсақ* «доглон» < түр. *ақса-* «догол-»; *илбээс* «загасны өгөөш; хавхны улавч» Өртний хэлбэр нь \**ilbegesün* < түр. *илмек* ~ *илбек* «дэгээ» < түр. *ил-* «хатга-, зүү-»; *торомдой* «турамтай шонхор, хар нүдэн торомдой» < түр. *турумтай* «ид»; *итлэг* «итлэг шонхор, алтан халбага шувуу, начин» < түр. *ителги* «ид»; *явлаг* «яваг шар шувуу» < түр. *ябалақ, япалақ* «ууль»; *хад* «хад жимс» < түр. *қат* «жимс».

Буриад хэл ба буриад хэлний аялгуунуудад, ялангуяа баруун аялгуунд түрэг хэлний өвөрмөц шинж багагүй илэрдэг. Жишээлбэл, *бойног* «үхрийн омрууны дагуух сул арьс» < түр. *мойнақ* «ид» < түр. *мойун* «хүзүү»; *бүхэ-* «идэгд-» < түр. *бөк* «хэтрүүлж ид-»; *жэрхэ-* «сэжиглэ-, гол-» < түр. *йиркен-*; *туюу* «нягтаршсан бөөм цас, шавар, морины туурайнд наалдсан нягтаршсан цас, шавар» < түр. *түйүг* «туурай»; бар.-бур. *саажа* «бүсгүй хүний гээг» < түр. *сачы* «түүний үс»; бар.-бур. *соол* «пийшин, байшин» < сиб.түр. *соол, чувал* «камин зуух»; бар.-бур. *шишхан*

«хатиг» < түр. *чыйықан* «id»; бар.-бур. *балаг* «жараахай, гүрцгий, нүцгэн жараахай» < түр. *балық* «загас» гэх мэт.

Түрэг хэлнээс орсон үг халимаг хэл болон халимаг хэлний аялгуунуудад хамгийн их тохиолддог. Жишээлбэл, халимаг хэлний *аю* «баавгай» < түр. *аю*; *ашу* «өш хонзон» < каз. *ашу*; *буриш* «чинжүү» < каз. *бұрыш*; *шалһ* «өвсний хадуур» < каз. *шалгы* «id» < каз. *шал*- «хад- цавч-»; *жилк* «дарвуул» < түр. *желкен, жылкэн* «id» < түр. *жел, жыл* «салхи».

Дээрх үгс нэлээд хожуу цаг үеийн түрэг, монгол хэлний холбоо хамаарлын илрэл юм.

Үүнээс харахад түрэг, монгол хэлний тохирдог нийтлэг шинж маш харилцан адилгүй байна. Нийтлэг тохирдог үгийн санг дор хаяж гурван бүлэгт хувааж болно. Үүнд: 1. Эрт ба хожуу үед түрэг хэлнээс монгол хэлэнд орсон үг; 2. Эрт ба хожуу үед монгол хэлнээс түрэг хэлэнд орсон үг; 3. Түрэг ба монгол хэлэнд нийтлэг тохирдог үг. Алтай хэл шинжлэл чухамдаа энэ талыг судлах ёстой учир өөр түвшний судалгаа шинжилгээний арга хэрэглэх шаардлагатай. Тиймээс түрэг, монгол хэлний тохирдог нийтлэг шинжийг одоогийн шатанд судлах ойрын хийгээд хойшлуулшгүй асуудал бол харилцан орсон үгийг тогтоох ба түрэг, монгол хэлний тохирдог нийтлэг уугуул шинжийг тогтоох явдал юм. Учир нь түрэг, монгол хэлний тохирдог нийтлэг шинж бүрэлдэн тогтоход хоёр хэлэнд харилцан үг орсон явц шийдвэрлэх үүрэгтэй биш гэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг болно.

#### АШИГЛАСАН БҮТЭЭЛ

1. *Щербак А.М.* Об алтайской гипотезе в языкознании // ВЯ. 1959. №6.
2. *Баскаков Н.А.* Алтайская семья языков и ее изучение. М., 1981.
3. *Рорре Н.* Introduction to Altaic linguistics. Wiesbaden. 1965.
4. *Насилов Д.М.* Об алтайской языковой общности. К истории проблемы // Тюркологический сборник. 1974. М., 1978.
5. *Clauson G.* Turkish and Mongolian studies. L., 1962.
6. *Щербак А.М.* О характере лексических взаимосвязей тюркских, монгольских и тунгусо-маньчжурских языков // ВЯ. 1966. №3.
7. *Клоусон Дж.* Лексикостатистическая оценка алтайской теории // ВЯ. 1969. №5.
8. *Лигети Л.* Алтайская теория и лексикостатистика // ВЯ. 1971. №3.
9. *Дёрфер Г.* Базисная лексика и алтайская проблема // ВЯ. 1981. №4.
10. *Дёрфер Г.* Можно ли проблемы родства алтайских языков разрешить с позиций индоевропеистики? // ВЯ. 1972. №3.
11. *Doerfer G.* Türkische und Mongolische Elemente in Neuperschen. Bd 1. Mongolische Elemente in Neuperschen. Wiesbaden. 1963. S.51-105
12. *Герценберг Л.Г.* Об исследовании родства алтайских языков // ВЯ. 1974. №2.
13. *Рона-Таш А.* Общее наследие или заимствования? (К проблеме родства алтайских языков) // ВЯ. 1974. №2.
14. *Санжеев Г.Д.* Б.Я.Владимирцов – исследователь монгольских языков // Филология и история монгольских народов. Памяти академика Бориса Яковлевича Владимирцова. М., 1958. С. 26.
15. *Рассадин В.И.* Монгольско-бурятские заимствования в сибирских тюркских языках. М., 1980.
16. *Булгакова-Баранникова А.А.* Сопоставительные материалы по лексике современного татарского и бурят-монгольского языков. // Сборник трудов по филологии. Вып., 3. Улан-Удэ, 1958.
17. *Хаджилаев Х.-М.* Очерки карачаево-балкарской лексикологии. Черкесск, 1970.

18. Суюнчев Х.И. Карачаево-балкарские и монгольские лексические параллели. Черкесск, 1977.
19. Рассадин В.И. О тюркизмах в бурятском языке. // К изучению бурятского языка. Улан-Удэ, 1969.
20. Рассадин В.И.. О бурятско-тюркских языковых взаимоотношениях // Диалектология и ареальная лингвистика тюркских языков Сибири. Новосибирск, 1986.
21. Рассадин В.И. Тюркизмы в халха-монгольском языке. // Материалы по истории и филологии Центральной Азии. Вып. 5. Улан-Удэ, 1970.
22. Рассадин В.И. Тюркские лексические элементы в калмыцком языке. // Этнические по историко-культурные связи монгольских народов. Улан-Удэ, 1983.

